



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САН

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

(Багшийн ном)

Улаанбаатар хот
2019 он

Насан туршийн боловсролын үндэсний төв

Захиалагч байгууллага: МонголБанк
Санхүүжүүлэгч байгууллага: Бичил санхүүгийн хөгжлийн сан
Боловсруулсан байгууллага: Насан туршийн боловсролын үндэсний төв

Зохиогчид:

I, II сэдэв: О.Ирвэс /БСШУСЯ-ны харьяа НТБҮТ-ийн мэргэжилтэн/
III, IV, V сэдэв: Ж. Оюунчимэг /Судлаач/
VI, X, XI сэдэв: Д.Оюунцэцэг /Доктор, МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш/
VII, VIII, IX сэдэв: П. Баянсан /МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш/

Хянан тохиолдуулсан:

Ц. Болормаа /Доктор, МУИС-ийн Бизнесийн сургуулийн захирал/
Л. Болортунгалаг /БСШУСЯ-ны харьяа НТБҮТ-ийн захирал/

Хэвлэлийн хуудас: 20хх
Хэвлэсэн тоо: 300ш
Цаасны хэмжээ: А4

© Энэхүү багшийн номыг Монголбанк, БСШУСЯ-ны харьяа НТБҮТ, Бичил санхүүгийн хөгжлийн сангийн зөвшөөрөлтэйгээр бүтнээр буюу хэсэгчилэн хувилахыг хориглоно.

Үнэгүй тараагдана.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
СЭДЭВ 1. МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?	7
1.1. Мөнгө, мөнгөний үнэ цэнэ	7
1.2. Орлого, түүнийг бүрдүүлэх боломж нөөц	10
1.3. Зардал, түүнийг хэмнэх арга	12
1. “МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?” Сэдвийн арга зүй	16
СЭДЭВ 2. ӨРХИЙН ТӨСӨВ	24
2.1. Өрхийн төсөв, түүний бүтэц	24
2.2. Өрхийн төсөв зохиох аргачлал	27
2.3. Өрхийн төсөв хөтлөлтийн давуу тал, ач холбогдол	28
2. “ӨРХИЙН ТӨСӨВ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	31
СЭДЭВ 3. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	35
3.1. Санхүүгийн байгууллагын төрөл, үйл ажиллагаа	35
3.1.1 Монголбанк	38
3.1.2 Сангийн яам	44
3.1.3 Санхүүгийн зохицуулах хороо	45
3.1.4 Хадгаламжийн даатгалын корпорацн	47
3.1.5 Бичил санхүүгийн хөгжлийн сан	49
3.1.6 Монголын банкны холбоо	50
3.2. Банк, түүний бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ	52
3.3. Банкнаас бусад санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ	62
3. “БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	63
СЭДЭВ 4. ХУРИМТЛАЛ БА ХАДГАЛАМЖ	64
4.1. Хуримтлалын зорилго, хуримтлал үүсгэх арга	64
4.2. Хадгаламжийн төрөл, түүний давуу ба сул тал	68
4.3. Хэрхэн хадгаламжтай болох вэ?	69
4.4. Хадгаламжийн хүүний тооцоолол	71
4.5. Хадгаламжид үзүүлэх инфляцийн нөлөөлөл	72
4. “ХУРИМТЛАЛ БА ХАДГАЛАМЖ” сэдвийн арга зүй	73
СЭДЭВ 5. ЗЭЭЛ	79
5.1. Зээл, түүний төрөл	79
5.2. Зээлийн бүтээгдэхүүний сонголт	80
5.3 Зээлийн хүү, төлбөрийн тооцоолол	80
5.4. Зээлийн барьцаа, түүнд тавигдах шаардлага, үнэлгээ	83
5.5. Зээлийн зардал, түүний зориулалт	84
5.6. Зээлийн гэрээ, талуудын үүрэг хариуцлага	84
5.7. Зээлийн сайн түүх бүрдүүлэхийн ач холбогдол	85
5.8. Зээлийн эрсдэлээс сэргийлэх арга	86
5.” ЗЭЭЛ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	87
СЭДЭВ 6. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ БА ВАЛЮТЫН ХАНШ	93
6.1. Үнийн өсөлт ба амьжиргааны өртгийн уялдаа холбоо	93
6.2. Валютын ханшийн өөрчлөлт бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?	95
6. “БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ БА ВАЛЮТЫН ХАНШ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	98
СЭДЭВ 7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МӨНГӨӨ ӨСГӨХ АРГА	101
7.1. Хөрөнгө оруулалтын зорилго, төрөл	101
7.2. Хувьцааны хөрөнгө оруулалт	101
7.3. Бонд буюу өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалт	103

7.4. Хөрөнгө оруулалтын эрсдэл ба өгөөж	105
7.5 Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ?	108
7. “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МӨНГӨӨ ӨСГӨХ АРГА” сэдвийн арга зүй	109
СЭДЭВ 8. ЭРСДЭЛ БА ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙН ХАМГААЛАЛТ	115
8.1. Эрсдэлийн тухай ойлголт, төрөл	115
8.2. Эрсдэлийг удирдах арга	116
8.3. Санхүүгийн луйвар ба залилан, түүнээс хамгаалах арга	119
8.4. Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалт	120
8. “ЭРСДЭЛ БА ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙН ХАМГААЛАЛТ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	122
СЭДЭВ 9. ДААТГАЛ	127
9.1. Даатгал, түүний үүрэг, ач холбогдол	127
9.2. Даатгалын бүтээгдэхүүнийг сонгох нь	130
9.3. Даатгалын нөхөн төлбөрийг хэрхэн яаж авах вэ?	132
9.4. Амьдралын даатгал	133
9. “ДААТГАЛ, ТҮҮНИЙ ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	134
СЭДЭВ 10. ТАТВАР ТАНЫ АМЬДРАЛД	139
10.1. Татварын тухай ойлголт	139
10.2. Хувь хүний орлогын албан татвар, түүнийг тооцоолох нь	140
10.3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	142
10.4. Татварын тайлан гаргах, төсөвт төлөх	145
10: “ТАТВАР ТАНЫ АМЬДРАЛД” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	146
СЭДЭВ 11. ТЭТГЭВЭР	151
11.1. Тэтгэврийн даатгал	151
11.2. Та хэдэн төгрөгийн тэтгэвэр авах вэ?	155
11.3. Өв хөрөнгийн төлөвлөлт	156
11. “ТЭТГЭВЭР” СЭДВИЙН АРГА ЗҮЙ	158
АШИГЛАСАН НОМ ЗҮЙ	161

ӨМНӨХ ҮГ

2015 онд Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан үүний дагуу оролцогч талууд олон тооны ажлуудыг хамтран хэрэгжүүлж ирлээ. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, улмаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих, Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэх боломж бүрдэх юм.

Нийгэм, эдийн засгийн тодорхой нөхцөлд иргэд өөрсдийн нөөц бололцоог зөв үнэлэх, ашиглах, өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээний талаар мэдээлэл олж авах, сонголт хийх, шийдвэр гаргахдаа түшиглэж буй **мэдлэг**(хувийн санхүүгийн талаарх ойлголт), **чадвар**(санхүүгийн талаарх мэдлэгээ өөрийн санхүүг удирдахад ашиглах), **итгэл үнэмшил**(санхүүгийн шийдвэр гаргахдаа өөртөө бүрэн итгэлтэй байх) гэх мэт санхүүгийн боловсролтой байх шаардлагатай байна.

Иймээс БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвөөс иргэдэд санхүүгийн боловсрол олгох багш нарт зориулсан “Санхүүгийн боловсрол” багшийн номыг боловсруулан гаргаж та бүхэнд хүргэж байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
МУ	Монгол Улс
МХБ	Монголын хөрөнгийн бирж
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УБ	Улаанбаатар
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХДК	Хадгаламжийн даатгалын корпораци
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ХК	Хувьцаат компани
ХНХ	Хувь нийлүүлэгчдийн хурал
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

ТАЙЛБАР

Сэдвийг амьдралд ойртуулах, ойлгомжтой болгох үүднээс Монголын мянга, мянган өрхийг төлөөлсөн Гарьдын гэр бүлийн гишүүдийн зохиомол дүрийг жишээнд ашиглан айл өрх бүрд тулгардаг санхүүгийн асуудлыг зөв шийдвэрлэхэд туслахыг зорилоо. Та бүхэнд Гарьдын өрхийн гишүүдийг товч танилцуулъя.



СЭДЭВ 1. МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?

*“Мөнгөний мөн чанар нь эд зүйлс биш
нийгмийн харилцаа болдогт оршдог”*
К.Маркс

1.1. Мөнгө, мөнгөний үнэ цэнэ

Мөнгө бол бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрт төлж болох санхүүгийн хэрэгсэл. Мөнгө нь өөрийнхөө өртгөөр бусад барааны өртгийг илэрхийлж байдаг онцгой таваар. Өөрөөр хэлбэл, мөнгө нь ямар ч таваараар солигдож чадах хөрвөх чадвар сайтай арилжаа, гүйлгээний хэрэгсэл юм.

Таны сонорт

Бидний өвөг дээдэс эзэн Чингис хааны үе залгамжлагчид тэртээ Монголын нэгдсэн гүрний үеэс алт, мөнгө, зэс, гууль, хүрэл зоосыг цутгаж, цаасан мөнгийг хэвлэн гүйлгээнд гаргаж, эд баялгаа тооцоолж, гадаад гүрнүүдтэй худалдаа наймаа хийж байсан түүх бий. Мөнгөн гүйлгээний энэ баялаг уламжлал эзэнт гүрний задрал, манжийн дарлалын он жилүүдэд тасалдахад Монгол оронд мал, арьс шир, хадаг, цай зэрэг зүйл мөнгөний үүргийг гүйцэтгэж байжээ. Ардын засгийн үед буюу 1925 онд мөнгөний шинэчлэл хийх тухай түүхэн тогтоол гарч анх 200100 төгрөгийг гүйлгээнд оруулж байсан. Үндэсний шинэ мөнгөн тэмдэгтээр 900 сорьцтой 18 грамм жин бүхий цагаан мөнгөн зоосыг батлан гаргаж “төгрөг” гэж нэрлэсэн түүхтэй.

Мөнгө бол амьдралын зорилго биш харин зорилгод хүрэх хэрэгсэл юм. Мөнгийг байгаагаар нь хэрэглэдэггүй харин та түүнийг ашиглан хэрэгцээтэй зүйлээ худалдаж авдаг. Энэ нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнэтэй зүйлийг өөр нэг үнэ цэнэтэй зүйлээр солих боломжийг олгоно.

Мөнгө нь зөөвөрлөхөд хялбар, тогтмол үнэ цэнэтэй, дахин ашиглах боломжтой, мөнгөн тэмдэгтийг хэдэн онд гүйлгээнд гаргаснаас үл хамааран ижил худалдан авах чадвартай, нийтээр хүлээн зөвшөөрсөн байх ёстой.



Тоологдохуйц, авч явахад хялбар байх



Нийт хэмжээ нь хязгаарлагдмал, нийлүүлэлтийг хянах боломжтой байх



Залгамж чанартай, хэдэн онд гүйлгээнд гарснаас үл хамааран ашиглагддаг байх



Жижиглэн худалдаа хийхэд зориулсан хуваагдмал нэгжтэй байх



Урт хугацаанд хэрэглэхүйц чанартай байх



Бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байх

Зураг 1.1. Мөнгөний үндсэн шинж

Аливаа улс орны төв банк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангаж ажилладаг. Харин арилжааны банкууд мөнгийг өсгөж арвижуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 1.2. Мөнгөний гүйцэтгэх үүрэг

Төлбөрийн хэрэгслийн үүрэг. Бүтээгдэхүүн үйлчилгээг зээлээр худалдан авахад үүссэн өр төлбөрийг төлөх хэрэгсэл хэрэгтэй ба энэ үүргийг мөнгө гүйцэтгэдэг. Жишээ нь: Бид зээлээр машин худалдан авах үед үүссэн, зээлийн өрийг төлөхдөө мөнгийг ашигладаг.

Тооцооны буюу өртгийн хэмжүүрийн үүрэг. Таваар гүйлгээнд гарахын өмнө түүний үнэ цэнэ хэмжигдсэн байх ёстой бөгөөд аливаа таваарын өртөг мөнгөөр хэмжигддэг учраас мөнгөний өөр нэг үүрэг нь өртөг тооцох хэмжүүр болдог.

Жишээ нь: Бидний өдөр тутамд хэрэглэж байдаг 500 граммын савалгаатай усыг үйлдвэрлэхэд байгалийн усыг шүүх, цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн зардал, тухайн усыг үйлдвэрлэж буй ажилчдын цалин хөлсний зардал, цахилгаан, дулааны зардал, сав, хаяглалтын зардал гэх зэрэг маш олон зардлууд тухайн бүтээгдэхүүний өртөгт шингэдэг бөгөөд үүнийг мөнгөөр хэмждэг.


Хуримтлалын хэрэгслийн үүрэг. Энэ нь аливаа бараа таваарыг хүссэн цагтаа худалдан авах боломжийг хангасан бэлэн мөнгөний нөөц санг бий болгоно гэсэн үг юм. Үүний тулд мөнгө хөрвөх чадвартай байх ёстой. Жишээ нь: Бид гэнэтийн шинжтэй хэрэгцээ үүссэн үед нөөц сан хэлбэрээр хуримтлуулсан мөнгөө ашиглаж байдаг.

Арилжааны буюу гүйлгээний хэрэгслийн үүрэг. Энэ үүргийн тусламжтайгаар бид өөрсдийн хэрэгцээт зүйлээ худалдан авах боломжтой болдог. Энэ үүргийн үед мөнгө бараа, үйлчилгээтэй нэгэн зэрэг солигддог.

Тодорхой хугацааны туршид бий болох мөнгөний орох, гарах урсгалыг мөнгөн гүйлгээ гэнэ. Хүний амьдралын өдөр тутам хэрэгцээнд зарцуулагдаж буй мөнгөний урсгалууд нь тухайн хүний цэвэр хөрөнгийн хэмжээнд нөлөөлж байдаг. Аливаа хүн мөнгийг хэрэгцээндээ зарцуулахаасаа өмнө заавал хуримтлал үүсгэсэн байвал зохино. Энэ нь тухайн хүний ойрын үеийн аюулгүй байдалд нөлөөлөхөөс гадна урт хугацаанд санхүүгийн эрх чөлөөнд хүрэхэд алхам алхмаар тусалдаг.

Мөнгө нь хүмүүсийн янз бүрийн эрэлт, хэрэгцээтэй холбогдож, таваарыг таваараар солилцох үеэс үүсэж хөгжсөөр өнөөг хүрсэн бөгөөд түүхийн явцад дараах хэлбэрийг дамжин хөгжиж иржээ.

Зураг 1.3. Мөнгөний төрөл



Мөнгө бол хүн төрөлхтний агуу их нээлтүүдийн нэг бөгөөд эдийн засгийн ухааны хамгийн чухал зүйл. Нийгэм эдийн засгийн нэг чухал харилцаа нь санхүүгийн харилцаа бөгөөд энэ нь мөнгөөр дамжиж хэрэгждэг.

Таны мэдлэгт

Нийгэм хөгжиж, үйлдвэрлэлийн харилцаа гүнзгийрэхийн хэрээр мөнгөний гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж ирсэн нь Монгол Улсын хөгжлийн түүхээс тодорхой харагддаг. Эрт үед мөнгөний үүргийг бод мал, хонь гэх мэт эд бараа гүйцэтгэж байсан. Орос Улсын Монголч эрдэмтэн И.М.Майскийн тодорхойлсноор, 1919 онд дараах жишгийг ардууд өөрсдийн худалдаанд ашиглаж байжээ. Жишээ нь: 1 гүү = 12 төлөг, 1 морь = 15 төлөг, 1 шар = 32 төлөг гэх мэт.

Мөнгийг хүн өөрийн хичээл зүтгэл, уйгагүй хөдөлмөр, бүтээлч ажлын үр дүнд цалин хөлс, шагнал, төлбөр хэлбэрээр олохоос гадна хөрөнгө оруулалтаас ногдол ашиг, хүү хэлбэрээр олдог. Жишээ нь: Хадгаламжийн хүү, хувьцааны ногдол ашиг гэх мэт.

Мөнгийг янз бүрийн зорилгоор хэрэглэж болно. Тухайлбал, мөнгийг бусдад зээлдүүлэх, бусдаас зээлэх, төлбөр тооцоо хийх, хувьцаа бонд гэх мэт үнэт цаас болон үл хөдлөх хөрөнгө худалдаж авах гэх зэрэг маш олон янзаар ашиглаж болно.

Зураг 1.4. Мөнгөний хэрэглээ¹



Санхүүгийн хамгийн энгийн хэлцэл бол мөнгийг хэн нэгэнд тодорхой хугацаанд, тодорхой хүүтэй ашиглуулж, өсгөж авах явдал байдаг. Үүнтэй холбоотой мөнгөний үнэ цэнэ гэсэн ойлголт үүснэ. Цаг хугацаа өнгөрөх тусам мөнгө аажмаар үнэ цэнэ буюу худалдан авах чадвараа алддаг. Ирээдүйд орж ирэх цаг хугацаанаас хамаарч хүлээн авах мөнгөний үнэ цэнэ өөр өөр байна. Мөнгө нь цаг хугацааны хувьд ирээдүйн болон өнөөгийн гэсэн 2 үнэ цэнэтэй. Энэ нь “Өнөөдрийн мөнгө маргаашийн мөнгөнөөс илүү үнэ цэнэтэй” гэсэн үзэлд үндэслэдэг. Монголчууд үүнийг “Маргаашийн өөхнөөс, өнөөдрийн уушги дээр” хэмээн ярьдаг.

Санхүүгийн төрөл бүрийн шийдвэр гаргахад мөнгөний үнэ цэнийг зайлшгүй авч үзэх шаардлагатай. Мөнгийг яаж зарцуулахаас хамаарч мөнгөний үнэ цэнэ тогтоно. Эдийн засгийн оновчтой зөв бодлого хэрэгжүүлээгүйн улмаас бараа, үйлчилгээний үнэ нэмэгдэх үед мөнгө үнэ цэнээ алдана. Мөнгөний ирээдүйн үнэ цэнэ гэдэг нь өнөөдөр хадгалуулах мөнгө, хүү болон хугацааны нөлөөллөөр тодорхой хугацааны дараа өсөх дүнг илэрхийлдэг.

Мөнгийг банканд хадгалуулж, банканд ашиглуулсны төлөө хүү тооцуулж авна. Энэ нь өнөөдрийн мөнгийг өсгөдөг. Тархиа гашилган бодож, хөлсөө дуслуулан хөдөлмөрлөж олсон мөнгө илүү үнэ цэнэтэй байх бөгөөд, үргэлжийн сэтгэл ханамжийг бий болгоно.

1.2. Орлого, түүнийг бүрдүүлэх боломж нөөц

Та аль болох зарцуулснаасаа илүүг олох эсвэл олсноосоо багыг зарцуулах хэрэгтэй. Ингэснээр хуримтлал үүсгэх боломжтой. Орлого нь бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанаас тухайн хугацаанд бий болсон мөнгөн хөрөнгө юм. Өөрөөр хэлбэл, хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө авч буй

¹ Жеймс Е.Стоверс, (2010). Санхүүгийн тусгар тогтнол, х.21.

мөнгөний хэмжээ юм.


Орлого нь биеийн болон оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болдог. Хувь хүн өөрт байгаа мөнгөө хадгалуулах эсвэл хөрөнгө оруулах шийдвэр гаргасны үр дүнд орлого олох боломж бүрддэг. Орлого олох эх үүсвэрийг Зураг 1.5-д үзүүлэв.

Зураг 1.5. Орлого олох эх үүсвэр




Хувь хүн аливаа хэлбэрийн аж ахуй эрхэлж орлого олбол энэ нь бизнесийн орлого болно. Бизнес эрхлэхийн тулд үндсэн дөрвөн төрлийн нөөц ашиглах ба үүнд газар, капитал, хөдөлмөр, ур чадвар зэрэг орно. Орлого бүрдүүлэх үндсэн нөөцийг Зураг 1.6-д үзүүлэв.

Зураг 1.6. Орлого бий болгоход ашиглагдах нөөц



Хүмүүсийн хооронд нас чацуу, мэргэжил ижил, нэг нутгийнх гээд нийтлэг шинж олон ч, амьдралын түвшин өөр өөр байх үзэгдэл элбэг. Үүний нэг шалтгаан нь тухайн хүмүүсийн орлогын ялгаа юм. Тухайлбал, зарим хүмүүс хэд хэдэн эх үүсвэрээс орлого олж байхад зарим нь орлогын ганц эх үүсвэртэй, зарим хүмүүс өөрийн гэсэн орлогын эх үүсвэргүй байдаг. Орлогыг нэмэгдүүлэх олон арга зам байх бөгөөд үүнийг Зураг 1.7-д үзүүлэв.

Зураг 1.7. Орлого нэмэгдүүлэх арга зам



Мөнгө, хүмүүст хүсэл зорилгодоо хүрэхэд тусалж, гачигдаж дутагдах зүйлгүй тайван амьдрах боломжийг олгодог. Ухаан бодолдоо мөнгө бий болгож сурах нь онцгой чухал. Учир нь мөнгө, эд баялаг оюун ухаанд байр сууриа эзлээд дараа нь биетээр орж ирнэ. Бодож сэтгэх оюун ухааны орон зайгаа тэлж, ядуу явцуу бодлоосоо салахгүй бол тэр жижигхэн орон зайд их мөнгөний санаа орж ирэхгүй.

1.3. Зардал, түүнийг хэмнэх арга

Маш олон хүмүүс олоогүй мөнгөө үрж, хүсээгүй зүйлээ авч, дургүй хүнээ дагуулах гэдэг.

–Will Rogers

Мөнгийг олохоос илүү зөв зарцуулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Учир нь хэрэгцээ цаг ямагт байдаг бөгөөд өсөн нэмэгдэх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, хүний хэрэгцээ нь хязгааргүй, хэрэгцээг хангах мөнгө хязгаартай. Иймд хязгаарлагдмал нөөц буюу мөнгийг хязгааргүй хэрэгцээнд зөв зохистой зарцуулах нь хувь хүнээс илүү их ур чадвар шаардана. Түүнчлэн мөнгийг хэрэгтэй зүйлсэд шаардлагатай хэмжээгээр зарцуулах нь зүйтэй. Олж байгаа мөнгө биш, үлдэж байгаа мөнгө л хүнийг чинээлэг болгодог гэсэн үгийг үргэлж санаж явах хэрэгтэй.

Хувь хүн эсвэл өрх гэр зардлаа төлөвлөхдөө дараах зүйлсэд анхаарвал зохино. Үүнд:

- Зарцуулалт хийх зүйлс нь хэрэгцээ юу? эсвэл хүсэл үү? гэдгийг ялгаж таних;
- Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг харгалзаж үзэх;
- Бэлэн мөнгөөр худалдан авалт хийх үед мөнгөний хариултыг бага гэлтгүй авч байх;
- Амьдралын энгийн зүйлсээс таашаал авах;
- Эд зүйлсээ гамнаж тордох зэрэг орно.

Хувь хүний амьдралд тулгарч болзошгүй дараах сорилтууд байж болно. Үүнд:


1. Амьжиргаагаа хангах;
2. Ажлын байраа хадгалах;
3. Хуримтлал үүсгэх;
4. Юунд хөрөнгө оруулалт хийхээ шийдэх;

5. Мөнгөнийхөө үнэ цэнийг хадгалж авч үлдэх;
6. Боловсрол эзэмших;
7. Эрүүл мэндээ хамгаалах;
8. Зээлээ төлж дуусгах;
9. Өөрийгөө хөгжүүлэх;
10. Үр хүүхэд, хань нөхөд, эцэг эхээ халамжлах;
11. Даатгалд хамрагдах гэх мэт.

Олсон орлогоо зөв зохистой зарцуулж байж амьдралд тохиолдох эдгээр үйл явдлыг шийдэх боломжтой.

Хүн олсноороо биш хэмнэснээрээ баяждаг гэх үг ч бий. Хүн хэрэглээгээ хянаж, төлөвлөж, тооцоолж байж сая хэмнэлт үүсгэж, хуримтлал бий болгоно. Хувь хүн хэрэглээгээ танах, үргүй зүйлд мөнгө зарцуулахгүй байх аргуудыг зураг 1.8-д харуулав.

Зураг 1.8. Хэрэглээг танах арга



Дараах хүснэгтээс ямар зардал таны орлогын хэдэн хувийг эзэлж байвал “Зохистой”-г ойлгох боломжтой.

Хүснэгт 1.1. Орлогод эзлэх зардлын хувь²

Зардлын ангилал	Зохистой хэмжээ	Зохистой хэмжээнээс 5-10 % болон түүнээс дээш хувиар хэтрэх үед
Өрхийн хэрэглээ (Хоол хүнс, ахуйн хэрэглээ, хувцас, унаа тээвэр гэх мэт)	30%	Таны хоол хүнсэндээ зарцуулж буй зардал орлогын 30%-иас хэтрэхгүй байх нь тохиромжтой. Хэрвээ энэ хэмжээнээс 5-10 % хэтэрвэл таны өрхийн санхүүгийн байдал хүндрэх аюултай. Иймээс тазардлуудаа хянаж багасгах арга хэмжээ авах шаардлагатай.
Тогтмол төлбөр	25%	Тогтмол төлбөртөө зарцуулах мөнгө таны орлогын 25%-иас хэтрэхгүй байх нь тохиромжтой. Хэтэрсэн тохиолдолд та одооноос хэмнэлт хийж эхлээрэй.

² Таны өрхийн орлого, зарлагын зохистой хэмжээ ямар түвшинд байх ёстой вэ?, Өдрийн сонин, 2016-11-29-ний №273 (5538) дугаарын нийтлэл

Боловсрол	10%	Та боловсролдоо зориулан хөрөнгө оруулалт хийж байгаа нь сайшаалтай ч энэ хэсгийн зардал таны орлогын 10%-иас хэтрэхгүй байвал тохиромжтой. Тиймээс гарч буй зардлуудаа хянаж багасгах арга хэмжээ аваарай. Хамгийн гол нь боловсролдоо зориулах мөнгөн хуримтлалыг эртнээс төлөвлөж үүсгэснээр танд ирэх санхүүгийн дарамт буурна гэдгийг санаарай.
Хүүхдийн зардал Сургууль, цэцэрлэгийн төлбөр, хувцас, халаасны мөнгө (унаа, хоол гэх мэт)	10%	Таны хүүхдэдээ зарцуулж буй зардал хэдий өндөр байгаа нь сайн хэдий ч уг зардал нь таны хүүхдийн ирээдүйд хир өгөөжтэй байж чадах вэ? Өнөөдрийн чихэр жимснээс нь багахан хасаад хүүхдийнхээ ирээдүйд зориулж хуримтлал үүсгэдэг үү? Энэ асуултыг өөртөө нэг тавиад үзээрэй.
Чөлөөт цаг	10%	Чөлөөт цагтаа зориулан зарцуулах мөнгө таны орлогын 10%-иас хэтрэхгүй байвал тохиромжтой. Хэрвээ та үүнээс илүү мөнгийг зарцуулж байгаа бол таны санхүүгийн байдал хүндрэх аюултай. Судалгаанд хамрагдагсдын ихэнх нь гадуур хооллоход их мөнгө зарцуулж байгааг тогтоожээ. Энэ нь таны өрхийн санхүүд эргээд дарамт үзүүлэх болно. Иймд та гадуур хооллох давтамжаа багасгаж, зарим наргиан цэнгээнийг алгасаж сураарай.
Эрүүл мэнд, гоо сайхан	10%	Таны эрүүл мэнд, гоо сайхны зардал таны орлогын 10%-иас хэтрэхгүй байвал тохиромжтой. Үнэтэй брэндийн бараануудын сав боодолд хамаг мөнгө үрждэгийг санаарай. Харин эрүүл мэндийн асуудлыг эрүүл мэндийн даатгалд даатгуулснаар шийдвэрлэх боломжтой. Мөн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдсанаар өвдсөн хойноо их мөнгө үрэхээс сэргийлнэ. Улиралд нэг удаа гэр бүлээрээ бүх төрлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж сураарай.
Төлөвлөөгүй зардал	5%	Таны төлөвлөөгүй зардал нь орлогын 5%-иас хэтрэхгүй байх нь тохиромжтой. Тиймээс та гэнэтийн хэрэгцээндээ зориулан хуримтлал үүсгэж байгаарай. Хүнд хэцүү үед 10 төгрөг ч олдохгүй үе тохиолддог. Иймээс та үүнд зориулсан хадгаламжийн бүтээгдэхүүнийг судлаад хэрэгжүүлээрэй.

Хүн хэрэглээгээ зөв зохистой, аль болох хүрээлэн буй байгаль орчинд хор хөнөөлгүй, нийгэм-эдийн засгийн хувьд үр ашигтай байх хэмжээнд хангах нь XXI зууны дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага болсон “Тогтвортой хөгжил”-ийн үзэл санаанд нийцэх юм. Ингэснээр тогтвортой амьдралын хэв маяг бий болно.



Мөнгө хангалттай байвал бүх зүйл тэгш сайхан, санаа зовох асуудалгүй тайван сайхан байна даа гэж хүмүүс уулга алдацгаадаг. Мөнгө аз жаргалыг цогцоор нь бүтээгч хараахан биш. “Харамсалтай нь мөнгө жаргал авчрахгүй, гай тарих нь ч бий”. Хэтэрхий их мөнгөтэй хирнээ аз жаргалтай байж чадахгүй зовж яваа хүн олон. Хангалттай их мөнгөтэй мөртлөө унтаж чадахгүй шөнөжингөө тарчилдаг хүн аз жаргалтай байж чадах уу? Мөнгөөр худалдан авч болдоггүй зүйл хүний амьдралд олон бий. “Мөнгөөр унтах ор худалдан авч болно, харин нойр худалдан авч чадахгүй” гэдэг. Амьдралд хангалттай хүрэлцэх мөнгөтэй болж, түүнийгээ зөв зарцуулж, санхүүгийн эрх чөлөөнд хүрч, аз жаргалын үүдийг өөрсдөө нээцгээе.

1. “МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

1.1 Мөнгө, мөнгөний үнэ цэнэ

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Мөнгө түүний шинж, төрөл, үүрэг, хэрэглээг тодорхойлох, тайлбарлах чадвартай болох, ийм чадваруудынхаа үндсэн дээр мөнгөө зөв удирдан хуримтлал үүсгэх, улмаар цаашид мөнгөний ирээдүйн үнэ цэнийг тооцож санхүүгийн шийдвэр гаргадаг болох.

Хэрэглэгдэх нэр томьёо:

Мөнгө, санхүүгийн хэрэгсэл, мөнгөний үнэ цэнэ, мөнгөний төрөл, шинж, мөнгөний үүрэг ба хэрэглээ, мөнгөний ач холбогдол.

Хэрэглэгдэхүүн:

- 1993 оноос өмнө хэрэглэж байсан 100, 50, 25, 20, 10, 5, 1 төгрөг, 1, 5, 10, 20, 50 мөнгө (заавал бүх тооны мөнгөн дэвсгэрт, зоосон мөнгө байх албагүй олдсоныг нь биетээр харуулах, эсвэл тэдгээрийн хэвлэмэл зураг, цахим зураг ашиглаж болно. <http://mass.mn/n/12405> гэсэн хэсэгт социалист тогтолцооны үеийн мөнгөн дэвсгэртийн цахим зураг байгаа)
- 1993 оноос хойш хэрэглэж байгаа 1, 5, 10, 20, 50, 100, 500, 1000, 10000, 20000 төгрөг, зоосон мөнгө (бүгд одоо хэрэглэж байгаа тул зургийг нь харуулахад болно. Одоо хэрэглэж байгаа мөнгөний цахим зургийг https://mn.wikipedia.org/wiki/Монголын_мөнгөн_тэмдэгт гэсэн хэсгээс татаж авч болно.
- Багийн ажлын цаас, цаасны маркер, банкны хадгаламжийн дэвтрийн хуулбар.

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, тайлбарлах, мэдээлэл олж авах, өөртөө ашиглан тооцоолон бодох, бүлгээр ажиллах.

Сургалтын зохион байгуулалт:

Мэдээлэл өгөх, мэдлэг бүтээлгэх, бүлэг тус бүрийн онцлогт тохирсон бүлгийн ажил хийлгэх, зөвлөмж боловсруулах, тайлбарлах арга зүйг баримтлан дараах 6 алхмыг хийнэ.

Алхам 1:

Эхлээд мөнгөний тухай ярихын өмнө мөнгө хаана үүссэн, хэзээнээс хэрэглэж эхэлсэн тухай суралцагчдаар яриулна. Хүмүүсийн мэдээллийг сонссоны дараа “таны сонорт 1” мэдээллийг болон түүнтэй холбоотой мэдээллийг өгнө.

Алхам 2:

Суралцагчдыг санхүүгийн мэдлэгийн түвшинг нь өөрсдөөр нь үнэлүүлэн “анхан, дунд, ахисан” гэсэн 3 бүлэгт хуваасныхаа дагуу суудлыг нь бүлгийн ажил хийлгэх зохион байгуулалттай болгоно. Анхан шатны мэдлэгтэй бүлэгт “Мөнгө гэж юу вэ? гэсэн асуултад хариулах, дунд бүлэгт мөнгөний шинжүүд, ахисан түвшний мэдлэгтэй бүлэгт мөнгөний төрөл хэлбэр, гүйцэтгэх үүргийг хамтаараа ярилцан бичих даалгавар өгнө.

Бүлгийн ажлыг 10 минутад багтаан хийлгээд бүлэг тус бүрийн төлөөллөөр багаараа гаргасан санаануудыг нэгтгэж яриулна. “Санхүүгийн хэрэгсэл” гэсэн ойлголтыг оруулж ирсэн байвал тэр хэсэгт төвлөрч “Мөнгө бол

бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрт төлж болох санхүүгийн хэрэгсэл буюу мөнгө нь ямар ч таваараар солигдож чадах хөрвөх чадвар сайтай арилжаа, гүйлгээний хэрэгсэл” гэсэн тодорхойлолтыг тайлбарлаж өгнө. Хэрвээ уг бүлэг “санхүүгийн хэрэгсэл” гэсэн санаа гаргаж ирээгүй бол санхүүгийн хэрэгсэл гэж юу болох, түүний дотор мөнгө ямар байр суурь эзэлдэг тухай дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө.

Алхам 3:

Мөнгө гэдгийг сайн ойлгохын тулд мөнгөний дараах шинжүүдийн талаар чиглэл өгнө. Санхүүгийн мэдлэгээ бага болон дунд гэж үнэлсэн бүлгийн төлөөллийн мөнгөний шинжүүдийн тайлбарыг сонсоод мөнгөний дараах нарийвчилсан тайлбарыг өгнө.

	Мөнгөний шинжүүд	Тайлбар
1	Тоологдохуйц, авч явахад хялбар	Дэвсгэрт дээр тоо байдгийн учир, том нэгжийн мөнгийг цаасаар хийдэг, задгай мөнгийг металлаар хийдгийн учрыг тайлбарлана.
2	Тогтмол үнэ цэнэтэй	Мөнгө яагаад үнэ цэнэтэй болдог вэ? гэвэл алт, мөнгө зэрэг хэзээ ч үнэ цэнэ алддаггүй зүйлс болох үнэт металлаар баталгаажсан байдаг тухай тайлбарлана.
3	Дахин ашиглах боломжтой	Мөнгөн дэвсгэртийг нэгээс нөгөөд дамжуулдаг ч тэр авсан хүн нь цааш дамжуулан хэрэглэхэд огт үнэ цэнээ алддаггүйн учрыг тайлбарлана.
4	Залгамж чанартай буюу хэдэн онд гүйлгээнд гарснаас үл хамааран ашиглагддаг байх	Гүйлгээнээс тухайн мөнгөн дэвсгэрийг хасах шийдвэрийг Төв банкнаас гаргасан ч түүнийг шинэ гарсан мөнгөн дэвсгэртээр сольж өгдөг, шинээр мөнгөн дэвсгэрт гаргасан ч өмнөх дэвсгэртийн тоотой давхцуулахгүй байгаа нь залгамж чанартай тухай зэрэг тайлбар хийнэ.
5	Жижиглэн худалдаа хийхэд зориулагдсан хуваагдмал нэгжтэй байх	Мөнгөн дэвсгэрт тодорхой тоотой байдаг нь жижиглэн худалдаа хийхэд зориулагдсан байдаг тухай хэрэглэгдэхүүн дээр тайлбарлана.
6	Нийтэд зөвшөөрөгдсөн хүлээн	Монгол төгрөг Монгол улсын хилийн дотор нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн төлбөрийн хэрэгсэл болох тухай болон доллар зэрэг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн валютын тухай жишээн дээр тайлбарлана.
7	Урт хэрэглэгдэхүйц байх хугацаанд чанартай	Хэрэглэгдэхүүн дээр задгай мөнгийг төмрөөр хийдгийн учрыг тайлбарлах, мөнгөн дэвсгэртийн цаасны бат бөх байдлын тухай тайлбарлана. (Санамсаргүй угаасан ч будаг нь арилдаггүй)

Алхам 4:

Суралцагчид мөнгийг тодорхойлж, мөнгөний шинжүүдийг тайлбарлаж чаддаг болсон бол мөнгөний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар тайлбарладаг болох хэрэгтэй. Энэ тухай багш өөрсдийгөө санхүүгийн ахисан мэдлэгтэй гэж үнэлсэн бүлгийн төлөөллийг нь сонгон яриулна. Ихэнх хүмүүс мөнгөний үүргүүдээс “арилжаа, худалдааны”, “төлбөрийн” зэрэг үүргийг бичих боломжтой бөгөөд бусад буюу “өртгийн хэмжүүр”, “хуримтлалын хэрэгсэл” гэдэг талаас багш өөрөө гүйцээн бичиж тайлбарлах байдлаар чиглүүлэг өгнө. Ингэхдээ үүрэг тус бүрээр жишээ болгон хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэж харуулах эсвэл зураг 1.2-ыг

үзүүлэн таниулах материал болгон бэлтгэж ашиглана.

Алхам 5:

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэг болгоод мөнгөний төрөл, хэлбэрийн талаар суралцагчдын санаа бодлыг бүлэг бүрээр 5 минутад багтаан хэлэлцүүлнэ. Багш бүлэг тус бүрийн төлөөллийн санаа бодлыг сонсоод доорх төрөл, хэлбэрүүдээс аль нь байхгүй байгааг тогтоогоод гүйцээн тайлбарлана.

	Мөнгөний хэлбэр	Тайлбар
1	Эд зүйлсэн мөнгө	Танай гэрт алт мөнгөн аяга, хэрэгсэл, хэт хутга, үнэт чулуун хөөрөг зэрэг бий эсэх тухай асууж ярилцан тэдгээр зүйлс уг чанартаа мөнгөөр үнэлэгдэх тул ийм хэлбэрт хамаарах тухай тайлбарлана.
2	Зоосон мөнгө	Зоосон мөнгөний хэрэглэгдэхүүн ашиглаж юмуу http://www.caak.mn/view/8250055/ зэрэг цахим зураг ашиглан тайлбарлана. Мөн мөнгөн болон алтаар хийгдсэн дурсгалын зоосны талаар болон Монголын эзэнт гүрний үеийн хосгүй үнэт зоосны тухай тайлбарлаж болно.
3	Цаасан мөнгө	Мөнгийг яагаад цаасаар хийх болсон бэ? Гэвэл хэрэглэхэд хялбар болгох зорилгоор хийсэн тухай, цаасан мөнгөний хэлбэрүүдийн тухай, Монгол 1920-оод оны үеэс цаасан мөнгө хэрэглэсэн тухай (http://www.caak.mn/view/8250061/) цахим зураг ашиглан тайлбарлана. Өөр цаасан мөнгөтэй холбоотой (https://www.news.mn/r/152103 , https://www.youtube.com/watch?v=JSq14ZO-p6Y) зэрэг сонирхол татах хэрэглэгдэхүүн ашиглаж болно.
4	Дансны мөнгө	Банкинд харилцах данс, хадгаламжийн данс зэрэг арилжааны цахим хэрэгсэл ашигласанаар таны мөнгө дансны хэлбэрт орно. Тэрийгээ даснаас мөнгө гаргах банк болон банкны АТМ зэрэг төхөөрөмжийн тусламжтай бэлэн мөнгө болгох, бэлэн мөнгө болгохгүйгээр бусдад шилжүүлэх, төлбөр төлөх, хадгаламж болгох, зээл авах зэргээр ашиглаж болдог банкны тооцооны аргачлалын тухай тайлбарлана.
5	Цахим мөнгө	Цахим мөнгө бол банкны дансны мөнгөнөөс ялгаатай нь цахим вэб сайтад тусгай систем ашиглан бүтээсэн програмчлалын мөнгө болох тухай https://mn.wikipedia.org/wiki/Биткойн зэрэг цахим мэдээллийг ашиглан тайлбарлана.

Мөнгөний төрөл, хэлбэрийг тодорхойлсны дараа тус номны “Таны мэдлэгт” мэдээллийг хүргэнэ.

Алхам: 6

“Хүн мөнгийг хэрхэн хэрэглэдэг вэ? гэдэг асуудлыг дээрх 3 бүлгээр тус бүр 5 минут хэлэлцүүлнэ. Багш бүлэг тус бүрийн төлөөллийн санаа бодлыг сонсоод мөнгөний хэрэглээг дараах байдлаар гүйцэд тайлбарлаж өгнө.

Мөнгөний
хэрэглээний төрөл

Тайлбар

- | | | |
|---|--------------------|--|
| 1 | Хуримтлуулах | Хүн тодорхой хэмжээний мөнгөн орлогоосоо 10 хувиас багагүй хэмжээтэйгээр таслан авч хэрэглээгээ зохицуулж хадгалах, тэгэхдээ бэлэн хэлбэрээр биш банкинд хийх, эргэлтэд оруулж өсгөх, эсхүл хөрөнгө оруулалт хийх, хувьцаа худалдан авч арилжаалах зэргээр тогтмол өсгөх хэрэгтэй тухай тайлбарлахдаа хуримтлалын сав, банкны хадгаламжийн дэвтрийн хуулбарыг харуулан холбогдох тооцоог хийлгэнэ. |
| 2 | Зээлэх, зээлдүүлэх | Бусдад орлогоосоо юм уу хадгаламжаасаа тодорхой хэмжээний мөнгийг тохиролцсон хугацаагаар түр өгөх, авахдаа ямар хүү тооцох, хэд болгож авахаа тохиролцох, хэрвээ бусдаас зээлбэл хэд болгож буцааж төлөх тухай тооцооллыг хийж тохиролцох зэргийг тайлбарлана. Зээлийн эргэн төлөлтийн график тооцоолол бүхий хэрэглэгдэхүүн ашиглах хэрэгтэй. |
| 3 | Бэлэглэх, өвлүүлэх | Өөрийн хуримтлуулсан мөнгийг үр хүүхэд, ах дүү төрөл садны хүндээ өгөх явдал бол бэлэглэх, өвлүүлэх харилцаа бөгөөд үүний үр дүнд хүлээн авсан хүнийхээ санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалж, өр зээлд эрсдэхээс хамгаалах тухай тайлбарлана. Тухайлбал хүүхдийн хадгаламжийг 18 нас хүрэхээр нэр дээр нь шилжүүлэх үүний жишээ гэж тайлбарлаж өгнө. |
| 4 | Арилжаалах | Хүн амьдрах явцад өөрийн хэрэгцээнд шаардлагатай эд зүйл, ажил үйлчилгээг аваад хариуд нь мөнгө өгнө. Энэ харилцааг мөнгөний арилжаа гэдэг тухай тайлбарлана. |

Үүний дараа “мөнгийг хэрхэн зарцуулах шийдвэр гаргаснаас хамаарч мөнгөний үнэ цэнэ тодорхойлогдох тухай, ирээдүйн мөнгөний үнэ цэнийг тооцон мөнгөн хөрөнгө оруулалт хийх, банкны хадгаламж болгох, үнэт эдлэл худалдан авах, хувьцаа худалдан авах зэрэг санхүүгийн шийдвэрүүдээс аль оновчтойг сонгох шаардлагатай болдог” тухай тайлбарлаж ярилцана.

Нэмэлт мэдээлэл:

Санхүүгийн хамгийн энгийн хэлцэл бол мөнгийг хэн нэгэнд тодорхой хугацаанд, тодорхой хүүтэй ашиглуулж, өсгөж авах явдал байдаг. Үүнтэй холбоотой “мөнгөний үнэ цэнэ” гэсэн ойлголт үүсдэг тухай ярилцана. “Цаг хугацаа өнгөрөх тусам мөнгө аажмаар үнэ цэнэ буюу худалдан авах чадвараа алддаг, ирээдүйд орж ирэх цаг хугацаанаас хамаарч хүлээн авах мөнгөний үнэ цэнэ өөр өөр байна. Мөнгө нь цаг хугацааны хувьд ирээдүйн болон өнөөгийн гэсэн 2 үнэ цэнэтэй” талаар чиглэл өгөөд мөнгөө удирдах хэрэгцээг тайлбарлаж өгнө.

Анхаарах зүйлс:

Энэ хэсэгт тайлбар хийхдээ “хуримтлал үүсгэнэ гэдэг бол мөнгө цуглуулах гэсэн үг”, “мөнгийг зөв удирдах гэдэг бол зарцуулахдаа заавал бүгдийг зарах биш хуримтлал болгож бага хэсгийг нь үлдээх явдал юм”, “бараа бүтээгдэхүүнийг бараа бүтээгдэхүүнээр сольж болох ч алдагдал үүсэж мэдэх бол ямар ч бараа бүтээгдэхүүнийг алдагдалгүй солих арга зам болж мөнгө” зэрэг хойшид үзэж судлах сэдвүүдтэйгээ холбох эхлэлийг тавихаа мартажгүй байвал зохино.

1.2. Орлого, түүнийг бүрдүүлэх боломж нөөц

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Өөрийнхөө болон өрхийн орлогын эх үүсвэрүүдийг тодорхойлох, нөөц бололцоогоо ашиглах, зардлын төрөл зүйлийг тодорхойлох, ямар зардлыг тэвчиж болох талаар шийдвэр гаргах, ингэснээр хуримтлал үүсгэж сурах

Хэрэглэгдэх нэр томьёо:

Орлого, орлогын эх үүсвэр, орлогын нөөц буюу орлогоо нэмэгдүүлэх арга зам

Хэрэглэгдэхүүн:

Өрхийн орлого, зардлын дэвтэр (Бичил санхүүгийн хөгжлийн сангаас гаргасан өрхийн төсөв ном), бизнесийн ашиг тооцох аргачлалын хүснэгт, багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Орлого зарлагын тэмдэглэл хөтлөх, тооцоолон бодох арга, балансын арга, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт:

Суралцагчдаар өөрсдийнхөө орлогын эх үүсвэр, нөөцөө тогтоох, орлогоо нэмэгдүүлэх арга зам хайх үндсэн дээр мэдлэг бүтээлгэх, бүлгийн ажил хийлгэх, нэгдсэн санал дүгнэлтэд хүрэх зэрэг арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг суудлаар нь 2 бүлэг болгоод “Орлого гэж юу вэ?” гэсэн асуулт тавьж тэдний санаа бодлыг сонсоод багш “Орлого бол бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанаас тухайн хугацаанд бий болгосон мөнгөн хөрөнгө” гэсэн тодорхойлолтыг тайлбарлаж өгнө. Ингэхдээ тэдний ярьсан зүйлд энэхүү санаа хэрхэн туссаныг бүртгээд орлогын эх үүсвэрүүдийн талаар зураг 1.2-ийг хэрэглэгдэхүүн болгон ашиглаж тайлбарлана.

	Орлогын эх үүсвэр	Тайлбар
1	Цалин, хөдөлмөрийн хөлс	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2016 оны дөрөвдүгээр сарын 20-ны өдрийн 04 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг цагт 1,428 төгрөг 60 мөнгө буюу сард 240,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоож 2017 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж байгаа тухай мэдээллийг тухайн хүмүүсийн сард авдаг цалингийн хэмжээтэй холбон тайлбарлана. Хэрвээ тухайн хүн аливаа хэлбэрийн аж ахуй эрхэлж байгаа бол сард олсон мөнгөн орлогыг тооцон гаргах, тэмдэглэл хөтлөх шаардлагатай байдаг тухай тайлбарлана. Ашгийн марж дунджаар та үйлдвэрлэл эрхэлдэг бол 20-40 хувь, худалдаа эрхэлдэг бол 10-20 хувь, үйлчилгээ эрхэлдэг бол 30-50 хувь байдаг тухай, бизнесийн ашгийг тооцох аргачлалын тухай тайлбарлана. Ингэхдээ бизнесийн ашиг тооцох аргачлалын хүснэгтийг ерөнхий байдлаар хийж хэрэглэгдэхүүн болгон ашиглах хэрэгтэй.
2	Бизнесийн ашиг	

3	Хадгаламжийн хүү		Сэдэв 4-т ашиглагдах банкны хүүгийн хэрэглэгдэхүүнийг ашиглан хүү бодох аргачлалын тухай, хадгаламжийн хүүгийн орлогын татвар ногдуулдаг болсон тухай тайлбарлана.
4	Хувьцааны ашиг	ногдол	Сэдэв 7-д ашиглагдах хувьцааны ногдол ашгийн тухай хэрэглэгдэхүүнийг ашиглан хувьцааг нь худалдан авсан компани чинь ашигтай ажиллаж, ногдол ашиг хуваарилсан тохиолдолд ямар орлого орж ирэх бололцоотой тухай тайлбарлана.
5	Бусад орлого		Энэ хэсэгт тэтгэврийн болон нийгмийн халамжийн мөнгөн орлого болон өөрийн хэрэглээнээс илүү гарсан юм уу хэрэглэхгүй байгаа эд хөрөнгө, байр байшин, хашаа байшинг түрээсэлсны төлбөр болох орлогын тухай тайлбарлана. Түрээсийн орлого зах зээлийн эрэлтээс хамаардаг тогтворгүй орлогын эх үүсвэр болох талаар жишээ татан тайлбарлана.

Алхам 2:

Орлого бүрдүүлэхэд түүнийг ямар нөөц дээр тулгуурлан бий болгодог тухай зураг 1.3-ыг ашиглан дараах байдлаар тайлбарлана. Тайлбарлахдаа суралцагчдад ямар нөөц бололцоогоо ашиглан орлогоо нэмэгдүүлэх боломжтой тухай өөрсдөөр нь бодуулах, дүгнэлт гаргуулах чиглэлээр багш ажиллах шаардлагатай.

Орлогын нөөц	Тайлбар		
1	<table border="0" style="width: 100%;"> <tr> <td style="vertical-align: top;">Байгалиас нөөц</td> <td style="vertical-align: top;">үүссэн</td> </tr> </table> Байгалийн хэвлийн баялаг, сэргээгдэх эрчим хүч, амьтан ургамал зэргийг ашиглан орлого олдог бол энэхүү хэлбэрт хамаарах тухай тайлбарлана.	Байгалиас нөөц	үүссэн
Байгалиас нөөц	үүссэн		
2	<table border="0" style="width: 100%;"> <tr> <td style="vertical-align: top;">Оюуны болон хөдөлмөр</td> <td style="vertical-align: top;">биеийн</td> </tr> </table> Биеийн болон оюун хүч шаардсан ажил, үйлчилгээ, хөдөлмөрийн дүнд орлого олдог бол уг хэлбэрт хамаарах тухай жишээ татан тайлбарлана.	Оюуны болон хөдөлмөр	биеийн
Оюуны болон хөдөлмөр	биеийн		
3	Капитал		
4	<table border="0" style="width: 100%;"> <tr> <td style="vertical-align: top;">Менежментийн чадвар</td> <td style="vertical-align: top;">ур</td> </tr> </table> Үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн хийх явцад хөдөлмөрийн хүчний санхүүгийн болон удирдлага зохицуулалт, зохион байгуулалт хийсний төлөө орлого олдог бол энэхүү хэлбэрт хамаарах тухай тухайлбал ТУЗ-ийн гишүүдийн болон захирал, менежерүүдийн цалин, урамшуулал авах чадварыг энд хамааруулах тухай тайлбарлана.	Менежментийн чадвар	ур
Менежментийн чадвар	ур		

Алхам 3:

Орлогын нөөцөө тодорхойлсны дүнд суралцагчдад орлогоо нэмэгдүүлэх, нөөцөө ашиглах ямар арга зам байгаа тухай асуулт хар аяндаа гарч ирнэ. Ийм хэрэгцээ сонирхлыг төрүүлэх замаар багш ямар арга замууд байгаа тухай бүлэг тус бүрээр 10 минутад багтаан бүлгийн ажил хийлгэж жагсаалт гаргуулна. Энэхүү жагсаалтад зураг 1.4-д үзүүлсэн арга замууд гарсан эсэхийг нягталж үзнэ. Эцэст нь “орлогоо нэмэгдүүлэх өөрт тохирсон арга замыг сонгож чадвал хүсэл санхүүгийн зорилгодоо хүрч гачигдах зүйлгүй болж чадна” гэсэн нэгдсэн дүгнэлтийг суралцагчдаар гаргуулах чиглэлд анхаарч ярилцана.

Нэмэлт мэдээлэл:

Санхүүгийн урт хугацааны болон дунд хугацааны төлөвлөлт хийснээр эрсдэлийг тооцох, алдсан боломжийн өртөг тооцоолох зэргээр санхүүгийн зөв шийдвэр шаардлагатай мэдлэг, мэдээллийг олгож буй тухай тайлбар хийнэ.

Анхаарах зүйлс:

Энэхүү сэдвийн агуулгыг өөрсдийнх нь гаргаж ирсэн санаануудыг баяжуулах замаар хөтлөн дагуулах байдлаар багш сургалтыг зохион байгуулахыг хичээж дүгнэлт гаргуулах чиглэлд анхаарлаа хандуулах буюу өөрийн оролцоог бага байлгахыг хичээх шаардлагатай. Ингэхдээ хувь хүний “өрхийн орлого нэмэгдэж зарлагаасаа илүү болж чадвал хуримтлал үүсгэх”, “зарлага орлогоосоо илүү гарвал өр төлбөр үүсэх” бололцоотой болдог гэдгийг сануулах хэрэгтэй.

1.3. Зардал, түүнийг хэмнэх арга

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Зардлын төрөл зүйлийг тодорхойлох, зарим зардлыг хэмнэж болох арга зүйд суралцах суралцах

Хэрэглэгдэх нэр томьёо:

Зардал, зардлын төрөл, тэвчиж болох зардал, хэрэглээгээ танах арга зам, үхмэл хөрөнгө, орлого зарлагын баланс

Хэрэглэгдэхүүн:

Өрхийн орлого, зардлын дэвтэр (Бичил санхүүгийн хөгжлийн сангаас гаргасан өрхийн төсөв ном), бизнесийн ашиг тооцох аргачлалын хүснэгт

Сургалтын арга:

Орлого, зарлагын тэмдэглэл хөтлөх, тооцоолон бодох арга, балансын арга, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт:

Суралцагчдаар зардлын тооцоог гаргуулах, зардал хэмнэх арга замаа тодорхойлох үндсэн дээр зарлагын талаарх мэдлэг бүтээлгэх, бүлгийн ажил хийлгэх, нэгдсэн санал дүгнэлтэд хүрэх зэрэг арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг өөрийгөө үнэлэх байдлаар санхүүгийн мэдлэгээрээ “анхан, дунд, ахисан” гэсэн 3 бүлэгт хуваагдана. “Зардал гэж юу вэ?” гэсэн асуулт тавиад бүлэг тус бүрээр бодол санааг нь бичүүлнэ. Бичиж дууссаны дараа санаа давхардуулахгүйгээр “Зардал гэдэг бол тухайн гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангахад шаардагдах хөрөнгийн зарцуулалт юм” гэсэн тодорхойлолтыг гаргуулж ярилцах юм. Мөнгийг удирдахад “орлого олохоосоо илүү зарцуулахдаа анхаарал хандуулах чухал” гэсэн чиглэл өгөөд зардлыг хэмнэхийг тулд түүнийг ангилах, тухайлбал зайлшгүй болон зайлшгүй биш гэж хуваан авч үзэх ёстой гэсэн зөвлөгөөг өгнө.

Алхам 2:

Зардлын төрлийг тогтмол болон хувьсах гэсэн ерөнхий 2 хэсэгт хувааж тайлбарлаад өмнө бичсэн өөрсдийн зардлуудаа аль хэлбэрт хамаарахыг ангилуулна. Тухайлбал “хоол, хүнсний зардал бол тогтмол биш хэрэглээний

зардал” гэх мэтээр

Зардлын төрөл	Тайлбар
1 Хэрэглээ	Хүнс хоол, байр, хувцас, ахуйн хэрэглээний зардлыг энэхүү хэлбэрт хамаарах тухай тайлбарлана.
2 Даатгалын хураамж	Эрүүл мэндийн, байрны, автомашины, жолоочийн хариуцлагын зэрэг даатгалд зарцуулсан мөнгөн хөрөнгийг зардал гэж тооцох тухай тайлбарлана.
3 Хөрөнгө оруулалтын зардал	Үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, бонд зэрэг ирээдүйд ашиг өгөөж өгөх ч одоо гарч буй зардлуудыг энэхүү хэлбэрт хамруулдаг тухай тайлбарлана.
Татвар	Хадгаламжийн татвар, автомашины татвар, аливаа гишүүнчлэлийн татвар зэрэг цалин хөлс, орлогоос гадна төлдөг татваруудыг энэхүү төрөлд багтаадаг тухай тайлбарлана.

Алхам 3:

Зардлын төрлийг ялгаснаар тогтмол заавал гарах зардлуудыг гаргаад хувьсах, заавал гарах албагүй зардлуудыг танаж хэрэглээгээ хумьснаар орлогоо зарлагаасаа илүү болгох дараах арга замууд байгаа тухай зураг 1.5-ыг харуулж тайлбарлана.

Үүний дараа зайлшгүй гарах зардлуудын хэмжээг орлогын хэдэн хувь байхаар зохицуулан зарцуулбал зохистой гэсэн тооцооллыг дараах хүснэгтээр харуулж тайлбарлана. Гэхдээ (хүснэгт 1.1-ийн) зохистой хэмжээ 100 хувь болох тооцоо тул хуримтлал үүсгэх боломжгүй тооцоо гэдгийг суралцагчдад анхааруулна.

Нэмэлт мэдээлэл:

“Өрхийн хэрэглээнд мөнгө зарцуулан худалдан авсан боловч өдөр тутам хэрэглэгддэггүй зүйлсийг үхмэл хөрөнгө” гэх бөгөөд хэрвээ ийм хөрөнгө зардал гаргадаг бол нэн даруй худалдан борлуулж зардлаа хэмнэх хэрэгтэй тухай тайлбарлана. Мөн өрхийн хэрэглээгээ цомхон, ухаалаг болгож буй бол тогтвортой хөгжих эхлэл болох тухай тайлбарлаж өгнө.

Анхаарах зүйл:

Энэ хэсэгт “өрхийн дэвтэр хөтлөх буюу зарлагаа заавал тэмдэглэж байж орлогод ногдох зардлын хэмжээг нарийвчлан тооцоолох боломжтой болно” гэдгийг суралцагчдад ойлгуулах хэрэгтэй. Бидний ихэнх ийм тодорхой тэмдэглэл хөтөлдөггүй болохоор хуримтлал үүсгэж чаддаггүй тухай анхааруулах хэрэгтэй.

СЭДЭВ 2. ӨРХИЙН ТӨСӨВ

*Долоо хэмжиж, нэг огтол.
(Монгол ардын зүйр цэцэн үг)*

2.1. Өрхийн төсөв, түүний бүтэц



Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээр нийгэм эдийн засгийн болон өрх гэрийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарсан. Өрх гэр бүл бол хүний хөгжил, төлөвшлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, зан заншил, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн.

Өрх гэр: Нэг орон байранд амьдардаг, нэгдмэл төсөвтэй, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтдаа хангадаг хүмүүсийн нэгдэл юм.

Өрхийн орлого, зардлыг тооцож, төсөвлөх нь өрхийн гишүүдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хүртээмжтэй хуваарилалт хийх, хуримтлалыг бий болгоход ихээхэн ач холбогдолтой юм. Төсвийг өрхийн гишүүдийн хэрэгцээнд хуваарилах мөнгөний тооцоолол, төлөвлөгөө гэж ойлгоно.

Өрхийн төсөв: Мөнгөн хөрөнгийг бүртгэж, захиран зарцуулах тоон төлөвлөгөө юм. Хамгийн энгийн байдлаар тодорхойлбол, өрхийн мөнгөн орлого, зарлагын төлөвлөгөөг өрхийн төсөв гэнэ.

Өрхийн төсвийн зорилго нь өрхийн гишүүдийн материаллаг болон оюун санааны хэрэгцээг өрхийн хязгаарлагдмал нөөцөөр бүрэн дүүрэн хангахад чиглэдэг. Иймээс өрхийн төсвийн гол үүрэг нь өрхийн орлогыг зөв, үр ашигтай хуваарилж, зарцуулахад оршдог. Мөнгөө зөв зүйлд зарцуулж, хуримтлал үүсгэхийн тулд төсөв зохиож, төсвийн дагуу зарцуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, мөнгө санхүүгээ зөв удирдаж, амьдралаа ухаалгаар авч явахад тань өрхийн төсөв тусална.

Таны мэдлэгийн санд

Монгол улс 1935 онд 198792 өрхтэй байсан бол 2015 онд 859106 болж өдгөө 80 жилийн хугацаанд 4,3 дахин нэмэгджээ. Үүнээс улсын нийт хүн ам 3100000 гэж үзвэл нэг өрхөд 3-4 хүн ногдож байна. Өрхийн тоо, түүний бүтэц, ам бүлийн тоо нь хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдийн нэг мөн.

Төсөв нь орлого, зарлага гэсэн үндсэн бүтэцтэй байх бөгөөд өрхийн төсвөөс тухайн өрхийн гишүүдийн олж буй орлого (жишээлбэл, цалин хөлс), мөнгөний зарцуулалт, хуримтлал, хадгаламж, өр төлбөрийн хэмжээг харж болно.

Зураг 2.1. Өрхийн төсвийн үндсэн ойлголтууд



Гэр бүлийн гишүүдийн нас, хүйс, боловсрол, эрхэлж буй ажил, мэргэжил зэргээс хамаараад өрхийн орлого харилцан адилгүй эх үүсвэрээс бүрддэг. Зарим өрхийн орлого зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос бүрддэг бол заримынх нь бизнесийн, түрээсийн гэх мэт олон төрлийн орлогын эх үүсвэртэй байна.

Зураг 2.2. Өрхийн орлогын ангилал



Өрхийн орлогыг олон шинжээр ангилж болох бөгөөд Зураг 2.2-т үзүүлсэн ангилал нь ХХОАТ-ын зорилгоор ангилсан ангилал юм. Үүнээс гадна жил бүр МУ-ын ҮСХ-ноос өрхийн сарын дундаж орлогын бүтцийг тодорхойлон гаргадаг. Үүнийг Зураг 2.3-аас харна уу.

Зураг 2.3. Монгол Улсын нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц /2015 он/



Эх сурвалж: МУ-ын ҮСХ.

Өрхийн орлогыг гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангахад зарцуулдаг. Өрхийн орлого хязгаарлагдмал, хэрэгцээ хязгааргүй байдаг тул гишүүдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, амь зуулгыг хангахын тулд өрхийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай болдог. Үүний тулд өрхийн боломж, гишүүдийн тоо, бүтэц, нас, хүйсийн онцлогоос хамаарч орлого нэмэгдүүлэх боломжийг ашиглах хэрэгтэй. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг Зураг 2.4-өөс харна уу.

Зураг 2.4. Өрхийн орлого нэмэгдүүлэх боломж

- Өрхийн аж ахуй эрхлэх
- Төсөл бичих, бизнес эрхлэх
- Төсөл, хөтөлбөрт хамрагдах
- Өрхийн гишүүдийг мэргэжилтэй болгох, боловсролыг дээшлүүлэх
- Ажил хөдөлмөр эрхлэх
- Хуримтлалтай болох
- Хөрөнгө оруулалт хийх



Манай улсын нийт өрхийн сарын орлогыг ангилж үзэхэд тал хувь нь сарын 700000 төгрөгөөс бага орлоготой байгаа бол 13 хувь нь тэднээс 2-3 дахин их орлоготой байна. Олохоосоо илүү ухаалаг зарцуулалт хийх нь санхүүгийн


хүнд байдлаас гарах гарц байх болно. Иймээс өрхийн төсөв зохиоход зардлын төсөв чухал ач холбогдолтой. Зардлаа төлөвлөхдөө мөнгөө хэрэгцээт зүйлд зарцуулах, мөнгө хэмнэх боломжуудыг ашиглахад анхаарах хэрэгтэй.

2.2. Өрхийн төсөв зохиох аргачлал

Өрхийн төсөв зохиохдоо хамгийн багадаа 3 сарын турш орлого, зарлагаа нэг бүрчлэн бүртгэсэн байх ёстой. Бидний хамгийн гол асуудал бол орлого, зарлагаа бүртгэж хөтөлдөг байх явдал юм. Өрхийн орлого, зарлагаа бүрдгэснээр та ашиг, алдагдал болон цэвэр хөрөнгийн дүнгээ тооцож чадна. Энд өрхийн гишүүд ямар нэгэн хэмжээнд бүгд оролцоотой байх ёстой. Төсвөө хэлэлцээд шийдвэрлэсэн бол аль болох чанд баримтлах нь зүйтэй.

Санхүүгийн сахилга бат сайтай өрхүүд улирал, хагас болон бүтэн жилээр өрхийн төсвийн төлөвлөгөөгөө гарган мөрддөг. Үүний тулд ихээхэн хэмжээний орлого, зарлагаа урьдчилж тооцоолсон байна. Өрхийн төсвөө тогтмол хөтлөх явцдаа тодорхой хугацаанд хянаж, шинжилгээ хийгээд өнгөрсөн хугацаанд ямар зүйлд мөнгө их зарцуулсан, юунаас хэмнэлт гаргаж чадсан гэдгээ дүгнэж байх шаардлагатай. Энэ үйл явцад хамгийн чухал нь өрхийн гишүүн бүр тооцоотой байх хандлагын болоод үйлийн өөрчлөлт бий болгож байвал үр дүн харагдана.

Зураг 2.5. Өрхийн төсөв зохиох үе шат



Өрхийн төсөв зохиох хэд хэдэн арга байдаг бөгөөд Зураг 2.6-д өргөн ашигладаг, нийтлэг аргуудыг харууллаа.

Зураг 2.6. Өрхийн төсөв зохиох аргачлал





Дугтуйт төсвийн арга

Зардлын төрөл бүрээр дугтуй бэлтгэн өрхийн төсвийн тооцоогоо хуваарилж, төлөвлөгөөтэй зарцуулах арга юм. Америк болон Солонгос, Хятад улсуудад их хэрэглэгддэг. Энэ арга олон гэр бүлд үр ашгаа өгч чадсан байдаг. Дугтуйт төсвийн аргыг хэрэгжүүлэхийн өмнө орлого, зарлагаа бүртгэх бөгөөд түүнд үндэслэн орлого, зарлагаа төлөвлөнө. Өрхийн орлогыг зарцуулахын өмнө бага ч гэсэн мөнгийг хуримтлалдаа тогтмол хийсний дараа хэрэглээнд хуваарилна. Орлого хэрэглээнээс илүү гарвал хадгаламжаа нэмэгдүүлэх нь зүйтэй.

Энэ аргын гол агуулга бол өдөр болон сараар нийтлэг гардаг зардлуудаа тус тусад нь дугтуйнд хийнэ. Жишээ нь: Хоол хүнс 200000 төгрөг, унаа тээвэр 75000 төгрөг, өр зээл 280000 төгрөг, хадгаламж 200000 төгрөг гэх мэт.

Компьютерын системийн арга



Манай улсын хувьд орлогын хэмжээ их байсан ч хэрэглээндээ захирагдаж, орлогоосоо давсан зарлага гарган, улмаар хуримтлуулах, хадгалах боломжгүй болох тохиолдол элбэг. Дундаж орлоготой гэр бүлүүдийн хувьд ядуу, эмзэг байдалд өртөх магадлал өндөр байдаг гэж статистик судалгаагаар гаргасан байна. Энэ нь магадгүй тэдний хэрэглээ өндөр байдагтай холбоотой юм. Энд мөнгөө зөв менежменттэй зарцуулах нэг аргыг танилцуулья.³

Өрхийн төсвөө зохиохдоо тодорхой түвшинд алхамчлах хэрэгтэй. Жишээ нь: Өрхийн орлого, зарлагаа бүртгэх, зарлагын түүхээ дүгнэж, тэвчиж болох зардлаа олжилруулэн, өрхийн төсвөө зохиох, өрхийн төсвөө чанд мөрдөн санхүүгийн сахилга баттай байх.

Өрхийн төсвийн үндсэн зарчим

- Өрхийн төсвөө нэг байлгаж, шийдвэрийг хамтдаа хэлэлцэж гаргах;
- Хадгаламжийн дансаа хоёр хүний нэртэй, мөн хоёр хүний гарын үсэгтэй байлгах;
- Аль болох зээлгүй байхыг эрмэлзэх;

2.3. Өрхийн төсөв хөтлөлтийн давуу тал, ач холбогдол

Өрхийн төсөв хөтлөлтийн байдал Монгол Улсад хангалтгүй байна. 2010-2013 оны хооронд хийсэн түүвэр судалгаанаас харвал, өрхийн төсөв хөтлөлтийн байдал:

- Өрхийн төсөв огт хөтөлдөггүй 70 хувь;
- Өрхийн төсвөө хааяа бүртгэдэг 25 хувь;
- Өрхийн төсвөө бүрэн хөтөлдөг 5 хувь байна.

Өрхийн төсвөө хөтөлснөөр дараах давуу талтай. Үүнд:

- Гэр бүлд санхүүгийн маргаан гарахгүй, эхнэр, нөхөрт итгэлцэл бий болно.
- Гэр бүл бүх гишүүдийн хэрэгцээг хангах төлөвлөгөөтэй болно. Өрхийн төсвийн орлого, зарлага тэнцэх үү, үгүй юу? гэдгийг шийдвэрлэхэд хэрэгцээтэй материал нь болж байдаг. Өрхийн төсвийн бүртгэлийн дэвтэрт орлогын агуулга ба түүний шинж чанарыг сайн бүртгэснээр өрхийн төсвийн орлого, зарлага тэнцэх үү гэдгийг шийдвэрлэж байдаг.
- Нийгэм эдийн засгийн эрсдэлийг даван туулах арга замаа хайхад тусална.
- Өрх өөрийн төсвийн онцлог чанар, дадал зуршил, хэрэглээний өөрчлөлтийг харж болно.
- Санхүүгийн зорилготой болж төлөвлөгдсөн тооцоотой амьдралыг зохиоход хялбар болдог.

Өрхийн төсвөө хөтлөхгүй байх нь дараах сөрөг талтай. Үүнд:

- Өөрийн гэр бүлийн санхүүгийн онцлог чанарыг мэдэхгүй, хэт үрэлгэн зардал их

³ Оюунсүрэн, Б. (2014). Гэр бүлийн эдийн засгийн боловсрол. х.73.

гаргадаг.

- Гэнэтийн эрсдэл төлөвлөгөөгүй зардал гарах үед гэр бүлийн амьдрал хүндрэлд орно.
- Гэр бүлд санхүүгийн маргаан хөтөлдөг өрхийг бодоход илүү их гарна.
- Гэр бүл дэх гишүүдийн хэрэгцээ нь хангагдахгүйн улмаас зөрчил бий болно.
- Өдөр тутмын тооцоогүй амьдрал нь ирээдүйн эдийн засгийн эмзэг, ядуу байдалд хүргэх нь элбэг.
- Өрхийн төсөв хөтлөхгүй байх нь хадгалах, хуримтлуулах сэтгэлгээг бий болгохгүй байх хандлагатай юм.

Мөнгө их олдог хүн бүр баян байдаггүй. Харин хэрхэн яаж зарцуулахаас л хамаарна. Өнөөдөр та хир зэрэг хөрөнгөтэй хүн бэ? Та дараах загварын дагуу өөрийн хөрөнгө болон өр төлбөрөө тодорхойлно уу.

Хүснэгт 2.1. Хөрөнгө ба өр төлбөр

	Хөрөнгө (А)	Өр төлбөр(Б)
1	Бэлэн мөнгө	Хувь хүнд төлөх өр
2	Хадгаламж	Банкны зээл
3	Авлага	Ус, цахилгааны төлбөр
4	Хашаа байшин	
5	Газар	
6	Автомашин	Бусад өр төлбөрүүд
7	Мал	Өр төлбөрийн дүн
	Хөрөнгийн нийт дүн	Цэвэр хөрөнгө(В)

Цэвэр хөрөнгийн хэмжээг олохдоо хөрөнгийн нийт дүнгээс өр төлбөрийн нийт дүнг хасна. Өөрөөр хэлбэл, $B=A-B$ гэсэн томъёог ашиглана.

Та өрхийн төсвөө цахим байдлаар хөтлөх бол www.sankhuuginbolovsrol.mn хаягаар орж нэмэлт мэдээлэл авч ашиглах боломжтой.

Таны мэдлэгт

Өрхийн орлогын талаарх бүрэн мэдээлэл байхгүй үед түүнийг төлөөлж чадахуйц бусад үзүүлэлтүүдийн тусламжтайгаар амьжиргааны түвшинг үнэлэх аргыг орлогыг орлуулан тооцох арга гэнэ. Энэхүү аргачлалыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасны дагуу ҮСХ-ны дарга, Нийгмийн хамгааллын сайд хамтран 2010 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 58/36 дугаар тушаалаар баталсан. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2012-2015 онд “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн.

Хүснэгт 2.2. Өрхийн зарлагыг бүртгэх маягт*

№	Үзүүлэлтүүд	Хугацаа /сараар/																																
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30			
Хүнсний бараа	Талх, гурил, будаа																																	
	Мах, махан бүтээгдэхүүн																																	
	Сүү, сүүн бүтээгдэхүүн																																	
	Сахар, жимс																																	
	Төрөл бүрийн тос, өөх																																	
	Ундаа, жүүс																																	
Хүнсний ногоо	Согтууруулах ундаа																																	
	Тамхи																																	
Хувцас	Эрэгтэй																																	
	Эмэгтэй																																	
	Хүүхдийн																																	
Орон	Байрны төлбөр																																	
	Ус																																	
Цахилгаан	Байрны төлбөр																																	
	Ус																																	
Гэр ахуйн бараа	Цахилгаан																																	
	Ус																																	
Эм тариа	Гэр ахуйн бараа																																	
	Ус																																	
Тээвэр	Эм тариа																																	
	Ус																																	
Тээвэр	Такси																																	
	Нийтийн тээвэр																																	
Үйлчилгээ	Бензин, шатахуун																																	
	Үсчин																																	
Үйлчилгээ	Гар утас																																	
	Суурин утас																																	
Үйлчилгээ	Сургалтын төлбөр																																	
	Ном, хэвлэл, үзвэр																																	
Ахуйн хэрэглээний бараа	Сургалтын төлбөр																																	
	Ном, хэвлэл, үзвэр																																	
Зээлийн төлөлт	Ахуйн хэрэглээний бараа																																	
	Зээлийн төлөлт																																	
Амралт, баяр ёслол	Амралт, баяр ёслол																																	
	Зээлийн төлөлт																																	
Бусад	Амралт, баяр ёслол																																	
	Зээлийн төлөлт																																	
Нийт зардал	Бусад																																	
	Нийт зардал																																	

2. “ӨРХИЙН ТӨСӨВ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

2.1. Өрхийн төсөв, түүний бүтэц

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Өрхийн төсөв болон түүний бүтцийг тодорхойлдог болох, улмаар өрхийн төсвийн орлогоо нэмэгдүүлэх боломжуудаас ашиглах чадварт суралцах

Хэрэглэгдэх нэр томьёо:

Өрхийн төсөв, түүний бүтэц, өрхийн орлогын ангилал, орлого нэмэгдүүлэх боломж

Хэрэглэгдэхүүн:

Өрхийн төсвийн дэвтэр (Бичил санхүүгийн хөгжлийн сангаас гаргасан өрхийн төсөв ном), багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Өрхийн төсвийн задаргаа, тооцоолон бодох арга, балансын арга, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт:

Суралцагчдаар өрхийн төсөв гэж юу болох, түүний бүтцийг тодорхойлох, орлогыг яаж ангилж болох, орлого нэмэгдүүлэх ямар арга зам байгаа тухай бодол санааг нь бичүүлээд нэмж тайлбарлах, нэгтгэн дүгнэх замаар дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн бүлэг болгон хуваагаад “Өрхийн төсөв гэж юу вэ?” гэсэн асуулт тавьж бүлэг тус бүрийн санаа бодлыг бичүүлнэ. Ингэхдээ “өрх гэр гэж юу болох” талаарх мэдээллийг өгч 10 минут орчим ярилцуулж санаа бодлыг нь цаасан дээр бичүүлээд хэлэлцэнэ. Багш суралцагчдын бичсэнийг нэгтгэн “*Өрхийн төсөв бол мөнгөн хөрөнгийг бүртгэж, захиран зарцуулах тоон төлөвлөгөө юм. Хамгийн энгийн байдлаар тодорхойлбол, өрхийн мөнгөн орлого, зарлагын төлөвлөгөөг өрхийн төсөв гэнэ*” гэсэн тодорхойлолтод чиглүүлэн тайлбарлана. Энэ үйл явцад багш бүлэг тус бүрийн онцлог төлөөллийн санаа бодлыг нэгтгэхээс гадна бусдын оролцоог хангаж чиглүүлнэ.

Алхам 2:

“Төсөв нь орлого, зарлага, хуримтлал, өр төлбөр” гэсэн үндсэн бүтэцтэй гэсэн мэдээллийг өгсний дараа суралцагчдыг дээрх насны бүлгийн зохион байгуулалтыг хэвээр хадгалж бүлэг тус бүрийг “орлого, зарлага гэж юу болох, хэрхэн хуримтлал үүсэх, хэрхэн өр төлбөр болох тухай тайлбарла” гэсэн даалгавар өгнө. Багш тус бүрийг 10 минутад багтаан хэлэлцүүлээд тайлбарыг сонсоно. Үүний дараа өрхийн төсвийн бүрэлдэхүүн хэсгүүдийн агуулгыг зураг 2.1-д харуулсан агуулгаар тайлбарлана.

Алхам 3:

Өрхийн орлогыг хувь хүний орлогын ангилалтай адил (сэдэв 1.2-т буй хүснэгт) авч үздэг гэдгийг зураг 2.2-т илэрхийлснээр үзүүлээд өмнө ярилцсан хувь хүний орлогын төрлийг нэмэгдүүлэхийн тулд нөөц бололцоогоо ашиглах тухай зураг 2.4-т харуулсан аргуудыг хэрэглэх хэрэгтэй гэсэн зөвлөгөөг

өгнө. Үүнтэй холбоотойгоор Үндэсний статистикийн газраас гаргасан Монгол улсын нэг өрхийн дундаж орлогын бүтцийг зураг 2.3-г харуулж энэ жишээнээс санаа аван хэрхэн өөрийн өрхийн төсвийн орлогын бүтцийг тодорхойлж, орлогоо нэмэгдүүлэх боломжоо ашиглах тухай тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл:

Сэдэв 1.3-т өгүүлсэн хувь хүний санхүүгийн зардлын асуудлыг өрхийн зардал болгон өөрчилж өрхийн зардал хэмнэх аргуудаас ярилцаж болно. Мөн тогтвортой хэрэглээний асуудлыг оруулж ирснээр өрхийн зардлыг бууруулах ач холбогдолтой гэдгийг дурьдаж өгнө.

Анхаарах зүйлс:

“Хэрвээ та санхүүгийн асуудлаас гаръя гэж бодож байгаа л бол өрхийн төсвөө заавал бичиж хөтлөх хэрэгтэй” гэсэн зөвлөгөөг өгөх хэрэгтэй. Дээрх алхмуудад орлогын талыг голлон харуулсан бол “зардлын төлөвлөлтөө сайн хийж байж мөнгө хэмнэх боломж бүрдэнэ” гэдгийг суралцагчдад тайлбарлах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл “орлогын талаа нэмэгдүүлэх гэж хичээснээс зардлын талаа хянах илүү боломжтой зүйл” гэдэг талаас тайлбарлах хэрэгтэй.

2.2. Өрхийн төсөв зохиох аргачлал

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Өрхийн төсөв зохиох, дугтуйт төсвийн болон компьютерийн системийн аргыг ашиглах чадварт суралцах

Хэрэглэгдэх нэр томъёо:

Өрхийн төсөв зохиох аргачлал, түүнийг зохиох үе шат, дугтуйт төсвийн арга, компьютерын системийн арга, төсвийн зарчим

Хэрэглэгдэхүүн:

Өрхийн 3 сарын орлого, зарлагын тэмдэглэл (Бичил санхүүгийн хөгжлийн сангаас гаргасан өрхийн төсөв ном), багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Өрхийн төсөв зохиох аргачлал, тооцоотой байх, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт:

Суралцагчдаар өрхийн төсөв зохиолгох замаар дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг санхүүгийн мэдлэгийн түвшингээр “анхан, дунд, ахисан” гэсэн 3 бүлэг болгоод нэгэн өрхийн 3 сарын орлого, зарлагын тэмдэглэл үзүүлэн (хэрэглэгдэхүүн) бүлэг тус бүрийг 10 минутад багтаан уг жишээн дээр өрхийн төсөв зохиох даалгавар өгнө. Ингэхдээ зураг 2.5-д харуулсан үе шатуудыг ашиглана. Мөн тэрхүү үе шатуудын дагуу бэлтгэсэн хүснэгтийг багш самбар дээр зурж үзүүлээд бүлэг тус бүрийн төлөөллийн санаа бодлыг сонсоно.

Алхам 2:

Өмнө төсөв зохиож байгаагүй бол суралцагчдад хүндрэл учирна. Тиймээс төсөв зохиох аргачлалуудыг зураг 2.6-д харуулсны дагуу “хүснэгтэн, матрицан, дугтуйт төсвийн, компьютер системийн арга” тус бүрийн талаар товч тайлбарлана. Үүний дараа “зардлын төрөл бүрээр дугтуй бэлтгэн хийж зардал гарсны дараа мөнгө үлдвэл хуримтлал болгон тооцдог” аргыг

“дугтуйт төсвийн арга” гэдэг тухай, “компьютерын тооцооны систем бүхий бэлэн хүснэгтэд тоо оруулан тооцоо хийхийг компьютерын системийн арга” гэдэг тухай тайлбарлана. Ингээд төсвөө зохиож сурсан бол төсвийн дараах үндсэн зарчмыг тайлбарлана.

Үүнд:

- Өрхийн төсвөө нэг байлгах, шийдвэрээ хамтаараа хэлэлцэж гаргах
- Хадгаламжийн дансаа хоёр хүний нэртэй, мөн хоёр хүний гарын үсэгтэй болгох
- Аль болох зээлгүй байхыг эрмэлзэх зэрэг юм.

Нэмэлт мэдээлэл:

Өрхийн төсөв зохиох аргачлалыг боловсруулж тэрхүү аргачлалын дагуу биечлэн хийлгэх хэрэгтэй. Ялангуяа өрхийн төсөв хийдэг, гүйцэтгэл хянадаг програм ашиглан тооцоо хийвэл илүү үр дүнтэй болно.

Анхаарах зүйл:

Өрхийн төсвийг өдөр бүрээр биш юмаа гэхэд сар бүр хянахгүй бол төлөвлөлтийн дагуу биш болно гэдгийг байнга сануулах хэрэгтэй. Мөн өрхийн төсвийн төлөвлөлт эцсийн дүндээ хуримтлал бий болгох, хэмнэлт гаргах замаар санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилготой гэдгийг сайтар тайлбарлаж өгнө.

2.3. Өрхийн төсөв хөтлөлтийн давуу тал, ач холбогдол

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Өрхийн төсөв хөтлөх, түүний сул болон давуу талуудыг мэдэх, улмаар тогтмол хөтөлдөг хэвшил дадалтай болох

Хэрэглэгдэх нэр томъёо:

Өрхийн төсөв хөтлөлт, түүний зэрэг ба сөрөг тал

Хэрэглэгдэхүүн:

Өрхийн төсөв хөтөлсөн 1-3 жилийн тэмдэглэл, өрхийн төсвийн Excel программ дээр хийсэн жишээ (www.sankhuuginbolobsrol.mn), багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Өрхийн төсөв хийх, хөтлөх, хянах тооцоотой байх

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдад мэдлэг олгох, чиглүүлэх аргачлалыг хэрэгжүүлэн дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдаас “Та өрхийн төсөв хөтөлдөг үү?” гэсэн асуултыг асууна. Тэднийг “тийм, үгүй” гэсэн хэсэгт хувааж улмаар “тийм бол байнга, хааяа” гэсэн хэсэгт хэдэн хүн орж байгааг гар өргүүлэн мэдээд хэдэн хувь болж буй талаар тооцоо хийлгэнэ. Үүний дараа номонд буй 2010-2013 онд иргэдээс авсан өрхийн төсөв хийдэг эсэхийг тодруулсан судалгаанд “оролцогчдын дөнгөж 5 хувь хөтөлдөг” тухай мэдээллийг өгнө. Суралцагчид өөрсдийн дүнг дээрх судалгаатай харьцуулан ярилцана. Үүний дараа өрхийн зарлагыг хөтлөх хүснэгт 2.2-ийг танилцуулна. Энэ хүснэгтийг үзүүлэн

таниулах материал хэлбэрээр бэлтгэсэн байна.

Алхам 2:

Сургалтад оролцогчдыг суудлаар нь 2 хэсэгт хуваагаад нэг хэсгийг төсөв хөтлөхийн давуу талыг, нөгөөгөөр төсөв хөтлөхийн сөрөг талуудыг жагсаан бичүүлнэ. Ингэхдээ самбарыг 2 хэсэгт хуваан суралцагчдыг ээлжлэн гаргаж санаа давхардуулахгүйгээр жагсаан бичүүлнэ. Түүний дараа дараах хүснэгтээр утга санаа давхардаж байгаа эсэх, бичээгүй зүйл байгаа эсэх талаар өөрсдөөр нь дүн шинжилгээ хийлгэнэ. Дараах хүснэгтийг үзүүлэн таниулах материал болгон урьдчилан бэлтгэвэл зохино.

Давуу тал

Гэр бүлд санхүүгийн маргаан гарахгүй, гэр бүлийн гишүүдийн хооронд итгэлцэл бий болно.

Гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангах төлөвлөлт бий болно.

Нийгэм эдийн засгийн болон гэнэтийн эрсдэлийг даван туулах арга зам хайхад тусална.

Өөрийн өрхийн төсвийн онцлог, өөрчлөлт, төсөвт баригддаг дадал зуршил бий болж буй эсэхийг харж болно.

Хуримтлал үүсгэж урт хугацааны санхүүгийн төлөвлөлт хийх, тооцоотой амьдрах хэвшилтэй болно.

Үүний дараа өрхийн төсвөө хөтлөхгүй байхын сөрөг талуудын тухай ярилцана. Хүснэгт 2.1-д харуулсан аргачлалын дагуу цэвэр хөрөнгөө бодож тооцоолуулах дасгал ажлыг бүх суралцагчдаар хийлгэнэ. Тэгснээр цаашид цэвэр хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэхийн тулд өрхийн төсвөө тогтмол хөтөлдөг байхын ач холбогдлыг хэлүүлж дүгнэлт гаргуулна.

Нэмэлт мэдээлэл:

Өрхийн орлогын хөтлөлт байхгүй тохиолдолд өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх аргыг таны мэдлэгт гэсэн хэсгийн мэдээллийн хамт хүргэнэ. Мөн өрхийн зарлагыг хянах нэг боломж бол ebarimt.mn сайт болон аппликешн болж болох тухай тайлбарлана.

Анхаарах зүйл:

Өрхийн төсөв тогтмол хөтлөх буюу орлого, зардал, хуримтлал хөрөнгө, өр төлбөрийн мэдээллийг нэгтгэж байж санхүүгийн эрх чөлөөнд хүрдэг тухай суралцагчдад ухуулах хэрэгтэй. Ихэнх хүмүүс орлогоо нэмээд л байвал цаашдаа санхүү сайжирна гэж боддог тул “Хэр их олсондоо биш хир хямгач зарсандаа хуримтлалтай болдог” гэдэг энгийн үнэнийг ойлгуулах хэрэгтэй.

СЭДЭВ 3. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

3.1. Санхүүгийн байгууллагын төрөл, үйл ажиллагаа

Санхүүгийн байгууллага гэж санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг, санхүүгийн зуучлагчдыг хэлэх бөгөөд эдгээр нь зээл олгох, мөнгөн хөрөнгийг хадгалах, төлбөр тооцоо хийх, Монголбанк, Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг.

Хүснэгт 3.1. Санхүүгийн байгууллагууд

Монголбанк	Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ. Монгол Улсын Төв Банкныг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанкны төв нь Монгол Улсын нийслэлд байрлана. Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд мөн. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.
Банк	Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө болон харилцагчдын итгэж хадгалуулсан мөнгийг бусдад зээлдүүлэх, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлах үйл ажиллагаа явуулдаг Монголбанкнаас зөвшөөрөл авсан ашгийн төлөө байгууллага.
Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/	Өөрийн эзэмшигчдийн хөрөнгөөр зээл олгохоос гадна валют арилжаа, төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга хийх үндсэн үйл ажиллагаа явуулдаг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос зөвшөөрөл авсан ашгийн төлөө байгууллага.
Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/	Зөвхөн ХЗХ-ны гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлдэг байгууллага юм. ХЗХ-ны хөрөнгө нь гишүүдийн хадгаламжаас бүрддэг.
Даатгалын компани	Ирээдүйд учирч болох санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор гэрээгээр тохирсон нөхөн төлбөр авах хэлцэл юм. Үүнд албан журмын /жолоочийн хариуцлага/ болон сайн дурын даатгал /амь нас, эд хөрөнгө, бизнесийн үйл ажиллагааны тасалдлын, бусдад учруулсан хохирол/ зэрэг даатгалыг хамруулдаг.

<p>Брокер, дилер, андеррайтерийн компани /ҮЦК/</p>	<p>Харилцагчийн нэрийн өмнөөс үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээ нь үнэт цаасны брокерийн компанийн үндсэн үйл ажиллагаа юм.</p> <p>Харин ҮЦК өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагаа нь дилерийн компанийн үйл ажиллагаанд хамаарна.</p> <p>Хөрөнгийн зах зээл дээр компанийн хувьцаа гаргах, санхүүжилтийн эх үүсвэр олж авах зорилгоор үнэт цаасны танилцуулгыг мэргэжлийн түвшинд бэлтгэх, түүнчлэн анхдагч зах зээл дээр борлогдоогүй үлдсэн үнэт цаасыг худалдаж авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ.</p>
<p>Бичил санхүүгийн хөгжлийн сан</p>	<p>Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан (БСХС) нь Сангийн яамны харьяа байгууллага бөгөөд иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад бөөний зээл олгохоос гадна бичил санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих, салбарын чадавхыг бэхжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор шаталсан сургалтуудыг зохион байгуулдаг юм. БСХС нь санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ гэсэн 2 үндсэн үйл ажиллагааны чиглэл баримтлан ажилладаг байгууллага.</p>
<p>Хөрөнгө оруулалтын сан / ХОС/</p>	<p>Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагад мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор нийтийн болон хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн санг ХОС гэж нэрлэдэг. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь ХОС-тай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах СЗХ-оос тусгай зөвшөөрөл авсан байгууллага.</p>
<p>Зээлийн батлан даалтын сан /ЗБДС/</p>	<p>Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм. Гэхдээ батлан даалтын шимтгэл хураамж авах бөгөөд энэ нь сангийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зориулагддаг.</p>
<p>Хөдөө аж ахуйн бирж / ХААБ/</p>	<p>Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийг арилжих нэгдсэн төв юм. Бирж дээр борлуулагдах түүхий эд нь гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан байна. Бирж нь нэгдсэн мэдээллийн сангаар дамжуулан түүхий эдийг зах зээлийн үнээр борлуулах боломжийг олгодог.</p>

Монголын банкны холбоо

Монголын Банкны Холбоо нь Монголбанкнаас албан ёсоор зөвшөөрөл авч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа банкны болон бусад санхүүгийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, гишүүддээ үйлчилдэг, хараат бус, бие даасан, ашгийн бус төрийн бус байгууллага юм.

Эдгээр санхүүгийн үйл ажиллагаа нь дараах тухайлсан хуулиудаар зохицуулагдсан байдаг.

- Банкны тухай хууль /2018.02.08/
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль /2017.05.18/
- Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль /2015.12.04/
- Даатгалын тухай хууль /2015.05.18/
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2018.01.18/
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль /2016.07.21/
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль /2015.12.04/
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль /2017.12.21/

3.1.1 МОНГОЛБАНК /ТӨВ БАНК/




МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ. Монгол Улсын Төв Банкыг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Түүхэн замнал

Иргэд зөвхөн арилжааны банкаар л үйлчлүүлдэг учраас Төв банкы нэрийг сонссон хэдий ч үйл ажиллагааны талаар төдийлөн мэдээлэл багатай байдаг.

1924 оны 6 дугаар сарын 2-нд Монгол, Зөвлөлт Орос улсын хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулагджээ. Анх нээгдэхдээ 260 мянган янчааны хөрөнгөтэй, 22 орон тоотой, үүний дотор зөвлөлтийн мэргэжилтэн 18, монгол ажилчид 4 байжээ. Энэ бол Монголбанкны суурь тавигдсан түүхт үйл явдал байв.



1920-иод онд мөнгөний шинэчлэлт хийж, Монголын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг гүйлгээнд гаргаж, худалдаа бэлтгэлийн ажиллагааг санхүүжүүлж, зах зээлийн барааны хангамж, үнийн хөдөлгөөнийг зохицуулж, ардын аж ахуйтанд зээл олгож байсан нь Монголбанкны үндсэн үйл ажиллагаа болж байлаа. Тэр үед Монголбанкны бүх ажилчдын 20 хүрэхгүй хувийг монголчууд бүрдүүлж байсан тоо баримт бий.

1990 онд улс төр, нийгэм, эдийн засагт шинэчлэл хийгдэж 1990 онд “Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм”, 1991 онд “Банкны тухай хууль” батлагдсанаар Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигджээ.

2017 оны байдлаар нийт 14 арилжааны банк үйл ажиллагаагаа явуулж байгаагаас төрийн өмчийн /Төрийн банк/ 1 банк байна.

Төв банкны үндсэн зорилт



Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ. Монголбанк Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд заасан өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараахь чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ:

4 дүгээр зүйл. Монголбанкны үндсэн зорилт

1. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.
2. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Монголбанкны тухай хуульд заасан өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараахь чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ:

1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах;
2. Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
3. Засгийн газарын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;
4. Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
5. Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
6. Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах.
7. Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
8. Макро зохистой бодлого хэрэгжүүлэх.

Өөрөөр хэлбэл, Монголбанк нь нэн тэргүүнд инфляцийг тогтвортой байлгах зорилгын төлөө ажиллах ёстой. Энэхүү зорилготойгоо нийцтэйгээр Монголын банк, санхүүгийг тогтолцоог мөн тогтвортой байлгах үүрэгтэй гэж ойлгож болох юм. Харин Монгол Улсын Засгийн газар нь эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл г.м. макро эдийн засгийн бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогыг явуулдаг.

Үнийн тогтвортой байдлын ач холбогдол



Инфляци нь эдийн засгийн өсөлт, ядуурал г.м. асуудлууд шиг үргэлж олны анхаарлын төвд байдаг сэдэв биш бөгөөд үнэ тогтвортой үед “мартагддаг” гэж хэлж болохоор үзүүлэлт. Харин үнэ тогтвортой байхаа больсон цагт л бид ямар чухал зүйл болохыг нь гэнэт ухаарах тохиолдол олон.

Үнэ тогтвортой байх нь нийгэмд бүхэлд нь ашигтай зүйл бөгөөд эдийн засаг тогтвортой, үр ашигтай ажиллах суурь хөрс нь болдог. Учир нь бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өөрчлөлт бол худалдан авалт хийж буй хэрэглэгчид, мөнгөө хадгалуулж буй хадгаламж эзэмшигчид, эсвэл хөрөнгө оруулалт хийж буй бизнесийн байгууллагууд гээд хэн бүхэнд шууд нөлөөтэй. Харин үнэ тогтворгүй үед иргэдийг бодит орлого буурах, ядуурал ихсэх, нийгэмд тэгш бус байдал даамжрах г.м. олон сөрөг талууд бий болдог.



Үнэ тогтворгүй үед юу болох вэ?

- Үнийн өсөлт 231 сая хувьд хүрч, 100 триллионы дэвсгэрт гүйлгээнд гаргахад хүрч байсан Зимбабве улсын 2008 оны туршлага гипер инфляци эдийн засгийг яаж сүйтгэдгийг харуулсан.
- Мөнгөн хуримтлалыг богино хугацаанд үнэ цэнэгүй цаас болгон хувиргах хурдтай үнийн өсөлт нь банк санхүүгийн системийг хэрхэн тогтворгүй болгодгийг 2016 оны байдлаар 40% болон 800%-ийн инфляцитай байсан Аргентин, Венесуель улсуудын жишээ харуулж байна.
- Японы сүүлийн 30 жилийн түүхээс бараа, бүтээгдэхүүний үнэ эсрэгээрээ олон жил дарааллан буурч дефляци үргэлжлэх үед компаниуд хэрхэн хөрөнгө оруулалтаа танаж, ажиллах хүчээ цомхотгож байсныг ч харж болно. Үнэ тогтворгүй, савлагаатай байхын зовлонг Монголчууд ч туулж үзсэн бөгөөд 90-ээд оны эхэнд инфляци 300% давж, жилийн дотор үнэ 3 дахин өсөхөд иргэдийн хэрэглээ, худалдан авах чадварт ихээхэн дарамт учирч байсан.

Мөнгөний бодлого

Аливаа улс оронд төрөөс үндсэн 2 төрлийн эдийн засгийн бодлогыг авч хэрэгжүүлдэг. Нэг нь иргэд, аж ахуйн нэгжүүдээс цуглуулдаг татварын орлогоор дамжуулж засгийн газраас явуулдаг төсвийн буюу сангийн бодлого юм. Харин нөгөө нь Төв банкнаас явуулдаг мөнгөний бодлого юм. Энэхүү хоёр бодлого аль аль нь зохистой байхаас гадна, хоорондоо уялдаатай байх нь эдийн засаг тогтвортой хөгжих үндэс болдог.



Төв банкууд мөнгөний бодлогоор дамжуулж мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлж, эцсийн дүндээ эдийн засаг дахь үнийн тогтвортой байдал буюу инфляцийг тогтвортой байлгахад чиглэдэг. Үнэ тогтвортой байснаар эдийн засаг урт хугацаанд тогтвортой өсөх, улс орон хөгжих нэг суурь нь болж өгдөг. Төв банкны мөнгөний бодлогын шийдвэр харьцангуй богино хугацаанд гарах боломжтой ч, үр дүн нь эдийн засагт аажмаар илэрдэг онцлогтой. Жишээ нь, төв банк бодлогын хүүг өөрчлөх шийдвэрийг гаргаснаас хойш 3-5 улирлын дараа эдийн засагт хамгийн өндөр нөлөөллөө үзүүлж, тэрхүү нөлөө нь 1-3 жил ч үргэлжлэх боломжтой байдаг.

Бодлогын хүү

Төв банкуудын санхүүгийн зах зээлтэй харьцдаг нэг гол арга хэрэгсэл нь бодлогын хүү юм. Монголбанкны хувьд 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг Бодлогын хүү гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, арилжааны банкууд 7 хоногийн хугацаатай төв банкинд мөнгөө хадгалуулаад авах хүү нь Бодлогын хүү юм. Бодлогын хүү нь банк хоорондын захын хүү, Засгийн газрын үнэт цаасны хүү, цаашлаад хадгаламж, зээлийн хүү зах зээл дээр тогтох хөтөч хүү болдог.

Монголбанкны бодлогын хүүний өсөлт нь инфляцийн хөөрөгдлийг бууруулах, мөнгө зээлийн агрегатуудын хурдацтай өсөлтийг сааруулж зохистой түвшинд байлгах, эдийн засгийн хэт халалтаас зайлсхийхэд чиглэгддэг. Харин эдийн засгийн өсөлт саарах шинж тэмдэг ажиглагдвал төв банк бодлогын хүүгээ бууруулж мөнгөний үнэ цэнийг хямдруулдаг. Ингэснээр зээл олголт болон хэрэглээг дэмжиж, эдийн засгийг сэргээх бодлогыг баримталдаг байна. Мөнгөний бодлогын хүүг өөрчлөх, эсвэл хэвээр хадгалах шийдвэрийг Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл тогтсон хуваарийн

дагуу (жилд 4 удаа) хуралдаж гаргадаг.

Бодлогын хүү гэж юу вэ?



Арилжааны банкууд төв банкинд хадгалуулж буй мөнгөн хөрөнгийн хариуд төв банкнаас төлж буй хүүгийн хувь хэмжээ юм.

Бодлогын хүү эдийн засагт хэрхэн нөлөөлдөг вэ?



Бодлогын хүү өндөр байх тусам арилжааны банкуудын төв банкинд мөнгөн хөрөнгөө эрсдэлгүй, найдвартай хадгалуулах сонирхол нэмэгдэнэ. Тэр хэрээр арилжааны банкуудын гадагш буюу хувийн хэвшил рүү зээл гаргах сонирхол нь буурч, зээлийн хүүгээ нэмэгдүүлдэг. Эсрэгээрээ бодлогын хүү багассан байгаа үед арилжааны банкууд зээлийн хүүгээ тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой. Бодлогын хүүгийн түвшин хэр байхаас хамаарч арилжааны банкуудын зээлийн хүү тогтоно гэсэн үг.

Бодлогын хүү – инфляцийг жолоодох арга хэрэгсэл



Бодлогын хүүг нэмэгдүүлэх нь инфляцийн хэт өсөлт, эдийн засгийн болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилготой. Харин эдийн засгийн өсөлт саарч байгаа үед бодлогын хүү нь зах зээл эх мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах арга хэрэгсэл болдог. Бодлогын хүү өндөр байх нь инфляцийг нам дор түвшинд барихад чухал нөлөөтэй. Харин инфляци нэгэнт нам дор төвшинд очиж, эдийн засаг тогтворжсон үед бодлогын хүүг зөөлрүүлэх замаар эдийн засгийн идэвхжлийг хангах боломжтой юм.

“Мэдлэгт дусал нэмэр”

Мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нь

Мөнгийг үнэ цэнэтэй байлгахын тулд төв банкнаас явуулж буй мөнгөний бодлого нь олон төрлийн арга хэрэгслүүд болон хэд хэдэн төвөгтэй суваг, дамжлагуудыг давах шаардлага гардаг. Мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд дараах 3 зүйл нэн чухал:

1. Мөнгөний бодлогын зорилго тодорхой байх

Мөнгөний бодлогын зорилго тодорхой байх тусмаа тэрхүү зорилго амжилттай биелэхэд дөхөм болно гэсэн үг. Зорилго тодорхой байснаар мөнгөний бодлогын үр дүн богино болон дунд урт хугацааны аль алинд нийцтэй байх боломж үүснэ. Аливаа улс орны мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, мөнгөний нийлүүлэлтийг удирдах зэрэг нь маш их эрх мэдэл, үүрэг хариуцлага юм. Иймд зорилгыг аль болох нарийвчлан зааж өгснөөр мөнгөний бодлого хэрэгжүүлэгч институци буюу төв банкин дээр хэт их эрх мэдэл төвлөрөх, улмаар үүсч болох эрсдэлүүдээс сэргийлэх боломжтой болно.

2. Мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэгч төв банк хараат бус байх

Төв банкны хараат бус байдал алдагдаж, улс төрөөс хэт хамааралтай шийдвэрүүд гарснаар улс орны эдийн засаг өндөр эрсдэлд орсон түүх цөөнгүй. Богино хугацаанд үр дүнгээ өгч сонгогчдод таалагдах шийдвэрүүд нь дунд урт хугацааны үнийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн жишээ ч бий. Тийм ч учраас өнөөдөр дэлхийн ихэнх улс орнууд, тэр дундаа эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэгч орнуудад төв банкны хараат бус байдлыг хуулиар онцгойлон баталгаажуулж өгдөг жишиг тогтжээ. Үүний үндсэн дээр мөнгөний бодлого урт хугацааны зорилго биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээг мэргэжлийн баг хөндлөнгийн нөлөөгүйгээр авч хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

3. Төв банк ил тод байх, олон нийттэй харилцах харилцаа ойлгомжтой байх


Төв банк ил тод, нээлттэй байснаараа нэг талаас мөнгөний бодлого хэрэгжүүлэгч институцийг хянах, улмаар хариуцлагатай ажиллуулах боломж бүрдэнэ. Харин нөгөө талаас мөнгөний бодлогод итгэх итгэлийг бий болгох чухал хөшүүрэг болох юм.

Төв банк олон нийттэй идэвхтэй харилцаж, бодит мэдээллийг түгээх нь эргээд зах зээл тогтвортой байх, улмаар мөнгөний бодлогын зорилт амжилттай биелэхэд эерэг нөлөөтэй. Эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх нарийн мэдээллүүд, цаашдын төлөвийн талаарх хамгийн оновчтой төсөөллийг гаргадаг нэг гол институцийн хувьд төв банк өөрт байгаа мэдээллээ зах зээлтэй хуваалцах нь мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, зах зээлд оролцогчид илүү үр ашигтай шийдвэр гаргахад нөлөөлөн, улмаар эдийн засгийн ирээдүйн төлөвийг илүү таамаглагдахуйц болгох юм.

3.1.2 САНГИЙН ЯАМ



Түүхэн замнал



Монгол улсын хуулиар тогтоосон үндсэн чиг үүрэг болон үйл ажиллагааныхаа зарчимд нийцүүлэн Сангийн яамны алсын хараа, эрхэм зорилгыг дараах байдлаар томъёолсон байна.

Алсын хараа

Яамны алсын хараа нь Монгол Улсын санхүү, эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийнхээ амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэн Тогтвортой хөгжлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг биелүүлж, цаашдаа хөгжингүй орнуудын дундаж жишигт хүргэх явдал мөн.

Үйл ажиллагааны эрхэм зорилго

Сангийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татварын таатай орчин бүрдүүлэх, санхүү, эдийн засгийн оновчтой удирдлагаар хангахад оршино.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

- Санхүү, эдийн засаг, төсвийн удирдлагын чадавхийг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Санхүү, эдийн засгийн шинэчлэл, зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах;
- Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, эдийн

засаг, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;

- Санхүүгийн салбарын бодлого, хамтын ажиллагаа, санхүүгийн хөрөнгийн удирдлага, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод хяналт, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх.

3.1.3 САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Түүхэн замнал

1994 онд Үнэт цаасны тухай анхны хууль батлагдсанаар Үнэт цаасны хороо байгуулагдаж, Монгол Улсад хөрөнгийн зах зээл, түүнийг зохицуулж, хяналт тавих төрийн байгууллага болон түүнд оролцогч мэргэжлийн байгууллагууд байгуулагдаж, цаашдын хөгжлийнхөө суурийг тавьж байсан билээ.

2000 он гарснаар манай улсын эдийн засаг, санхүүгийн зах зээл бусад улс орнуудын зах зээлтэй улам бүр холбогдож, түүний хэрээр гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхол ч ихээр нэмэгдэх болж, улмаар санхүүгийн зохицуулалтыг нэгдмэл удирдлагаар хангах, нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай болсон.

Тиймээс Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 11 дүгээр сард Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг, 2006 оны 45 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийг тус тус баталж, Хорооны бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээг хуульчлан тогтоосон байдаг. Ийнхүү Хороог үүсгэн байгуулахдаа тухайн үеийн Үнэт цаасны хороонд Монгол банкны банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавих газар, Улсын мэргэжлийн хяналтын газрын даатгалын салбарын үйл ажиллагаанд хяналт тавих газрыг тус тус багтаасан юм. Ингэснээр Монгол Улсад банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн хяналт, зохицуулалтын анхны байгууллага байгуулагдсан түүхтэй.

Эрхэм зорилго

“Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх”.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага билээ.

Мөн Хороо нь холбогдох хуулийн хэрэгжилт болоод өөрийн үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнадаг, түүний харъяа байгууллага юм. Хороо анх байгуулагдахдаа банкнаас бусад санхүүгийн салбарыг хариуцахаар хуульчлагдаж, үүнд нь үнэт цаасны салбар, даатгалын салбар, бичил санхүүгийн салбарын зохицуулалт хамрагдаж байсан. Гэвч шинэ тутам үүсэн бий болж буй зах зээлийн харилцаанаас шалтгаалан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан даатгалын үйл ажиллагаа, Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа зэрэг зохицуулалтын хүрээний шинэ үйл ажиллагаанууд хамрагдах болсон.

Үйл ажилгааны хамрах хүрээ



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО		ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГА											
ХУВЬЦААТ КОМПАНИ		387	383	376	358	336	330	328	323	303	299	302	300
ХӨРӨНГӨ БӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАСАН ХХК								1	1	4	7	9	14
ХАРИУЦАГЧИЙН НЭГҮЙН ӨЛНӨӨС ТҮҮНИЙ ДААЛГАВААР ГҮИЦЭГЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУСАД САНХҮҮГИЙН ЗЭРГЭХ БАЙГУУЛЛАГА								11	12				
ДААТГАЛЫН КОМПАНИ		22	15	16	18	17	17	18	17	17	17	17	17
ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО		51	181	209	212	179	162	148	141	159	254	280	290
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА		139	137	132	177	182	195	212	263	378	450	518	534
		2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017

2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

3.1.4 ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ



Түүхэн замнал

Үүсгэн байгуулагдсан өдөр: 2013 оны 6-р сарын 14

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг УИХ-аар хэлэлцэн 2013 оны 01 дүгээр сарын 10-ний өдөр баталснаар хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Хадгаламжийн даатгалын корпораци байгуулагдах эрх зүйн үндэс тогтсон. Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд юм.

Хадгаламжийн даатгалын корпораци нь (ХДК)2013 оны 08 дугаар сарын 16-ны өдөр албан ёсны нээлтийн үйл ажиллагааг банк, санхүүгийн салбарын удирдах албан тушаалтнуудын хүрээнд зохион байгуулж, арилжааны банкуудад гишүүн банк болохыг гэрчилсэн “Гэрчилгээ”-г гардуулснаар 13 гишүүн банктайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрхэм зорилго

Монгол улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, банкны салбарын харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх итгэлийг бэхжүүлэх, эрхэм зорилго бүхий олон улсын стандарт шаардлагад нийцэж, хүлээн зөвшөөрөгдсөн хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад оршино.

Зорилт

- Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах замаар иргэдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх;
- Банкны үйл ажиллагааны сахилга батыг сайжруулах;
- Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах.

Үйл ажиллагааны ерөнхий схем



Корпорацийн үйл ажиллагаа

1. Даатгалын хураамжийг төвлөрүүлэх;
2. Даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр олгох;
3. Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу удирдах;
4. Сангийн санхүүгийн эрсдэлийг үнэлэх зорилгоор банкны эрсдэлийг үнэлж, хянах.

Хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгох үйл явц

1. Монголбанкнаас даатгалын тохиолдол бий болсон тухай мэдэгдлийг Хадгаламжийн даатгалын корпорацид ирүүлснээс хойш ажлын гурван өдөрт багтаан Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гаргана.
2. Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын нөхөн төлбөр олгох хэлбэр, хугацааны талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шийдвэр гарснаас хойш 48 цагийн дотор мэдээлж, мэдээллийн хувийг Монголбанкинд хүргүүлнэ.
3. Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо нөхөн төлбөр олгох шийдвэрийг гаргаснаас хойш Хадгаламжийн даатгалын корпораци ажлын 30 өдрийн дотор нөхөн төлбөр олгож эхэлнэ.
4. Гадаад валютын хадгаламжийн даатгалын нөхөн төлбөрийг төгрөгөөр гүйцэтгэх бөгөөд түүний дүнг даатгалын тохиолдол бий болсон өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар тооцно.
5. Даатгалын нөхөн төлбөр олгох журмыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.
6. Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын нөхөн төлбөр олголтын явцын талаар хадгаламж эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй.
7. Нөхөн төлбөр олгох мэдээллийн агуулга, түүнийг түгээх журмыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

Хадгаламж эзэмшигчийн эрх

1. Хадгаламж эзэмшигч даатгалын тохиолдол бий болоход даатгалын нөхөн төлбөр авах эрхтэй.
2. Хадгаламжийн гэрээг гуравдагч этгээдийг төлөөлөн байгуулсан бол даатгалын нөхөн төлбөр авах эрхийг уг гуравдагч этгээд эдэлнэ.
3. Өв залгамжлалаар даатгалын нөхөн төлбөр авахад өв залгамжлагчийн өөрийн нэр дээр хадгалуулсан хадгаламжид авах даатгалын нөхөн төлбөр хамаарахгүй.

Корпорацийн бүрэн эрх

1. 2018 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн чуулганаар “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хадгаламж болон хадгаламж эзэмшигчдийн талаарх сар, улирлын тайлан, бусад мэдээллийг банкнаас авах;
2. Банкны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт, санхүүгийн үзүүлэлт, бусад мэдээллийг банкнаас авах;
3. Хадгаламжийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой, эсхүл даатгалын тохиолдлын магадлалыг үнэлэхэд шаардлагатай гэж үзвэл банкинд хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Монголбанкинд тавих;
4. Татан буугдсан банкны эрх хүлээн авах ажиллагаанд Корпорацийн төлөөллийг

- оролцуулах хүсэлтийг Монголбанкинд тавьж, гүйцэтгүүлэх;
- Корпорацийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Сангийн хөрөнгө хүрэлцэхгүй байгаа тохиолдолд Монголбанк, Засгийн газраас зээл, санхүүгийн дэмжлэг авах;
 - Корпораци өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар журам баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих.

3.1.5 БИЧИЛ САНХҮҮГИЙН ХӨГЖЛИЙН САН



Эрхэм зорилго

Ядуу болон бага орлоготой иргэд, айл өрхийн хэрэгцээнд тохирсон зээл болон санхүүгий бусад үйлчилгээг тогтвортой хүргэж, өрхийн орлогыг нэмэгдүүлж, хуримтлал, өмчтэй болоход дэмжлэг үзүүлэх замаар Монгол Улсын хөгжлийг шинэ үе шатанд хүргэхэд хувь нэмэр оруулахад оршино.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциаци /ОУХА/, Европын хамтын ажиллагааны нийгэмлэг, Японы Засгийн газрын Хүний нөөц ба бодлогын хөгжлийн сангийн хамтран хэрэгжүүлсэн Тогтвортой Амьжиргаа төслийн хүрээнд 2002 онд бичил зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар салбарын хөгжлийг дэмжих зорилгоор Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан нь байгуулагдсан.

Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан (БСХС) нь иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад бөөний зээл олгохоос гадна бичил санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих, салбарын чадавхийг бэхжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор шаталсан сургалтуудыг зохион байгуулдаг юм. БСХС нь санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ гэсэн 2 үндсэн үйл ажиллагааны чиглэл баримтлан ажилладаг.

СХС нь иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бичил санхүүгийн үйлчилгээ явуулдаг **банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад** бөөний зээл олгодог. Түүнчлэн бичил санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих, салбарын чадавхийг бэхжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

1. БСХС-ийн бөөний зээлд хамрагдах хүсэлт гаргасан банкуудад тавигдах эхний шатны шалгуур

- Сүүлийн 2 жилийн хугацаанд бичил санхүүгийн салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа;
- Монголбанкнаас тавьсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 2 улирлын турш ханган ажилласан;
- Чанаргүй зээлийн хувь нь банкны салбарын дундаж чанаргүй зээлийн хувиас бага байх;
- Активын ангилал, активын эрсдэлийн санг холбогдох байгууллагуудын баталсан

журмын дагуу байгуулсан байх.

2. Бөөний зээл авахаар хүсэлт гаргасан ББСБ-д тавигдах эхний шатны шалгуур

- Сүүлийн 2 жилийн хугацаанд бичил санхүүгийн салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа; Активын өгөөж (АӨ) үзүүлэлт нь 1.5 хувиас дээш;
- СЗХ-оос тавьсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 2 улирлын турш ханган ажилласан;
- Чанаргүй зээлийн хэмжээ СЗХ-нд мэдээлсэн зээлийн өрийн үлдэгдлийн 5 хувиас ихгүй;
- Активын ангилал, активын эрсдэлийн санг холбогдох байгууллагуудын баталсан журмын дагуу байгуулсан байх.

Санхүүгийн бус үйлчилгээ

Бичил санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих, нэмэлт үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

- Ядуу болон алслагдсан хөдөө орон нутгийн өрх, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, шинэлэг арга барил нэвтрүүлсэн санхүүгийн байгууллагад өрсөлдөөнт тэтгэлэг олгох замаар шинэ бүтээгдэхүүн бий болгож санхүүгийн секторын шинэ санал санаачилгыг дэмжих;
- Олон нийт мэдээллийн болон бусад мэдээллийн сувгуудыг ашиглан иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах;
- Оролцогч санхүүгийн байгууллагууд болон тэдгээрийн салбаруудад Бичил санхүүгийн үйлчилгээний талаарх мэдээллийн булантай болгох, оролцогч санхүүгийн байгууллагуудтай хамтран алслагдсан сум орон нутгийн зээлдэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зайн сургалтыг зохион байгуулж тэдний чадавхийг бэхжүүлэх;
- Оролцогч санхүүгийн байгууллагуудын ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд нь чиглэсэн сургалт, семинаруудыг зохион байгуулах;
- Олон улсын Бичил санхүүгийн шилдэг туршлагыг нэвтрүүлэх боломжуудыг судлан нэвтрүүлэх;

3.1.6 МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО



Монголын Банкны Холбоо нь Монголбанкнаас албан ёсоор зөвшөөрөл авч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа банкны болон бусад санхүүгийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, гишүүддээ үйлчилдэг, хараат бус, бие даасан, ашгийн бус төрийн бус байгууллага юм.

Үндсэн зорилт

- Нийт гишүүдийн хууль ёсны, нийтлэг ашиг сонирхол, эрхийг төлөөлөн хамгаалах;
- Банк, санхүүгийн салбарын өмнө тулгарсан бодлогын асуудал, түүний оновчтой шийдэл рүү нийт гишүүдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх;

- Санхүүгийн салбарын үр ашигтай, эрүүл хөгжилд манлайлж, гишүүдийн оролцоо, бодитой хувь нэмрийг татан оруулах юм.

Тус Холбоо нь Монгол Улсын банкны салбарын хөгжлийг дэмжих, санхүүгийн салбарын дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор банк, санхүүгийн чиглэлээр сургалт дагнан явуулах академи, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх төв, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх байгууллага болон ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх корпораци зэрэг байгууллагуудыг гишүүн байгууллагуудын хамт үүсгэн байгууллаа.

Анх 2000 онд үүсгэн байгуулагдаж байсан бол өдгөө арилжааны 14 банк, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан, Сумитомо Мицуи банкны корпорацийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Токио Мицүбиши банкны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Банк оф Чайна Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, ЮнионПэй Интернейшнл, Зээлийн мэдээллийн төв ХХК, Банк санхүүгийн академи, Монголын ипотекийн корпораци ХХК зэрэг компаниудыг эгнээндээ нэгтгэсэн 24 гишүүнтэй санхүүгийн салбарын мэргэжлийн холбоо болон өргөжөөд байна.

Гишүүн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг бий болгох, банкны салбарт болж буй үйл явдлын талаарх мэдээ мэдээллийг харилцагчид, олон нийтэд хүргэх зорилгоор 2007 оноос хойш өөрийн нэрийн сонин, сэтгүүлийг гаргаж эхэлсэн бөгөөд одоо MBA Email Newsletter-ийг цахим хэлбэрээр, мөн түүнчлэн www.mba.mn цахим хуудас, твиттер, фейсбүүк сувгуудаар дамжуулан мэдээллээ тогтмол хүргэж байна.

Манай байгууллага нь банк, санхүүгийн мэргэжилтнүүдийн нэгдэл, мэргэжлийн холбоо болохын хувьд Холбооны ажлын албаны дэргэд мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж байна. Мэргэжлийн зөвлөл байгуулагдсанаар гишүүн байгууллагуудын мэргэжилтнүүд чиглэл чиглэлээр уулзаж, мэдлэг, туршлагаа хуваалцах, хамтдаа хөгжих, цаашлаад тулгамдаж буй асуудлуудаа тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зэргээр хамтран ажиллах боломж бүрдэж байгаа юм.

Одоогийн байдлаар Холбооны дэргэд нийт 12 мэргэжлийн зөвлөл ажиллаж байна. Үүнд:

1. Эрсдэлийн удирдлагын мэргэжлийн зөвлөл
2. Компаенсийн мэргэжлийн зөвлөл
3. Хуульчдын мэргэжлийн зөвлөл
4. Цахим банкны мэргэжлийн зөвлөл
5. Мэдээллийн технологийн мэргэжлийн зөвлөл
6. Судлаачдын мэргэжлийн зөвлөл
7. Хүний нөөцийн мэргэжлийн зөвлөл
8. Дотоод аудитын мэргэжлийн зөвлөл
9. Санхүү бүртгэлийн мэргэжлийн зөвлөл
10. Харилцагчийн үйлчилгээний мэргэжлийн зөвлөл
11. Маркетингийн мэргэжлийн зөвлөл
12. Даатгалын зуучлалын мэргэжлийн зөвлөл


Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг Удирдах Зөвлөлөөс гаргасан тогтоол, шийдвэр, өгсөн чиглэлийн дагуу гүйцэтгэх захирлаар удирдуулсан ажлын алба явуулж байна.



3.2. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГӨӨЖ БА ЭРСДЭЛ

Санхүүгийн байгууллага бүр өөрийн гэсэн онцлог бүтээгдэхүүн үйлчилгээтэй, үүнээс хамааран эрсдэл болон ашгийн түвшин ялгаатай байдаг.

Зураг 3.2. Санхүүгийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний өгөөж болон эрсдэлийн түвшний хамаарал



Энгийн хувьцаа болон банкны хадгаламж хоёрын хувьд харьцуулалт хийж үзье. Хувьцааны хувьд тухайн компани нь ашигтай ажиллаж байвал банкны санал болгож буй хадгаламжийн хүүнээс ч өндөр ашиг олох боломжтой. Гэхдээ компани ашиг багатай цаашлаад ашиггүй ажиллавал алдагдалд ч орж болзошгүй. Өөрөөр хэлбэл, хүлээж буй ашиг тодорхой бус байгаа нь эрсдэл их байгааг харуулж байна. Энэ тохиолдолд банкинд хадгалуулсан бол тогтмол хүүний орлогоор ашиг хүртэх боломжтой байсан. Дээрх зурагт харуулснаар эрсдэл их байх нь өгөөжийг их байлгах боломжтой. Иймд өөрийн хүлээх боломжтой эрсдэлийг тооцоолон бүтээгдэхүүнээ зөв сонгох нь чухал юм.

Банк, түүний бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ

Банк нь иргэдийн хадгалуулсан хөрөнгө ба өөрийн хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдан ашиг олох зорилготой байгууллага юм.

Монгол Улс нь 2 шатлал бүхий банкны системтэй бөгөөд дараах 3 төрлийн банк үйл ажиллагаа явуулж байна. Иргэд зөвхөн арилжааны банкаар л үйлчүүлдэг учраас Төв банк, Хөгжлийн банкны нэрийг сонссон хэдий ч үйл ажиллагааны талаар төдийлөн мэдээлэл багатай байдаг.

Банкийг өмчийнх нь хэлбэрээр төрийн, хувийн, төрийн өмчийн оролцоотой банк гэж тус тус ангилдаг.

Зураг 3.3. Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банк, Арилжааны банкуудын үндсэн үүрэг, ялгаа

•ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД	•АШГИЙН ТӨЛӨӨ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД	•АШГИЙН ТӨЛӨӨ ХУУЛИЙН ЭТГЭЭД
<ul style="list-style-type: none"> •Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах; •Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх; •Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих; •Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах; •Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж удирдах; •Засгийн газрын санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх. 	<ul style="list-style-type: none"> •Хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх; •Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; •Өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа батлан даалт гаргах; •Гадаад валют арилжаа, зээлтэй холбоотой төлбөр тооцоо. 	<ul style="list-style-type: none"> •Зээл, хадгаламж; •Гадаад валют арилжаа, төлбөр тооцоо; •Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; •Үнэт зүйл, металл хадгалах; •Өөрийн нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргах; •Санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; •СЗХ-оос зөвшөөрөлтэйгээр даатгалын зуучлал, андеррайтер, кастодиан гэх мэт үйл ажиллагаа.
<p>МОНГОЛБАНК</p> 	<p>МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК</p> 	<p>АРИЛЖААНЫ БАНК</p> 

Арилжааны банк нь харилцах, хадгаламж татах, зээл олгох, төлбөр тооцоо хийх үндсэн үйлчилгээ үзүүлдэг. Орчин үед харилцагчдынхаа цаг хугацаа, ажлыг хөнгөвчлөн бүтээгдэхүүн үйлчилгээгээ цахимжуулж, интернэт банк, мобайл банк, олон төрлийн карт, орлого, зарлага, мөнгөн шилжүүлэг хийдэг бэлэн мөнгөний машин зэрэг олон үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлж байна. Мөн харилцагчдадаа санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд их анхаарч байна.

Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ

Зураг 3.4 Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл



Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ нь зориулалт, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн байдлаасаа хамааран маш олон төрөлтэй байдаг.

➤ Харилцах, хадгаламж

Харилцах данс нь байгууллагын болон иргэдийн гэж байдаг. Харилцах дансанд тооцогдох хүү хадгаламжийн данстай харьцуулахад харьцангуй бага байдаг.



Хадгаламжийн дансны хувьд хугацаатай болон хугацаагүй гэж ерөнхий ангилалддаг. Хугацаатай хадгаламж нь хэдий хир хугацаагаар хадгалах, хугацааны дундуур орлого нэмэх эсэх, хүүгээ сар бүр авах эсэх зэрэг нөхцөлүүдээс хамаарч хадгаламжийн хүү ялгаатай байдаг. Хадгаламжийн сертификат нь хугацаатай хадгаламжийн төрөлд хамаарах бөгөөд хугацааны дундуур орлого нэмэх боломжгүй ч, бусдад

бэлэглэх, өвлүүлэх боломжтой байдгаараа давуу талтай байдаг

➤ Зээл



Хэрэглээний зээлд цалингийн, тэтгэврийн, малчны, хэрэглээний лизингийн, кредит картын зээлүүдийг хамруулан ойлгоно. Бизнесийн зээлийн ангилалд эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, санхүүгийн түрээс, төслийн зээл ордог. Мөн орон сууцны зээлийн ангилалд орон сууц, хашаа байшин, амины сууц худалдан авах, засварлах, барих зээлүүдийг хамруулдаг.

➤ Карт ба цахим бүтээгдэхүүн



Техник технологи хөгжихийн хэрээр банкны бүтээгдэхүүн үйлчилгээ улам боловсронгуй болж, банкны үйлчилгээг авахад илүү хялбар болсоор байна.

Карт нь мөнгөтэй л адил төлбөр тооцооны хэрэгсэл хэдий ч

бэлэн мөнгөний сул талыг илүү найдвартай, түргэн шуурхай, боловсон байдлаараа бууруулж байдаг.

Картыг зөвхөн хугацаагүй хадгаламж болон харилцах дансандаа авах боломжтой байдаг.



✓ Дотоодын карт: Зөвхөн Монгол Улсад ашиглах боломжтой төгрөгийн карт.

✓ Олон улсын карт: Гадаад болон дотоодод ашиглах боломжтой гадаад валютын дансанд холбогдсон карт юм. Мөн гадаадад валютаар, дотоодод төгрөгөөр төлбөр тооцоо хийх карт бий болжээ.

➤ **АТМ буюу Бэлэн мөнгөний машин**



АТМ буюу Бэлэн мөнгөний машин нь зөвхөн мөнгө авдаг биш орлого хийдэг, дансны үлдэгдлээ шалгах, мөнгөн шилжүүлэг хийдэг байхаас гадна автомашинд суурилагдсан зөөврийн хэлбэрээр ч үйлчилгээ үзүүлж байна. Бэлэн мөнгөний машин нь банкны

Таны мэдлэгт

Картын сүлжээний төрлөөс хамааруулж Виза /VISA/, Мастер /Mastercard/, Американ экспресс /American express/, Юнион Пей /Union pay/ гэж шууд нэрлэх тохиолдол түгээмэл байдаг. АНУ-ын Виза болон Мастеркарт нь 50 гаруй жилийн түүхтэй бөгөөд 200 гаруй улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн өргөн сүлжээ юм. Харин БНХАУ-ын Юнион Пей-ийн хувьд 14 жилийн түүхтэй ба 141 оронд сүлжээгээ оруулаад байна. Мөн үүнтэй адилаар Монгол Улс ч өөрийн картын сүлжээг “Т-карт” нэртэйгээр 2012 онд гаргасан байна.

ажилтнаас авдаг байсан үйлчилгээг өнөөдөр хүссэн үедээ өөртөө үйлчлэн авах боломжийг олгож байна.



АТМ ашиглахдаа дараах зүйлсийг анхаарч байгаарай. Үүнд:

- ПИН код /нууц дугаар/ хийхдээ бусдад харагдуулахгүй байх, нууцлах;
- Дэлгэцийн зааварчилгаа монгол хэлний сонголттой тул зааврыг сайтар унших;
- Гүйлгээ хийх явцдаа аль болох бусдын тусламжийг авахгүй байх;
- АТМ-ын гүйлгээг бүрэн хийж дуустал хвлээх хэрэгтэй. Карт болон бэлэн мөнгө авах зааварчилгаа гарснаас хойш үйлдэл хийхгүй 30 секунд болвол АТМ картыг буцааж татах тохиргоотой байдаг.
- Мөн картын нууц дугаараа олон дахин буруу хийхэд АТМ картыг залгидаг.
- Нэгэнт картаа залгиулсан бол АТМ дээрх банкны холбогдох утас руу холбогдож картаа буцаан авна.
- Картаар үйлчлүүлж байх үед бусдын халдлагад өртөх нөхцөл байдалд орвол пин кодоо урвуулан хийснээр танд яаралтай тусламж ирэх болно.

➤ **Мобайл банк**



Орчин үед арилжааны банкууд гар утсанд тохирсон мобайл банкны цэстэй болжээ. Банкан дээр нэг удаа очиж гэрээ байгуулан гар утсандаа мобайл банкны цэс суулгана. Ингэснээр дансны үлдэгдэл болон хуулгаа шалгах, банк дотроо болон өөр банк хооронд мөнгө шилжүүлэх, зээлээ төлөх, гар утас болон байрны төлбөр төлөх, валютын ханшийн мэдээлэл авах зэрэг банкны үйлчилгээг авах боломж бүрдэнэ.

➤ **Интернэт банк**




Банкны үйлчилгээ амар хялбар болж байна. Интернет банкны үйлчилгээ нь заавал банкинд очихгүй гэрээсээ, ажлаасаа, гадуур явж байхдаа интернэтийн сүлжээтэй орчинд байвал банкны бүхий л төрлийн үйлчилгээг өөрөө авах боломжийг олгож байна. Энэхүү үйлчилгээг банкинд дээр нэг удаа очиж үйлчилгээг авах хүсэлтээ гаргаад авах боломжтой болно. Гарутсандаа банкуудын интернэт банкны аппликейшн/цэсийг суулгаад эсвэл банкуудын мэдээллийн цахим хуудас руу орж үйлчилгээг авна. Ихэнх арилжааны банкны интернэт банкаар дамжуулан дараах үйлчилгээг өөрөө өөртөө үзүүлэх боломжтой. Үүнд:

Хүснэгт 3.2. Интернет банкаар хийх үйлчилгээ

- Дансны үлдэгдэл, хуулга харах, хянах;	- Өөрийн дансаа удирдах, үйлчилгээнд ашиглах дансуудаа нэмж, хасах;
- Дотоод шилжүүлгийн гүйлгээ хийх / Банк дотроо болон банк хооронд/;	- Цахим үйлчилгээнд бүртгүүлэх
- Гадаад шилжүүлгийн гүйлгээ хийх;	- Зээлийн төлбөр төлөх;
- Валютын ханшийн мэдээлэл авах;	- Гар утас, байрны төлбөрөө төлөх;
- Данс нээх;	- Татварын мэдээлэл харах, төлөх
- Хадгаламжийн хугацаагаа сунгах;	- Хадгаламж барьцаалсан зээл авах / Зарим банкинд энэ үйлчилгээ амжилттай хэрэгжиж байна/;
- Арилжааны хэлцэл хийх;	- Хувийн санхүүгээ хөтлөх, хянах гэх мэт.
- Өөрийн мэдээллийг засах, өөрчлөх;	

Зураг 3.5. Мобайл банк, интернэт банкны гол ялгаа



➤ **И-биллингийн үйлчилгээ**

Сар бүр гардаг хэрэглээний төлбөрөө өөрийн данснаасаа шууд суутгуулах хүсэлтийг банкинд нэг удаа очиж гаргаад банкинд байнга очихгүйгээр төлбөрөө цаг тухайд нь төлж байх боломжийг энэхүү үйлчилгээ олгодог. Өөрөөр хэлбэл гэрээ байгуулсны үндсэн дээр таны өмнөөс хэрэглээний төлбөрийг тань банк шилжүүлдэг үйлчилгээ юм. Харин та тухайн гэрээнд тусгасан дансаа өөрийн тогтмол орлого ордог данстайгаа холбуулах хэрэгтэй.

➤ **Гадаад төлбөр тооцоо**



Монголын банкууд нь гадаадын банкуудтай харилцан хамтын ажиллагаа тогтоосны үндсэн дээр Олон улсын банк хоорондын сүлжээ /SWIFT/-ээр дамжуулан гадаад руу мөнгөн шилжүүлэг хийдэг.

Дэлхийн хамгийн олон оронд салбартай Вестэрн Юнионы /Western Union/ сүлжээгээр дамжуулан бэлэн мөнгөний гуйвуулга хийх шуурхай үйлчилгээ үзүүлдэг.

MoneyGram Мөн Мониграм /Moneygram/-ын сүлжээгээр дамжуулан гадаад шилжүүлэг хийх боломжтой. Энэхүү гадаад шуурхай шилжүүлэг нь улс орны хамрах хүрээ, үйлчилгээний шимтгэл хураамжаараа бага зэрэг ялгаатай байдаг.

➤ **Даатгалын зуучлалын үйлчилгээ**

Арилжааны банкны Банкны тухай хууль болон “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай” хуулийн хүрээнд Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос авсны үндсэн дээр даатгалын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон. Өөрөөр хэлбэл, банкнаас даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломж бүрдэж байна.



3.3. Банкнаас бусад санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ

Хүснэгт 3.6. Санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ

ДААТГАЛ	ҮЦК	ХОС	ХААБ
 <ul style="list-style-type: none"> •Ердийн даатгал <ul style="list-style-type: none"> - гэнэтийн ослын даатгал - эд хөрөнгийн даатгал - санхүүгийн даатгал •Урт хугацааны даатгал <ul style="list-style-type: none"> - амь насны даатгал - тэтгэврийн даатгал - эрүүл мэндийн даатгал 	 <ul style="list-style-type: none"> •Компанийн хувьцаа, бонд худалдах, худалдан авах үйлчилгээ •Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ •Хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл өгөх үйлчилгээ •Хөрөнгийн зах зээл, хувьцаа, бонд 	 <p>Хөрөнгөө өсгөн нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн компанид шилжүүлэн хөрөнгө оруулалт хийх</p>	 <ul style="list-style-type: none"> •Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг ил тод зах зээлийн ханшаар худалдах, худалдан авах боломжтой.
 <ul style="list-style-type: none"> •Зээл •Валют арилжаа •Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх •Итгэлцлийн үйлчилгээ 	 <ul style="list-style-type: none"> •Зөвхөн ХЗХ-ны гишүүдэд •Зээл •Хадгаламж 	 <p>Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад дутагдаж буй барьцаа хөрөнгөд батлан даалт гаргах үйлчилгээ</p>	


Санхүүгийн зах зээл дээрх эдгээр олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнээс өөрийн эрэлт хэрэгцээнд тохирсон сонголтыг хийхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, давуу, сул талуудыг харьцуулж судалсны үндсэн дээр санхүүгийн шийдвэрээ гаргаж сурах нь чухал юм.

Жишээ: Телевизор үзэж буй Тэмүүлэнгийн гэр бүл Засгийн газрын бонд арилжаалагдсан талаар мэдээллийг үзээд дараах яриаг өрнүүлэв.



Тэмүүлэн судалж үзээд дараах мэдээллүүдийг цуглуулжээ. Засгийн газрын бондыг иргэн, аж ахуйн нэгжүүд аль аль нь худалдан авах боломжтой бөгөөд нэг бүрийн нэрлэсэн үнэ нь 100000 төгрөг, тогтсон хугацаанд хүү төлдөг Засгийн газрын өрийн бичиг. Үүнийг авахын тулд дараах схемийн дагуу Хөрөнгийн биржид бүртгэлтэй брокер, дилерийн компанид хандан өөрийн нэр дээр үнэт цаасны данс нээлгэн, захиалга өгч, төлбөрөө арилжааны банкаар дамжуулан төлдөг. Засгийн газрын бонд худалдан авах үйл явцыг дараах зургаар харуулав.

Зураг 3.7. Засгийн газрын бонд худалдан авах үйл явц



Эх сурвалж: Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, <http://www.mse.mn/>

Засгийн газрын бонд нь дараах хэд хэдэн давуу талтай.

1. Засгийн газар нь зээлдэгч учраас тухайн улсдаа хамгийн эрсдэлгүй хөрөнгө оруулалтын нэгд тооцогддог.
2. Үнэт цаасны төлбөр болон хүү нь иргэд болон аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгддөг.
3. Зах зээлийн зарчмаар хүүний өгөөж нь тогтоогддог учраас өгөөж өндөр байх боломжтой.
4. Худалдан авагч нь бэлэн мөнгөний хэрэгцээ үүссэн үедээ бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах боломжтой.

Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсан дээр илүү дэлгэрэнгүй мэдээлэл байдаг.

3. “БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

3.1. Санхүүгийн байгууллагын төрөл, үйл ажиллагаа

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Санхүүгийн байгууллагуудын төрлүүдийг мэдэж авах үндсэн дээр тэдгээрийн зорилго, үйл ажиллагааны цар хүрээ болон ялгааг нарийвчлан тодорхойлж сурах, санхүүгийн олон талт үйлчилгээг сонгон хэрэглэх боломжтой болох

Хэрэглэх нэр томьёо:

Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын компани, брокер, дилер, андеррайтерийн компани (ҮЦК), хөрөнгө оруулалтын сан, зээлийн батлан даалтын сан, хөдөө аж ахуйн бирж, санхүүгийн зохицуулах хороо

Хэрэглэгдэхүүн:

Банк болон ББСБ, бусад байгууллагын танилцуулга брошур, тараах материалууд

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, харьцуулах, мэдээлэл олж авах, тайлбарлах, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх, багаар ажиллах, харьцуулсан үнэлэлт өгөх, суралцагчдаар мэдлэг бүтээлгэх үйл ажиллагааны үндсэн дээр дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдын мэдлэгийн түвшинг харгалзан “анхан, дунд, ахисан” түвшний 3 бүлэгт хуваана. Баг тус бүр банк, санхүүгийн байгууллагуудын төрлүүдийг цаасан дээр жагсаан бичиж, тэдгээрийн бүтээгдэхүүн үйлчилгээг авч байсан туршлагаа танилцуулна. Тэдний танилцуулгад ороогүй үлдсэн санхүүгийн байгууллагуудын талаар багш тайлбарлан зураг 3.1-д үзүүлсэн санхүүгийн байгууллагуудын талаар ерөнхий танилцуулга өгнө.

Алхам 2:

Санхүүгийн байгууллагуудаас хамгийн түгээмэл харилцдаг банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани гэсэн 3 байгууллагыг сонгож баг тус бүрд нэг байгууллагын зорилго, үйл ажиллагаа, бусад байгууллагуудаас ялгарах онцлог зэргийг бичиж тайлбарлах даалгавар өгнө. Багууд 10 минут бүлгээрээ ажиллаад төлөөлөл бүлгийн ажлаа танилцуулах явцад багш шаардлагатай үед нэмэлт мэдээлэл өгөх замаар дэмжин чиглүүлнэ. Түүний дараа бусад санхүүгийн байгууллагуудын талаар багш мэдээлэл өгч тайлбарлана.

Алхам 3:

Санхүүгийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хэрхэн сонгох талаар хэлэлцүүлэг явуулна. Ингэхдээ зураг 3.2-т үзүүлсэн санхүүгийн байгууллагуудын эрсдэл ба өгөөжийн харилцан хамаарлыг тайлбарлана. Үүний дараа суралцагчид өөрийн санхүүгийн мэдлэг, нөхцөл байдал,

ирээдүйн төлөвлөгөөндөө тулгуурлан сонголтоо хийж аль хэсэгт хөрөнгө оруулбал өөрийнх нь санхүүд сайнаар нөлөөлөх тухай өөрсдөөр нь яриулна (Сонголт нэгээс олон байж болно).

Суралцагчид банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний онцлог, эрсдэлийн түвшинг тооцон харьцуулалт хийх чадвар эзэмшсэн бол энэ сургалтын зорилго биелсэн гэж үзэж болно.

Нэмэлт мэдээлэл:

Хувь хүн өөрийн санхүүгийн байдлаа сайжруулан зөв удирдахад үнэн, зөв мэдээлэл хамгийн чухал бөгөөд санхүүгийн байгууллагуудтай холбоотой мэдээллийг хаанаас авах талаар танилцуулна.

Банк	www.mba.mn	www.mongolbank.mn
ББСБ	www.bbsb.mn	
ХЗХ	www.moccu.mn	
Даатгалын компани	www.mia.mn	
Брокер, дилер, андеррайтерийн компани	www.schcd.mn	
Хөрөнгө оруулалтын сан(ХОС)	www.frc.mn	
Зээлийн батлан даалтын сан(ЗБДС)	www.lgf.mn	
Хөдөө аж ахуйн бирж(ХААБ)	www.mce.mn	

Анхаарах зүйл:

Санхүүгийн зөв мэдээлэл олж авах санхүүгийн шийдвэр гаргахад маш чухал нөлөөтэй гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл санхүүгийн байгууллагын талаар зөв мэдээлэлтэй байж аль байгууллагатай харилцахаа оновчтой сонгох чухал гэдгийг анхааруулна.

3.2 Банк, түүний бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Банк түүний үүрэг, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэгтэй болж, улмаар өөрт тохирсон банкны үйлчилгээг авах чадвартай болно

Хэрэглэгдэх нэр томьёо:

Төв банк, хөгжлийн банк, арилжааны банк, интернэт банк, мобайл банк, карт, орлого, зарлага, шилжүүлэг, харилцах, хадгаламж, олон улсын карт, дотоодын карт, цахим бүтээгдэхүүн, АТМ, И-биллингийн үйлчилгээ, гадаад төлбөр тооцоо

Хэрэглэгдэхүүн:

Хадгаламж, харилцах, зээл төлөлтийн график, төлбөр тооцооны баримтын хуулбарууд (Банкны үндсэн зорилго, үйлчилгээний талаар сануулах зорилготой), notebook (интернэтэд холбогдох боломжтой байх).

Сургалтын арга:

Мэдээлэл өгөх, харилцан ярилцах, тооцоолон бодох, бүлгээр ажиллах.

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдаар өөрсдийн мэддэг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар жагсаан бичүүлэх замаар дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчид арилжааны банкуудын талаар харьцангуй сайн мэдлэгтэй байвал жагсаалт гаргуулан арилжааны банкны зорилго, үйл ажиллагааны чиглэлийг харилцан ярилцаж тодорхойлно. Багш оролцогчдоос Монгол банк, хөгжлийн банкны зорилго, үйл ажиллагааны чиглэлийн талаар асууж өөрсдөөр нь тодорхойлуулах гэж оролдоно. Хангалттай мэдлэг, мэдээлэлгүй байвал багш зураг 3.3-ыг ашиглан мэдээлэл өгөөд арилжааны банктай харьцуулан тайлбарлана.

Алхам 2.

Багш дараах судалгааны маягтыг бүлэг тус бүрд өгч мэдээлэл авна. Оролцогчдын банкнаас бүтээгдэхүүн үйлчилгээ авдаг эсэхээр тоон мэдээллийг гаргана. Үүний үндсэн дээр “хамгийн түгээмэл авдаг бүтээгдэхүүн, үйлчилгээний” талаар оролцогчдын туршлага дээр үндэслэн харилцан ярилцах бол “хамгийн цөөн авдаг болон огт авдаггүй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар” багш чиглэл өгч дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

		Бүлгээс хэдэн хүн үйлчилгээ авч байсан		
Банкны үйлчилгээний төрөл	бүтээгдэхүүн	Үйлчилгээ авч байгаа	Үйлчилгээ авч байсан	Үйлчилгээ авч байгаагүй
Хадгаламж				
Зээл				
Карт				
Цахим банкны үйлчилгээ				
Гадаад төлбөр тооцоо				
Бусад санхүүгийн үйлчилгээ (даатгал, санхүүгийн зөвлөгөө)				
санхүүгийн мэдээлэл, зуучлал, мэдээлэл,				

Алхам 3:

Оролцогчид өөрсдийгөө үнэлэх зарчмаар санхүүгийн мэдлэгийн “анхан, дунд, ахисан” гэсэн түвшинд тулгуурлан 3 баг болгоно. Багш банкуудын бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх танилцуулгыг тараан өгөөд Монголын арилжааны банкуудыг бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судалгаа хийлгэнэ (Бүлэг тус бүр Төрийн банк, Хаан банк, Капитал банкны аль нэгийг сонгоно).

Баг тус бүрд зөөврийн компьютер өгч интернэтээр банкуудын мэдээллийг олж авахуулна. (Интернэтэд холбогдох боломжгүй орчинд сургалт явагдаж байвал багш холбоотой мэдээллийг тараахаар бэлтгэсэн байна.) Багууд банк тус бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг жагсаан бичиж үнэ тариф, нөхцөл, өгөөжийг тооцон анализ хийнэ.

Багууд тус тусын бүлгийн ажлыг 10 минут хийсний дараа 3 бүлгийн ажлыг харьцуулан ялгаатай тал, уян хатан, нөхцөл, үр өгөөжийн талаар нэгдсэн дүгнэлт хийлгүүлнэ. Үүний дүнд суралцагчид банкны үйлчилгээг өөрийн хэрэгцээнд тохируулан сонгож чаддаг болно.

Нэмэлт мэдээлэл:

Хугацаа хэтэрсэн болон найдваргүй зээлийн барьцаанд хураагдсан их хэмжээний үл хөдлөх хөрөнгөнүүд банкны мэдэлд очсон байдаг. Энэ хөрөнгөнүүд нь зах зээлийн үнээс харьцангуй хямдаар үнэлэгддэг бөгөөд зарим банкнууд зуучлан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг газруудтай хамтарч ажиллахгүй тохиолдол байдаг. Иймээс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, түрээслэх сонирхолтой иргэд банканд хураагдсан борлуулах шаардлагатай хөрөнгийн талаарх мэдээллийг судалж үзэх хэрэгтэй.

Анхаарах зүйл:

Арилжааны банкнуудын санал болгодог зарим дэвшилтэт үйлчилгээг хэрэглэдэггүйгээс цахимаар авч болох үйлчилгээг заавал банканд очиж авах явдал байсаар байгаа. Банкуудын үйлчилгээг цахим хэлбэрээр авахтай холбоотой мэдээллийг өгөн цаг хугацаа, зардлаа хэмнэх боломжтой гэдгийг анхааруулах хэрэгтэй.

3.3. Банкнаас бусад санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглээ

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Суралцагч өөрийн санхүүгийн аливаа үйлдлийг зөв төлөвлөх, орлогоо нэмэгдүүлэх, ашигтай хөрөнгө оруулалт хийх, илүү хялбар байдлаар худалдах, худалдан авах үйл ажиллагаанд оролцох, элдэв эрсдэлээс өөрийгөө хамгаалах, сэргийлэх чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Хувьцаа, бонд, хөрөнгө оруулалт, валют арилжаа, барьцаа хөрөнгө

Хэрэглэгдэхүүн:

Санхүүгийн байгууллагуудын танилцуулга, бүтээгдэхүүн үйлчилгээний санал бүхий жагсаалт, зарим үйлчилгээг авсан хуулбар баримтууд

Сургалтын арга:

Уг сэдвийн хүрээнд тодорхойлолт өгөх, мэдээлэл олж авах, харьцуулсан дүгнэлт хийх, тайлбарлах, тооцоолон бодох

Сургалтын зохион байгуулалт :

Санхүүгийн төрөлжсөн үйлчилгээнүүдийг оролцогчдын хувийн туршлага дээр үндэслэн мэдлэг бүтээлгэх замаар дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Багш оролцогчдоос банкнаас бусад санхүүгийн байгууллагатай харилцаж байсан болон харилцаж байгаа эсэх талаар асууж ярилцана. Багш самбар дээр банкнаас бусад санхүүгийн байгууллагуудыг жагсаан бичиж хамгийн “түгээмэл харилцдаг”, “дунд зэрэг”, “харилцдаггүй” гэсэн утгыг илэрхийлэх тэмдэглэгээг хийнэ. Түгээмэл болон дунд зэрэг харилцдаг байгууллагуудын зорилго үйл ажиллагааны чиглэлийн талаар багш дэмжин чиглүүлж оролцогчдоор тодорхойлуулна. Харин харилцдаггүй гэсэн тэмдэглэгээтэй байгууллагын талаарх мэдээллийг онцолж зураг 3.6-д харуулсан мэдээллийг тайлбарлаж өгнө.

Алхам 2:

Банкны хадгаламжийн үйлчилгээнээс гадна хувьцаа (энэхүү номын сэдэв 7.2), бонд (сэдэв 7.3), үл хөдлөх хөрөнгөнд (сэдэв 7.4) хөрөнгө оруулахын ач холбогдлын талаар товч мэдээлэл өгнө. Энэ тохиолдолд банкны хадгаламжийн хүүнээс илүү өгөөжтэй, эрсдэлгүй байх талаар тооцоолол хийх шаардлагатай болно. Хэдийгээр банкнаас бусад үйлчилгээг авахад өгөөж их байх байлаа ч өгөөжийн хувийг дагаж эрсдэлийн түвшин нэмэгддэг гэдгийг тооцох ёстой. Энэ төрлийн бизнесийн нэг бол валютын арилжаа юм. Банкнаас бусад төрлийн үйлчилгээг сонгохдоо заавал тэр салбарын мэдлэг, мэдээлэлтэй байж хөрөнгөө зөв удирдах ёстой тухай чиглэл өгнө.

Нэмэлт мэдээлэл:

Монгол улсад банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тоо баримтын тухай цахим үзүүлэн ашиглан мэдээлэл өгнө.

Анхаарах зүйлс:

Санхүүгийн үйлчилгээ авахаар гэрээ хийхдээ гэрээний заалт бүрдээ нарийвчлан танилцаж байх хэрэгтэй гэдгийг сануулна. Жишээ нь: Хууль тогтоомжид харшлах заалт байгаа эсэх, гэрээний үргэлжлэх хугацаа, хэрэглэгчийн нөхцөл боломжид хир нийцэж байгаа, тухайн байгууллагын түүх, тогтвортой байдал гэх мэт олон хүчин зүйлийг сайтар судлах хэрэгтэй байдаг.

СЭДЭВ 4. ХУРИМТЛАЛ БА ХАДГАЛАМЖ

4.1. Хуримтлалын зорилго, хуримтлал үүсгэх арга

Яагаад бид хуримтлалтай болох шаардлагатай вэ?

Бидний амьдралд урт ба богино хугацааны төлөвлөж болох болон төлөвлөж болохгүй бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлага гардаг. Энэ үед нэг бол хуримтлалаараа, эсвэл зээл авах, эд хөрөнгөө худалдах байдлаар зохицуулах шаардлагатай болдог.


Мэдээж хамгийн сонгодог арга нь мөнгөн хуримтлалаараа гэнэтийн мөнгөний хэрэгцээгээ хангах юм. Өөрөөр хэлбэл, зээл авбал та зээлийн хүү төлөх хэрэгтэй болно. Эд хөрөнгө зарж борлуулан богино хугацаанд бэлэн мөнгөтэй болохын тулд магадгүй зах зээлийн үнээс хямдаар зарах шаардлага үүснэ. Иймээс гэнэтийн хэрэгцээ шаардлагад бэлэн байх, урт хугацааны хүсэл, зорилгодоо хүрэхэд хуримтлал чухал.

Ирээдүйг хэн ч харж чадахгүй учраас санхүүгийн хувьд хүчтэй, өөртөө итгэлтэй, төлөвлөгөөтэй амьдрах нь аз жаргалтай амьдралын үндэс юм.

Зураг 4.1. Хадгаламжийн зориулалт



Жишээ: Тэмүүлэн, Солонго хоёр, аав ээжийгээ сувилалд амраахыг сүүлийн хэд жил бодсон хэдий ч санхүүгийн боломж төдийлөн бүрдэхгүй байсаар өдийг хүрчээ. Тэд энэ асуудлыг хэрхэн шийдэхээ ярилцаж байна.



Тэмүүлэн :

- Зээл авахаар зээлийн хүүнд илүү зардал гарах гээд байдаг.
- Энэ удаа хоёулаа зээл аваад ээж аавыгаа амраая. Харин одооноос хуримтлал хийж эхэлье.


Солонго:

- Уг нь энэ жил ээж аавыгаа амраачихвал, тийм ээ?
- Зөв санаа. Хоёулаа ч гэсэн амралтаараа аялалд явахаа эртнээс төлөвлөж хуримтлал хийж болно шүү дээ.



Хуримтлал хийж эхлэх нь заримдаа тийм ч амар зүйл биш байдаг. Гэхдээ энэхүү амаргүй байдлыг давах нь мөнгө хуримтлуулах зорилго, төлөвлөгөөгөө гаргахаас эхэлнэ. Хуримтлалыг нэг өдөрт биш алхам алхмаар хийх боломжтой.

Зураг 4.2. Хуримтлал үүсгэх алхмууд



1. Орлого, зардлаа бүртгэх.

Төсөв зохиох нь маш энгийн бөгөөд дараах зүйлсийг амьдралдаа хэвшүүлэх нь үр дүнтэй.

- Сарын тогтмол болон нэмэлт тогтмол бус орлогуудаа бүртгэх;
- Өдөр бүрийнхээ зарцуулалтыг гарын дор дэвтэр гаргаад ч юм уу эсвэл гар утсан дээрээ бүртгэх;
- Орлого, зардлаа бүртгэн өрхийн төсвөө гаргаарай.

Сарын орлого, зардлаа ийнхүү тооцох нь:

- Хэрвээ таны орлого зардлаасаа их байгаа бол та шууд хуримтлуулж эхлээрэй.
- Орлого тань зардлаасаа илүү гарахгүй бол зардлаа хэмнэх боломжийг хайгаарай. Мөн орлогоо нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлээрэй.



УХААЛАГ ХЭМНЭЛТ гэж юу вэ?

- төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийж хэвших;
- рекламны дагуу худалдан авалт хийхгүй байх;
- гадуур хооллохоо багасгах, өөртөө тохирсон эрүүл хоол хийж авч явах, гэртээ хооллох;
- цахилгаан, ус гэх мэт хэрэглээний зардлаа хянах;
- унаа шатахууны зардлаа хэмнэх, тухайлбал, алхах, нийтийн тээврээр зорчих, дугуй унах гэх мэтээр өөрийн эрүүл мэндэд тустай байдлаар шийдэх.

2. Хэмнэж болох зардлыг хасч орлого болон зардлын төлөвлөгөө гаргах.

Сарын эцэст зардал тус бүрийг нягтлан үзээд үр ашиггүй, илүү зардлаа танаж, хэмнэх боломж байгаа эсэхийг тодорхойл. Гэхдээ тэмдэглэлт баяр, төрсөн өдөр гэх мэт тогтмол бус нэмэлт зардлуудыг тусгахаа мартуузай. Мөн тогтмол орлого болон тогтмол бус орлого орж ирэх хугацаагаа нягталж, орлого нэмэгдүүлэх бодит боломжоо үнэлээрэй.

3. Хуримтлуулж чадах хэмжээгээ тодорхойлох.

Ийнхүү өрхийн төсвөө шинэчлэн гаргаж хуримтлал хийх боломжит хэмжээгээ тодорхойлно. Санхүүгийн мэргэжилтнүүд цэвэр орлогынхоо 10-15 хувийг хуримтлуулахыг зөвлөдөг. Мэдээж хуримтлал танд дарамт болж болохгүй. *Хэмнэлт тань ухаалаг* байх хэрэгтэй. Төсөв гаргаж, дээрээс нь хэмнэлт хийж сурсан байхад та санаанд оромгүй их мөнгийг хуримтлуулсан байх болно.

4. Хуримтлал хийх зорилгоо ач холбогдлоор нь жагсаан бичих.

Хүн бүрийн хувьд харилцан адилгүй хамгийн чухал зүйлтэй байх тул өөрийнхөө хувьд цаг хугацаа, хуримтлалын хэмжээнээсээ хамааруулан хуримтлалаа хийх нь чухал юм.

5. Урт, богино хугацааны хуримтлалын зорилгоос хамааруулан хуримтлалын хэлбэрээ сонгох.

Урт болон богино хугацааны зорилготойгоо уялдуулан хуримтлал хийх нь илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, зорилгуудыг дараах байдлаар урт болон богино хугацааных гэж ангилж болох юм. Үүнд: Богино хугацааны зорилгыг санхүүжүүлэхэд зориулсан хуримтлал /1-3 жилийн хугацаа/

- Гэнэтийн хэрэгцээнд зориулан хуримтлуулах /ажил хийхгүй байхдаа 6 сараас 1 жил амьдрах зардлаа нөхөх хэмжээний хуримтлал/
- Амралт зугаалга, аялалд зориулан хуримтлуулах
- Сурч боловсроход зориулан хуримтлуулах
- Шинэ машин худалдан авахад зориулан хуримтлуулах гэх мэт.

Урт хугацааны зорилгоо санхүүжүүлэхэд зориулсан хуримтлал /3 болон түүнээс дээш жилийн хугацаа/

- Тэтгэвэрт гарахдаа зориулан хуримтлал хийх
- Хүүхдийнхээ их дээд сургуулийн боловсролд нь зориулан хуримтлал хийх
- Байрны урьдчилгаа төлбөр бүрдүүлэх болон байрны засвар өргөтгөлд зориулан хуримтлуулах гэх мэт.

Урт болон богино хугацааны зорилгоосоо хамааруулан хуримтлалын бүтээгдэхүүний төрөл хэлбэрээ зөв сонгох нь илүү үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, урт хугацааны зорилгодоо хуримтлал хийж байгаа бол 1 жилээс дээш урт хугацаатай хадгаламжийг сонгох, богино хугацааны зорилгодоо хуримтлал хийх бол 1 жилээс доош богино хугацаатай хадгаламжийг сонгох нь төлөвлөсөн хадгаламжийн хүүний орлогоо эрсдэлгүйгээр *(хадгаламжийн хугацаагаа цуцлуулж бага хүүтэй хадгаламж авахгүй)* авах боломжийг бүрдүүлдэг.

6. Хуримтлалаа эхлүүлж, хэрхэн өсч байгааг хянаж байх.


Нэгэнт та хуримтлал хийхээр шийдсэн бол цалин болон орлогоосоо шууд хадгаламжийн данс руугаа тодорхой өдрүүдэд тогтмол дүнгээр мөнгөө автоматаар шилжүүлбэл илүү үр дүнтэй.

Эцэст нь таны хуримтлал таны төлөвлөгөөний дагуу өсөх болно. Хуримтлалтай болох дээрх үйл явцыг сар бүр хянаж, хуримтлал хийх төлөвлөгөөгөө хэрэгжүүлж чадвал хүссэн хэмжээний хуримтлалаа хийж санхүүгийн гэнэтийн эрсдэлээс өөрийгөө хамгаалж чадна.

4.2. Хадгаламжийн төрөл, түүний давуу ба сул тал

Мөнгөө хадгалуулах эрсдэл багатай арга бол банкинд хадгалуулах юм. Хадгаламж нь хугацаатай болон хугацаагүй гэсэн үндсэн төрөлтэй байдаг.

Зураг 4.2. Хадгаламжийн төрөл



Дээрх нийтлэг хадгаламжийн төрлөөс гадна хүүний төлбөрийг хэдий хугацаанд ямар давтамжтайгаар өгч байгаагаас хамаарсан хадгаламжийн бүтээгдэхүүнүүд байдаг. Тухайлбал:


- Урьдчилсан хүүт хадгаламж- Хадгаламж нээлгэсэн даруй эсвэл сар бүр харилцах дансандаа авах хадгаламж юм. Хүссэн цагтаа орлого хийж болох ч данснаасаа хугацаанаас өмнө мөнгө авах бол хүүг бууруулсан хүүгээр тооцдог.
- Хүүнээс хүү тооцох хадгаламж- Сар бүрийн эцэст хуримтлагдсан хүүг тухайн хадгаламжийн дансанд шилжин хүүнээс хүү тооцдоггоороо онцлог. Өөрөөр хэлбэл, жилийн хүү нь 13,3% байхад хүүнээс хүү бодсоноор таны хадгаламжид бодогдох бодит хүү 16,53% болж байна.

Эдгээр хадгаламжийн онцлогийг 6 сарын хугацаатайгаар 5000000 төгрөгийг хадгалах нөхцөл дээр харьцуулж үзье.

Хүснэгт 4.1. Хадгаламжийн хүүний орлого тооцоолол

Төрөл	Жилийн хүү	Жилийн бодит* хүү	Хүүний орлого тооцоолох /төгрөг /
Харилцах	0%	0%	0
Хугацаагүй хадгаламж	6%	6%	151233
Энгийн хугацаатай хадгаламж	13,3%	13,3%	335233
Хүүгээ сар бүр олгох урьдчилсан хүүт хадгаламж	15,4%	15,4%	388164
Хүүнээс хүү тооцох хадгаламж	15,4%	16,53%	400938
Хадгаламжийн сертификат	15,8%	15,8%	398247

*Хадгаламжийн хугацаанд хэд хэдэн удаа хүү олгох тохиолдолд бодит хүүг тооцоолдог.



4.3. Хэрхэн хадгаламжтай болох вэ?

Хадгаламж нь таны зорилго, мөрөөдөлтэй холбогдвол илүү үр дүнтэй болно. Өрхийн гишүүн бүр өөр өөрийн гэсэн хүсэл зорилго, мөрөөдөлтэй байдаг.



Иймд мөрөөдөл, зорилгодоо хүрэхийн тулд хуримтлалын төлөвлөгөөгөө гаргаж түүнд тууштай, санхүүгийн сахилга баттай байх нь чухал.

Гишүүн бүрийн хүсэл зорилго, мөрөөдөл өрхийн санхүүтэй холбоотойгоор шийдэгдэх учир ач холбогдлын дарааллыг гарган өрхийн хуримтлалын төлөвлөгөө гаргаарай. Хүснэгт 4.2-т хуримтлалын төлөвлөгөөний жишээг авч үзлээ.

Хүснэгт 4.2. Гарьдын гэр бүлийн хуримтлалын төлөвлөгөө

2016 оны 1-р сар	Гарьдын гэр бүлийн өрхийн орлого сарын 2.0 сая төгрөг			
	Аав	Ээж	Дунд хүү	Отгон хүү
Хуримтлалын зорилго	Хүүгийн хурим		Компьютер	Унадаг дугуй
Ач холбогдол	1		2	3
Хуримтлалын хэмжээ	5000000		1000000	200000
Хуримтлалын хугацаа	10 сар		9 сар	6 сар
Хадгаламжийн төрөл	10 сарын хугацаатай хүүнээс хүү бодох хадгаламж		9 сарын хугацаатай хадгаламж	6 сарын хугацаатай хадгаламж
Хуримтлалын төлөвлөгөө	Өрхийн орлогынхоо 15%-ийг том хүүгийн хуримд, 5%-ийг 2 бага хүүгийн хэрэгцээнд зориулах.		Зуны амралтаараа ажиллаж төлбөрийн 50%-ийг өөрөө олох.	Тэмдэглэлт баяруудаар цугларсан мөнгөө мөнгөний гахайдаа хадгалах.

Гарьдын гэр бүл хуримтлалын төлөвлөгөөнийхөө дагуу өрхийн орлогынхоо 27% буюу 540000 төгрөгийг цалингийн данснаасаа хадгаламжийн данс руугаа шууд шилжүүлэх банкны үйлчилгээ авснаар хуримтлал хийхэд илүү хялбар, үр дүнтэй болсон байна.

Бүх банкуудад энэхүү үйлчилгээ байдаг бөгөөд нэршлийн хувьд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, зарим банк захиалгат шилжүүлгийн үйлчилгээ, стэндинг ордер буюу захиалгат гүйлгээ гэдэг бол зарим нь хуримтлалын үйлчилгээ ч гэж нэрлэдэг. Та ч мөн энэхүү үйлчилгээг авснаар санхүүгийн хувьд сахилга баттайгаар хуримтлал хийх боломжтой.



Хүснэгт 4.3. Зээлэх үү, хуримтлуулах уу

ХЭРХЭН АВТОМАШИНТАЙ БОЛОХ ВЭ?	
<p>Одоо зээлэх үү?</p> <p>Тэмүүлэн 2192369 төгрөгийн хадгаламжаар урьдчилгаа төлбөрөө төлөөд 10.0 сая төгрөгийн үнэтэй автомашин худалдан авахад зээлийн төлбөрт сард 716447 төгрөг төлөхөөр байна.</p> <p>Сул тал</p> <p>1 жилийн хугацаанд зээлийн хүүнд 777148 төгрөг төлөх ба зээл авахтай холбоотой нэмэлт зардлууд гарна</p> <p>Давуу тал</p> <p>Яг одоо автомашинтай болох боломжтой.</p>	<p>Нэг жилийн өмнөөс хуримтлуулах уу ?</p> <p>Харин одоо зээл авахгүйгээр 2192369 төгрөгөө үргэлжлүүлэн 1 жил хадгалахдаа зээлийн төлбөрт төлөх байсан дүнтэй ойролцоо буюу 650000 төгрөгийг сар бүр нэмж хийхэд 1 жилийн дотор зээлгүйгээр 10.0 сая төгрөгийн автомашинаа авах боломжтой.</p> <p>Давуу тал</p> <p>Харин эсрэгээрээ банк 882414 төгрөгийн хүү таны хадгаламжид төлөхөөр байна.</p> <p>Сул тал</p> <p>1 жилийн дараа автомашинаа авна.</p>

4.4. Хадгаламжийн хүүний тооцоолол



Хүснэгт 4.4. Хадгаламжийн хүүг хэрхэн тооцдог вэ?

<p>Энгийн хадгаламж</p>	<p>Хадгалуулах мөнгөн дүн, хугацаа, хүүний хувийг ашиглан ирээдүйд өсөх мөнгөн хэмжээг тооцоолж болно.</p> $\text{Хадгаламжийн дүн} = \text{Анхны мөнгөн дүн} * (1 + \text{хүү})^{\text{жил}}$ <p>Жишээ нь: 1 сая төгрөгийг, жилийн 12%-иар хадгалуулбал 3-н жилийн дараа хэдэн төгрөгтэй болох вэ?</p> <p>Хадгаламж = $1000000 * (1 + 0,12)^3 = 1404928$ төгрөг</p>
<p>Хүүнээс хүү бодох хадгаламж</p>	<p>Банкууд энэ төрлийн хадгаламжийг хүүгээр арвижих хугацаатай хадгаламж, хуримтлалын хадгаламж гэх мэтээр нэрлэдэг.</p> <p>Өмнөх жишээгээр сар бүр хүүнээс хүү тооцдог хадгаламжийн дүнг бодож үзье.</p> $\text{Хадгаламжийн дүн} = \text{Анхны мөнгөн дүн} * \left(1 + \frac{\text{жилийн хүү}}{12}\right)^{\text{жил} * 12}$ <p>Хадгаламж = $1000000 * (1 + 0,12/12)^{3 * 12} = 1430768.78$ төгрөг</p>
<p>Сар бүр тодорхой дүнгээр тогтмол дүнгээр хуримтлал үүсгэх хадгаламж</p>	<p>Тухайлбал, сар бүр 100000 төгрөгийн хуримтлалыг, жилийн 12%-ийн хүүтэй хадгална гэж үзвэл, 3 жилийн дараа хичнээн хэмжээний хуримтлалтай болсон байхыг бодье.</p> $\text{Хадгаламжийн дүн} = \text{Сар бүрийн хуримтлалын дүн} * \frac{(1 + \text{жилийн хүү}/12)^{\text{жил} * 12} - 1}{\text{жилийн хүү}/12}$ <p>Хадгаламж = $100000 * \frac{(1 + 0,12/12)^{3 * 12} - 1}{0,12/12} = 4307687.84$ төгрөг</p>



Жилийн хүүг бодоходоо хувийг тоон хэлбэр лүү шилжүүлдэг. *Жилийн хүү 12% бол энэ нь коэффициентээр бол 0.12 юм.*

Харин сарын хүүг олоходоо жилийн хүүг 12-т хувааж гаргана. Тоон хэлбэрт оруулбал $=0,12/12$ буюу 0.01 болох юм.

Та одоо хуримтлалгүй байсан ч одооноос эхлээд хуримтлуулж болно. Хамгийн гол нь хуримтлал хийх зорилго болон төлөвлөгөөгөө гаргах хэрэгтэй.

- Ямар хугацааны зорилго тавих вэ?
- Зорилго маань урт, дунд, богино хугацааны аль нь вэ?
- Ач холбогдлын дарааллаараа аль зорилго хамгийн чухал вэ?
- Хуримтлал маань хэзээ хэрэгтэй болох вэ?
- Хэдий хэмжээний мөнгө хэрэгтэй болох вэ?
- Сард хэдийг хуримтлуулбал би зорилгодоо хүрэх вэ?

Тэмүүлэн, Солонго хоёр түрээсийн байранд 4 дэх жилдээ амьдарч байгаа. Тэдний хувьд түрээсийн төлбөрт зардал гаргаж байснаас орон сууцны зээлийн төлбөрт төлөх нь ирээдүйдээ хөрөнгө оруулж буй нэг хэлбэр гэж үзсэн. Залуу гэр бүл 50.0 сая төгрөгөөр 1 өрөө орон сууц худалдан авах хүсэлтээ байгаа ба урьдчилгаа төлбөр 30% болох 15.0 сая төгрөгийг хуримтлуулж чадвал орон сууцны зээлд хамрагдах боломжтой болох юм. Тэмүүлэнгийн гэр бүлийн хувьд сард 350000 төгрөгийн хуримтлал хийх боломжтой. Урт хугацаатай хадгаламжийн хүүг жилийн 15,6% гэж үзвэл хэдэн жилийн дараа урьдчилгаа төлбөрөө бүрдүүлж чадах вэ?

Дээрх томъёог ашиглан Тэмүүлэнгийн гэр бүлийн хуримтлалын хэмжээг бодож үзье.

$$\text{Хадгаламж} = \text{Сар бүрийн хуримтлалын дүн} * \frac{(1 + \text{жилийн хүү}/12)^{\text{жил}*12} - 1}{\text{жилийн хүү}/12}$$

$$(1 + 0,156/12)^{\text{жил}*12} = \left(\frac{15000000}{350000} * 0,156 \right) / 12 + 1$$

$$\text{Жил} = 2,7 \text{ жил}$$



Тэмүүлэнгийн гэр бүл 2,7 жилийн дараа буюу 2 жил 9 сарын дараа урьдчилгаа төлбөрөө бүрдүүлж чадахаар байна.

4.5. Хадгаламжид үзүүлэх инфляцийн нөлөөлөл

Инфляци бидний худалдан авалтад нөлөөлөхөөс гадна хадгаламжийн орлогод нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, инфляци хэдий чинээ их байна, хадгаламжийн хүүнээс олох орлогыг бууруулж байдаг. Дараах жишээгээр инфляци хадгаламжинд хэрхэн нөлөөлж байгааг хугацаагүй хадгаламжийн хүү 6% байх тохиолдолд бодит хүүг бодож үзье.

Хүснэгт 4.5. Бодит хүүний тооцоолол /2013-2015 он/

Он	Бодит хүү	
2013	-6,5% = 6% - 12,5%	Энэ үед хадгаламжийн хүү инфляциас бага байх тул таны хадгалуулж буй мөнгө 6.5%-иар үнэ цэнэ нь буурч байна. Өөрөөр хэлбэл, энэ үед та бусад хэлбэрийн үнийн өсөлттэй байгаа зүйл хөрөнгө оруулах эсэхээ шийдэх хэрэгтэй. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэх мэт
2014	-5% = 6% - 11%	2013 онтой харьцуулахад арай дээр боловч мөнгөн хөрөнгө маань 5%-иар үнэ цэнээ алдахаар байна. Магадгүй бэлэн мөнгөөр гэртээ хадгалсан бол таны мөнгөний үнэ цэнэ 11%-иар буурах байлаа.
2015	4,1% = 6% - 1,9%	Таны хадгалуулсан мөнгө 4,1% өсөлттэй байхаар байна.



Бодит хүү гэдгийг инфляцийн нөлөөллийг тооцсон хүү гэж ойлгож болно.

4. “ХУРИМТЛАЛ БА ХАДГАЛАМЖ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

4.1. Хуримтлалын зорилго, хуримтлал үүсгэх арга

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хуримтлалын зорилгыг ойлгох чадвартай болсны үндсэн дээр хуримтлал бий болгох аргуудаас өөрт тохирохыг сонгон хэрэгжүүлэх

Хэрэглэгдэх нэр томъёо:

Хуримтлал, хадгаламж, хуримтлал үүсгэх арга замууд, ухаалаг хэмнэлт

Хэрэглэгдэхүүн:

Хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн хүүгийн тооцоолол (www.sankhuuginbolovsrol.mn), багийн ажлын цаас, цаасны маркер.

Сургалтын арга:

Хадгалах, хэмнэх тооцоотой байх, бүлгээр ажиллах.

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх, чиглүүлэх аргачлалыг хослуулан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд ахмад” гэсэн 3 бүлэг болгоод “Хуримтлал юунд хэрэгтэй вэ?” гэсэн нэг асуулт тавиад 10 минут бүлгийн ажил хийлгэнэ. Бүлэг тус бүрийн төлөөллийг гарган самбарт жагсаалт үйлдүүлнэ. Ингэхдээ утга санааг давхардуулахгүй байхыг эрмэлзэнэ. Энэхүү жагсаалтад бичигдсэн санаануудаас зураг 4.1-д байхгүй санааг нь нөхөж бичээд суралцагчдаар хуримтлал үүсгэхийн ач холбогдлын тухай тайлбарлуулна. Жишээ болгон аав, ээжийгээ сувилалд амрахаар шийдсэн Тэмүүлэн, Солонго 2-ын хэрхэн хуримтлал үүсгэж санаа зорилгодоо хүрсэн тухай ярилцана. Хуримтлал бол алхам алхмаар бий болдог зүйл учраа шийдвэр гаргасан тул шууд хуримтлуулж эхлэх хэрэгтэй гэсэн зөвлөгөөг өгнө.

Алхам 2 :

Хуримтлал үүсгэх амар ажил биш тул суралцагчдад зураг 4.2-т харуулсан хуримтлал үүсгэх арга замуудын талаар дараах байдлаар тайлбарлаж чиглэл өгнө. Мөн “ухаалаг хэмнэлт гэж юу вэ?” гэсэн хэсгийн талаар суралцагчдад мэдээлэл өгөх хэрэгтэй.

	Мөнгөний хэлбэр	Тайлбар
1	Орлого зардлаа бүртгэх	Өдөр, сарын орлого, зарлагыг заавал бичиж тэмдэглэж байх хэрэгтэй.
2	Хэмнэж болох зардлыг хасаж орлого болон зардлын төлөвлөгөө гаргах	Сарын эцэст зардал тус бүрийг нягтлаад илүү, ашиггүй зардлаа танаж, хэмнэх боломжтой хэмжээгээ тодорхойлно.
3	Хуримтлуулж чадах хэмжээгээ тодорхойлох	Мэргэжилтнүүд орлогынхоо 10-15 хувийг хуримтлуулахыг зөвлөдөг тул өөртөө дарамт болохгүй хэмжээгээр хуримтлал үүсгэх хэрэгтэй.
4	Хуримтлал хийх зорилгоо ач холбогдлоор нь жагсаан бичих	Хуримтлалын хэмжээ, цаг хугацаа, зорилгоосоо хамаарч өөр өөр байна.

- | | | |
|---|---|--|
| 5 | Хуримтлалын хэлбэрээ сонгох | Урт хугацааны болон богино зорилготойгоо уялдуулан хуримтлалын хэлбэрээ сонгох хэрэгтэй. |
| 6 | Хуримтлалаа хэрхэн өсч байгааг хянаж байх | Нэгэнт хуримтлал хийхээр шийдсэн бол цалин, орлогоосоо тодорхой хэсгийг хадгаламжийн данс руугаа тодорхой өдрүүдэд тогтмол шилжүүлж хэвших хэрэгтэй. |

Нэмэлт мэдээлэл:

Хичээлийг илүү сонирхолтой болгох үүднээс хуримтлал үүсгэж хэвшсэн Хятад зэрэг улсын жишээг Монголын хуримтлалын байдалтай харьцуулсан мэдээлэл өгч болно.

Анхаарах зүйл:

Суралцагчдад өрхийн төсөв зохиож, бүртгэл хөтөлж тооцоотой байж, тэвчиж, хэмнэж болох зардлуудаа танаж байж хуримтлалтай болдог тул хүнээс ихээхэн хичээл, зүтгэл шаарддаг гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл санхүүгийн сахилга батад суралцах явдал чухал гэсэн санааг ойлгуулж, цаашид ийм сахилга баттай байхгүй бол яагаад ч хуримтлал үүсгэж чадахгүй гэдгийг зөвлөх хэрэгтэй.

4.2. Хадгаламжийн төрөл, түүний давуу ба сул тал

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хадгаламж, түүний төрлүүдийг мэдэж авах үндсэн дээр ямар хэлбэрээр хадгаламж болгох талаар шийдвэр гаргах, хэрвээ хадгаламжтай бол өгөөжийг нь нэмэгдүүлэх

Хэрэглэгдэх нэр томьёо:

Хугацаатай болон хугацаагүй хадгаламж, урьдчилсан хүүтэй хадгаламж, хүүнээс хүү тооцох хадгаламж

Хэрэглэгдэхүүн:

Хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн хүүгийн тооцоолол, (www.sankhuugiinbolobsrol.mn) багийн ажлын цаас, цаасны макер

Сургалтын арга:

Хадгалах, хэмнэх тооцоолох, анализ хийх

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх, чиглүүлэх аргачлалыг хослуулан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хуваагаад бүлэг тус бүрд хугацаагүй хадгаламжийн давуу болон сул талуудыг дараах хүснэгт хэлбэртэйгээр гарга гэсэн даалгавар өгнө. 10-20 минут ажиллуулсны дараа бүлэг тус бүрийн тайлбарыг хамтдаа сонсоно.

Хугацаагүй хадгаламж	Хугацаат хадгаламж
Давуу талууд Сул талууд	Давуу талууд Сул талууд

Багуудын гаргасан санаануудыг нэгтгэн зураг 4.2-т үзүүлсэн хадгаламжийн

төрлүүдийн давуу болон сул талуудыг багш тайлбарлана. Ингэхдээ бүлгийн гишүүдийн гаргасан санаануудыг биш гаргаж чадаагүй санаануудад илүү тайлбар хийх хэлбэрээр сургалтыг удирдана.

Алхам 2:

Суралцагчдад багш “урьдчилсан хүүт хадгаламж” болон “хүүнээс хүү тооцох хадгаламж”-ийн талаар тайлбарлал хийнэ. Үүнтэй холбоотойгоор хүснэгт 4.1-д илэрхийлсэн хадгаламжийн орлого тооцоолох аргачлалын талаар мэдээлэл өгнө.

Хадгаламжийн төрөл	Жилийн хүү	Ж и л и й н бодит хүү	Хүүний орлого /мөнгө/
--------------------	------------	-----------------------	-----------------------

Харилцах
Хугацаагүй хадгаламж
Хүүгээ сар бүр олгох урьдчилсан хүүт хадгаламж
Хүүнээс хүү тооцох хадгаламж
Хадгаламжийн сертификат

Нэмэлт мэдээлэл:

Банк дампуурсан тохиолдолд таны хадгаламжийг яах тухай “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн нөхөн төлбөр олгох аргачлалыг хэлж өгнө.

Анхаарах зүйлс:

Хуримтлал үүсгээд түүнийгээ өсгөхгүй хадгалахгүйн тулд хадгаламж хэлбэртэй болгон банкинд хадгалуулах, тэгэхдээ өөртөө хамгийн ашигтай байх нөхцөл юу байгааг сайтар судалж, тооцоолж хадгаламж болгох хэрэгтэй гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

4.3. Хэрхэн хадгаламжтай болох вэ?

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хэрхэн хадгаламжтай болохоо мэддэг болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Хуримтлалын төлөвлөгөө

Хэрэглэгдэхүүн:

Гарьдын гэр бүлийн хуримтлалын төлөвлөгөө, багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Орлогоо нэмэгдүүлэх, зардал хэмнэх, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Хадгаламжтай болгох бодит зөвлөгөөг өгөх хэлбэрээр дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Бүх суралцагчдаар ямар мөрөөдөл, зорилготой байгааг 5 минутад багтаан бичүүлнэ. Ингээд тодорхой тооны хүмүүсийн бичсэн зүйлийг сонсоод “гэр бүлийн ямар нэгэн зорилгод хүрэх арга зам бол хуримтлалын төлөвлөгөө” тул үүнийг хийх аргачлалыг хүснэгт 4.2-т үзүүлсний дагуу тайлбарлаж өгнө. Энэ мэт гэр бүл бүрд өөр өөр зорилго, төлөвлөгөөгөө хуримтлалын

хэмжээ, хугацаатай холбож байж биелэгдэх боломжтой болох тухай тайлбарлана.

Алхам 2 :

Суралцагчдыг гэр бүлийн хэрэгцээний автомашинтай эсэхээр 2 бүлэг болгоно. Гэр бүлийн хэрэгцээндээ автомашингүй бол хэрхэн автомашинтай болох талаар, автомашинтай бол хэрхэн сольж сайжруулах вэ? гэсэн тооцоог хийх даалгавар өгнө. Гэхдээ бүлэг тус бүрд 10 сая төгрөгний хэрэгцээ байгаа тухай чиглэл өгнө. 10 минут орчим багийн хэлэлцүүлэг хийлгээд үр дүнг бүлэг тус бүрийн төлөөллөөс сонсоно. Үүний дараа хүснэгт 4.3-т харуулсан хэлбэрээр зээлэх, хуримтлуулж авах гэсэн хоёр арга замын давуу болон сул талын талаар хамтдаа ярилцана.

Зээлээр авах нөхцөл

Хуримтлуулж авах нөхцөл

Давуу тал

Сул тал

Давуу тал

Сул тал

Нэмэлт мэдээлэл:

Автомашинтай байх бол зайлшгүй хэрэгцээ биш буюу машин худалдаж авна гэдэг бол зарлага нэмэгдэнэ гэсэн үг. Тиймээс автомашиныг өөрийн эзэмшлийн байр, оронгүй бол худалдан авахгүй байхыг зөвлөх хэрэгтэй. Хүн өөртөө хэт их хүлээлт үүсгэвэл худалдан авалтаа ухаалаг хийхгүй байх аюултай тул автомашин худалдан авахдаа ашиглалтын зардлыг заавал тооцох хэрэгтэй гэсэн мэдээллийг өгнө.

Анхаарах зүйл:

Суралцагчдад ямар зорилго хэрэгцээ байна, тэдгээрийг эрэмбэлээд зайлшгүй, нэн шаардлагатай зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хуримтлалын төлөвлөгөө хийх нь зүйтэй тухай сануулах хэрэгтэй. Хүний мөрөөдөл, хүсэл хязгааргүй тул аль болох хэрэгцээгээ эрэмбэлж, тооцоолохгүй бол санхүүгийн хүндрэлд өртөнө.

4.4. Хадгаламжийн хүүний тооцоолол

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хадгаламжийн мөнгөө хэрхэн өсч, татвар ноогдуулсаны дараа хэд болж байгааг тооцоолох чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо: Хадгаламжийн хүү

Хэрэглэгдэхүүн:

Хадгаламжийн хүүгийн тооцоолол, банкны хадгаламжийн хүүгийн танилцуулга брошур, багийн ажлын цаас, цаасны маркер.

Сургалтын арга:

Тооцоолон бодох, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Хадгаламжийн хүүгийн тооцооллыг хийж сургахын тулд дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг тооцоо хийхдээ хир зэрэг болохыг тодруулаад тооцоо “сайн хийж чадна”, “нэг их сайн чадахгүй” гэсэн 2 бүлэгт хуваана. Ингээд

Хүснэгт 4.4-ийн энгийн хадгаламжийн хүү тооцох аргачлалыг тайлбарлаж өгнө. Үүний дараа “Та 1 сая төгрөгийн хугацаагүй энгийн хадгаламжтай бол Хаан банкны жилийн 5,4 хувийн хүүтэйгээр 3 жилийн дараа таны хадгаламж хэд болох вэ?” гэсэн тооцоог бодох дасгал ажил хийлгэнэ. Тооцооллыг 10 минутад багтаан хийлгээд бүлэг тус бүрээс төлөөлөл гарган зөв бодсон эсэхийг хэлэлцэнэ.

Алхам 2 :

Тооцоо хийх чадвараар хуваасан 2 бүлэгтээ “Хүүнээс хүү бодох хадгаламжид 1 сая төгрөгтэй бол 3 жилийн дараа мөнгө тань хэд болох вэ?” гэсэн тооцоог хийлгээд өмнөх хугацаатай хадгаламжийн 3 жилийн дүнтэй харьцуулан аль нь ашигтай тухай дүгнэлтийг гаргуулна.

Хэрвээ сайн ойлгосон бол “Тэмүүлэн, Солонго хоёрын сардаа 350000 төгрөг хуримтлуулаад жилийн 15,6 хувийн хүүтэй хадгаламж хийвэл хэдэн жилийн дараа байрны урьдчилгаа төлбөр 15 сая төгрөгийг бүрдүүлэх боломжтой вэ?” гэсэн тооцооллыг хийлгэнэ. Зөв хийсэн бол “Тэмүүлэнгийн гэр бүл 2 жил 9 сарын дараа байрны урьдчилгаа мөнгийг хуримтлуулж чадна” гэсэн хариуг хэлж баталгаажуулна.

Нэмэлт мэдээлэл:

Ямарваа тооцоог хялбар хийх аргачлал бол томъёонд өгөгдөл оруулах явдал гэдгийг тайлбарлаж бэлэн тооцоолуур байвал ашиглан тооцоо хийхийг үзүүлнэ. Тооцоо сайн хийж чаддаг хэсэгт төдийгүй тооцоо хийж чадахгүй бүлгийн суралцагчдад түлхүү тайлбарлавал зохино.

4.5. Хадгаламжид үзүүлэх инфляцийн нөлөөлөл

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хадгаламжийн хүүгийн орлогыг инфляцийн хувь хэрхэн бууруулах тооцоог хийж сурах

Хэрэглэгдэх нэр томъёо:

Хадгаламжийн хүү, бодит хүү, инфляцийн хувь

Хэрэглэгдэхүүн:

Хадгаламжийн хүүгийн тоцоолол, инфляци тооцох аргачлал, багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Тооцоолон бодох, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Хадгаламжийн хүүгийн тоцоололд инфляцийн нөлөөллийг тогтоохын тулд дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчид ийм тооцоог шууд бие даан хийж чадахгүй тул багш эхлээд хүснэгт 4.5-д үзүүлсэн “хугацаагүй хадгаламжийн хүү 6 хувь байхад инфляци 12,5 байх үеийн нөлөөллийг” тооцоолон бодож үзүүлнэ. Үүнийгээ хадгаламж эзэмшигч 1 сая төгрөгийн хадгаламжтай бол түүний мөнгөний хэдийг инфляци үнэгүйдүүлэх жишээгээр тайлбарлана. Энэ тохиолдолд банкны хүү инфляциас хамаагүй их тул банкны хадгаламжаас өөр үнийн өсөлт авчрах зүйлд хөрөнгө оруулахаа шийдэхгүй бол хуримтлал байсан хэмжээнээсээ ч буурна гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

Алхам 2:

Суралцагчдыг “тооцоо сайн хийдэг”, “тооцоо муу хийдэг” гэсэн 2 бүлэгт хуваана. Багшийн чиглүүлсэн тооцоо хийх аргачлалын дагуу тооцоо муу хийдэг бүлэгт “хадгаламжийн хүү 6 хувь байх болон инфляци 11 хувь байх”, тооцоо сайн хийдэг бүлэгт “инфляци 1,9 хувь байх үеийн 1 сая төгрөгийн хуримтлал” өсөх, буурахын аль болохыг тооцоолох даалгавар өгнө. Тооцоо муу хийдэг бүлэг ойлгохгүй бол 1 сая төгрөгийн тооцоог хийлгэхгүй, зөвхөн 6 хувийн хадгаламжийн хүү 11 хувийн инфляцийн үед өсөх, буурахын тооцоог хийлгэж болно.

Нэмэлт мэдээлэл:

Инфляцийн өсөлтийг тогтоодог аргачлалыг болон тухайн онд инфляци хэд байгааг хэрхэн яаж олж мэдэх тухай мэдээллийг өгнө. Хэрвээ интернэтийн орчинтой байвал <https://www.nso.mn/> гэсэн хаягаар орж Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд инфляцийн түвшин байгааг харуулж болно.

Анхаарах зүйл:

Монгол банкнаас улирал тутамд инфляцийн төлөв байдлын тайланг гаргадаг бөгөөд эндээс тухайн жилийн дундаж инфляцийн түвшингийн шалтгааныг нарийвчлан харж болох тухай зөвлөгөө өгөх хэрэгтэй. Мөн “хадгаламжийн хүүгээс инфляци давсан тохиолдолд хадгаламжаа татаж санхүүгийн өөр ашигтай шийдвэр гаргах хэрэгтэй” гэсэн дүгнэлтийг хийлгэхэд анхаарах хэрэгтэй.

СЭДЭВ 5. ЗЭЭЛ

5.1. Зээл, түүний төрөл

Зээл гэж юу вэ? Санхүүгийн байгууллага, хувь хүнээс өөрийн хувийн хэрэгцээ болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтыг тодорхой хугацаатай, хүүтэй, эргүүлж төлөх нөхцөлтэй авахыг зээл гэж энгийнээр тодорхойлж болох юм.

Зээл сэдвийн хүрээнд үндсэн зээл /зээлийн хэмжээ, хүү, хугацаа, зээл эргэн төлөгдөх хуваарь, барьцаа хөрөнгө, түүний шаардлага, зээлийн болон барьцаа/батлан даалтын гэрээ, зээлтэй холбоотой гарах зардал гэсэн үндсэн ойлголтуудыг мэдэх хэрэгтэй.

Үндсэн зээл: Зээлийн хүү, шимтгэл ороогүй зээлийн үлдэгдэл дүн.

Зээлийн хүү: Зээлийг тодорхой хугацаанд ашигласныхаа төлөө зээлдүүлэгчид төлж буй төлбөр. Зээлийн хүү нь тогтмол болон хувьсах хүүтэй байж болно. Тогтмол хүү нь зээлийн хугацааны турш өөрчлөгддөггүй бол хувьсах хүү нь гэрээгээр тохирсон аргачлалын дагуу тодорхой хугацаанд өөрчлөгдөж байдаг.

Нэмэгдүүлсэн хүү: Зээлийн эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөх төлбөрөө хугацаа хэтрүүлсэн тохиолдолд үндсэн зээлийн хүү дээр зээлийн хүүний 20%-иас ихгүйгээр нэмж төлж буй хүү юм.

Зээлийн хугацаа: Зээлийн гэрээгээр тохиролцсон зээл авснаас эхлэн төлж дуусах хүртэл хугацаа.

Зээлдэгч, хамтран зээлдэгч: Зээлийн гэрээний үүргийг хамтран гүйцэтгэх үүрэг хүлээсэн иргэн, хуулийн этгээд.

Зээлийг зориулалт болон эргэн төлөгдөх эх үүсвэрийн хэлбэрээс нь хамааруулан дараах байдлаар ангилсан байдаг.

Зураг 5.1. Зээлийн бүтээгдэхүүний төрөл



Иймд та зээл авах тухай бодохоосоо өмнө зээлийг хэрхэн, юунд зарцуулахаа тодорхойлсон байхаас гадна зээлийг хүүний хамт тогтмол давтамжтайгаар буцаан төлөх ирээдүйн орлогоо тооцоолсон байх ёстой.

5.2. Зээлийн бүтээгдэхүүний сонголт

Ямар төрлийн зээлийг сонгох нь таны хэрэгцээ шаардлагад нийцсэн, эрсдэлгүй, үр ашигтай байхыг урьдчилан судлах хэрэгтэй. Иймд зээл авахдаа дараах хүчин зүйлсийг тодорхойлох нь зүйтэй.

Зураг 5.2. Зээл авахад анхаарах хүчин зүйлс



5.3 Зээлийн хүү, төлбөрийн тооцоолол

Зээл авахаар төлөвлөж байгаа иргэд сар, улиралд төлөх зээл болон хүүний төлбөрөө урьдчилан тооцоолон, түүнийг хангах мөнгөн орлогоо тооцоолдог чадвартай байх нь бидний анхан шатны мэдлэг байх учиртай.

Зээлийн эргэн төлөгдөх хуваарь: Зээлийн хугацааны туршид зээл болон хүүний төлбөрийг тодорхой давтамжтайгаар хэсэгчлэн төлөх үүргийг тохиролцсон хуваарь.

Хөнгөлөлтийн хугацаа: Бизнесийн онцлог болон зээл эргэн төлөх орлогоос хамааран үндсэн зээлийн төлбөрийг төлөх үүргийг хойшлуулж тодорхой хугацаанд зөвхөн хүүний төлбөр төлөх хугацаа.

Зээлийн урьдчилсан төлөлт: Зээлийн төлбөрийг хуваарьт хугацаанаас нь өмнө үндсэн зээлийг хэсэгчлэн болон бүтнээр нь буцаан төлөх.

Зээлийн хүүний зардлыг энгийн байдлаар тооцоолоход, үндсэн зээл буюу авсан зээлийн үлдэгдэл, зээлийн жилийн хүү, зээл ашиглах хоног мэдэгдэж байхад хангалттай.

$$\text{Зээлийн хүүний тооцоолол} = \frac{\text{Зээлийн үлдэгдэл} \times \text{Зээлийн жилийн хүү}}{365} \times \text{Зээл ашигласан хугацаа}$$

Иргэн Гарьд сарын 1.0 сая төгрөгийн цалинтай ажил эрхэлдэг ба автомашин худалдан авахаар жилийн 18%-ийн хүүтэй, 3.0 сая төгрөгийн зээл авах болсон. Тэрээр зээлээ 5 сарын хугацаатай авбал зээлийн хүүнд сард хэдэн төгрөг төлөхийг тооцож үзье.

$$\text{Сарын хүүний зардал} = (3,000,000 \times 18\%) / 365 \times 30 = 44,384 \text{ төгрөг байна.}$$

Та тодорхой бизнесийн болон цалингийн орлоготой бол сар бүр зээлийн төлбөрөөс тодорхой хэсгийг зээлийн хүүтэй хамт төлүүлэхийг банкууд эрмэлздэг. Мэдээж зээлийг эргэн төлөх хуваарийг таны орлого орж ирэх хугацаа, ажил болон бизнесийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан төрөл бүрээр банк тооцоолон гаргадаг.

Зураг 5.3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн төрөл, хэлбэр



Зээлийн төлбөр төлөх дээрх хувилбаруудын ялгааг, Гарьдын гэр бүлийн авсан жилийн 18%-ийн хүүтэй, 5 сарын хугацаатай, 3.0 сая төгрөгийн дүнтэй автомашины лизингийн зээлийн жишээн дээр авч үзье.

I. Үндсэн зээл болон хүүний төлбөрөөс бүрдсэн тэнцүү төлбөртэй хуваарь

Зээл төлөх огноо	Үндсэн зээлийн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үндсэн зээлийн үлдэгдэл
Нийт	3 000 000	135 965	3 135 965	3 000 000
2016.02.10	581 330	45 863	627 193	2 418 670
2016.03.10	592 602	34 590	627 193	1 826 068
2016.04.10	599 276	27 916	627 193	1 226 792
2016.05.10	609 043	18 150	627 193	617 749
2016.06.10	617 749	9 444	627 193	-

Зээлийн хүү зээлийн үндсэн үлдэгдлээс тооцогдох тул эхний саруудад хүүний төлбөр өндөр, үндсэн зээлийн төлбөр бага байгаа боловч Гарьдын сард төлөх хэмжээ ижил байна.

II. Сар бүр тэнцүү үндсэн зээлийн төлбөр + зээлийн хүү

Зээл төлөх огноо	Үндсэн зээлийн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үндсэн зээлийн үлдэгдэл
Нийт	3 000 000	134 630	3 134 630	3 000 000
2016.02.10	600 000	45 863	645 863	2 400 000
2016.03.10	600 000	34 323	634 323	1 800 000
2016.04.10	600 000	27 518	627 518	1 200 000
2016.05.10	600 000	17 753	617 753	600 000
2016.06.10	600 000	9 173	609 173	-

Гарьдын сар бүр төлөх үндсэн зээлийн үлдэгдэл нь ижил боловч хүүнээс хамааран сард төлөх нийт төлбөр нь харилцан адилгүй байна.

III. Сар бүр зээлийн хүүг төлөх ба тодорхой саруудад үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, бусад хугацаанд зээлийн төлбөр тэнцүү төлөх хуваарь

Зээл төлөх огноо	Үндсэн зээлийн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үндсэн зээлийн үлдэгдэл
Нийт	3 000 000	179 507	3 179 507	3 000 000
2016.02.10	-	45 863	45 863	3 000 000
2016.03.10	-	42 904	42 904	3 000 000
2016.04.10	1 000 000	45 863	1 045 863	2 000 000
2016.05.10	1 000 000	29 589	1 029 589	1 000 000
2016.06.10	1 000 000	15 288	1 015 288	-

Энэ хувилбарын хувьд эхний 2 сард зөвхөн зээлийн хүү төлөх ч үлдэх саруудад үндсэн зээлээс өндөр хэмжээгээр төлж эхлэх учраас нийт төлбөр 1.0 сая төгрөгөөс илүү гарч байна. Өөрөөр хэлбэл, Гарьд улирлын шинжтэй бизнес эрхэлдэг бол ийм нөхцлөөр зээл авах боломжгүй нь харагдаж байна. Энэ тохиолдолд 3.0 сая төгрөгийн зээлийг арай урт хугацаатай авах хүсэлтийг банкинд тавьж болно.

IV. Сар бүр зээлийн хүүг төлөх ба тодорхой саруудад үндсэн зээлээ хувааж төлөх хуваарь

Зээл төлөх огноо	Үндсэн зээлийн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үндсэн зээлийн үлдэгдэл
Нийт	3 000 000	156 823	3 156 823	3 000 000
2016.02.10	-	45 863	45 863	3 000 000
2016.03.10	1 500 000	42 904	1 542 904	1 500 000
2016.04.10	-	22 932	22 932	1 500 000
2016.05.10	-	22 192	22 192	1 500 000
2016.06.10	1 500 000-	22 932	1 522 932	-

Гарьдын тухайд энэ хувилбараар зээл авах боломжгүй. Гэхдээ тогтмол бус улирлын шинж чанартай бизнес эрхлэгчдэд илүү тохиромжтой хувилбар юм.

Дүгнэлт: Үндсэн зээлээс боломжит өндөр дүнгээр төлж эхлэх нь нийт хүүнд төлөх төлбөрийг бууруулж байгааг харж болно. Хамгийн бага хүүний төлбөр II хувилбар дээр гарч байгаа бол хамгийн өндөр төлбөр III хувилбар дээр гарсан. Өөрөөр хэлбэл орлоготой уялдаагүй л бол үндсэн зээлээс чөлөөлүүлэх нь хүсэлт нь нэмэлт зардлыг бий болгож байгааг анхаарах хэрэгтэй.

5.4. Зээлийн барьцаа, түүнд тавигдах шаардлага, үнэлгээ

Барьцаа хөрөнгө

Зээлийн гэрээний үүрэг биелэгдэхгүй байх нөхцөл ирээдүйд бий болох үед гэрээний үүргийг гүйцэтгүүлэх зорилготой хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эрх.

Батлан даалт

Гуравдагч этгээд зээлдэгчийн нэрийн өмнөөс зээлийн гэрээний үүргийг эд хөрөнгөөр болон орлогоороо хариуцан төлөх үүрэг хүлээсэн гэрээ.

Барьцаа хөрөнгийг дараах байдлаар ангилдаг.

Зураг 5.4. Барьцаа хөрөнгийн төрөл

Үл хөдлөх хөрөнгө	Хөдлөх хөрөнгө	Биет бус хөрөнгө
		
<ul style="list-style-type: none">• Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, байгууламж, хувьчлагдсан орон сууц, амины сууц, хашаа байшин өмчлөх/эзэмших эрхтэй газрын хамт,• Газар өмчлөх/эзэмших эрхийн гэрчилгээ,• Газар эзэмших эрхийн гэрчилгээний тухайд зээлийн барьцаанд авч болох ба зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээнд оруулж тооцохгүй.	<ul style="list-style-type: none">• Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж• Банкин дахь хугацаат хадгаламж• Үнэт эдлэл• Мал• Бизнесийн бараа материал	<ul style="list-style-type: none">• Ашигт малтмал ашиглалтын лиценз• Үнэт цаас, хувьцаа• Бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил үйлчилгээ үзүүлэх гэрээний орлого

Арилжааны банкууд зээлийн барьцаанд тавих хөрөнгөнд дараах ерөнхий шаардлагуудыг тавьдаг. Үүнд:

- Хөрөнгийг гэрчлэх баримт бичиг эрхзүйн хувьд зөрчилгүй, гэрчилгээтэй байх,
- Хөрөнгийн чанар байдал,
- Зах зээлд эрэлттэй байх,
- Бусдын эзэмшлийн хөрөнгө барьцаалах бол эрх зүйн хувьд хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх.

Хэдийгээр банк зээлдэгчдийн орлогод тулгуурлан зээл олгодог ч ирээдүйд тохиолдох төлбөрийн эрсдэлийг бууруулах үүднээс барьцаа хөрөнгө шаарддаг. Нөгөө талаас, банк харилцагчдын итгэж хадгалуулсан хөрөнгөөр зээл олгодог учраас хадгаламж эзэмшигчдээ эрсдэлээс хамгаалах үүднээс барьцаа хөрөнгийг авдаг.


Зээлийн төлбөрийн эрсдэл үүссэн үед хамгийн богино хугацаанд барьцаа хөрөнгийг борлуулж зээлийг төлүүлэх зорилгоор банкууд хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бууруулан зээлийн барьцаанд авдаг.

Мөн зээлээр бий болгосон хөрөнгө, тоног төхөөрөмж, түүхий эд материалыг зээлийн барьцаа хөрөнгийн нэг хэсэгт оруулж болдог. Түүнчлэн барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллага байдаг.

5.5. Зээлийн зардал, түүний зориулалт

Зээлийн зардалд үйлчилгээтэй холбогдон гардаг төрөл бүрийн шимтгэл хураамжууд ордог. Шимтгэлийг тодорхой үнийн дүнгээс хувиар тооцдог бол хураамж нь тогтмол дүнгээр илэрхийлэгдсэн байдаг.

Зураг 5.5. Зээлийн шимтгэл, хураамжийн төрөл, зориулалт, жишиг дүн



5.6. Зээлийн гэрээ, талуудын үүрэг хариуцлага

Зээлийн гэрээ

Зээлдэгч болон зээлдүүлэгчийн хооронд зээл авах, зээлийг буцаан төлөхтэй холбоотой үүсэх бүхий л харилцааг зохицуулсан гэрээ.

Барьцааны гэрээ

Зээлийн гэрээний үүргийг барьцаа хөрөнгөөр хангуулах нөхцөлийг тохиролцсон гэрээ.

Фидуцийн гэрээ

Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэсэн тохиолдолд эд хөрөнгийг буцаан шилжүүлэх нөхцлийг тохирсон гэрээ.



Зээлийн гэрээ нь оролцогч 2 талын эрх, үүргийг зохицуулах бичиг баримт юм.

Банкуудын зээлийн гэрээ стандарт зүйл заалттай байдаг хэдий ч гэрээ байгуулахаасаа өмнө заавал нухацтай уншиж үзэж өөрийн эрх ба үүргийг мэдэж авах нь чухал. Магадгүй тухайн гэрээнд таны хүлээж чадахгүй үүргийг тусгасан байж болох юм. Гэрээнд заасан эрх үүргээ мэдэхгүйгээс болж санхүүгийн болон сэтгэл санааны хохиролд орох ч магадлалтай.

Зээлийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө

зээлийн гэрээтэй бүрэн танилцах шаардлагатай бөгөөд дараах заалтуудыг анхааралтай тогтож хараарай.

- Зээлийн үндсэн нөхцөл /зээлийн хэмжээ, хугацаа, хүү, нэмэгдүүлсэн хүү/
- Зээлийн эргэн төлөлтийн хуваарь
- Зээлдэгчийн эрх, үүрэг
- Зээлийн төлбөрийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хүлээх хариуцлага
- Зээлийг барьцаа хөрөнгийг худалдан борлуулах нөхцөл

Гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээний оролцогчид хангах үүрэгтэй. Гэхдээ аливаа нэг хүндрэл үүсэхэд түүнийг шийдэх гарц байдаг. Хамгийн гол нь банкттайгаа нээлттэй илэн далангүй байж, нөхцөл байдлаа тайлбарлах нь ирээдүйд үүсэх том эрсдлийг бууруулж болох юм. Тухайлбал, анхны байгуулсан зээлийн гэрээний нөхцлийн дагуу зээлээ төлөх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол банкиндаа хандан зээлийн гэрээний анхны нөхцөлд өөрчлөлт оруулах нөхцлийг тохирч гэрээг шинэчлэн байгуулах боломж байдаг гэдгийг мэдэхэд илүүдэхгүй.

Энэ тохиолдолд зээлийн гэрээний бүтцэд өөрчлөлт оруулсны шимтгэл гэж зээлийн үлдэгдэл дүнгийн 0.5-1%-ийн төлбөр авч, таны нөхцөлд тохирсон байдлаар гэрээг шинэчилдэг.

i **Зээлийн гэрээтэй уншиж, танилцалгүйгээр гарын үсэг бүү зураарай.**

5.7. Зээлийн сайн түүх бүрдүүлэхийн ач холбогдол


Арилжааны банкууд зээлдэгчийн зээлээ цаг хугацаандаа төлж байгаа байдлаас хамааруулан зээлдэгчдээ үнэлгээ өгдөг ба энэ мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулж өгдөг. Зээлийг ашиглах хугацаанд зээлээ гэрээний дагуу төлж байсан болон хугацаа хэтрүүлж байсан хоногоос нь хамааруулан энэхүү үнэлгээ өгч байдаг. Өөрөөр хэлбэл, таны банкнаас авсан зээлийн ерөнхий мэдээлэл, эргэн төлөгдсөн байдал зэрэг мэдээллийг Монгол Улсад үйл ажиллагаа явж буй бүх банкууд нэгдсэн зээлийн мэдээллийн сангаасаа авах боломжтой.

Мөн банкууд сүүлийн үед Скоринг буюу зээлжих чадварын үнэлгээг хийж зээлдэгчийн зээлжих чадвар, эрсдэлийн түвшинг тодорхойлох орчин үеийн арга хэрэгслүүдийг дотооддоо ашигладаг болоод байна. Ингэснээр сайн түүхтэй зээл хүсэгчийн цаг хугацааг хэмнэсэн, түргэн шуурхай үйлчлэх бүтээгдэхүүн үйлчилгээнүүд гарсаар байна.

Мөн энэхүү үнэлгээгээ дараа дараагийн зээл олгох эсэх, зээлийн нөхцөл болох зээлийн хэмжээ, хугацаа, хүүг тогтоохдоо ашигладаг. Өөрөөр хэлбэл, зээлээ цаг хугацаандаа төлж чадаж байвал банкны сайн зээлдэгч болж зээлдэгчийн сайн түүх

бүрдүүлэх нь танд эдийн засгийн хувьд ач холбогдолтой гэсэн үг юм.

Зураг 5.6. Зээлдэгчийн зээлийн түүх, түүний үр дагавар



5.8. Зээлийн эрсдэлээс сэргийлэх арга

Зээлийн эрсдэл нь зээлдэгч банкт байгуулсан зээлийн гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсонтой холбоотойгоор үүсэх алдагдал юм. Зээлийн эрсдэл макро болон микро маш олон хүчин зүйлсээс хамаарч байдаг.



Зураг 5.7. Эрсдэлийн төрлүүд

Эдгээр эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд та юун түрүүнд өөрөөс хамаарах дараах зүйлсийг хянаж чадвал зээлийн эрсдэлээс тодорхой түвшинд хамгаалагдах боломж бүрдэнэ.

- Зээл авахдаа сар бүр төлөх зээлийн хэмжээг өөрийн цэвэр орлоготойгоо уялдуулах
- Өөрийн хэрэгцээ шаардлагад тохирсон нөхцөлтэй зээл авах. Өөрөөр хэлбэл, зээлийн бүтээгдэхүүнээ зөв сонгох, зээлийн хэмжээ,

хугацаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөрийн орлогын эх үүсвэр, түүний онцлогт тохируулан хийх,

- Зээлээ төлөвлөснийхөө дагуу зориулалтаар нь ашиглах,
- Хувь хүн, байгууллага аль нь ч эрсдэлээс хамгаалах тодорхой хэмжээний сан/ нөөцийг үүсгэж байх нь эрсдэлээс хамгаалах нэг чухал хүчин зүйл болдог.

5." ЗЭЭЛ" СЭДВИЙН АРГА ЗҮЙ

5.1. Зээл, түүний төрөл

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Зээл гэж юу болох, зээл өр болох, зээлийн бүтээгдэхүүний төрлүүдийн талаар мэдлэгтэй болж улмаар зээлийн менежментийг зөв хийдэг болох.

Хэрэглэгдэх нэр томъёо:

Үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, зээлийн хугацаа, зээлдэгч, хамтран зээлдэгч, цалингийн зээл, тэтгэврийн зээл, төслийн зээл, эргэлтийн хөрөнгийн зээл, орон сууцны зээл, малчны зээл, зээлийн карт, лизинг, хөрөнгө оруулалтын зээл

Хэрэглэгдэхүүн:

Зээлийн бүтээгдэхүүний төрлүүдийг харуулсан зурагт хуудас, зээлийн эргэн төлөлтийн график загварын цахим хэрэглэгдэхүүн

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, мэдээлэл олж авах, харьцуулсан дүгнэлт хийх, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Сэдвийн хүрээнд харилцан ярилцах, суралцагчдаар мэдлэг бүтээлгэх, нэмэлт мэдээлэл өгөх, бүлгийн ажил хийлгэж дүгнэлт гаргуулах, зөвлөмж боловсруулах арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Багш суралцагчидтай зээл гэж юу болох талаар санал солилцон ярилцана. Ингэхдээ “зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, зээлийн хугацаа, зээлдэгч, хамтран зээлдэгч” зэрэг ойлголтуудыг суралцагчдаар тодорхойлуулах оролдлого хийнэ. Үүний дараа “*Санхүүгийн байгууллага, хувь хүнээс өөрийн хувийн хэрэгцээ, бизнесийн үйл ажиллагаандаа шаардлагатай санхүүжилтийг тодорхой хугацаатай, хүүтэй, эргүүлж төлөх нөхцөлтэй авахыг зээл гэнэ*” гэсэн тодорхойлолтыг тайлбарлаж өгнө. Улмаар “зээлийг ямар тохиолдолд өр гэж тооцогдох вэ?” гэдэг асуудлыг хөндөн ярилцаж өөрийн орлого, зарлага болон бусад нөлөөлж болох хүчин зүйлүүдийг тооцон зээл авах хэрэгтэй болохыг тайлбарлана.

Алхам 2:

Суралцагчдад “үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдсэн хүү, зээлийн хугацаа, зээлдэгч, хамтран зээлдэгч, зээлийн эргэн төлөлтийн график, хүү алданги тооцох” зэрэг ойлголтуудын агуулгыг тайлбарлаад зураг 5.1-д илэрхийлсэн зээлийн төрөл, хэлбэрүүдийг үзүүлнэ. Ингэхдээ уг зургийг хэрэглэгдэхүүн болгон урьдчилан бэлтгэсэн байна. Зээлийн эргэн төлөлтийн үед гардаг эрсдэлүүдийн тухай ч мөн тайлбарлана.

Алхам 3:

Суралцагчдыг банк санхүүгийн байгууллагаас авсан зээлтэй эсэх талаар “зээлтэй болон зээлгүй” гэсэн 2 бүлэг болгон хуваана. Зээлтэй хүмүүсийн бүлгээс “Зээл авахад ямар шаардлага тулгарсан, нөхцөл, зээлийн хүүгийн талаар” харин зээлгүй хүмүүсийн бүлэгт “Зээл авахаар хүсэлт гаргахад ямар шаардлагуудыг хангахгүй байгаа тухай” бичих даалгавар өгнө. Уг бүлгийн ажлыг 10 минутад багтаан хийлгээд баг тус бүрийн төлөөллийг

яриулан бүгдээрээ хэлэлцэнэ. Ингэхдээ зээлийн хүү, нөхцөл, зориулалт, зээлийн өгөөж зэргийн талаар тухайлан ярилцаж мэдлэгээ хэрэглэж буй эсэхэд анхаарал хандуулна.

Нэмэлт мэдээлэл:

Арилжааны банкны зээлийн төрөл, зээлийн хүүгийн хэмжээ, зээлийн нөхцөл, эргэн төлөлтийн график, зээлийн өгөөж зэргийн талаар холбогдох мэдээллийг өгнө.

Анхаарах зүйл:

Хүн заавал зээлтэй байх ёстой биш бөгөөд заавал хэрэгцээтэй биш бол зээл авахгүй байхыг хичээх хэрэгтэй. Учир нь зээл бол таны орлогыг ирээдүйд багасгаж, авсан мөнгийг өсгөн төлүүлж байгаа хэлбэр гэдгийг сануулах хэрэгтэй. “Мэдээж хүн ямар нэгэн зээлийг аваад хүүнээс нь дээгүүр орлого олох тийм бизнест зарцуулах тохиолдолд л авах хэрэгтэй” гэдгийг анхааруулах шаардлагатай.

5.2-5.3. Зээлийн бүтээгдэхүүний сонголт, зээлийн хүү, төлбөрийн тооцоолол

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Зээлийн зориулалт, эргэн төлөлтийн хуваарийг өөрийн ашиг, орлогын байдалтай уялдуулан зөв сонгох, зөв төлөвлөх чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томъёо:

Зээлийн хүүгийн тооцоолол, зээлийн үлдэгдэл, зээлийн эргэн төлөгдөх хуваарь, хөнгөлөлтийн хугацаа, зээлийн урьдчилсан төлөлт, үндсэн зээлийн төлбөр, нийт төлбөр, үндсэн зээлийн үлдэгдэл

Хэрэглэгдэхүүн:

Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн төрөл, хэлбэрийг илэрхийлсэн график үзүүлэн, тооны машин

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, мэдээлэл олж авах, тооцоолон бодох, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Харилцан ярилцах, суралцагчдаар мэдлэг бүтээлгэх, математик тооцоолол хийх, бүлгээр ажиллуулах, дүгнэлт гаргах арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдаар зээл авахад юуг анхаарах тухай бодлыг нь бичүүлнэ. Ингэхдээ өөрөө зээл авсан болон бусдын зээл авсан шалтгаан нөхцөл байдлыг шинжлэх үндсэн дээр “зээл авсан” болон “зээл аваагүй” гэсэн 2 бүлэгт суралцагчдыг хуваан бүлгийн ажил хийлгэх хэрэгтэй.

10 минут бүлгээр нь ажиллуулаад төлөөллийг нь гаргаж яриулна. Үүний дараа багш зураг 5.2-т анхааруулсан хүчин зүйлсийн аль нь дурдагдсан болон дурдагдаагүй тухай тайлбарыг хийнэ.

Зээлийн нөхцөл	Тайлбар
Зээл үр ашгийг бий болгодог байх	Зээл нь зөвхөн зардлыг бус ирээдүйн ашиг орлого, зохистой хэрэглээг санхүүжүүлж байх

2	Зориулалт тодорхой байх	Зээлийн хэрэгцээ шаардлага буюу зориулалт тодорхой байх
3	Ирээдүйн орлогоо тооцсон байх	Зээлээ эргэн төлөх арга зам нь тодорхойлогдсон байх
4	Зээлийн нөхцөл тохирсон байх	Зээлийн нөхцөл зээлийн зориулалтад тохирсон байх

Алхам 2:

Багш зээлийн хүүг бодох томъёонуудыг самбарт бичиж тайлбарлана. Иргэн Гарьд автомашин авах зориулалтаар 5 жилийн хугацаатай, жилийн 18 хувийн хүүтэй зээл авсан бол зээлийн хүүнд сард хэдэн төгрөг төлөхийг тооцоолох даалгавар өгнө. Үүний дараа зураг 5.3-д харуулсан зээлийн эргэн төлөлтийн хэлбэрүүдийг тайлбарлана. (Хэрэглэгдэхүүн)

Суралцагчдыг мэдлэгийн түвшингээр нь “анхан, дунд, ахисан” гэсэн 3 бүлэг болгон хуваагаад бүлэг тус бүрд өөр өөр даалгавар өгнө. 1-р багт “үндсэн зээл болон хүүний төлбөрөөс бүрдсэн тэнцүү төлбөртэй хуваарь”, 2-р багт “сар бүр тэнцүү үндсэн зээлийн төлбөр + зээлийн хүү гэсэн хуваарь”, 3-р багт “сар бүр зээлийн хүү төлөх ба тодорхой саруудад үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, бусад хугацаанд зээлийн төлбөр тэнцүү төлөх хуваарь”-ийн дагуу тооцооллыг Гарьдын автомашины зээлийн төлөлт дээр хийх даалгавар өгнө.

Энэхүү тооцооллыг баг тус бүрд 20 минут хийлгээд зарим оролцогчдоор тайлбарлуулж дүгнэлт хийлгэнэ.

Алхам 3:

Багш дээрх 3 төрөл дээр нэмж “сар бүр зээлийн хүүг төлөх ба тодорхой саруудад үндсэн зээлээ төлөх хуваарь”-ийн тооцооллыг бодож үзүүлэн зээлийн эргэн төлөлтийн 4 хэлбэрийн тухай нэгтгэн ярилцана. Багш оролцогчдод тохируулан энэ мэтээр тооцоолол хийж өөрийн санхүүгийн нөхцөл байдалдаа тохируулан зээлийн төрлийг зөв сонгохын ач холбогдлын талаар чиглэл өгнө.

Нэмэлт мэдээлэл:

Банкнаас зээл авахад дараах нийтлэг шаардлагыг тавьдаг тухай мэдээллийг өгнө.

Үүнд:

- Тодорхойлох боломжтой орлогоороо банкнаас тавьж буй шалгуурыг хангах, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлбөрөө төлөх боломжтой байх
- Зээл хүсэгч болон хамтран үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байх
- Тухайн байгууллагад ажиллаж байх, цаашид тогтвор суурьшилтай ажиллах, сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд тухайн байгууллагад ажилласан байх
- Банк шаардсан тохиолдолд хөрөнгө барьцаалах, даатгуулах боломжтой байх
- Банктай цалингийн зээлээр хамтран ажиллах гэрээтэй байх гэх мэт

Анхаарах зүйл:

Зээлийг авахаасаа өмнө сайтар төлөвлөж буюу аль болох орлого олох зүйлд зориулж хэрэглэх нь зүйтэй. Зээл авахад хамгийн чухал үзүүлэлт

бол орлогоо тодорхойлох явдал байдаг. Ялангуяа хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүст бизнес эрхэлдэг гэдгээ батлахын тулд орлого, зарлагаа гараараа тэмдэглэсэн дэвтэр хэрэгтэй байдаг тухай анхааруулна.

5.4. Зээлийн барьцаа, түүнд тавигдах шаардлага, үнэлгээ

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Зээл авахад орлогын байдлаас хамааран барьцаа хөрөнгө шаардагддаг бөгөөд барьцаа хөрөнгийг зээлийн гэрээний үүрэг биелэгдэхгүй болсон нөхцөлд банк худалдан борлуулдаг учир суралцагчид зээл авах болон эргэн төлөлтөд маш хариуцлагатай хандаж сурах

Хэрэглэгдэх нэр томьёо:

Барьцаа хөрөнгө, батлан даалт, үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, биет бус хөрөнгө

Хэрэглэгдэхүүн:

Барьцаа хөрөнгийн төрлүүдийг илэрхийлсэн бодит болон цахим зураг

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, тайлбарлах, тооцоолон бодох, дүгнэлт өгөх

Сургалтын зохион байгуулалт :

Мэдээлэл солилцох, туршлага хуваалцах, бүлгийн ажил хийлгэх, өөрсдөөр нь дүгнэлт гаргуулах арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдаар банкны зээлийн барьцаанд шаарддаг хөрөнгийн жагсаалт хийлгэнэ. Үүний дараа зураг 5.4-т харуулсан үл хөдлөх, хөдлөх, биет бус хөрөнгийн талаар тайлбарлаад “Хэрвээ та одоо зээл авлаа гэхэд ямар хөрөнгө тавих боломжтойгоо бичнэ үү?” гэсэн чиглэлийг өгнө.

Суралцагчид тодорхой хэмжээний хөрөнгийн жагсаалт гаргах бөгөөд ямар нэг байдлаар хөрөнгийн үнэлгээ хийсэн үгүй талаар ярилцана. Арилжааны банкнуудын зээлийн барьцаанд тавих хөрөнгөнд тавьдаг ерөнхий шаардлагууд байгаа эсэх, хөрөнгөө ямар аргачлалаар үнэлсэн тухайг нь тодруулан ярилцана.

Алхам 2:

Банк яагаад батлан даагч болон барьцаа хөрөнгө шаарддаг талаар ярилцлага хийж “зээлийн эргэн төлөлтийн баталгаа буюу банкыг эрсдэлээс хамгаалах хэрэгсэл бол таны барьцаа хөрөнгө болохыг тодорхойлуулахыг хичээнэ. Хэрэв зээл авах болон зээлийн эргэн төлөлтөд хариуцлагатай хандахгүй бол зээлдэгч болон батлан даагч том эрсдэлд орж болохыг багш тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл:

Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллага ямар байгууллага болох, ямар шаардлага тавьдаг тухай мэдээллийг өгнө (уг номны сэдэв 3-ын холбогдох хэсэг).

5.5, 5.6, 5.7 Зээлийн зардал, түүний зориулалт, зээлийн гэрээ, талуудын үүрэг хариуцлага

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Зээл авахад гарах зардлуудыг тодорхой мэддэг болох, зээлийн гэрээ,

барьцааны гэрээ, фидуцын гэрээнүүдийг байгуулахдаа маш хариуцлагатай ханддаг болох.

Хэрэглэгдэх нэр томъёо:

Өргөдлийн хураамж, зээл олголтын шимтгэл, нотариатын зардал, барьцааны гэрээ, фидуцын гэрээ

Хэрэглэгдэхүүн:

Зээлийн, барьцааны, фидуцын гэрээний загварууд (цахим байж болно).

Сургалтын арга:

Өгөгдлийг тайлбарлах, мэдээлэл олж авах, тооцоолон бодох, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Мэдээлэл өгөх, тайлбарлах, сэдэлжүүлэх, бүлгээр ажиллуулах, дүн шинжилгээ хийлгэх арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдын туршлагад үндэслэн зээл авах үйл явцад гардаг зардлуудыг самбарт жагсаан бичүүлнэ. Эндээс багш “хураамж, шимтгэл, нотариатын зардал” зэргийг нарийвчлан тодорхойлж зураг 5.5-д үзүүлсний дагуу дэлгэрэнгүй тайлбарлана. Үүний дүнд суралцагчид зээл авах үйл явцад гардаг зардлуудыг мэдэж авна.

Алхам 2:

Багш суралцагчидтай гэрээ хийж байсан эсэхийг асууж ярилцаад туршлагаар нь “анхан, дунд, ахисан” гэсэн 3 бүлэг болгоод зээлдэгчийн банктай байгуулдаг гэрээнүүдээс 3 өөр загварыг бүлэг тус бүрд өгнө. Бүлгийн ажлаар зээлдэгчийн эрх ашгийг хамгаалсан ямар заалт нэмж оруулж болох вэ? бичнэ үү гэсэн даалгавар өгнө.

Багууд 10 минутад багтаан *“гэрээ гэдэг бол аль нэг талын тулган хүлээлгэсэн баримт бичиг биш өөрийн хүсэл, сонирхлыг тусгах эрхтэй”* гэдэг дээр үндэслэн гэрээ тус бүрд өөрийн оруулах заалтын жишээг гаргаж ярилцана. Хэрвээ аль ч баг хийж чадаагүй бол багш гэрээ тус бүрд ямар заалт оруулж болох тухай жишээ тайлбар хийнэ.

Нэмэлт мэдээлэл:

Зээлээ цаг хугацаанд төлж банкны зээлдэгчийн сайн түүх бүрдүүлбэл банктай харилцахад илүү хялбар нөхцөл бүрддэг. Учир нь зээлдэгчийн мэдээлэл зээлийн мэдээллийн санд ордог тухай зураг 5.6-д харуулсан мэдээллийг тайлбарлаж өгнө.

Анхаарах зүйл:

Зээлдэгчид зээлийн гэрээний нөхцөл, шаардлага зэргийг сайтар уншиж танилцалгүйгээр хүүг л хараад гарын үсэг зурдаг ба дараа нь гэрээний нөхцөл юу гэж заасныг мэдэх тохиолдол их гардаг. Иймээс гэрээ байгуулахдаа гэрээг сайтар уншиж танилцах, улмаар өөрийн саналыг тусгах хэрэгтэй. Гэрээ бол тулгалт биш харилцан зөвшилцөл гэдгийг сануулах хэрэгтэй.

5.8 Зээлийн эрсдэлээс сэргийлэх арга

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зээлийн зарцуулалтад хариуцлагатай сахилга баттай хандаж сурах.

Хэрэглэгдэх нэр томъёо:

Зах зээлийн эрсдэл, бизнесийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хууль эрх зүйн эрсдэл

Хэрэглэгдэхүүн:

Эрсдэлийн мэдээллийг агуулсан үзүүлэн тараах материал

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, тайлбарлах, тооцоолон бодох, өгөгдөлд үнэлэлт, дүгнэлт өгөх, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Мэдээлэл өгөх, мэдлэг бүтээлгэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг “зээлтэй”, “зээлгүй” гэсэн 2 бүлэгт хуваана. Зээлтэй хүмүүсийн бүлэгт “зээл төлөхөд хүндрэл учирч байсан нөхцөл байдлыг бичих”, зээлгүй хүмүүсийн бүлэгт “зээл төлөхөд учирч болох нөхцөл байдлыг бичих” даалгавар өгнө.

Бүлгийн ажлыг 10 минут орчим хийлгээд бүлэг тус бүрийн төлөөллийг гарган тайлбарлуулна. Үүний дараа зураг 5.7-д үзүүлсэн эрсдэлийн төрлүүдийг бүлгийн ажлаар яригдсан зээл төлөхөд үүссэн болон үүсэж болох нөхцөл байдлуудыг холбон тайлбарлаж ярилцана.

Алхам 2 :

Суралцагчдыг авсан зээлээ төлөхөд болон зээл авсан тохиолдолд дараах эрсдэлгүй төлөх нөхцөлүүдийг тайлбарлаж ярилцана.

Үүнд:

- Зээл авахдаа сар бүр төлөх хэмжээг цэвэр орлоготойгоо холбох
- Өөрийн хэрэгцээ шаардлагад тохирсон зээл авах
- Зээлээ зориулалтын дагуу ашиглах
- Эрсдэлээс хамгаалах мөнгөн сан үүсгэх зэрэг болно.

“Зээлийг зээлээр төлөх бол хамгийн муу арга тул зээлийн эргэн төлөлтийн чадвар муудвал орлогоо нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай” гэдэг дүгнэлтийг суралцагчдаар өөрсдөөр нь гаргуулна.

Нэмэлт мэдээлэл:

Зээлийн хугацаа хэтэрснээс дараах үр дагаврууд гарна.

Үүнд:

- Монголбанкны мэдээллийн санд муу зээлдэгчээр бүртгэгдэж дахин зээл авах боломжгүй болно
- Бизнес болон хувь хүний нэр хүндэд сөрөг нөлөөтэй
- Хуулийн байгууллагад асуудал шилжвэл цаг хугацаа алдах
- Бизнес дампуурах
- Эд хөрөнгөө алдах зэрэг болно.

Анхаарах зүйл:

Банк зээл өгөхөөсөө өмнө эрсдэлээ тооцсон байдаг тул зээлдэгч нь эрсдэлийн үнэлгээг зээл авахаасаа өмнө хийж байх хэрэгтэй. Барьцаа хөрөнгө бага үнэлгээгээр зээл авсан газарт хураагдаж тухайн хүн эд хөрөнгөө алдахад хүрч болзошгүй тухай анхааруулах шаардлагатай.

СЭДЭВ 6. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ БА ВАЛЮТЫН ХАНШ


6.1. Үнийн өсөлт ба амьжиргааны өртгийн уялдаа холбоо

Хүн бүр өдөр тутам мөнгөтэй холбоотой шийдвэр гаргадаг. Үүнийг санхүүгийн шийдвэр гэж нэрлэнэ. Бид санхүүгийн оновчтой шийдвэр гаргаснаар мөнгөө зөв зарцуулж, хуримтлал үүсгэн, сайн сайхан амьдрах боломж бүрдүүлж чадна. Гэтэл биднээс хамаарахгүйгээр өөрчлөгдөж, эргээд бидний амьдралд нөлөөлдөг хүчин зүйлс байна. Жишээ нь: Ажил эрхлэлт, улсын эдийн засгийн байдал, зээлийн хүүний түвшин, мөнгөний нийлүүлэлт гэх мэт. Эдгээрээс бидний өдөр тутмын амьдрал, амьжиргаанд хамгийн их нөлөө үзүүлдэг хүчин зүйлийн нэг нь инфляци юм.

Инфляци: Үнийн ерөнхий түвшний өсөлтийг харуулсан үзүүлэлт юм.

Инфляцийг бид хялбараар бараа, үйлчилгээний үнийн өсөлт, мөнгөний худалдан авах чадварын бууралт гэж ойлгож болно.

Зураг 6.1. Инфляци



Хэрэв инфляцигүй байвал юмны үнэ өөрчлөгдөхгүй. Гэтэл инфляци өсөхөд мөнгөний худалдан авах чадвар буурч, барааны үнэ өсдөг. Жишээ нь: “Атар” талхны үнэ 1990 онд 1.2 төгрөг байсан бол 2016 онд 1200 төгрөг болж 1000 дахин өссөн байна. Эсрэгээрээ мөнгөний худалдан авах чадвар 1200 дахин буурчээ.

Зураг 6.2. Талхны үнийн өсөлт



Гэхдээ инфляцийг зөвхөн нэг барааны үнийн өсөлтөөр биш нийт бараа, үйлчилгээний үнийн дундаж түвшний өсөлтөөр хэмжинэ. Бүх бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг улсын хэмжээгээр нэг бүрчлэн хэмжих боломжгүй. Иймээс хүн амын өргөн хэрэглэж байгаа гол нэрийн бараа, үйлчилгээг сонгон авч, тэдгээрийн үнийн дундаж өөрчлөлтийг тооцдог. Сонгон авсан эдгээр бараа, үйлчилгээг САГСНЫ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ гэнэ.

Сагсны бараа, үйлчилгээ: Айл өрхийн бүх хэрэглээг төлөөлж чадах, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн багцыг хэлнэ. Хэрэглээний сагсны бүтцийг айл өрхүүдийн хэрэглээ, түүний хэв маягт судалгаа хийсний үндсэн дээр тодорхойлдог. Улаанбаатар хотод 344, аймгуудад 238 нэр, төрлийн бараа, бүтээгдэхүүн уг сагсанд ордог.

Дээрх нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийн дундаж өсөлтөөр инфляцийг хэмжинэ. Хэрэв зах зээл дээр бараа, үйлчилгээний үнэ өсөөд байвал иргэдийн амьдралд муугаар нөлөөлдөг. Жишээ нь: Өнөөдөр 6000 төгрөгний үнэтэй байсан 1 кг хонины мах нэг сарын дараа 7000 төгрөгний үнэтэй болсон гэж бодъё. Тэгвэл 1 кг хонины мах худалдаж авахын тулд дахиад 1000 төгрөг хэрэгтэй. Гэтэл цалин, тэтгэврийн хэмжээ энэ хугацаанд нэмэгдээгүй. Иймээс мах авахын тулд бусад зардлаа танах хэрэгтэй болно.

Инфляци танд сонголт өгнө. Гэхдээ...

Мөнгөөрөө хоол, хүнс авах уу эсвэл хүүхдэдээ гутал авах уу?

Сонголтоо өөрөө хий!!!

ИНФЛЯЦИ

Үүнийг нөгөө талаас авч үзвэл, инфляци өсөхөд айл өрхийн олж байгаа орлого буюу мөнгөнийх нь худалдан авах чадвар буурна. Жишээ нь: Инфляци 25 хувиар өсөхөд 1000 төгрөгийн худалдан авах чадвар 25 хувиар буурна. Үүнийг талхаар зүйрлэн харуулъя

Зураг 6.3. Нэг мянган төгрөгийн худалдан авах чадвар



Талхны 4-ний 1 нь хаачихав аа???

Инфляци мөн иргэдийн хуримтлал, хадгаламжид сөргөөр нөлөөлнө. Инфляцийн түвшний өсөлт хадгаламжийн хүүний өсөлтөөс давсан тохиолдолд иргэдийн хадгаламж үнэгүйдэж эхэлдэг. Хадгаламж төдийгүй бусдад бэлэн мөнгө зээлдүүлсэн тохиолдолд мөн адил үр дагаврыг авчирна. Энэ талаар иргэн Гарьдын хадгаламж дээр жишээ авч үзье.

Гарьд 45 настай.

Түүний гурав дахь хүү Тэнгис 17 настай. Дараа жил дээд сургуульд элсэн орох зорилготой бөгөөд түүний орохыг хүссэн дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 1000000 (нэг сая) төгрөг байна.

Иргэн Гарьд хүүгийнхээ сургалтын төлбөрт зориулж 1000000 төгрөгийг нэг жилийн хугацаатай, жилийн 15 хувийн хүүтэй хадгаламжид хийв.

ГЭТЭЛ!!!

Жилийн дараа инфляцийн түвшин 20 хувиар өссөн тул Тэнгисийн элсэн орохоор төлөвлөж байсан дээд сургууль нэг жилийн сургалтын төлбөрөө 20 хувиар нэмэгдүүжээ.

Үүний үр дагавар юу болох вэ?

Гарьдын хадгаламж жилийн дараа хүүний хамт 1150000 төгрөг болсон бол Тэнгисийн орохоор зорьсон дээд сургуулийн сургалтын төлбөр 1200000 төгрөг болж нэмэгджээ.

Жилийн өмнө нэг жилийн сургалтын төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц мөнгө Гарьдын хадгаламжид байсан. Жилийн дараа инфляцийн улмаас түүний хадгаламж дахь мөнгөний үнэ цэнэ буурч, сургалтын төлбөр төлж хүрэлцэхгүй болсон байна.

Таны мэдлэгт

Манай улсад 1992 онд инфляцийн түвшин 325.5 %-д хүрч байжээ.

6.2. Валютын ханшийн өөрчлөлт бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?




Бидний өдөр тутмын амьдрал, санхүүгийн байдалд нөлөөлж байдаг өөр нэг хүчин зүйл бол валютын ханшийн өөрчлөлт юм. Өөрөөр хэлбэл, гадаад валютын ханш хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч бараа, үйлчилгээний үнэ, ханш өөрчлөгддөг.

Валют: Гадаад, дотоод төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа аль нэг улсын мөнгөн тэмдэгийг хэлнэ.




Зураг 6.4. Валютын ангилал



Валютын ханш: Аль нэг улсын валютыг өөр нэгэн улсын валютаар илэрхийлсэн үнэ.

Валютын ханш нь тухайн улсын нэгж валют өөр улсын валютын хэдэн нэгжтэй тэнцэхийг харуулдаг үзүүлэлт юм. Жишээ нь: АНУ-ын 1 ам.доллар = 2450 төгрөг гэх мэт.

Зураг 6.5. Валютын ханшийг хэн тогтоодог вэ?



Валютын ханшийн өөрчлөлт бараа, үйлчилгээний үнээр дамжин иргэдийн амьжиргаанд нөлөөлдөг. Хэрэв гадаад валютын ханш өсвөл гадаадаас импортоор оруулж байгаа бүх барааны үнэ нэмэгдэнэ. Хялбар жишээ бодож үзье.

Хүснэгт 6.1 Ханшийн өөрчлөлтийн үнэд үзүүлэх нөлөө

Хугацаа	Ам.долларын албан ханш	Гадаад зах зээлээс худалдан авсан бараа	Ам.доллараар илэрхийлэгдсэн үнэ	Төгрөгөөр илэрхийлэгдсэн үнэ
2015-01-01	1888	1 кг чихэр	2 ам.доллар	3776 төг
2016-01-01	1995	1 кг чихэр	2 ам.доллар	3990 төг

Дээрх жишээнээс үзэхэд худалдаж авсан барааны хэмжээ, төрөл, гадаад зах зээлээс худалдан авсан үнэ өөрчлөгдөөгүй байна. Гэтэл долларын ханш өссөнөөс шалтгаалан чихрийн үнэ нэмэгджээ. Энэ мэтчилэн гадаад валютын ханшийн өсөлт валютаар худалдан авдаг бүх бараа, үйлчилгээний үнэд нөлөөлж, улмаар инфляцийг нэмэгдүүлдэг. Бидний хамгийн сайн мэдэх жишээ бол шатахууны үнэ. Шатахууныг гадаадаас доллараар авдаг. Иймээс долларын үнэ өсвөл гадаад зах зээл дээр шатахууны үнэ нэмэгдээгүй ч импортоор оруулж ирэхэд гарах зардал өснө. Шатахууны үнийн өсөлт нь эргээд бүх барааны тээвэрлэлтийн зардлыг нэмэгдүүлж, улмаар үнийг хөөрөгддөг. Иймээс аль болох импортын хэрэглээнээс татгалзаж гадаадаас бараа, бүтээгдэхүүн худалдан авахгүй байх, өөрсдийн хэрэгцээг эх орны үйлдвэрийн бараагаар хангавал бид өөрсдийн амьдрал, улс орны эдийн засагт оруулах чухал хувь нэмэр болно.

Гэхдээ гадаад валютын ханш өсөх нь зарим тохиолдолд ашигтай байдаг. Тухайлбал, гадаадад бараа, бүтээгдэхүүнээ гаргаж худалдаж байгаа байгууллага, иргэдийн хувьд гадаад валютын ханшийн өсөлтөөс хамаарч орлого, ашиг нь нэмэгддэг. Хүснэгт 6.1-д авсан жишээг гадаад зах зээл дээр чихэр худалдсан гэж төсөөлбөл 1 кг чихэр үйлдвэрлэж, борлуулаад олох орлого нь $3990 - 3776 = 214$ төгрөгөөр нэмэгдэж байна. Мөн гадаад валютын хадгаламжтай иргэдийн хувьд энэ нь ашигтай байх болно. Банкинд хадгалуулсан валютын үнэ өсвөл хуримтлалын үнэ цэнэ буюу хадгаламж дахь валютын төгрөгөөр илэрхийлэгдсэн үнэ цэнэ нэмэгдэнэ.



Уран бэрийн ухаан

Нэгэн өдөр Гарьдын бэр Солонго ингэж хэлжээ: “Одоо л валютын ханш хамгийн бага байдаг цаг. Удахгүй намар болж, бүх хүн сургууль, цэцэрлэгийн бэлтгэл хийгээд эхлэхээр гадаад явах хүний тоо нэмэгдэж, валютын ханш өснө. Бүгдээрээ төгрөгийн хугацаагүй хадгаламжид байгаа мөнгөө ам.доллар болгочихоё”. Энэ санаа бүгдэд таалагдаж, 2016 оны 6-р сарын 24-ний өдөр банкнаас 9725000 төгрөгөөр 5000 доллар (1\$=1945₮) авч валютын хадгаламж нээлгэв.

ГЭТЭЛ???

2016 оны 10-р сарын 20-ны өдөр Тэмүүлэн санаандгүй байдлаар интернэтээс ам.долларын ханшийн мэдээлэл хартал 1 долларын ханш 2315 төгрөг болж өссөн байлаа. Орой нь бүгд хадгаламжаа Монгол төгрөгөөр тооцож үзэхэд 11575000 (5000\$ x 2315₮) төгрөг болж байв. Анх ам.доллар худалдаж авсантайгаа харьцуулахад 1850000 төгрөгөөр мөнгө нь өсжээ.

“Аргагүй л уран бэрийн ухаан байна даа” гэж хэлээд Самбуу өвөө сахлаа шувтарлаа.



6. “БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ БА ВАЛЮТЫН ХАНШ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

6.1. Үнийн өсөлт ба амьжиргааны өртгийн уялдаа холбоо

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаан, үнийн өсөлт амьжиргааны өртөгт хэрхэн нөлөөлдгийг тооцоолж сурах, урьдчилан сэргийлэх чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Инфляци, мөнгөний худалдан авах чадвар, зардлын таналт, сагсны бараа бүтээгдэхүүн

Хэрэглэгдэхүүн:

Инфляцийн өсөлт төгрөгийн худалдан авалтын хамаарлыг харуулсан үзүүлэн таниулах материал (талхны жишээн дээр), сагсны бараа, бүтээгдэхүүний жагсаалт, Гарьдын хадгаламж дээр хийсэн тооцоолол, багийн ажлын цаас, цаасны маркер.

Сургалтын арга:

Тооцоолон бодох, зардал танах, бүлгээр ажиллах

Сургалтын арга зүй:

Инфляцийн өсөлт, амьжиргааны өртгийн уялдаа холбоог сайтар ойлгуулахын тулд дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдад “Бараа, бүтээгдэгдэхүүний үнийн өсөлт төгрөгийн худалдан авалтад эерэг нөлөөтэй юу, сөрөг нөлөөтэй юу?” гэсэн асуултыг тавина. “Эерэг нөлөөтэй” гэсэн хариулт бараг гарахгүй бөгөөд “сөрөг нөлөөтэй” гэсэн хариулт дийлэнх байвал тэрхүү сөрөг нөлөөг “төгрөгийн худалдан авах чадвар буурах” гэж хэлдэг тухай тайлбарлана. Жишээ болгон “Атар” талхны 2016 оны үнийг 1990 онтой харьцуулан зураг 6.2-т харуулсны дагуу төгрөгийн худалдан авах чадварын бууралтыг тайлбарлана. Үүний дараа “Инфляци гэж юу вэ?” гэсэн асуултыг тавина. Хариултуудыг авсны дараа “*Инфляци бол үнийн ерөнхий түвшний өсөлтийг харуулсан үзүүлэлт*” гэсэн тодорхойлолтыг тайлбарлаад зураг 6.1-ийг харуулна.

Алхам 2:

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хувааж инфляцийг хэмжихдээ өргөн хэрэглээний сагсны бараа, бүтээгдэхүүний үнийг өөрчлөлтийн дунджаар тооцдог тухай тайлбарлана. Ийм тайлбар өгсний дараа сагсанд орох бараа, бүтээгдэхүүний жагсаалт гаргах чиглэл өгнө.

Багуудыг 15 минут хэлэлцүүлээд нэгтгэж хэчнээн төрлийн бараа, бүтээгдэхүүн болсон тухай мэдээлээд Улаанбаатар хотын 329, аймгуудын 214 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг 12 бүлгээр харуулдаг тухай тайлбарлана.

(1. Хүнсний бараа, ундаа, ус 2. Сөгтууруулах ундаа, тамхи 3. Хувцас, бөс бараа, гутал 4. Орон сууц, ус, цахилгаан, түлш 5. Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 6. Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ 7. Тээвэр 8. Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 9. Амралт, чөлөөт цаг, соёлын бараа,

үйлчилгээ 10.Боловсролын үйлчилгээ 11.Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 12.Бусад бараа, үйлчилгээ) Энэ жагсаалтыг хэрэглэгдэхүүн болгон урьдчилан бэлтгэсэн байна.

Алхам 3:

Суралцагчдад өмнө нь үзсэн бол сэдэв 4.5-ын хадгаламжийн орлогод инфляцийн түвшин хэрхэн нөлөөлөх тухай тооцооллыг сануулна. Хэрвээ суралцагчид үзээгүй бол тухайн сэдвийн аргачлалаар алхмуудыг товчоноор тайлбарлаж холбогдох тооцоог хамтран хийнэ. Жишээ болгон Гарьдын хадгаламж дээр авсан тооцооллыг харуулна. Үүнийг хэрэглэгдэхүүн болгон урьдчилан бэлтгэсэн байна. Сургалтыг сонирхолтой болгох үүднээс энэхүү сэдвийн таны мэдлэгт мэдээллийг өгнө.

6.2. Валютын ханшийн өөрчлөлт бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Валют гэж юу болох, түүний ханшийн өөрчлөлт бидэнд хэрхэн нөлөөлдгийг ойлгох чадвартай болох, улмаар ханшийн өсөлтийн үед эрсдэл гаргахгүй байх

Хэрэглэгдэх нэр томьёо:

Валют, валютын ханш, валютын эрэлт, нийлүүлэлт, валютын тэмдэглэгээ

Хэрэглэгдэхүүн:

Валютын цахим хэрэглэгдэхүүн /<http://ikon.mn/n/p10/>, ханшны мэдээллийн самбар

Сургалтын арга:

Ханш тооцоолон бодох, зарах, худалдан авах, мэдээлэл олж авах

Сургалтын зохион байгуулалт :

Валютын ханшийн өөрчлөлтийг суралцагчдад хэрхэн нөлөөлдөг талаар тайлбарлахдаа дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдаас валют гэж юу болохыг асуугаад хариултуудад үндэслэн *“Гадаад, дотоод төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа аль нэг улсын мөнгөн тэмдэгтийг валют гэнэ”* гэсэн тодорхойлолтыг өгч зураг 6.4-т харуулсан ангиллыг тайлбарлана.

Монгол улсад “доллар, евро, фунт, юань, рубль, вон, иен” голлох үүрэгтэй валют бөгөөд учир нь тухайн орнуудаас манай улс импортын гол бараа, бүтээгдэхүүн оруулж ирдэг буюу бусдаас илүү харилцаатай байдагтай холбоотой тухай чиглэл өгнө.

Алхам 2:

Суралцагчдаас валютын ханш гэж юу болохыг асуугаад *“Валютын ханш бол аль нэг улсын валютыг өөр нэг улсын валютаар илэрхийлсэн үнэ юм”* гэсэн тодорхойлолтыг өгнө. Валютын ханш эрэлт, нийлүүлэлтээсээ хамаарч тогтмол өөрчлөгдөж байдаг бөгөөд тухайн улсын төв банк албан ханшийг тогтоодог тухай зураг 6.5-д харуулснаар тайлбарлана.

Алхам 3:

“Валютын ханшийн өөрчлөлт та нарын амьдралд хэрхэн нөлөөлөх вэ?” гэсэн асуултыг суралцагчдад нийтэд нь тавьж хэлэлцүүлнэ. Үүний дараа

хүснэгт 6.1-д илэрхийлсэн бараа, бүтээгдэхүүний үнэ, төгрөгийн худалдан авах чадварт валютын ханш хэрхэн нөлөөлдөг тухайд элсэн чихрийн жишээн дээр тайлбарлана. Валютын ханшийн өсөлт нь түүгээр худалдан авдаг бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлөхөөс гадна түлш, шатахууны үнэд нөлөөлж, цаашид бусад валютаар худалдан авдаггүй бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлдөг дам нөлөө байдаг тухай тайлбарлана. Эсрэгээрээ зарим тохиолдолд валютын хадгаламжтай хүнд валютын ханшийн өсөлт ашигтай байх тохиолдол байхыг тайлбарлана. Ийм тохиолдлын жишээ болгон “Уран бэрийн ухаан” хэсгийн үйл явц, тооцоолол, үр дүнг суралцагчдад тайлбарлаж өгнө.

Нэмэлт мэдээлэл:

Монгол банкнаас гаргадаг валютын албан ханшны мэдээлэл, түүнийг хэрхэн олж авах талаар мэдээллийг болон www.mongolbank.mn/ арилжааны банк бүрийн ханш, валют арилжааны захын мэдээллийг хэрхэн авах тухай танилцуулна. Мөн валютын ханшны хэт их өсөлтийн үед Монгол банкнаас ямар зохицуулалт хийдэг тухай ярилцаж болно.

Анхаарах зүйл:

“Хэдийгээр хүн өдөр тутмын амьдралдаа гадаад валют хэрэглэдэггүй, үнэ ханшийг нь мэддэггүй ч дам байдлаар түүний өөрчлөлтөөс хамаарч байдаг, хуримтлал, хадгаламж зэрэгт нөлөөлдөг учраас мэдээллийн утгаар ч болтугай сонирхож байх шаардлагатай” гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Зах зээлийн нийгэмд мэдээлэл өөрөө мөнгө болдог билээ.

СЭДЭВ 7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МӨНГӨӨ ӨСГӨХ АРГА

7.1. Хөрөнгө оруулалтын зорилго, төрөл

Хөрөнгө оруулалт гэдэг нь ашиг олох, хөрөнгөө өсгөх зорилгоор тодорхой нэг хөрөнгөд мөнгөө байршуулахыг хэлнэ. Хөрөнгө оруулагчид зорилгодоо хүрч хөрөнгийнхөө үнэ цэнийг өсгөж, ашиг олох боломж байдаг хэдий ч хөрөнгө оруулалт нь ашиггүй болж, хөрөнгө нь үнэ цэнээ алдах тохиолдол ч цөөнгүй бий.

Юунд хөрөнгө оруулж болох вэ?

Хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө, банкны хадгаламж зэргээр хөрөнгө оруулалтын олон хувилбар бий. Эдгээр нь бүгд өөр өөрсдийн давуу болон сул талтай.

Хөрөнгө оруулалт хийхэд хэр их мөнгө хэрэгтэй вэ?

Хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай хөрөнгийн доод хэмжээ гэж байхгүй. Жишээлбэл, та 5000 төгрөгтэй бол 100 төгрөгний үнэтэй 50 хувьцаа авах боломжтой.

Танд сонирхуулахад

Үнэт цаас, хувьцааны талаар ойлголтгүй байсан нь олон хүний хувьд цэнхэр, ягаан тасалбараа будаа, гурил, эсгий гутлаар солиход хүргэжээ. Дахиад тэдний алдааг давтах хэрэггүй. 1992 онд Монгол Улсын 1.1 сая иргэнд 475 улсын үйлдвэрийн газрыг цэнхэр, ягаан тасалбараар эн тэнцүүхэн хувьчилж өгсөн. Гэтэл энэ хөрөнгө Монгол Улсын нийт хүн амын 1 хувь хүрэхгүй хүний гарт төвлөрч байна гэвэл та итгэх үү? Үнэндээ бол тийм.

Хувьцааны ашиг тусыг мэддэг хүмүүс хувьцаа цуглуулж, харин мэддэггүй нь сольж, зарж үгүй хийсэн. Ерээд онд ийм л юм болсон. Ихэнх хүмүүс үнэт цаасны зах зээл гэж юу болох, хувьцаа ямар ашиг тустай болох талаар ойлголтгүйгээсээ болж хөрөнгө оруулалтын эрхийн бичиг болох цэнхэр, ягаан тасалбараа ашиглаж чадаагүй. Иймээс үнэт цаасны зах зээл, хувьцааны талаар ойлголттой болох хэрэгтэй.

7.2. Хувьцааны хөрөнгө оруулалт

Хувьцаа нь компанийн тодорхой хэсгийг эзэмших эрх юм. Жишээлбэл, та нийт 10,000 ширхэг хувьцаатай компанийн 100 ширхэг хувьцааг эзэмшдэг гэвэл тэр компанийн 1%-н эзэн гэсэн үг.

Хувьцаанд хөрөнгө оруулах нь дараах давуу талуудтай. Үүнд:

- **Хувьцааны үнэ цэнэ өсөх.**

Таны авсан хувьцаа анх худалдаж авсан үнээсээ өсөх боломжтой.

- **Ногдол ашиг хүртэх.**

Ногдол ашиг гэдэг нь компани тухайн жилд олсон ашгаа хувьцаа эзэмшигчиддээ тараахыг хэлдэг. Компани ашгаа тараахын оронд шинэ тоног төхөөрөмж худалдаж

авах, үйлдвэрлэлээ өргөтгөх зэргээр дотооддоо ашиглаж болох тул компани жил бүр ногдол ашиг тараахгүй байж болно.

- **Хөрвөх чадвар сайн.**

Танд бэлэн мөнгө хэрэгтэй болсон үед хувьцаагаа худалдаад түргэн бэлэн мөнгөтэй болох боломжтой ч зарим компанийн хувьцаа түргэн, зарим нь удаан зарагддаг гэдгийг анхаараарай.

- **Саналын эрх.**

Та эзэмшиж буй хувьцааныхаа тоотой тэнцүү хэмжээгээр компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /удирдлагад хяналт тавих зөвлөл/-ийг сонгоход санал өгөх эрхтэй.

Таны танин мэдэхүйд

Хөгжилтэй орнуудын хүн амын 45-80 % нь хувьцааны талаар мэдлэгтэй. Харин манай улсын хувьд хүн амын 12 орчим % нь л хувьцааны талаар ойлголттой байна.⁵

Хувьцаанд хөрөнгө оруулах нь дараах сул талуудтай. Үүнд:

- **Хөрөнгө үнэ цэнээ алдах**

Хувьцааны үнэ цэнэ өсч буурах байнгын хэлбэлзэлтэй байдаг. Хэрэв компанийн үйл ажиллагаа муудвал, компанийн хувьцааны үнэ цэнэ буурна. Хамгийн муугаар бодоход, компани дампуурвал тухайн компанийн бусдад төлөх өр төлбөрийг бүрэн төлсний дараа үлдсэн хөрөнгийг хувьцаа эзэмшигчид хувааж авдаг. Иймээс хөрөнгө бүрэн үнэгүйдэх ч тохиолдол гарч болно.

- **Удаан хугацааны хүлээлт**

Ихэнх хувьцаа удаан хугацаанд өгөөжөө өгдөг тул ашиг хүртэхийн тулд хувьцаагаа хэдэн жил хадгалах хэрэгтэй болдог. Мөн мэргэжлийн бус хүний зөвлөгөө, ам дамжсан яриан дээр үндэслэж хөрөнгө оруулах нь өндөр эрсдэлтэйг анхаараарай.

Таны мэдлэгт

“Сүү” ХК-ийн хувьцаа гэхэд л 2008 оны 11-р сарын 27-ны өдөр 1000 төгрөгийн үнэтэй байсан бол 2016 оны 06-р сарын 10-ны өдөр 145000 төгрөгөөр үнэлэгдэж өнгөрсөн 8 жилийн хугацаанд 145 дахин өссөн байна. Уг хувьцааны жил тутмын өгөөж нь ойролцоогоор 86 орчим хувь байсан байна. Энэ нь банкны хадгаламжийн хүүнээс даруй 5-6 дахин их байгаа юм. “Сүү” ХК 2008 оноос үйлдвэрийн шинэ шугам ашиглалтад оруулж хүчин чадал, бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмсэнээр хувьцааных нь ханш ийнхүү өссөн байна. Хувьцаагаар хэрхэн мөнгө хийж болохыг энэхүү жишээ харуулж байна. Гэхдээ хувьцаатай болмогц мөнгө асгарах юм шиг ойлгож болохгүй. Ашиг их бол эрсдэл их гэдгийг хэзээ ч мартаж болохгүй.

Давуу эрхийн хувьцаа

Давуу эрхийн хувьцаа бол энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос өмнө ногдол ашиг хүртэх эрхийг эзэмшигчдээ олгодог хувьцааны нэг төрөл юм. Ногдол ашиг гэдэг нь компани тухайн жилд олсон ашгаа хувьцаа эзэмшигчиддээ тараахыг хэлдэг.

⁵ Стандарт Инвестмент ХХК, (2011) Хувьцааны цагаан толгой, Улаанбаатар, Монгол Улс, 11-р нүүр.

“Мэдлэгт дусал нэмэр”

УИХ-ын 2010 оны 39-р тогтоол, 2012 оны 18-р тогтоол болон Засгийн газрын 2011 оны 3-р сарын 31-ний өдрийн 98-р тогтоол, 2012 оны 4-р сарын 11-ний өдрийн 116-р тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 20 хуртэлх хувийг 2012 оны 4-р сарын 11-нээс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр болсон. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын 2.7 сая иргэн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаанаас тус бүр 1072 ширхэгийг эзэмших эрхтэй.

Таны эзэмшиж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцаа нь энгийн хувьцаа юм. Харин “Хүний хөгжлийн сангийн тухай” хуульд зааснаар иргэн бүр “Эрдэнэс МГЛ” компанийн нэг ширхэг давуу эрхийн хувьцааг эзэмшинэ. Энэхүү үйл ажиллагааг Монгол Улсын засгийн газрын 2012 оны 06-р сарын 25-ны өдрийн 218 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Уг тогтоолоор хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй иргэн бүр нэг ширхэг давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй. Харин давуу эрхийн хувьцааг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах, өв залгамжлах нь хуулиар хориотой. Мөн тухайн хүн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмших эрх нь дуусгавар болно.

Хүснэгт 7.1. Энгийн болон давуу эрхийн хувьцааны ялгаа

Энгийн хувьцаа	Давуу эрхийн хувьцаа
• Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхтэй.	• Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхгүй.
• Ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд авна.	• Тогтмол хэмжээний ногдол ашиг олгоно.
• Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг тараасны дараагийн ээлжинд ногдол ашгаа авна.	• Эхний ээлжинд ногдол ашиг авна.
• Ногдол ашиг олгоогүй үед компани нөхөн олгох үүрэг хүлээхгүй.	• Олгоогүй ногдол ашиг компанийн хувьд өр хэлбэрээр бүртгэгдэх учир заавал нөхөн олгоно.
• Компани дампуурснаас хөрөнгө хуваарилах тохиолдолд зээлдүүлэгчид, давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн дараа авна.	• Компани дампуурснаас хөрөнгө хуваарилах тохиолдолд зээлдүүдэгчийн дараа хөрөнгөө авна.
• Компанийн үйл ажиллагааны ашиг алдагдал нь ногдол ашиг авах эсэхэд шууд нөлөөлнө.	• Компанийн үйл ажиллагааны ашиг алдагдал бараг нөлөөлдөггүй. Учир нь ногдол ашгаа тогтмол авах нөхцөлтэй.
• Хувьцааны ханшийн өсөлт бууралт хувьцаа эзэмшигчдийн орлогод шууд нөлөөлнө.	• Энгийн хувьцааны ханшийн өөрчлөлт давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд нөлөөлөхгүй.

7.3. Бонд буюу өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалт

Бонд гэж бусдад зээл олгосныг баталгаажуулсан үнэт цаас юм. Өөрөөр хэлбэл, та компанийн эсвэл Засгийн газрын бонд худалдаж авсан бол та компани, Засгийн газарт мөнгөө зээлүүлсэн гэсэн үг.

Таны мөнгийг зээлснийхээ төлөө бонд гаргагч нь тогтмол хүү төлөх ба заасан хугацааны дараа анх зээлсэн мөнгөө /нэрлэсэн үнэ гэх/ эргүүлэн төлөх зарчимтай.

Жишээлбэл, та 10,000 төгрөгний нэрлэсэн үнэтэй, жилд 5%-ийн хүүтэй 10 жилийн хугацаатай Засгийн газрын бонд худалдаж авсан гэвэл жил бүр 500 төгрөгийн хүү, 10 жилийн дараа анх зээлсэн 10,000 төгрөгөө эргүүлэн авна гэсэн үг.

Бондын давуу тал?

- Хугацаа тутамд тогтмол хүүгээр төлбөр төлөгдөж, тогтмол орлого олох зарчимтай.
- Засгийн газрын бонд нь хамгийн эрсдэл багатай.
- Компанийн бонд нь хувьцаатай харьцуулбал эрсдэл багатай, учир нь компани дампуурах тохиолдолд мөнгөө тэргүүн ээлжинд нэхэмжлэх эрхтэй.

Бондын сул тал?

- Эрсдэл бага байгаагийн хирээр ашиг нь бага. Компани маш өндөр ашигтай ажилласан ч тогтсон хэмжээгээр хүү төлнө.
- Компанид хувь эзэмшихгүй.
- Зөвхөн анх заасан хугацаанд эзэмшинэ.

Хүснэгт 7.2. Хувьцаа бондын ялгаа

Хувьцаа	Бонд
Компани гаргадаг.	Засгийн газар, компани гаргадаг.
Эргүүлж төлөх нөхцөлгүй хөрөнгө оруулалт. Гэхдээ бусдад зарж болно.	Тодорхой хугацааны дараа эргүүлж төлнө. Хугацаа дуусахаас өмнө бусдад зарж болно.
Эзэмшигч нь хувь эзэмшилдээ оногдох ногдол ашиг авна.	Эзэмшигч нь зээлсэн дүн буюу өөрөөр хэлбэл нэрлэсэн үнээс тооцож хүү авна.
Хувьцааны ногдол ашиг компанийн ашигт ажиллагаанаас хамаарах тул тогтмол биш байж болно.	Компанийн ашиг алдагдлаас үл хамааран анх тогтоосон хүүг тогтмол дүнгээр авна.
Хөрвөх чадвар сайтай. Хоёрдогч зах зээл дээр арилжаалагддаг.	Хөрвөх чадвар хувьцаанаас сул. Гэхдээ хүссэн үедээ хоёрдогч зах зээл дээр арилжиж болно.
Компани оршин тогтнох бүх л хугацаанд хүчин төгөлдөр.	Зээлийн хугацаанд хүчин төгөлдөр.
Компани дампуурвал хувьцаа эзэмшигчид өөрт ногдох хөрөнгийг компанийн бүх өр төлбөр, зээлийг барагдуулж дууссаны дараа авна.	Компани дампуурвал зээл олгогчид өөрийн зээлдүүлсэн хөрөнгийг хүүгийн хамт хамгийн түрүүнд авна.
Үнийн өөрчлөлт их.	Үнийн өөрчлөлт бага.
Ашиг өндөр бөгөөд эрсдэл их.	Ашиг бага бөгөөд эрсдэл бага.

Таны сонорт

Монголын анхны өрийн бичиг “Бага болзоот”-ыг 100 ам.долларын нэрлэсэн үнэтэй, жилийн 6 хувийн хүүтэй, олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны арван сарын хорин хүртэл хугацаагаар гаргаж байжээ. 1950 онд Сангийн яамнаас урьд гаргагдсан бүх зээллэгээ нэгтгэн 20 жилийн хугацаатай нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800000 ширхэг өрийн бичгийг гаргасан байдаг. Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойшхи хугацаанд Засгийн газраас хэд хэдэн удаа өрийн үнэт цаас гаргаж дотоод болон олон улсын зах зээл дээр арилжаалсан байна. Үүнд Хөгжлийн банкны Евро бонд, Засгийн газрын Чингис бонд, Самурай бонд гэх мэт.

7.4. Хөрөнгө оруулалтын эрсдэл ба өгөөж

Хөрөнгө оруулагч бүрийн эцсийн зорилго нь ашиг олох явдал байдаг. Зарим хүмүүс өндөр эрсдэлтэйгээр их ашиг олохыг хүсдэг бол зарим нь эрсдэл багатайгаар тогтмол ашиг олохыг эрмэлздэг. Иймд юунд хөрөнгө оруулахаа шийдэхдээ хөрөнгө оруулалтын зорилго, эрсдэл даах чадварт нийцүүлэх хэрэгтэй. Эрсдэл даах чадвар нь хувь хүний онцлогоос шалтгаалан хүн бүрт өөр өөр байдаг. Тухайн хүний нас, санхүүгийн чадвар, эрхэлдэг ажил, одоогийн орлогын хэмжээ, цаашид орлого олох чадвар зэрэг олон хүчин зүйл хөрөнгө оруулалтын эрсдэл даах чадварыг тодорхойлдог. Жишээлбэл, дөнгөж ажлын гараагаа эхэлж буй өсөх ирээдүйтэй залуу хүн эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийхэд алдагдал хүлээсэн ч цаашид хөрөнгөө нөхөх, өсгөх хангалттай хугацаа бий. Тийм учраас эрсдэл даах чадвар өндөр байна. Бэл бэнчин ихтэй хүн эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийгээд хөрөнгийн үнэ цэнээ алдсан ч бусад хөрөнгөөрөө амьдралаа авч явах боломжтой тул эрсдэл даах чадвар бас өндөр байна. Харин хурааж хуримтлуулсан хөрөнгөөрөө амьдарч буй өндөр настай хүмүүс бүх хөрөнгөө эрсдэлтэй хөрөнгөд байршуулах нь зөв шийдвэр биш. Учир нь хөрөнгийн үнэ цэнэ буурах тусам тухайн хүний ирээдүйд амьдралаа авч явах орлого нь багасч байгаа учраас хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хувилбарт дийлэнх хөрөнгөө байршуулах нь зүйтэй байна. Ерөнхийдөө, тухайн хүний нас залуу, хөрөнгө бэл их, тогтмол орлого их, санхүүгийн хэрэгцээ /тухайлбал, хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн төлбөр гэх мэт/ бага байх тусмаа эрсдэл даах чадвар өндөр байна. Эсрэгээр нас өндөр, хөрөнгө хуримтлал багатай, санхүүгийн хэрэгцээ ихтэй, тогтмол орлого бага байх тусмаа эрсдэл даах чадвар бага буюу аль болох болгоомжтой хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй юм.


Доорх зурагт үзүүлсэнчлэн, хөрөнгө оруулалтын эрсдэл ба өгөөж урвуу хамааралтай байдаг. Эрсдэл ихтэй байх тусмаа өндөр өгөөж хүртэх магадлал ихтэй бас алдагдал хүлээх магадлал ихтэй. Эсрэгээр, эрсдэл багатай буюу найдвартай хөрөнгө оруулалт байх тусмаа олох ашиг нь бага, мөн алдагдал хүлээх нь харьцангуй бага байдаг.

Хөрөнгө оруулалтын хамгийн түгээмэл хэлбэрүүдийг хамгийн бага эрсдэлтэйгээс нь жагсаавал:

1. Засгийн газрын бонд
2. Банкны хадгаламж
3. Компанийн бонд
4. Үл хөдлөх хөрөнгө
5. Компанийн хувьцаа

6. Гарааны бизнес, үүсмэл үнэт цаас гэх мэт бусад төрлийн хөрөнгө оруулалт орно.

Зураг. Хөрөнгө оруулалтын төрөл, тэдгээрийн эрсдэл ба өгөөжийн ерөнхий түвшин




Гэхдээ та хувьцаа, бонд, хадгаламж, үл хөдлөх хөрөнгө зэргээр өөр, олон төрлийн хөрөнгүүдэд хөрөнгөө тараан байршуулах замаар хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулж болно.

Хөрөнгөө тараан байршуулах гэдэг нь бүх мөнгөөрөө нэг төрлийн хөрөнгө худалдаж авахгүйгээр, олон төрлийн хөрөнгөд мөнгөө хувааж хөрөнгө оруулахыг хэлдэг. Жишээлбэл, та хувьцаа худалдаж авах гэж байгаа бол бүх мөнгөөрөө нэг компанийн хувьцаа авснаас өөр өөр салбарт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн компанийн хувьцаа худалдаж авахыг тараан байршуулалт гэдэг. Ингэснээр нэг компанийн хувьцааны үнэ буурах үед нөгөө компанийнх өсөх байдлаар таны нийт хөрөнгө оруулалтын үнэ цэнэ огцом унах эрсдэл буурна.

Хөрөнгө оруулагчид ийнхүү хөрөнгө оруулалтын эрсдлээ тараан байршуулж, өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хэд хэдэн төрлийн хөрөнгөөс бүрдэх **хөрөнгө оруулалтын багц** үүсгэж болно. Багцад орох хөрөнгө оруулалтын төрөл болон хэмжээг сонгохдоо хувь хүний эрсдэл хүлээх чадвар, хүсч буй өгөөжийн түвшин, хөрөнгө оруулалтын хугацаа зэрэг хүчин зүйлийг харгалзан дараах зурагт үзүүлсэн байдлаар үүсгэж болно.

Зураг. Хөрөнгө оруулагчийн хэв шинжээс хамаарсан багц бүрдүүлэлтийн жишээ



Та хөрөнгө оруулах үнэт цаасаа сонгохдоо аль болох олон төрлийн мэдээлэл, судалгаанд үндэслэн хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах хэрэгтэй.

Хөрөнгө оруулах компани сонгохдоо хамгийн түрүүнд тус компанийн үйл ажиллагаа явуулж буй салбар, зах зээл өсч томрох боломжтой эсэх, тухайн компанийн өрсөлдөгчид нь зах зээлд хэр хүчтэй байр сууриа олсон компаниуд байдаг, тухайн компани өсч томрох боломж байгаа эсэх, компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь ирээдүйд хэр их эрэлттэй байх, улмаар орлогоо нэмэгдүүлэх боломж байгаа эсэх, компанийн удирдлагууд нь хэр туршлагатай, зах зээлээ мэддэг хүмүүс байгаа, одоогийн орлого, ашгийн түвшин ямар байгаа зэрэг суурь хүчин зүйлүүдийг мэдэж судлахаас эхлэх нь зүйтэй юм. Мэргэжлийн бус хүний зөвлөгөө, ам дамжсан яриан дээр үндэслэж хөрөнгө оруулах нь мөрийтэй тоглохтой адил гэдгийг анхаарч болгоомжлох нь зүйтэй.

Дээр дурьдсан хүчин зүйлүүдийг судлахаас гадна, Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан компаниудад хандан зөвлөгөө авч үйлчлүүлэх боломжтой юм.

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа дараах төрлийн мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглаж болно. Үүнд:

Хүснэгт 7.3. Үнэт цаасны талаарх мэдээллийн эх сурвалжууд⁶

№	Мэдээллийн эх сурвалж	Тайлбар
	Интернэт	Та үнэт цаасны үнэ ханш, арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл болон үнэт цаас гаргагчтай холбоотой мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn хуудаснаас, мөн тухайн үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын одоогийн болон цаашдын хандлага, өрсөлдөөн, банкны хадгаламжийн хүү зэрэг мэдээллийг интернетийн баталгаат бусад эх үүсвэрээс олж авах боломжтой. (Үнэт цаасны арилжааны мэдээллийн тайлбарыг Хүснэгт 7.4-т үзүүлэв)
	Сонин хэвлэл, мэдээллийн хөтөлбөр	Өдөр тутмын сонин хэвлэл, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн сэтгүүлүүд болон санхүүгийн нэвтрүүлгүүдээс зах зээлийн төлөв байдал, сонгосон үнэт цаасны хамаарах салбарын мэдээлэл болон улс төр нийгмийн байдлын талаарх сүүлийн үеийн мэдээллийг олж мэдэх боломжтой.
	Засгийн газрын тайлан, хэвлэл	Монгол банкны тайлан, Санхүүгийн зохицуулах хорооны тайлан зэрэг нь хөрөнгө оруулагчдад нэн шаардлагатай мэдээллийг агуулдаг.
	Компанийн тайлан	Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид зааснаар хөрөнгийн биржид үнэт цаасаа арилждаг компаниуд нь ашиг орлого, хөрөнгө, өр төлбөр, бүтээгдэхүүн үйлчилгээ, гол хувьцаа эзэмшигчид, удирдлагын багийн бүрэлдэхүүн гэх мэт компанийн үйл ажиллагаатай холбоотой болон хувьцааны үнэд нөлөөлж болох мэдээллээр хөрөнгө оруулагчдыг хангах үүрэгтэй байдаг. Энэхүү мэдээллийг хөрөнгийн биржийн цахим хуудаснаас гадна компанийн цахим хуудсанд нийтлэгдсэн жилийн үйл ажиллагааны тайлангаас олж авах боломжтой.

Хүснэгт 7.4. Хувьцааны арилжааны дэлгэрэнгүй мэдээ

Симбол	Үнэт цаасны нэр	Ширхэг	Үнийн дүн	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Зах зээлийн үнэлгээ	Авах	Зарах	Арилжаа
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
BAN	Багануур	531	1 217 147.00	2 250.00	2 370.00	2 250.00	2 292.00	48 073 233 120.00	2 150.00	2 400.00	Энгийн

Эх сурвалж. Монголын хөрөнгийн бирж, 2016 оны 10-р сарын 20-ны өдрийн арилжаа Тайлбар:

1. МХБ-д бүртгэлтэй Багануур ХК-ийн хувьцааны латин үсгээр илэрхийлэгдсэн код;
2. Үнэт цаас гаргагчкомпанийн нэр;
3. Тухайн өдөр арилжаалагдсан хувьцааны тоо;
4. Арилжигдсан хувьцааны тоог арилжигдсан ханшаар үржүүлсэн дүн буюу тус хувьцааны нийт арилжааны үнийн дүн;
5. Тухайн өдрийн арилжааны нээлтийн ханш. Энэхүү ханш арилжааны өдөр бүр Улаанбаатарын цагаар 09:40-10:00 цагийн хооронд тогтдог;
6. Тухайн өдрийн арилжааны дээд ханш. Өөрөөр хэлбэл, тухайн өдрийн нэгж хувьцааны хамгийн өндөр үнэтэй захиалга 2370 төгрөгөөр биелэгдсэн;
7. Тухайн өдрийн арилжааны доод ханш. Өөрөөр хэлбэл, тухайн өдрийн нэгж хувьцааны хамгийн бага үнэтэй захиалга 2250 төгрөгөөр биелэгдсэн;
8. Тухайн өдрийн арилжааны хаалтын ханш. Энэхүү ханш арилжааны өдөр бүр Улаанбаатарын цагаар 13:00-13:05 цагийн хооронд тогтдог;
9. Бүртгэлтэй хувьцааны тоог нэгж хувьцааны хаалтын ханшаар үржүүлсэн дүн буюу 2016 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаарх Багануур ХК-ийн үнэлгээ;
10. Тус үнэт цаасыг худалдан авахаар өгсөн захиалгуудын хамгийн боломжит дээд үнэ
11. Тус үнэт цаасыг худалдахаар өгсөн захиалгуудын хамгийн боломжит доод үнэ
12. Хөрөнгийн бирж дээрх арилжаа энгийн болон багцын гэсэн 2 төрөлтэй бөгөөд тус үнэт цаасны арилжаа энгийн хэлбэрээр хийгдсэнийг харуулж байна.

7.5 Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ?

Монголын хөрөнгийн бирж дээр ажлын өдөр бүр өглөө 10:00-13:00 цагийн хооронд үнэт цаасны арилжаа явагддаг бөгөөд та хувьцаа, бонд худалдан авах, худалдах замаар энэхүү арилжаанд оролцох боломжтой. Үнэт цаасны арилжаанд оролцохын тулд та:

- Үнэт цаасны арилжаанд зуучлах үүрэг бүхий үнэт цаасны компани⁷ /брокер/-д хандан үнэт цаасны арилжааны дансаа нээлгэсэн байх шаардлагатай.
- Данс нээлгэсний дараа брокерийн компанидаа үнэт цаас худалдах эсвэл худалдаж авах захиалгаа өгнө.
- Брокер нь таны өгсөн захиалгыг хөрөнгийн биржийн арилжааны системд оруулдаг. Таны захиалгатай үнэ ханш болон тоо хэмжээний хувьд нийцэх захиалга байвал таны захиалга биелэгдэж хэлцэл хийгдэх ба нийцэх захиалга байхгүй тохиолдолд захиалгын санд хадгалагдаж биелэгдэх хүртэл тодорхой хугацаанд хүлээнэ.

Үнэт цаасны компани тус бүрийн харилцагчдад үйлчлэх нөхцөл, тухайлбал үйлчилгээний шимтгэл хураамж, арилжаанд онлайнаар алсаас ордог эсэх, арилжаанд идэвхтэй оролцдог эсэх зэрэг нь харилцан адилгүй байдаг тул үнэт цаасны компанийн сонгохдоо үйлчилгээний нөхцөлийг харьцуулан судлах зайлшгүй шаардлагатай юм. Та үнэт цаасны компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн [цахим хуудас болох www.mse.mn](http://www.mse.mn) хаягийн “Гишүүн компаниуд” хэсгээс авах боломжтой.

⁷ Үнэт цаасны компаниудын мэдээллийг www.mse.mn хуудаснаас авах боломжтой.

7. “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МӨНГӨӨ ӨСГӨХ АРГА” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

7.1. Хөрөнгө оруулалтын зорилго, төрөл

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хөрөнгийг зөв удирдаж, зөв зүйлд хөрөнгө оруулан өсгөж авах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Хөрөнгө, хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын хэрэгсэл, хэлбэр, хөрөнгө оруулалтын эрсдэл, өгөөж, тараан байршуулалт

Хэрэглэгдэхүүн:

Хөрөнгө оруулалтын хэлбэрийн хүснэгт, амжилттай хөрөнгө оруулалтын жишээ онлайн материал, багийн ажлын цаас, цаасны марке.

Сургалтын арга:

Хөрөнгө оруулах, өгөөжийн тооцоолол, хөрөнгө оруулалтын судалгааны арга, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Хөрөнгө оруулалтын талаар суралцагчдын мэдлэг, чадвар ямар байгааг эхлээд “Та хөрөнгөтэй юу?”, “Та өөрөө хөрөнгө оруулалт хийж байсан уу?”, “Та хөрөнгө оруулалт авч байсан уу?” зэрэг цөөн хэдэн асуултаар тандаж мэдэн онол арга зүйн чиглэл өгөх, тэднийг хөрөнгө оруулалт хийж байсан эсэхээр нь 2 бүлэг болгон хуваан өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх арга зүйг баримтлан дараах 4 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Багш “Хөрөнгө гэж юу вэ?” гэсэн гэсэн асуултад хариулж буй хүмүүсийн санаануудыг жагсаан бичээд *“Хөрөнгө бол хувь хүний болон аж ахуйн нэгжийн өмчлөлд буй мөнгөөр хэмжигдэх боломжтой санхүүгийн нөөц юм”* гэсэн тодорхойлолтыг тайлбарлаж өгнө.

Үүний дараа “Хөрөнгө оруулалт хийж байсан уу? гэсэн асуултыг тавьж “тийм, үгүй” гэдгээр нь суралцагчдыг 2 бүлэг болгоод хөрөнгө оруулалтын зорилгын талаар багийн ажил хийлгэнэ. Тайлбарыг сонсоод бүлэг тус бүр зорилгуудыг 10 минутад багтаан бичнэ.

Ингэхдээ “эрсдэл” гэсэн ойлголтыг хэрэглэхийг зорьж хүснэгт 7.1-д үзүүлсэн хөрөнгө оруулалтын эрсдэлийн тухай тайлбарлана. Энэхүү хүснэгтийг үзүүлэн таниулах материал болгон урьдчилан бэлтгэсэн байна. Багш бүлэг тус бүрийн төлөөллийн бичсэн зүйлийг сонсоод хөрөнгө оруулалтын зорилгын талаар тайлбарлана.

Алхам 2 :

Хөрөнгө оруулалтын уламжлалт болон уламжлалт бус хэлбэрийн тухай хүснэгт 7.2-т үзүүлснийг тайлбарлан ярилцана. Энэхүү хүснэгтийг үзүүлэн таниулах материал болгон урьдчилан бэлтгэсэн байна. Энд багшийн чиглүүлэх үүрэг голлоно. Багш боломжтой тайлбаруудыг өөрсдөөр нь гаргуулахыг хичээх хэрэгтэй ч цаг их алдахаар бол өөрөө тайлбарлахаар зохион байгуулах хэрэгтэй.

Уламжлалт бус хөрөнгө оруулалтын шинж чанаруудын тухай уламжлалт хөрөнгө оруулалтын хэлбэрүүдтэй харьцуулан тайлбарлана. Энд хүснэгтээс харахад *“уламжлалт хөрөнгө оруулалтын эрсдэл харьцангуй*

бага, уламжлалт бус хөрөнгө оруулалт нь эрсдэл ихтэй байгаа болон эрсдэлийн хэмжээнээс хамаарч өгөөжийн хэмжээ тодорхойлогдож байгаа” гэсэн дүгнэлтийг суралцагчдаар гаргуулахыг хичээж сургалтыг зохион байгуулна.

Алхам 3 :

Хөрөнгө оруулалтын зорилгоо тодорхойлж, уламжлалт болон уламжлалт бус хөрөнгө оруулалтын аль хэлбэрийг сонгохоо шийдсэн бол шийдвэрт нөлөөлөх дараах хүчин зүйлүүдийг тайлбарлана. Хөрөнгө оруулалт хийхдээ дараах хүчин зүйлүүдийг заавал тооцоолсон байх гэсэн тайлбар хийнэ.

	Хүчин зүйл	Тайлбар
1	Орлогын хүчин зүйл	Эрсдэл багатай хөрөнгө оруулалт тогтвортой орлогын эх үүсвэр болно.
2	Өсөлтийн хүчин зүйл	Хөрөнгө оруулалтын үнэ цэнэ ирээдүйд өсөх үр дүнтэй байдаг.
3	Хөрвөх чадварын хүчин зүйл	Зарим хөрөнгө оруулалт хөрвөх чадварын хувьд харьцангуй сул байдаг.
4	Эрсдэлийн хүчин зүйл	Хөрөнгө оруулалтад инфляцийн, хүүний, зах зээлийн, валютын ханшийн, үйл ажиллагааны гэх зэрэг олон эрсдэлүүд нөлөөлдөг.

Алхам 4 :

Хөрөнгө оруулалт хийхдээ дээрх хүчин зүйлүүдээс эрсдэлийг тусгайлан авч үзэх хэрэгтэй гэсэн чиглэл өгөөд зураг 7.1-д харуулсан эрсдэлийн 4 түвшинг тайлбарлана. “Эрсдэл багатай хөрөнгө оруулалтыг хийх шийдвэрт хүрэх ёстой” гэсэн дүгнэлтийг суралцагчдаар гаргуулах хэрэгтэй.

Мөн эрсдэлийг бууруулах зорилгоор “Бүх өндгөө нэг сагсанд бүү хий” гэсэн зарчмын утга санааг задлан тайлбарлаж үүнийг “тараан байршуулалт” гэж хэлдэг тухай ярилцана.

7.2. Хувьцааны хөрөнгө оруулалт

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хувьцааны хөрөнгө оруулалтыг оновчтой хийж мөнгөө өсгөх чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томъёо:

Хувьцаа, энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа, үнэт цаасны арилжаа

Хэрэглэгдэхүүн:

Цэнхэр, ягаан тасалбарын зураг, хувьцааны ханшийн мэдээллийн самбар, багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Хувьцаа худалдаж авах, худалдан борлуулах, бонд авах, хөрөнгийн биржийн мэдээлэл олж авах, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдаар мэдлэг бүтээлгэх, дүгнэлт гаргуулах арга зүйг баримтлан

дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Суралцагчдыг хувьцаа эзэмшиж байсан эсэхийг асууж бүлэг болгоно. Ихэнх нь хувьцаа эзэмшдэггүй бол насны бүлгээр нь “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хуваана. Ингээд энгийн хувьцаа гэж юу болох талаар бүлэг тус бүрийг 5 минут зөвлөлдүүлнэ. Дунд болон ахмад бүлгийн хүмүүст цэнхэр, ягаан тасалбарын тухай яриа өрнүүлэх байдлаар, харин залуу хүмүүст дэлхийн томоохон хувьцаат компанийн жишээг ярьж хувьцааны тухай хэлэлцүүлгийг эхлүүлнэ.

Багш бүлэг тус бүрээс 1 оролцогчийн “Хувьцаа гэж юу вэ?” гэдгийн хариултыг сонсоод “Хувьцаа бол компанийн дүрмийн сан буюу өөрийн хөрөнгийг бүрдүүлдэг санхүүгийн хэрэгсэл юм” гэсэн тодорхойлолтыг тайлбарлаж өгнө.

Энгийн хувьцаа бол зах зээл дээр нийтэд санал болгож байгаа, саналын эрхтэй хувьцааг хэлнэ” гэсэн тайлбарын өгөөд хөрөнгийн биржийн хувьцааны арилжааны талаар ярилцана. Та хувьцаа эзэмшигч болсноор дараах эрх эдлэх боломжтой тухай тайлбарлана.

Үүнд:

- Компанийн бодлогыг тодорхойлоход оролцож чадна.
- Компанийн ТУЗ-ийг сонгох эрхтэй.
- Ханшийн зөрүүнээс ашиг хүртэнэ.

Үүнтэй холбогдуулан “Таны танин мэдэхүйд” болон “Таны мэдлэгт” хэсгийн “Сүү” ХК-ийн хувьцааны өсөлтийн тухай мэдээллийг өгнө.

Алхам 2:

Суралцагчдад **“Давуу эрхийн хувьцаа гэдэг бол энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос өмнө ногдол ашиг хүртэх эрхийг эзэмшигчдээ олгодог хувьцааны нэг төрөл юм” гэсэн тодорхойлолтыг өгч тайлбарлана. Үүний дараа “Мэдлэгт дусал нэмэр” хэсгийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаанаас хүн тус бүр 1072 ширхгийг эзэмших эрхтэй болсон тухай мэдээлэл өгнө. Улмаар энгийн болон давуу эрхийн хувьцааны ялгааг хүснэгт 7.3-т харуулсныг тайлбарлаж өгнө.**

Алхам 3:

Хэрвээ та хувьцаанд хөрөнгө оруулах сонирхолтой бол дээрх зүйлсийг мэдэхийн зэрэгцээ хувьцааны арилжааны тухай юу мэдэх ёстой тухай хүснэгт 7.4 болон түүний тайлбар, арилжааны мэдээллийг олж авах эх сурвалжуудын тухай хүснэгт 7.5-д буй мэдээллийн тайлбарыг өгч холбогдох зөвлөгөөг өгөх хэрэгтэй. Мөн үүнтэй холбоотой “Танд сонирхуулахад” булангийн мэдээллийг өгнө.

Нэмэлт мэдээлэл:

Хөрөнгийн бирж, санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны төлбөр тооцооны төв, брокер, дилер, андеррайтерийн компани зэрэг хөрөнгийн зах зээлийн гол байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх хэрэгтэй. Энэ тухай энэхүү номын сэдэв 3.1-д байгаа болно.

Анхаарах зүйл:

Хөрөнгөө хувьцаанд оруулан худалдан авах, зарах үйл явц бол бүхэлдээ хөрөнгийн зах зээлийн талаарх ихээхэн мэдлэг, мэдээлэл, санхүүгийн тооцооллын мэдрэмж шаардсан, эрсдэл ихтэй шийдвэр гэдгийг

суралцагчдад ойлгуулах, гэхдээ хамгийн их өгөөж өгч чадах онцлогтой гэдгийг тайлбарлах хэрэгтэй.

7.3. Бондын хөрөнгө оруулалт

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Бонд худалдан авч хөрөнгөө өсгөх чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томъёо:

Бонд, хувьцаагаа ялгагдах ялгаа, Засгийн газрын үнэт цаас

Хэрэглэгдэхүүн:

Засгийн газрын бонд /цахим хэлбэр/, багийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Тооцоолох, мэдээлэл олж авах, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдаар мэдлэг бүтээлгэх, дүгнэлт гаргуулах арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Суралцагчдыг насны байдлаар “Залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэг болгоод “Бонд гэж юу вэ?” гэсэн асуултыг тавьж бүлгээр 5 минут ажиллуулна. Түүний дараа баг тус бүрийн гаргасан санаануудыг нэгтгэн “Тодорхой хэмжээний мөнгийг хүүтэйгээр эргүүлэн төлөхөөр Засгийн газраас бичгээр гаргасан баталгааг засгийн газрын бонд гэнэ” гэсэн тодорхойлолтыг тайлбарлана.

Мөн багш компанийн бонд гэж байх бөгөөд түүний богино, дунд, урт хугацааны гэдгийг ялгааг тайлбарлаж өгнө. Бонд худалдан авахын ач холбогдлыг компанийн бондын жишээндээр тайлбарлаад хөрөнгө оруулагч ямар шалтгаан, нөхцөлд бонд худалдан авдаг тухай тайлбарлана.

Алхам 2 :

“Хувьцаа”, “бонд” хоёр ямар ялгаатай талаар 3 бүлэг тус бүрээр 5 минут ярилцуулаад багш хүснэгт 7.6-д үзүүлсэн ялгаануудыг тайлбарлан хэлж чадаагүйг нь хэлж чиглүүлж өгнө. Дараа нь бондыг “хөрвөх бонд, индексжүүлсэн бонд, хөвөгч хүүтэй бонд, хүүгүй бонд, орлогын бонд, евро бонд” гэх мэтээр ангилдаг тухай, бондын төрөл тус бүрийн товч тайлбарыг хийнэ.

Алхам 3 :

Бүлэг тус бүрээс “Засгийн газрын бондын арилжааны тухай мэдээлэл авч байсан уу?” хэмээн асуугаад бүлэг бүрээс нэг оролцогч сонгон хэзээ, ямар бонд худалдсан тухай мэдээлэл сонсож байсныг яриулна.

Багш Засгийн газрын бондын арилжаа “Өрийн удирдлагын хууль”-ийн дагуу зохицуулагдсан байдаг тухай чиглүүлэг өгч үүнтэй холбоотой бонд гаргах шаардлагуудыг тайлбарлаж өгнө. Засгийн газар бондоос гадна төсвийн түр зуурын дутагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дараах Засгийн газрын үнэт цааснууд гаргадаг тухай мэдээлэл өгнө.

Үүнд:

	Засгийн газрын үнэт цаас	Тайлбар
1	Засгийн газрын вексель	Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жил ба түүнээс богино хугацаатай өрийн бичиг
2	Засгийн газрын дунд хугацааны өрийн бичиг	Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жилээс дээш, 10 жилээс доош хугацаатай өрийн бичиг
3	Засгийн газрын бонд	Засгийн газраас гаргасан 10-30 жилийн хугацаатай өрийн бичиг
4	Орон нутгийн бонд	Орон нутгийн засаг захиргаанаас гаргасан өрийн бичиг

Засгийн газрын бондтой холбоотой “Таны сонорт” мэдээллийг өгнө.

Нэмэлт мэдээлэл :

Засгийн газрын үнэт цаасны арилжааны схем, арилжааны журам, үр дүнгийн талаарх <https://www.mongolbank.mn/governmentbond/> хэсэгт байдаг мэдээллийг танилцуулна.

Анхаарах зүйл:

Засгийн газар хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ЗГ-ын бонд бол хэдийгээр хүү багатай ч эрсдэл багатай аргаар хөрөнгөө өсгөх боломж гэдэг талаас нь суралцагчдад тайлбарлах хэрэгтэй.

7.4. Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах нь

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Инфляцийн эрсдэлийг даван туулах болон хөрөнгөө өсгөх зорилгоор үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн зууч, хязгаарлагдмал нөхөрлөл, үл хөдлөх хөрөнгийн синдикат, үл хөдлөх хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан, моргейж, моргейжийн санд оруулах хөрөнгө оруулалт

Хэрэглэгдэхүүн:

Үл хөдлөх хөрөнгийн зураг, бүлгийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Үл хөдлөх хөрөнгийн судалгаа, шинжилгээ, ханшийн өөрчлөлтийг тооцох, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдад багш чиглүүлэг өгөх, мэдлэг бүтээлгэх, дүгнэлт гаргуулах арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Суралцагчдад “Үл хөдлөх хөрөнгө гэж юу вэ?” гэсэн асуултыг асуугаад суудлаар нь 2 бүлэгт хувааж бүлэг тус бүрээр жагсаалт гаргуулна. Гаргасан жагсаалтыг багш баяжуулан “газар болон түүнд суурилуулан бий болгосон орон сууц, байгууламжийг үл хөдлөх хөрөнгө” гэдэг тухай, **үл хөдлөх хөрөнгийг дараах байдлаар ангилдаг тухай тайлбарлана.** Үүнд:

Д/д	Үл хөдлөхийн зориулалт	Үл хөдлөх хөрөнгийн төрөл
1	Иргэний болон үйлчилгээний нийтийн болон тухайлсан орон сууц	Орон сууцны орц, Орцны давхрууд Давхрын нэг айл, айлын доторх өрөө тасалгаа Зуслангийн байр Дэд бүтцийн барилга байгууламж
2	Байгууламж	Зам талбай бие даасан инженерийн шугам сүлжээ ногоон байгууламж Барилгын давхар өрөө тасалгаа цех тасаг

Алхам 2 :

Суралцагчдаас “Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулахын давуу тал болон сул тал юу вэ?” гэсэн асуултыг асуугаад тэднийг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хувааж бүлгээр ажиллуулж жагсаалт гаргуулна. Тэдний гаргасан санаануудыг нэгтгээд хүснэгт 7.7-д харуулсан давуу болон сул талуудыг тайлбарлаж ярилцана.

Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах дараах ач холбогдолтой гэдгийг тайлбарлана.

Үүнд:

- Мөнгөө үл хөдлөх хөрөнгө болгох нь инфляцийн эсрэг сайн хамгаалалт болдог
- Орон сууцыг өөрсдөө амьдарч болно, түрээсэлж ашиг олж болдог
- Байгууламжийг үнэ өсгөн зарж эсвэл түрээсэлж болно.

Шууд замаар газар, орон, байгууламж сууц худалдан авахгүй ч хязгаарлагдмал нөхөрлөл, үл хөдлөх хөрөнгийн синдикат, үл хөдлөх хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан, моргейж, моргейжийн санд оруулах хөрөнгө оруулалт хийх арга замууд байгаа тухай багш тайлбар хийнэ.

Нэмэлт мэдээлэл:

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн тухай, үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай, барьцааны тухай, бүртгэлийн тухай ерөнхий мэдээлэл өгөх хэрэгтэй.

Анхаарах зүйл:

Суралцагчдад үл хөдлөх хөрөнгө бол хэдийгээр инфляцийн хамгаалалт болдог ч хөрвөхдөө муу, үнэлгээ нь унах, хуучирч муудах зэрэг эрсдэлтэй тул шийдвэр гаргахдаа сайтар тооцоолох, мэдээлэлтэй байх, мэдрэмжтэй байхыг шаарддаг гэдгийг анхааруулах хэрэгтэй. Энэ нь бэлэн мөнгө биш учраас (зарахаас нааш хөдөлгөөн хийж болдоггүй) харьцангуй хөдөлгөөн муу хөрөнгө оруулалт гэдгийг сануулах хэрэгтэй.

СЭДЭВ 8. ЭРСДЭЛ БА ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙН ХАМГААЛАЛТ

“Гай газар доороос гахай модон дотроос”
/Монгол ардын зүйр үг/

8.1. Эрсдэлийн тухай ойлголт, төрөл

Хүн оршин буй газар бүрд эрсдэл байдаг. Бид өдөр бүр эрсдэлтэй нүүр тулдаг. Тухайлбал, эд зүйлээ гээх, хулгайд алдах, халтирч унах гэх мэт. Дэлхийн эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг, хууль эрх зүйн тогтворгүй орчин, валютын ханшийн хэлбэлзэл, бүтээгдэхүүний үнийн өсөлт, зээлийн хүүний өсөлт гэх зэрэг олон хүчин зүйл эрсдэл үүсэхэд нөлөөлдөг. Хүмүүс эрсдэлийг тодорхойлж, төлөөлүүлж ярихдаа аюул, заналхийлэл, магадлал, үр дагавар, сөрөг үр нөлөө, алдагдал, хор хохирол, зарим тохиолдолд боломж гэж авч үздэг. Гэвч эдгээр нь эрсдэлийг дангаараа төлөөлөхгүй, харин эрсдэлийн тодорхой шинжийг агуулж байгаа юм.

Хүн өмнөө тавьсан зорилгодоо хүрэх нь амаргүй бөгөөд олон саад бэрхшээл, эрсдэлд нөхцөлтэй тулгардаг. Хүн зорилгодоо хүрэхийн тулд учирч болох эрсдэлийг тодорхойлж, түүнд тохирсон арга хэмжээг авах шаардлагатай. Эрсдэл үүсгэх, бий болгох ямарваа нэг зүйл, үйлдэл болон үйл ажиллагаанаас боломжтой бол татгалзах, зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах нь чухал.

Эрсдэл бол тодорхой бус байдал буюу урьдчилан тооцоолоогүй зүйл. Санхүүгийн үүднээс авч үзвэл, эрсдэл нь хувь хүнд учирч болзошгүй гарз, хохирол бөгөөд орлогын түвшний хэлбэлзэл буюу оруулсан хөрөнгөө алдах магадлал. Эрсдэл бол гадаад, дотоод орчны зүгээс хувь хүн, байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх тааламжгүй нөлөөлөл мөн. Жишээ нь, машины дугуй хэзээ хагарахыг жолооч мэддэггүй. Зам дээр хэн нэгний санамсаргүй хаясан хадаас машины дугуйг хагалах нь гадаад сөрөг хүчин зүйл болно. Үүний улмаас авто машинд эрсдэл учирна.

Хүснэгт 8.1. Эрсдэлийн шинж чанар

№	Эрсдэлийн шинж чанар	Тайлбар
1	Тодорхой бус байдаг.	Эрсдэлийг урьдчилан тодорхойлох боломж хомс. Хэзээ, хаана, ямар хэмжээний эрсдэл учрахыг өнөөдөр яг тодорхой тооцоход хэцүү байдаг.
2	Хор хохирол дагуулдаг.	Эрсдэл тохиолдсон этгээд заавал хохирол амсдаг. Тухайлбал зуд болоход малчдын мал хорогдоно гэх мэт.
3	Холбоо хамааралтай байдаг.	Эрсдэл нь шалтгаан үр дагавартай байдаг. Эрсдэлийн шалтгаан нь байгалийн хүчин зүйл, эсвэл хүний хүчин зүйл ч байж болно. Харин үр дагавар нь мөнгөн ба мөнгөн бус хохирол байдаг.

Урьдчилан тодорхойлох боломж хэдий чинээ бага байна эрсдэл төдий чинээ их байна.

Эрсдэлийг үүсэх шалтгаан, учрах объект, нөлөөлөх боломж, тохиолдох давтамж, үүсгэх хохирол гэх зэрэг маш олон шинж чанараар ангилан төрөлжүүлж болно. Энд

үүсэх шалтгаан болон хамрах хүрээгээр нь авч үзсэн ангиллыг харуулав.

Хүснэгт 8.2. Эрсдэлийн ангилал, төрөл

Ангилал	Төрөл
Үүсэх шалтгаанаар	<ul style="list-style-type: none"> • Байгалийн хүчин зүйлийн эрсдэл: Ган, зуд, газар хөдлөлт гэх мэт • Хүний хүчин зүйлийн эрсдэл: Хүний буруутай үйл ажиллагаанаас болж үүссэн эрсдэл • Эдийн засгийн хүчин зүйлийн эрсдэл: Ажилгүйдэл, инфляци, валютын ханш, гадаад өр гэх мэт • Улс төрийн хүчин зүйлийн эрсдэл: Хууль эрх зүйн өөрчлөлт гэх мэт • Технологийн эрсдэл буюу аливаа зүйлийн элэгдэх, хуучрах зэргээс үүсэх эрсдэл. • Холимог буюу дээрх хүчин зүйлийн аль алианаас нь хамаарч үүсэх эрсдэл
Объект буюу хамрах хүрээгээр	<ul style="list-style-type: none"> • Нэг эсвэл бүлэг хүнд учрах эрсдэл • Компанид учрах эрсдэл • Улс оронд учрах эрсдэл • Дэлхийн хэмжээнд учрах эрсдэл

Даатгах боломжтой эрсдэлүүдэд хувь хүний, эд хөрөнгийн болон хариуцлагын эрсдэлүүд орно. Эдгээр эрсдэлүүдийг даатгуулснаар хохирлыг даатгалын компаниар нөхөн төлүүлэх боломжтой болно. Үүнд:

- Хувь хүний эрсдэл бол цаг бусын үхэл, өвчин тусах, хөдөлмөрийн чадвараа алдах, хэт өндөр наслах, ажилгүй болох зэрэгтэй холбоотой орлого болон амьдралд учрах хохирлын хэмжээ юм.
- Эд хөрөнгийн эрсдэл нь гал, салхи, шуурга гэх мэт байгалийн аюулт үзэгдэл, аваар осол, хулгай болон бусад аюул зэргээс үүдэн эд хөрөнгөнд учрах шууд ба шууд бус хохирлын хэмжээгээр тодорхойлогдоно.
- Хариуцлагын эрсдэл бол хувь хүний санаандгүй, болгоомжгүй үйлдлийн улмаас бусдын амь нас, эд хөрөнгөнд хохирол учирч болох магадлал юм. Жишээ нь жолоочийн хариуцлагагүй үйлдлээс хэн нэгний амь нас, эд хөрөнгөнд хор хохирол учирч болно.

Харин хүний сэтгэл санаатай холбоотой эрсдэлийг даатгах боломжгүй байдаг. Учир нь хүний сэтгэл санааны хохирлыг мөнгөөр үнэлэх боломжгүй юм.

8.2. Эрсдэлийг удирдах арга

Эрсдэлийг удирдахын тулд эхлээд түүнийг илрүүлж, дараа нь хэмжиж, эцэст нь удирдах буюу эрсдэлд тохирсон арга хэмжээ авах шаардлагатай.

Эрсдэлийг хэрхэн илрүүлэх вэ?

Эрсдэлийг илрүүлнэ гэдэг нь хувь хүний амьдралд сөрөг нөлөө үзүүлж болох гадаад болон дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг нэг бүрчлэн судлах шаардлагатай. Эрсдэлийг илрүүлэхийн тулд асуудал, бэрхшээл, түүний шалтгаан, үр дагаврыг авч үзэх шаардлагатай. Тухайлбал, эрүүл мэндэд учрах эрсдэлийг илрүүлэхийн тулд эмнэлэгт шинжилгээ өгч болох юм. Авто тээврийн хэрэгсэлд учрах эрсдэлийг оношилгоо хийлгэх, хянах самбар дээрх мэдээллийг ажиглах замаар

илрүүлж болно.

Эрсдэлийг хэрхэн хэмжих вэ?

Эрсдэлийг удирдахын тулд эрсдэлийг хэмжих шаардлагатай. Эрсдэлийг хэмжинэ гэдэг нь учирч болох эрсдэлийг хохирлын давтамж, хохирлын хэмжээгээр эрэмбэлнэ гэсэн үг юм. Хохирлын давтамж бол эрсдэл тохиолдох магадлалыг хэмжиж буй хэмжүүр бол, хохирлын хэмжээ бол эрсдэл тохиолдох үед учрах мөнгөн хохирлын хэмжээг илтгэнэ.

Хүснэгт 8.3. Эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Хохирлын хэмжээ Хохирлын давтамж	бага	Дунд зэрэг	Их
Их	Дундаж эрсдэлтэй	Эрсдэл ихтэй	Эрсдэл маш ихтэй
Дунд зэрэг	Эрсдэл багатай	Дундаж эрсдэлтэй	Эрсдэл ихтэй
Бага	Эрсдэл маш багатай	Эрсдэл багатай	Дундаж эрсдэлтэй

Хэдий хэмжээний эрсдэл ямар давтамжтай тохиолдохыг тодорхойлсны дараа эрсдэлийг удирдах буюу тухайн эрсдэлд тохирсон арга хэмжээг авч болно.

Эрсдэлийг хэрхэн удирдах вэ?

Эрсдэлийн удирдлага бол хүний амь нас болон эд хөрөнгийг хамгаалах зохион байгуулалттай үйл ажиллагаа бөгөөд хохирлоос үүдэх санхүүгийн алдагдлыг бууруулахад тусалдаг. Ямар ч хүн бүх төрлийн эрсдэлээс өөрийгөө бүрэн хамгаалж чадахгүй тул эрсдэлийг аль болох багасгах арга замыг хайх хэрэгтэй. Хэрэв та эрсдэл гэж юу болох, түүнийг хэрхэн удирдах талаар ойлгодог бол өөрийгөө болон гэр бүлээ эрсдэлээс хамгаалж чадна. Ихэнх хүмүүс эрсдэлээс сэргийлэхийн тулд зөвхөн даатгалд хамрагдах хэрэгтэй гэж боддог. Гэвч даатгал нь эрсдэл, тодорхойгүй байдлыг зохицуулах цорын ганц арга зам биш юм.

Эрсдэлийг удирдах асуудал юуны өмнө ямар төрлийн эрсдэл учирч болохыг тодруулахаас эхлэх ёстой. Тухайлбал: Өрхийн түвшинд өвчин тусах, хөдөлмөрийн чадвараа алдах, гэнэт нас барах, ажилгүй болох, удаан эдэлгээтэй хэрэглээний зүйлс эзэмшихтэй холбоотой эвдэрч гэмтэх эрсдэл, бусдын өмнө хүлээх хариуцлагатай холбоотой эрсдэл, санхүүгийн хөрөнгөө алдах, санхүүгийн хүндрэлд орох зэрэг эрсдэл тохиолдож болдог. Ийнхүү учрах эрсдэлийг тогтоож, үнэлсний дараа удирдах аргаа сонгох хэрэгтэй. Ерөнхийдөө амьдралд хэрэглэгддэг эрсдэлийн удирдлагын дөрвөн төрлийн арга байдаг.

- 1. Эрсдэлээс сэргийлэх.** Эрсдэлтэй алхам хийхгүй байх нь эрсдэлээс сэргийлэх арга зам болно. Жишээ нь: та хувийн дэлгүүртэй бол хаалга, цонхондоо дохиолол, тусгай цоож хийх, эсвэл хамгаалагч авч ажиллуулснаар бараагаа хулгайд алдахаас сэргийлдэг. Хувь хүний хувьд архи, тамхи хэрэглэхгүй байх, гэмт хэрэг их гардаг газар нутгаар явахгүй байх зэргээр эрсдэлээс зайлсхийж болно. Хувьцааны талаар ямар ч мэдлэг, мэдээлэлгүйгээр зүгээр л хувьцааны үнэ их өсч байна гэсэн хэн нэгний мэдээллээр сэтгэлийн хөөрөлд автан хувьцаа худалдан авч болохгүй. Гэхдээ ямар ч хүн бүх эрсдэлээс зугтаж чадахгүй нь ойлгомжтой.
- 2. Эрсдэлийг бууруулах.** Эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжгүй үед уг Эрсдэлийг бууруулах, цар хүрээ, учрах хохирлыг багасгах арга хэмжээ авч болдог. Суудлын даруулгаа бүсэлснээр, автомашины аваар ослын үед гэмтэх эрсдэлийг бууруулж чадна. Галын дохиолол болон гал унтраагч суурилуулж, болзошгүй галын аюулыг

багасгах замаар амьдралаа хамгаалж чадна. Мөн зохистой хоол, хүнс хэрэглэх, идэвхтэй хөдөлгөөний ачаар өвчлөх эрсдэлийг бууруулах боломжтой. Түүнчлэн, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийхдээ зөвхөн нэг төрлийн, эсвэл нэг компанийн үнэт цаас авах биш олон төрлийн, өөр өөр компанийн үнэт цаас худалдан авбал таны хөрөнгө оруулалтын эрсдэл буурах юм. Олон төрлийн үнэт цааснаас аль нэг төрлийн үнэт цаасны үнэ унаж болно. Эсвэл олон зуун компаниудаас нэг, эсвэл хэд хэдэн компани дампуурч болно. Харин бүх төрлийн үнэт цаасны үнэ нэгэн зэрэг унах, эсвэл бүх компаниуд зэрэг дампуурах магадлал бага билээ.

3. **Эрсдэл хүлээн авах.** Эрсдэлийг хүлээн авах гэдэг нь эрсдэлээс үүдэх хохирол, алдагдлыг өөрөө хариуцна гэсэн утгатай. Ерөнхийдөө, болзошгүй алдагдал бага, эрсдэлийн удирдлагын хүрээнд эрсдэлийг бууруулчихсан, даатгалын хамгаалалт өндөр үнэтэй, хамгаалалт хийх бусад арга зам байхгүй үед эрсдэлийг хүлээн авна. Тухайлбал, хуучин машиныг даатгуулахгүй байж болно. Хэрвээ аваар осол тохиолдвол машинаа засах зардлаа өөрөө хариуцна гэсэн үг.
4. **Эрсдэлийг шилжүүлэх.** Эрсдэлийг удирдах хамгийн энгийн арга бол эрсдэлийг даатгалын компани, эсвэл өөр ямар нэг байгууллагад шилжүүлэх явдал юм. Мөнгөө хадгалуулсан банк дампуурахад хадгаламж чинь даатгагдаагүй бол та бүх хадгаламжаа алдана. Хэрэв хадгаламжаа ямар нэг хэлбэрийн даатгалд хамруулсан бол банк дампуурсан тохиолдолд таны хохирлыг даатгалын байгууллага нөхөн олгоно. Даатгал бол даатгалын компанитай даатгалын гэрээ байгуулсан даатгуулагчийн хохирлын эсрэг хамгаалалт болно. Эрсдэлийг шилжүүлэх даатгалын аргаас гадна диверсификаци хийх (эрсдэлийг тархаан байршуулах) арга байна.

Жишээ нь: Иргэн Гарьдын авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой үүсэх эрсдэлийг хэрхэн удирдаж болохыг дараах хүснэгтээр авч үзье.

Хүснэгт 8.4. Авто тээврийн хэрэгслийн эрсдэлийг удирдах аргууд

№	Эрсдэлийг удирдах арга	Хэрэгжүүлж болох арга хэмжээ
	Эрсдэлээс сэргийлэх	Авто машинаар зорчихгүй байх, эсвэл бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх
	Эрсдэлийг бууруулах	Хурдны зөвшөөрөгдсөн хязгаарыг давахгүй байх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ машин барихгүй байх, жолооны үнэмлэхгүй хүнээр машин бариулахгүй байх
	Эрсдэл хүлээн авах	Авто машин нь хэт хуучирсан бол даатгуулахгүй байх, эсвэл эрсдэлээс хамгаалах сан бүрдүүлэх
	Эрсдэлийг шилжүүлэх	Амь нас, авто тээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагыг даатгалд даатгуулах эсвэл илүү туршлагатай жолоочоор тээврийн хэрэгслээ жолоодуулах

Эрсдэлийн хэмжээнээс хамаарч эрсдэлийг ямар аргаар удирдах нь оновчтойг тодорхойлбол зохино.

Хүснэгт 8.5. Эрсдэлийн үнэлгээ, удирдлага

Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн удирдлага
Их давтамжтай, бага хохиролтой	Эрсдэлийг бууруулах
Их давтамжтай, их хохиролтой	Эрсдэлээс зайлсхийх
Бага давтамжтай, бага хохиролтой	Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх
Бага давтамжтай, их хохиролтой	Эрсдэлийг шилжүүлэх

8.3. Санхүүгийн луйвар ба залилан, түүнээс хамгаалах арга

Эрсдэл, санхүүгийн аюулгүй байдал гэсэн ойлголт нь хоорондоо салшгүй холбоотой, харилцан нөлөөлж байдаг хүчин зүйлүүд юм. Тухайлбал, эрсдэл өсөхөд санхүүгийн аюулгүй байдал алдагддаг. Санхүүгийн аюулгүй байдалд санхүүгийн залилан, луйвар гэх мэт хүчин зүйлс нөлөөлнө. Иймээс хүн өөрийн санхүүгийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, ирээдүйд гарч болох эрсдэлээ тооцон, санхүүгийн элдэв залилан, гэмт үйлдлээс сэргийлэх, санхүүгийн аюулгүй байдлаа хангаж байх шаардлагатай. Үүний тулд дараах зүйлсийг өөрийн амьдралдаа мөрдлөг болгохыг зөвлөдөг. Үүнд:

- Сар бүрийн тогтмол зардлаа байнга хянаж сурах;
- Санхүүгийн залилан хууран мэхлэлтээс сэргийлэх;
- Эрүүл мэндийн болон бусад төрлийн өөртөө тохирсон даатгалыг сонгох;
- Ашигтай, амар хялбар бүтэх, үнэн байх боломжгүй мэт санал бүрийг сайтар бодож олон талаас нь судалж үздэг байх; Энэ нь хууран мэхлэлт байх магадлалтай.
- Сар бүр дансны хуулгаа сайтар шалгаж, сэжигтэй санагдсан гүйлгээг банкнаас лавлаж байх;
- Төлбөрийн цахим үйлчилгээ ашиглахдаа баталгаатай төлбөрийн систем сонгож ашиглах;
- Цахим орчинд баталгаагүй хуудсанд өөрийн хувийн, төлбөрийн картын, нийгмийн даатгалын зэрэг мэдээллийг аль болох оруулахгүй байх;
- Цахим хэрэгслийн нууц үг, пин код зэрэг мэдээллийг бусдад дамжуулахгүй байх зэргээр аюулгүй байдлаа баталгаажуулах хэрэгтэй.

Санхүүгийн луйвар нь банк, санхүүгийн байгууллагын цахим сүлжээнд хууль бусаар нэвтрэх, гэрээний зүйл заалтаар дамжуулж гүйцэтгэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх замаар гүйцэтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн нээлттэй сайтыг санхүүжүүлэх замаар гүйцэтгэх зэрэг хэлбэрүүдээр илэрдэг.

Интернэтийн хэрэглээ асар хурдацтай өргөжин тэлэхийн хэрээр гарах сөрөг үр дагавар, гэмт үйлдлүүд ч нэмэгдэж байна. Үүний нэг нь цахим шуудангийн луйвар, интернэт залилангийн хэрэг юм. Манай улсын гадаад худалдаа эрхэлдэг иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад харилцагч талаас ирсэн цахим шууданд төлбөрийн данс солигдсон, өөрчлөгдсөн үндэслэлээр өөр дансанд төлбөрийг шилжүүлэхийг хүссэн цахим шуудан хүлээж авдаг ба тус шилжүүлгийг хийснээр цахим шуудангийн луйврын хохирогчид болдог. Иймээс энэ төрлийн цахим шууданг хүлээн авсан тохиолдолд үнэн эсэхийг харилцагч талаасаа заавал утсаар тодруулж асуух болон ирж буй и-мэйл хаягийн зөв бурууг нягталж шалгаж байх шаардлагатай. Мөн санамсаргүй байдлаар хонжворт сугалаанд түрүүлсэн, их хэмжээний бэлэн мөнгө хүлээж авахаар болсон тухай мэдээллийг и-мэйл хаяг, фэйсбүүк болон өөрийн гар утсанд хүлээн авсан бол энэ үйлдэл нь интернэт луйврын гэмт хэрэг байж болзошгүй тул нягтлах хэрэгтэй.

Танд сэрэмжлүүлэхэд⁸

Сүүлийн үед гадаад улсын гэмт бүлэглэлүүдийн зүгээс тухайлбал Малайз, Сенегал, Англи, Филиппин улсуудаас үйлдэж буй интернэт луйврын гэмт хэрэгт манай улсын иргэд хохирох байдал гарах боллоо. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн фэйсбүүк орчныг ашиглан үйлдэгдэж байгаа бөгөөд иргэдэд их хэмжээний бэлэн мөнгө өгөх, санамсаргүй байдлаар сугалааны эзнээр сонгогдох, өв залгамжлахад минь санхүүгийн туслалцаа үзүүлээч гэх зэрэг байдлаар харилцаа холбоо тогтоож итгэл үнэмшил төрүүлэх зорилгоор утсаар хэд хэдэн удаа холбогдох, цахим шуудангаар харилцах, сүүлийн тохиолдлуудад хуурамч батламж, гэрчилгээ, төлбөрийн карт зэргийг

шуудангаар илгээж үүний дараа урьдчилгаа төлбөр, татвар зэрэг шалтгаанаар бага бус хэмжээний мөнгийг өөрсдийн дансанд шилжүүлэн авдаг болов.

Гэмт этгээдүүд банкны данс ашиглахаас гадна Western Union, Moneygram, Swift зэрэг олон улсын мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг түгээмэл ашиглаж байна. Иймд ард иргэд интернэт орчинд үл таних гадаад иргэдтэй ямар нэгэн байдлаар харилцахгүй байх, банкны мэдээллээ солилцохгүй байх, хууран мэхлэх аливаа үйлдэлд автагдахгүй байхыг анхааруулж байна.

8.4. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалт

Санхүүгийн хэрэглэгч гэж санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зөвхөн өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан авч буй хувь хүнийг хэлдэг. Зарим улсад жижиг болон бичил аж ахуйн нэгжийг хамруулах тохиолдол байдаг.



Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гэж бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр өргөн хүрээтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг ашгийн төлөө байгууллагыг хэлдэг. Тухайлбал, банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани, үнэт цаасны арилжаа эрхлэгч, хөрөнгө оруулалтын сан, хадгаламж зээлийн хоршоо зэрэг болно.

Санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах институцийн болон хууль эрх зүйн өнөөгийн орчин

Банкны үйлчилгээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах одоогийн институц, хууль эрх зүйн орчинг Монгол Улсын дараах хууль тогтоомжууд тодорхойлж байна:

- Үндсэн хууль
- Иргэний хууль
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль
- Зар сурталчилгааны тухай хууль
- Өрсөлдөөний тухай хууль
- Банкны тухай хууль
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (“БЭБХЭМХТТЗҮА-ны тухай хууль”)

Монгол Улсын санхүүгийн зах зээлд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх институцын чиг үүргийг төрийн захиргааны дараах гурван байгууллага хүлээн ажиллаж байна. Эдгээр нь:

- Монголбанк (“МБ”);
- Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”);
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (“ШӨХТГ”).

Дээр дурдсан гурван байгууллагын сацуу Сангийн яам (“СЯ”) санхүүгийн зах зээлийг зохицуулах хууль эрх зүйн актуудыг боловсруулан батлуулахаар Монгол Улсын Их Хуралд өргөн барих үүргийг хүлээнэ. Мөн СЯ нь санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд ерөнхий хяналтыг тавьж ажиллана.

Монголбанк нь банкны салбар зохицуулалт, хяналт тавьж ажилладаг.

Санхүүгийн зохицуулах хороо нь даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагын харилцагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцаж ажилладаг.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр бүх салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцаж ажилладаг.

Хадгаламжийн даатгалын корпораци хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой байгууллага.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалахтай холбоотой асуудлууд⁹

Худалдаа, маркетингийн асуудал

- Худал, төөрөгдүүлсэн зар сурталчилгаа
- Дайрч давшилсан байгууллагын маркетинг
- Хэрэглэгчийн хүсээгүй бүтээгдэхүүн, үйлчилгээг
- Хэрэглэгчийн урьдаас таамаглаагүй шимтгэл, төлбөр, хураамж

СҮҮ байгууллага санхүүгийн мэдээллийг нээлттэй мэдээлэхтэй холбоотой асуудал

- Хууль, дүрэм журмыг биелүүлэхгүй байх
- Хэрэглэгчийн үүргийг таниулахгүй байх

Өр барагдуулахтай холбоотой асуудал

- Дарамт, шахалт үзүүлэх,
- Данснаас урьдчилан мэдэгдэлгүй мөнгө татах

Хүү, шимтгэл, хураамжтай холбоотой асуудал

- Зээлийн өндөр хүү
- Далд хүү
- Хэт өндөр алданги тооцоолт

Мэдээллийн ил тод байдалтай холбоотой асуудал

- Хэрэглэгчийг хэрэгтэй мэдээллээр бүрэн хангахгүй байх эсхүл дутуу тайлбарлах
- Ойлгомжгүй, мэргэжлийн үг хэллэгээр мэдээллэл өгөх

8. “ЭРСДЭЛ БА ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙН ХАМГААЛАЛТ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

8.1. Эрсдэлийн тухай ойлголт, төрөл

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Ямарваа эрсдэлээс түүн дундаа санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Эрсдэл, санхүүгийн эрсдэл, эрсдэлийн удирдлага

Хэрэглэгдэхүүн:

Эрсдэлийн жишээ, бүлгийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга: Эрсдэл тодорхойлох, эрсдэлийг давах туулах, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдын өөрсдийнх нь оролцоог дэмжих замаар дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хуваагаад “Эрсдэл гэж юу вэ? гэсэн асуултыг тавьж бүлгээрээ ярилцаарай гэсэн даалгавар өгнө. Бүлэг тус бүрийг 10 минут ажиллуулаад төлөөллийг самбарт гарган тайлбарлуулна. Үүний дараа “Эрсдэл бол тодорхой бус байдал буюу урьдчилан тооцоолоогүй зүйл” гэдэг тодорхойлолтыг өгөөд түүнийг “аюул занал, сөрөг үр дагавар, алдагдал, хохирол” гэсэн үгээр илэрхийлж болох боловч дандаа сөрөг утгатай биш цөөн тохиолдолд “боломж” байж болох талтай тухай тайлбарлана. Ингэхдээ хүснэгт 8.1-ийн тайлбаруудыг хүргэнэ.

Алхам 2 :

Эрсдэлийг үүсэх шалтгаан, учрах объект, нөлөөлөх боломж, тохиолдох давтамж, үүсгэх хохирол, хамрах хүрээгээр гэх зэрэг маш олон шинж чанараар ангилан төрөлжүүлж болох тухай тайлбарлаад хүснэгт 8.2-т үзүүлсэн ангиллыг танилцуулна.

Эрсдэлийн ангиллыг мэдэх явдал түүнээс урьдчилан сэргийлэх, түүнийг хор хохирол багатай даван туулахад тусална. Эрсдэлээс сэргийлэх гол арга зам бол даатгал бөгөөд энэ хэсэгт сэдэв 9-ийн эрсдэлийн даатгалын хэсгийг товч тайлбарлана.

8.2. Эрсдэлийг удирдах арга

Сургалтын хүлээгдэж буй үр дүн :

Эрсдэлийг илрүүлж, хэмжиж, түүнийг удирдах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо :

Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлага

Хэрэглэгдэхүүн :

Эрсдэлийн үнэлгээний болон удирдлагын хүснэгт

Сургалтын арга :

Эрсдэл илрүүлэх, хэмжих, эрсдэлийг удирдах, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдын оролцоог дэмжих замаар дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Суралцагчдыг санхүүгийн мэдлэгийн түвшингээр “анхан, дунд, ахисан” гэсэн 3 бүлэг болгоод “Эрсдэлийг илрүүлэх гэж юу вэ?” хэмээн асуугаад 5 минут бүлгийн ажил хийлгэнэ. Бүлэг тус бүрийн төлөөллийн бүлгийн ажлын танилцуулгыг сонсоод багш “*Эрсдэлийг илрүүлнэ гэдэг нь хувь хүний амьдралд сөрөг нөлөө үзүүлж болох гадаад болон дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг нэг бүрчлэн судлах явдал юм*” гэсэн чиглүүлгийг өгнө.

Эрсдэлийг удирдахын тулд түүнийг хэмжих шаардлагатай бөгөөд хүснэгт 8.3-т үзүүлсэн хохирлын хэмжээ, давтамжаар нь эрэмбэлэх тухай тухай танилцуулна. Хохирлын давтамж бол эрсдэл тохиолдох магадлалыг хэмжиж буй хэмжүүр, харин хохирлын хэмжээ бол эрсдэл тохиолдох үед учрах мөнгөн хохирлын хэмжээг илэрхийлсэн ойлголт болох тухай тайлбарлана.

Алхам 2 :

Суралцагчдад эрсдэлийг удирдах аргууд болох “эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эрсдэлийг шилжүүлэх” гэсэн 3 сэдвийг дээрх 3 бүлэг тус бүрд оноож өгнө. Ингэхдээ хүснэгт 8.4-т үзүүлсэн автомашины эрсдэлийг удирдах аргыг жишээ болгон харуулна

Бүлэг тус бүрийг 5 минут ажиллуулаад гаргасан санаануудыг нэгтгээд дараах үндсэн 4 аргын талаарх тайлбаруудыг хийнэ.

	Эрсдэлийг удирдах арга	Тайлбар
1	Эрсдэлээс сэргийлэх	Эрсдэлтэй алхам хийхгүй байх нь эрсдэлээс сэргийлэх арга зам болно.
2	Эрсдэлийг бууруулах	Эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжгүй үед уг эрсдэлийг бууруулах, цар хүрээ, учрах хохирлыг багасгах арга хэмжээ авч болдог.
3	Эрсдэл хүлээн авах	Эрсдэлийг хүлээн авах гэдэг эрсдэлээс үүдэх хохирол, алдагдлыг өөрөө хариуцна гэсэн утгатай.
4	Эрсдэлийг шилжүүлэх	Эрсдэлийг удирдах хамгийн энгийн арга бол эрсдэлийг даатгалын компани, эсвэл өөр ямар нэг байгууллагад шилжүүлэх явдал юм.

Үүний дараа эрсдэлийн удирдлагыг ямар арга замаар хэрэгжүүлэх вэ? гэсэн шийдвэрт хүснэгт 8.5-д харуулсан эрсдэлийн үнэлгээг зайлшгүй хийх шаардлагатай тухай тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл :

Эрсдэлийг яаж ангилдаг, диверсификаци (эрсдэлийг тараан байршуулах) хийх болон эрсдэлийн удирдлагын загваруудын талаар мэдээлэл өгнө.

Анхаарах зүйл:

Эрсдэлээ удирдахад дээрх арга хэрэгслүүдийг ашиглахаас гадна оюуны болон бие бялдрын, сэтгэл зүйн чадамжуудаа ашиглах шаардлагатай тухай тайлбарлаж өгнө. Ялангуяа эрсдэлийг даван туулахад сэтгэл зүйн тэвчээр чухал гэдгийг суралцагчдад сайн ойлгуулах шаардлагатай.

8.3. Санхүүгийн луйвар ба залилан, түүнээс хамгаалах арга

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Санхүүгийн залиланг тодорхойлж сурах үндсэн дээр түүний хохирогч болохоос зайлсхийх, мөнгө хөрөнгөө хамгаалах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томъёо:

Санхүүгийн луйвар, понзи схем

Хэрэглэгдэхүүн:

Понзи схемийн зураглал, санхүүгийн луйврын зарчмыг харуулсан үзүүлэн таниулах материал

Сургалтын арга:

Тооцоолох, урьдчилан сэргийлэх, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчдад санхүүгийн луйвар, залилангийн бодит жишээг мэдрүүлэх үндсэн дээр дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Суралцагчдыг насны түвшингээр “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хуваагаад “Та санхүүгийн луйвар, залиланд өртөж хохирч байсан уу?” гэсэн асуултыг тавиад “тийм” гэсэн хариулт дунджаас их бол тэрхүү тохиолдлууд дээр, хэрвээ дунджаас бага бол багш өөрөө санхүүгийн луйврын тодорхой бодит жишээ сонгон ярилцана.

Ямар ч хүнд санхүүгийн луйвар, залиланд өртөж санхүүгийн хувьд хохирох эрсдэл байгаа бөгөөд харин та түүнээс өөрийгөө өөрөө урьдчилан сэргийлж чадах тухай, ингэхийн тулд та дараах байдлаар сонор сэрэмжтэй байх хэрэгтэй тухай тайлбарлана.

Үүнд:

- Сар бүрийн тогтмол зардлаа байнга хянаж сурах;
- Санхүүгийн залилан хууран мэхлэлтээс сэргийлэх;
- Эрүүл мэндийн болон бусад төрлийн өөртөө тохирсон даатгалыг сонгох;
- Ашигтай, амар хялбар бүтэх, үнэн байх боломжгүй мэт санал бүрийг сайтар бодож олон талаас нь судалж үздэг байх; Энэ нь хууран мэхлэлт байх магадлалтай.
- Сар бүр дансны хуулгаа сайтар шалгаж, сэжигтэй санагдсан гүйлгээг банкнаас лавлаж байх;
- Төлбөрийн цахим үйлчилгээ ашиглахдаа баталгаатай төлбөрийн систем сонгож ашиглах;
- Цахим орчинд баталгаагүй хуудсанд өөрийн хувийн, төлбөрийн картын, нийгмийн даатгалын зэрэг мэдээллийг аль болох оруулахгүй байх;
- Цахим хэрэгслийн нууц үг, пин код зэрэг мэдээллийг бусдад дамжуулахгүй байх зэргээр аюулгүй байдлаа баталгаажуулах зэрэг болно.

Алхам 2 :

Та санхүүгийн луйварт өртөхгүй байх хамгийн сайн арга бол түүний талаар мэдлэг, мэдээлэлтэй байх явдал юм. *“Санхүүгийн луйвар банк, санхүүгийн*

байгууллагын цахим сүлжээнд хууль бусаар нэвтрэх, гэрээний зүйл заалтаар дамжуулж гүйцэтгэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх замаар гүйцэтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн нээлттэй сайтыг санхүүжүүлэх замаар гүйцэтгэх зэрэг хэлбэрүүдээр илэрдэг” гэдгийг суралцагчдад тайлбарлана. Үүнийг тодорхой болгохын тулд “Танд сэрэмжлүүлэхэд” хэсгийн интернэт луйврын талаар мэдээллийг хүргэнэ.

Нэмэлт мэдээлэл:

Ихэнх санхүүгийн луйвар толгой эргэм буюу үр дүн нь хурдан мэдрэгдэхгүй сүлжээний бизнесийн бинар (хоёрлогч буюу хоёр хоёр хүн багтаа элсүүлэх) системийг ашигладаг. Үүнийг “Понзи схем”, “Санхүүгийн пирамид” гэх зэргээр нэрлэдэг тухай мэдээлэл өгнө. Харин санхүүгийн залилан бол нэг их толгой эргүүлж удахгүй үр дүн нь хурдан хугацаанд мэдрэгддэг онцлогтойг тайлбарлана.

Анхаарах зүйл:

Суралцагчдад “ямарваа зүйлийг тооцоолохгүйгээр итгэх, гэнэн байдлаар хүлээж авахгүй байх, хялбар аргаар хурдан мөнгө олох гэж хичээдэггүй байх”, “мэргэжил, чадвар шаардахгүй ажил хийх тухай бодохгүй байх” зэрэг зан чанаруудад анхаарч байж санхүүгийн луйвар, залиланд өртөхгүй байх чадвартай болох тухай ухуулах шаардлагатай.

8.4. Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалт

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Та хэрэглэгч болохынхоо хувьд өөрийн эрхээ хамгаалах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Хэрэглэгчийн эрх ашиг, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, хууль

Хэрэглэгдэхүүн:

Хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдсөн тухай мэргэжлийн хяналтын байгууллагын үзүүлэн таниулах материал

Сургалтын арга:

Эрх ашгаа хамгаалах, мэдэх, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Суралцагчид өөрсдөө хэрэглэгчид тул тэднээр дүгнүүлэх үндсэн дээр дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1 :

Суралцагчдыг насны түвшингээр “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хуваагаад “Хэрэглэгч болохын хувьд эрх ашгаа зөрчүүлсэн тохиолдол бий бол бичнэ үү” гээд бичүүлнэ. Бүлэг тус бүрийн төлөөллийг сонссоны дараа хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн дагуу


- Чанар, аюулгүй байдлыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах;
- Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх;
- Сонголт хийхэд туслах, барааны талаар үнэн, зөв бодит мэдээлэл авах;
- Шүүхээр хамгаалуулах эрх зэрэг эрхтэй гэдгийг тайлбарлаж өгнө.

Алхам 2:

“Хэрэглэгч бол бараа, ажил, үйлчилгээг хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч үйлчлүүлж байгаа, эсвэл хэрэглэж байгаа хувь хүн юм” гэсэн тодорхойлолтыг суралцагчдад өгөөд “Танд сонирхуулахад” мэдээллийг хүргэнэ. Энэ байдлаас үүдэн хэрэглэгчид эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санааны хохирол амсах тохиолдол гардаг тул эрх ашгаа хамгаалахын тулд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах газар, шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, мэргэжлийн хяналтын байгууллага, цагдаа, шүүх хүчний байгууллага гэх зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудаар дамжуулж эрхээ хамгаалж болох тухай тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл:

Санхүүгийн пирамид бол сүлжээний орой хэсгийн мөнгийг өсгөөд бусад хэсгийг хохироодог тул иймэрхүү санхүүгийн луйварт өртөхгүйн тулд элсэн орохгүй байх хэрэгтэй тухай анхааруулна. “8 бөмбөгний тоглоом” буюу эхэлж орсон 3 хүн мөнгөө өсгөж аваад бусад нь хохирогч болдог схемийг Понзи схем гэдэг тухай тайлбарлана.



Анхаарах зүйл:

Санхүүгийн луйвар, залиланд өртөх эрсдэл бол хувь хүний өөрийнх нь хайхрамжгүй, болгоомжгүй байдал, итгэмтгий зан, хурдан түргэн мөнгө олох гэсэн хүсэл, шунал дээр тулгуурладаг тул хувь хүн өөрөө илүү анхаарах шаардлагатай тухай ухуулах хэрэгтэй.

СЭДЭВ 9. ДААТГАЛ

9.1. Даатгал, түүний үүрэг, ач холбогдол

Даатгал гэж юу вэ?

Хүний амьдралд учирч болох тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, учрах хохирлыг хамгийн богино хугацаанд арилгах үр дүнтэй санхүүгийн арга бол даатгал юм. Дэлхийн хүн бүр өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй байх энгийн хэрэгцээ байдаг бол түүнийг тааламжгүй үр дагавраас хамгаалах арга болох даатгал хүний өөрийнх нь туулж өнгөрүүлсэн бодит амьдралын хэрэгцээнээс үүсчээ. Хүмүүс хэсэг бүлгээрээ сан бүрдүүлж, тэрхүү сангаасаа хохирол учирсан нэгэндээ туслах болсон нь орчин үеийн даатгалын анхны хэлбэр байсан. Тэрхүү санг үүсгэхэд хамтарч оролцох хүмүүсийн тоо олон байх тусам нэг хүнд ногдох зардлын хэмжээ буурдаг болохыг тогтоосон байна.

Эрсдэл бол хэзээ ч, хэнд ч учирч болно. Зарим хүмүүс өөрийгөө сайн жолооч. Тиймээс ойрын 10 жилд ямар нэгэн осол гаргахгүй явчихна гэж тооцоод даатгалын шимтгэлд төлөх 400,000 төгрөгийг дэмий зүйлд зарцуулж байна гэж бодож болох юм. Гэтэл “Гай газар доороос гахай модон дотроос” гэдэг шиг, эрсдэл хэзээ ч тохиолдож болно. Эрсдэлийг даатгагдах болон үл даатгагдах эрсдэл гэж ангилдаг. Гэнэтийн шинж чанартай, санамсар болгоомжгүй байдлаас үүссэн, хохирол нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжтой эрсдэлийг даатгагдах эрсдэл гэдэг. Ийм эрсдэлийг шилжүүлж авдаг бизнес нь даатгал юм.

Даатгуулагч нь эрсдэл учирч болох бүх зүйлийг даатгалын компани буюу даатгагчид даатгуулж болно. Тухайлбал, эд хөрөнгө, хариуцлага, эрүүл мэнд, орлогоо даатгуулж болно. Даатгал нь гэрээний бизнес. Даатгалын компани нь эрсдэл тохиолдох үед нөхөн олговор олгох нөхцөлтэй гэрээг санал болгож харин даатгуулагч нь түүнийг худалдан авдаг. Энэхүү гэрээг худалдах болон худалдан авах үнэ нь даатгалын хураамж юм. Даатгалын талаар илүү нарийн ойлголт авахын тулд дараах үндсэн ухагдахууныг ойлгох нь зүйтэй.

Хүснэгт 9.1. Даатгалтай холбоотой үндсэн ухагдахуун

№	Нэр томъёо	Тодорхойлолт
1	Даатгал	Ирээдүйд учирч болох аливаа эрсдэлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа.
2	Даатгалын зүйл	Даатгалд хамрагдаж байгаа эд хөрөнгө, хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар.
3	Даатгалын гэрээ	Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх даатгалын харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг.
4	Даатгалын үнэлгээ	Даатгалын объектыг үнэлж даатгуулсан мөнгөний хэмжээ.
5	Даатгалын тохиолдол	Даатгуулсан зүйлд эрсдэл тохиолдож, хохирол учрах үйл явц.

6	Даатгалын хураамж	Даатгалын үнэлгээнээс хамаарч даатгуулагчийн төлж байгаа мөнгөний дүн.
7	Даатгалын нөхөн төлбөр	Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө.
8	Даатгалын баталгаа	Даатгалын компанийн зүгээс даатгуулагчдаа даатгасныг баталгаажуулан өгч буй баримт бичиг
9	Даатгалын хугацаа.	Даатгалын гэрээний хүчинтэй хугацаа.

Даатгуулагч нь даатгалын компанид өөрийн ашиг сонирхлоо даатгуулсны төлөө хураамж төлдөг. Хураамж нь тухайн даатгуулагчийг эрсдэлд орсон үед хохирлыг нөхөх төлбөр, даатгалын компанийн үйл ажиллагааны зардал, ашгийг багтаасан төлбөр байна. Даатгалын компанийн зүгээс даатгуулагчид баталгаа гаргаж өгдөг. Энэхүү баталгаанд даатгалын зүйл, эрсдэл, хоёр талын эрх үүрэг, нөхөн төлбөр олгох нөхцөл, үл олгох нөхцөл, гэрээ цуцлах үндэслэл зэргийг багтаасан байдаг. Даатгалын тохиолдол үүссэн үед нөхөн олговор авдаг.

Даатгалын харилцаа гэж юу вэ?

Даатгалын харилцаа гэдэг нь даатгалын гэрээтэй холбогдож иргэн болон хуулийн этгээдийн хооронд үүсдэг харилцаа юм. Даатгалын харилцаанд даатгагч, даатгуулагчаас гадна даатгалын мэргэжлийн оролцогч болон зохицуулагч байгууллагууд оролцдог. Даатгалын мэргэжлийн оролцогч гэдэгт даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын актуарч зэрэг орох ба Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлдэг.

Хүснэгт 9.2. Даатгалын харилцаанд оролцогчид ¹⁰

№	Оролцогч	Тодорхойлолт	Хамрах хүрээ
1	Даатгагч	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага.	Ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1 компани, тэдгээрийн 255 салбар үйл ажиллагаа явуулж байна.
2	Даатгуулагч	Өөрийн эд хөрөнгө, эрүүл мэнд, ашиг сонирхолоо даатгуулж, даатгалын хураамж төлж байгаа хувь хүн, хуулийн этгээд.	Үүнд, Монгол Улсад амьдарч буй бүх иргэд болон үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүд орно.
3	Даатгалын төлөөлөгч	Даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх үүрэг бүхий этгээд.	Нийт 3340 төлөөлөгч даатгалын компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байна.
4	Даатгалын зуучлагч	Даатгагчийг даатгуулагчтай холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээд.	Даатгалын зуучлагчаар нийт 37 компани үйл ажиллагаа явуулж байна.
5	Даатгалын хохирол үнэлэгч	Даатгалын тохиолдлоор үүссэн бодит хохирлын мөнгөн дүнг хараат бусаар тогтоох үүрэг бүхий этгээд.	Даатгалын хохирол үнэлэгчээр нийт 27 компани үйл ажиллагаа явуулж байна.

¹⁰ 2015 оны байдлаар, СЗХ-ны үйл ажиллагааны тайлангаас авав

6	Даатгалын актуарч	Даатгагчид учирч болох эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээд.	Даатгалын актуарч нийт 15 хүн ажиллаж байна.
7	Даатгалын зохицуулагч	Даатгалын харилцаа хуулийн дагуу явагдаж буй эсэхийг илрүүлж, хууль сахиулах үүрэг бүхий төрийн байгууллага.	Санхүүгийн зохицуулах хороо

Дээрх этгээдүүдээс гадна даатгалын компанийн санхүүгийн тайланд хараат бус, мэргэжлийн дүгнэлт өгөх үүрэг бүхий аудитын компаниуд СЗХ-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулдаг.

Даатгалын үйлчилгээг харилцагчид хүргэдэг 2 төрлийн суваг байдаг бөгөөд эдгээр нь “даатгалын зуучлагч” ба “даатгалын төлөөлөгч” юм. Та даатгуулагчийн хувьд зөвлөгөө авахыг хүсвэл даатгалын зуучлагчид хандана. Даатгалын зуучлагч нь даатгуулагчид үйлчилж түүнд зөвлөмж, заавар өгөх чиг үүрэгтэй байдаг бол даатгалын төлөөлөгч нь даатгалын байгууллагыг төлөөлөн төв байр нь байгаа газраас өөр газарт үйлчилгээг хүргэдэг.

Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих замаар даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо юм. Та энэ байгууллагын талаар болон бусад нэмэлт мэдээллийг авахыг хүсвэл www.frc.mn хаягаар хандаж болно.

Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Даатгалын тухай хууль, Иргэний хуулиар зохицуулдаг.

Хүснэгт 9.3. Даатгалын харилцааг зохицуулдаг хуулиуд

№	Хуулийн нэр	Батлагдсан он	Хамрах хүрээ
1	Даатгалын тухай хууль	2017-05-18	Даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
2	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль	2017-05-18	Даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.
3	Жолоочийн даатгалын тухай	2015-12-04	Жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
4	Иргэний хууль	2017-05-18	Иргэний хуулийн 43-р бүлэгт иргэний зүгээс үүсгэх даатгалын харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

9.2. Даатгалын бүтээгдэхүүнийг сонгох нь

Даатгал нь маш олон төрөлтэй байдаг бөгөөд тэдгээрийг даатгалын харилцааны шинж чанар, хугацаа, зорилго зэргээс хамааруулж ангилдаг. Монгол Улсын “Даатгалын тухай хууль”-д зааснаар даатгалыг урт хугацааны ба ердийн даатгал гэж ангилах бөгөөд албан журмын ба сайн дурын гэсэн хоёр хэлбэртэй¹¹ байна. Даатгалыг зорилгоос нь хамаарч арилжааны ба нийгмийн даатгал гэж ангилна. Заавал даатгал нь хуулиар зохицуулагддаг бол сайн дурын даатгал нь гэрээний үндсэн дээр хэрэгжинэ.

Хувь хүмүүс өөрсдийн эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар, амь нас, хариуцлагаа сайн дурын үндсэн дээр даатгуулахын зэрэгцээ зарим төрлийн даатгалд хуульд заасны дагуу заавал даатгуулдаг. Тухайлбал, Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа хувь хүн нийгмийн даатгалд заавал даатгуулна¹². Мөн жолоочийн хариуцлагын даатгал нь арилжааны даатгал боловч албан журмын даатгалын төрөлд хамаарна.

Арилжааны даатгалыг амьдралын ба амьдралын бус (ердийн) даатгал гэж ангилна. Амьдралын бус даатгалд хүний өмч хөрөнгө, хариуцлага, амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадвартай холбоотой богино хугацааны даатгалуудыг хамруулж үзэх ба манай улсын даатгалын тухай хуульд ердийн даатгал гэж нэрлэж байна. Хувь хүнтэй холбоотой ердийн даатгалуудад дараах даатгалууд хамаарч байна.

Хүснэгт 9.4. Даатгалын ангилал

Даатгалын төрөл	Тодорхойлолт	Жишээ
Объектоор нь	Хувь хүний	Хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт учрах эрсдлээс хамгаалах зориулалт бүхий даатгал.
	Эд хөрөнгийн	Хөрөнгөнд өөрийн болон бусдын буруугаас эсвэл давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан учирсан хохирлыг нөхөн төлөх зориулалт бүхий даатгал.
	Хариуцлаг-ын	Даатгуулагч этгээдийн зүгээс гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг даатгагчаар нөхөн төлүүлэхээр тохиролцож хийсэн даатгал.
Хугацаагаар нь	Ердийн даатгал	Нэг хүртэлх жилийн хугацаанд хувь хүний эд хөрөнгө амь нас эрүүл мэндэд учрах эрсдлээс хамгаалах зориулалт бүхий даатгал
	Урт хугацааны даатгал	Нэгээс дээш жилийн хугацаанд хувь хүний амьдралд учирч болох эрсдлээс хамгаалах зориулалт бүхий даатгал

11 Даатгалын тухай хууль. Шинэчилсэн найруулга. (2017). 6.1; 6.2-р дугаар зүйл.

12 Нийгмийн даатгалын тухай хууль. (2017). 4.2.1-р зүйл.

Төргөөр нь	Заавал	Хуульд заасны дагуу заавал даатгуулах даатгал.	Жолоочийн хариуцлагын даатгал, нийгмийн даатгал гэх мэт
	Сайн дурын	Иргэн, хуулийн этгээдүүд өөрийн хүсэлтийн үндсэн дээр даатгуулж болох даатгал.	Тээврийн хэрэгслийн гэх мэт
Зорилгоор нь	Нийгмийн даатгал.	Төрөөс хэрэгжүүлж буй ашгийн төлөө бус даатгал.	Тэтгэврийн, эрүүл мэндийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн гэх мэт.
	Арилжааны даатгал.	Хувийн даатгалын компаниудын хэрэгжүүлдэг ашгийн төлөөх даатгал.	Эд хөрөнгийн, тээврийн хэрэгслийн, орон сууцны гэх мэт.

Жишээлбэл, Гарьд авто машин жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ санамсаргүй бусдын авто машиныг мөргөж гэмтээх тохиолдолд гуравдагч этгээдэд учруулсан хохирлоо жолоочийн хариуцлагын даатгалын сангаас нөхөн төлүүлж болно. Харин тээврийн хэрэгслийн даатгалд даатгуулсан бол өөрийн авто машинд учирсан хохирлыг барагдуулж болох юм. Эндээс машин барьж авто замын хөдөлгөөнд оролцдог л бол жолоочийн хариуцлагын даатгалд заавал даатгуулах учиртай, харин тээврийн хэрэгслээ заавал даатгуулах албагүй бөгөөд энэ нь сайн дурын даатгал болох юм.


Хүснэгт 9.5. Даатгалын хэлбэр, тодорхойлолт

№	Даатгалын төрөл	Агуулга
1	Эд хөрөнгийн даатгал	Хувь хүн, байгууллагын өмчлөлд хамаарах бүх төрлийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн даатгал.
2	Гэнэтийн ослын даатгал	Даатгуулагч гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн болон хэсэгчлэн алдах, нас барсан тохиолдолд даатгуулагчид эсвэл түүний ар гэрийнхэнд нөхөн олговор олгох агуулга бүхий даатгал.
3	Эрүүл мэндийн даатгал	Иргэн ба хуулийн этгээдийн төлсөн даатгалын хураамжаар даатгалын санг бүрдүүлсний үндсэн дээр даатгуулагчдын эмчилгээ үйлчилгээний зардлыг төлөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ.
4	Иргэдийн хариуцлагын даатгал	Даатгуулагчаас гуравдагч этгээдэд ам нас, эд хөрөнгө, эрүүл мэндэд учруулсан хохирлыг нөхөн төлөх агуулга бүхий даатгал.
5	Жолоочийн хариуцлагын даатгал	Тээврийн хэрэгслийн жолоочийн санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулах хохирлыг нөхөн төлөх агуулга бүхий даатгал.
6	Орон сууц эзэмшигчийн хариуцлагын даатгал	Орон сууц эзэмшигчийн болон өмчлөгчийн буруутай вйл ажиллагаанаас шалтгаалж гарах сууц дундын өмчлөлийн эд хөрөнгө, сууц эзэмшигчдийн болон бусдын эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс хамгаалах даатгал.

Даатгалын компаниудын санал болгодог олон төрлийн даатгалаас хэрхэн сонголт хийх талаарх зөвлөгөөг дараах зургаас харж болно. Ингээд эцэст нь танд зөвлөхөд

танд хэрэггүй даатгалд бүү хамрагдаарай. Их хэмжээний хохиролд өртөх зүйлүүдээ эхний ээлжинд даатгуулах нь танд ашигтай.

Зураг 9.1. Даатгалын бүтээгдэхүүн авахад анхаарах зүйлс



9.3. Даатгалын нөхөн төлбөрийг хэрхэн яаж авах вэ?

Хэрэв даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол гарсан бол хохирлыг нөхөх үүргийг даатгагч хүлээдэг. Даатгалын төрөл, хэлбэрээс хамаарч даатгалын тохиолдол янз бүр байх ба үүнээс хамаарч даатгуулагчийн зүгээс авах арга хэмжээ ч өөр байна. Тухайлбал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдлын үед та:

- Замын цагдаагийн газар дуудлага өгөх;
- Ослын улмаас хүн бэртэж, гэмтсэн бол түргэн тусламж дуудах;
- Даатгалын компанийн шуурхай албанд дуудлага өгөх;
- Хэрэв дуудлага өгөх боломжгүй бол ослын газрын зургийг дөрвөн талаас, орчин нөхцөлийг оролцуулан, эвдрэлийг тодруулан авах;
- Осол гарсны улмаас зам түгжирсэн тохиолдолд ослын газрын зургийг авсны дараа байрнаас хөдөлгөх зэрэг арга хэмжээг авна.

Даатгуулагч даатгалын хохирлыг нөхөн төлүүлэхийн тулд даатгагчийн шаардсан баримтыг бүрүүлнэ. Даатгуулагчийн бүрдүүлэх баримт нь даатгалын төрлөөс хамаарч өөр өөр байх боловч дараах нийтлэг баримтууд шаардлагатай байдаг. Үүнд:

- Даатгалын гэрээний эх хувь;
- Даатгуулагчийн өргөдөл;
- Хохирол гарсан шалтгаан, хохирлын зүйлийг тогтоосон акт материал;
- Мэргэжлийн холбогдох байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт (засварын газрын дүгнэлт, эмчийн магадалгаа гэх мэт) ;
- Эрх бүхий байгууллагын хүлээн зөвшөөрсөн үнэлгээний компанийн гаргасан хохирлын үнэлгээний тайлан;
- Хохирлын нөхцөл байдал, орчинг харуулсан фото зураг гэх мэт.

Даатгалын нөхөн төлбөр хийгдэхгүй байж болох дараах нөхцөлүүд бий. Үүнд:

- Даатгалын тохиолдлыг санаатайгаар бүрдүүлсэн;
- Дайн байлдаан, хувьсгал, төрийн эргэлт, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, бослого, үймээний улмаас даатгалын тохиолдол болсон;
- Эвдэрч гэмтсэний дараа даатгуулсан;
- Буруутай этгээдээр хохирлоо нөхүүлсэн;
- Даатгалын хураамж төлөөгүй;
- Даатгалын төлбөр хийлгэх хугацаанд хандаагүй;

- Аж ахуйн нэгжийн ажилтны болон дээд байгууллага, харилцагчийн хариуцлагагүй үйл ажиллагаа, техник технологи, хадгалалт, тээвэрлэлтийн горим зөрчсөнөөс даатгалын тохиолдол болсон;
- Даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн

9.4. Амьдралын даатгал

Амьдралын даатгал нь хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл тохиолдсон үед даатгуулагчдынхаа орлогыг тасалдалгүй үргэлжлүүлэх, улмаар тэдний гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулах үүрэгтэй байдаг. Мөн хувь хүн болоод нийгмийн өмнөө тавьсан зорилгод хүрэхэд шаардлагатай мөнгөн хуримтлалыг бий болгох хөрөнгө оруулалтын хэрэгсэл болдог юм. Амьдралын даатгал нь ердийн даатгалтай харьцуулахад дараах онцлог ялгаатай байдаг. Үүнд:

1. Урт хугацаатай;
2. Даатгалын объект нь зөвхөн хүний амь нас, эрүүл мэнд, амьдрах баталгаат байдалтай холбоотой зүйл болдог ба үүнд: нэмэлт тэтгэвэр, тэтгэврийн даатгалын өв залгамжлал, эрүүл мэндийн даатгалын онцгой төрлүүд, хуримтлал зэргийг ойлгоно.
3. Ирээдүйд тохиолдох тодорхой эрсдэлийг /нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалт г.м./ даатгадаг.

Амьдралын даатгалын эрсдэл нь хүний амьдрах хугацаа болдог бөгөөд нас баралтын, насжилтын, эрүүл мэндийн гурван төрөлтэй байна. Үүнтэй холбоотойгоор амьдралын даатгалыг амь насны, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн гэсэн төрлүүдэд хуваадаг.

Амьдралын даатгалд хамрагдсанаар:

- Өөрийгөө болон гэр бүлийнхээ өнөөдрийг төдийгүй ирээдүйг хамгаалах;
- Өөртөө болон гэр бүлдээ санхүүгийн хөрөнгө оруулалт хийх;
- Хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулан өндөр өгөөж хүртэх;
- Ирээдүйн эрсдэлд хамгаалалттай, санхүүгийн хувьд бэлтгэлтэй байх;
- Ирээдүйдээ итгэлтэй, сэтгэл хангалуун амьдрах суурийг тавих;
- Эрүүл мэнддээ шаардагдах хөрөнгийн баталгааг бий болгох зэрэг боломж бүрдэнэ.

Иймээс амьдралын даатгалын төлөвлөлтийг хийхдээ өөрийн санхүүгийн зорилго, даатгалын хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх нь зүйтэй. Үүний тулд:

1. Ар гэрийнхэндээ хичнээн мөнгө үлдээхийг хүсч байна вэ?
2. Хэзээ тэтгэвэрт гарах вэ? Тэтгэвэрт гарсны дараа хичнээн хэмжээний нэмэлт орлого шаардлагатай болох вэ?
3. Даатгалын хураамжид хичнээн хэмжээний мөнгө төлж чадах вэ? гэдэг асуултад хариулах шаардлагатай болно. Энэ нь амьдралын даатгалын төрлүүдээс сонголт хийхэд тусална.

Амьдралын даатгал нь урт хугацаанд зөвхөн хүний амь нас, эрүүл мэнд, амьдралтай холбогдсон даатгалуудыг хийдгээрээ, ирээдүйд тохиолдох тодорхой эрсдэлийг даатгагчаараа ердийн даатгалаас ялгаатай.

9. “ДААТГАЛ, ТҮҮНИЙ ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

9.1. Даатгал түүний үүрэг, ач холбогдол

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Даатгалын тухай ойлголттой болсноор гарч болзошгүй эрсдэлийг тооцох, эд хөрөнгө болон ашиг сонирхлоо хамгаалах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томъёо:

Даатгал, эрсдэл, даатгалын зүйл, даатгалын гэрээ, даатгалын үнэлгээ, даатгалын тохиолдол, даатгалын хураамж, даатгалын нөхөн төлбөр, даатгалын баталгаа, даатгалын хугацаа, даатгалын харилцаа, даатгагч, даатгуулагч, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын актуйрч, даатгалын зохицуулагч

Хэрэглэгдэхүүн:

Даатгалын гэрээний маягт, даатгалын тухай хуулийн заалт бүхий тараах материал, даатгагч байгууллагуудын танилцуулга

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, мэдээлэл солилцох, дүгнэлт гаргах, бүлгээр ажиллах, асуулт хариулт

Сургалтын зохион байгуулалт :

Багш удирдан чиглүүлж суралцагчдын туршлага дээр үндэслэн тодорхойлолт гаргуулах, бүлгээр ажиллуулах, тайлбарлах арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Багш суралцагчидтай ямар нэг байдлаар даатгалд хамрагдаж байсан эсэх тухай ярилцана. Багш *“Хүний амьдралд учирч болох тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, учрах хохирлыг богино хугацаанд арилгах санхүүгийн арга хэрэгсэл бол даатгал”* болох чиглэл өгнө. Даатгалын нэр томъёонуудын талаар хүснэгт 9.1-д харуулсныг хэрэглэгдэхүүн байдлаар ашиглан тайлбарлана. Энэхүү хэсгийг эрсдэлийн тухай сэдэв 8.2-той холбож “даатгагддаг болон үл даатгагддаг эрсдэл” гэж ангилдаг тухай мэдээлэл өгнө. Суралцагчдаар эрсдэлүүдийг самбарт жагсаан бичүүлж даатгагддаг, үл даатгагддаг аль нь болохыг тодорхойлуулна.

Алхам 2:

Суралцагчдаар багш даатгуулах үед үүсэх “даатгалын харилцаа” гэсэн ухагдахууны тодорхойлолтыг гаргахыг хичээнэ. Энэ харилцаанд оролцогч талуудыг хүснэгт 9.2-т харуулсан байдлаар тайлбарлана.

Ингэхдээ бүлгийн ажил хэлбэрээр хийнэ. Оролцогчдыг 1-7 хүртэл тоолуулж ижил тоотой хүмүүс нэг баг гэх мэтээр 7 бүлэгт хуваана. Бүлэг тус бүрд дээрх хүснэгтэд буй нэг ойлголтыг өгч тодорхойлуулаад бүлэг тус бүрээс нэг хүнийг оролцуулан даатгалын тохиолдол болоход хэн ямар үүрэгтэй оролцохыг тайлбарлуулна.

Алхам 3:

Даатгалын харилцааг зохицуулдаг ямар хууль тогтоомж байдаг талаар багш чиглүүлж хүснэгт 9.3-т заасан хууль тогтоомжуудыг танилцуулна. Тухайлбал, Даатгалын тухай хуулийн 9-р зүйл “Даатгагчийн эрх, үүрэг”,

10-р зүйл “Даатгуулагчийн эрх, үүрэг” гэсэн хэсгийг тараах материал болгон суралцагчдад тарааж ажиллуулна. Ингэснээр даатгуулагч та ямар эрхтэй гэдгээ мэдэх боломжтой болно.

Нэмэлт мэдээлэл:

Багш санхүүгийн зохицуулах хороонд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг байдаг тухай болон энэхүү байгууллагын талаарх мэдээллийг www.frc.mn сайтаар дамжуулан хүргэнэ. Мөн Монгол улсын даатгалын зах зээлийн талаар нэмэлт мэдээлэл өгч болно.

Анхаарах зүйл:

Даатгалын гэрээг байгуулахдаа даатгуулагчийн зүгээс даатгуулж байгаа эд хөрөнгө, эрүүл мэнд, хариуцлагын талаараа үнэн зөв, бүрэн мэдээллийг даатгалын компанид мэдүүлэх үүрэгтэй байдаг. Бүрэн бус, дутуу эсвэл худал мэдээлэл өгч даатгуулсан нь тогтоогдвол даатгалын байгууллага гэрээг цуцлах эсвэл нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах эрхтэй байдаг тухай анхааруулна.

9.2. Даатгалын бүтээгдэхүүнийг сонгох

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Даатгалын ангилал, төрлийг танин мэдэж өөрийн нөхцөл байдалд тохирсон даатгалын бүтээгдэхүүнийг сонгох болон албан журмын даатгалыг хүлээн авах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

Урт хугацааны даатгал, ердийн даатгал, албан журмын даатгал, сайн дурын даатгал, арилжааны даатгал, амьдралын даатгал, амьдралын бус даатгал, эд хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал, нийгмийн даатгал, гэнэтийн ослын даатгал, эрүүл мэндийн даатгал, иргэдийн хариуцлагын даатгал, орон сууц эзэмшигчийн хариуцлагын даатгал

Хэрэглэгдэхүүн:

Даатгалын тухай хуулийн заалт бүхий тараах материал

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, мэдээлэл солилцох, мэдлэг бүтээх, бүлгээр ажиллах, асуулт хариулт

Сургалтын зохион байгуулалт:

Багш удирдан чиглүүлж бүлгээр ажиллуулах, тодорхойлолт гаргуулах, дүгнэлт зөвлөмж гаргуулах, шаардлагатай тохиолдолд тайлбарлах арга зүйг баримтлан дараах 3 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг суудлаар 2 хэсэгт хуваагаад нэг хэсгийг албан даатгалын, нөгөө хэсгээр албан бус даатгалын нэр төрлийг бичих даалгавар өгнө. Самбар ашиглан жагсаалтыг давхардуулахгүйгээр хүмүүсийг гарган бичүүлсний дараа хүснэгт 9.4-т үзүүлсэн даатгалын нэр төрлүүдтэй холбон авч үзнэ. Хүмүүсийн бичээгүй төрлийн даатгалын талаар нэмж тайлбарлал хийнэ.

Алхам 2:

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэг болгоод залуучуудын бүлэгт “Жолоочийн хариуцлагын даатгал гэж юу вэ?”,

дунд насны бүлэгт “Эрүүл мэндийн даатгал гэж юу вэ?”, ахмад насны бүлэгт “Тэтгэврийн даатгал” гэж юу вэ? гэсэн асуулт тавина. Ингэхдээ тэрхүү 3 төрлийн даатгалын тавигдах шаардлага болон хууль, эрх зүйн нөхцөлийг хэлж өгнө. Үүний дараа бүлэг тус бүр өөр өөрийн даатгалын тухай тайлбарлаж, ач холбогдлыг нь ойлгосон байвал дараагийн алхамд шилжинэ.

Алхам 3:

Суралцагчдад өөрийн туршлага болон хичээлийн явцад олж авсан мэдлэг дээрээ үндэслэн даатгалын бүтээгдэхүүн авахад юу анхаарах ёстой талаар дээрх 3 бүлэг тус бүр дүгнэлт хийх чиглэл өгнө. Ингэхдээ зураг 9.1-д үзүүлсэн анхаарах зүйлсийг тайлбарлана. Багийн ажлыг 10 минут орчим хийлгээд, бүлэг тус бүрийн төлөөлөл гарч танилцуулаад багш тэдний санаануудыг нэгтгэн дүгнэнэ.

Нэмэлт мэдээлэл:

Даатгалын хэлбэр, тодорхойлолтын талаар хүснэгт 9.5-д харуулсан агуулгыг тайлбарлаж өгнө.

Анхаарах зүйл:

Даатгалын гэрээний хугацааны туршид даатгалын зүйлийн эзэмшил, байршил, үнэлгээ болон бусад эрсдэлд нөлөөлөх мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдлуудад энэ тухай даатгагчид заавал мэдэгдэж гэрээнд өөрчлөлт оруулах үүрэгтэй байдаг тухай анхааруулна. Мөн даатгалын гэрээний нөхцөлийг сайн тохиролцох хэрэгтэй байдаг.

9.3. Даатгалын нөхөн төлбөрийг хэрхэн яаж авах вэ?

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Аливаа эрсдэлийн үед шаардагдах зүйлсийг баримтжуулах, нөхөн төлүүлэх хэрэгцээтэй бичиг баримтын бүрдэл, даатгалын нөхөн төлбөр хийгдэхгүй байж болох нөхцөлүүдийг тооцох чадвартай болох.

Хэрэглэгдэх нэр томьёо:

Даатгалын нөхөн төлбөр, даатгуулагчийн өргөдөл

Хэрэглэгдэхүүн:

Даатгалын гэрээний маягт, тараах материал

Сургалтын арга:

Тодорхойлох, тайлбарлах, мэдээлэл олж авах, бүлгээр ажиллах, тооцоолон бодох

Сургалтын зохион байгуулалт :

Багш мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах, бүлгээр ажиллуулах, дүгнэлт гаргуулах арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Багш суралцагчдаас даатгалын нөхөн төлбөр авч байсан эсэх талаар асууж тийм туршлагатай хүн байвал ямар төрлийн даатгалд хамрагдсан, бүрдүүлсэн бичиг баримт, нөхөн төлүүлэх үйл ажиллагаа хэрхэн явагдсан талаарх мэдээллийг яриулна.

Хэрэв энэ талаар туршлагатай суралцагч байхгүй бол багш даатгалын нөхөн төлбөр авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг үзүүлэн тайлбарлана. Тухайлбал, гэнэтийн ослын даатгалын нөхөн төлбөр авахад

дараах материалыг бүрдүүлнэ.

Үүнд:

- Нөхөн төлбөр авахыг хүссэн өргөдөл
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Өвчний түүх хуулбар /истори/, эмнэлгээс гарах үеийн эмчийн дүгнэлт /эпикриз/, дэлгэрэнгүй бичигдсэн амбулаторийн карт
- Эмнэлгийн хуудас /лист/-ны хуулбар
- Ажил олгогчийн хүсэлт /хэрэв групп даатгалд хамрагдсан бол/
- Компьютер томограмм хийлгэсэн бол эмчийн дүгнэлттэй хамт хавсаргах
- Гэнэтийн осол /авто осол, хүнд зодуулах г.м/-д орсон бол ослын талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт, гэмтлийн эмнэлэг, эсхүл шүүх эмнэлгийн эмчийн үзлэг хийсэн баримт
- Даатгалын баталгааны хуулбар
- Рентген зураг
- Ослын талаарх дэлгэрэнгүй бичсэн өргөдөл гэх мэт

Алхам 2:

Даатгалын нөхөн төлбөр хийгдэхгүй байж болох нөхцөлүүдийг суралцагчдын таамаглалаар самбарт бичүүлж багш нэмэлт мэдээлэл өгөн жагсаалтыг баяжуулна. Хувь хүнээс хамаарсан нөхцлүүдээс болж даатгалын нөхөн төлбөр хийгдэхгүй байхаас сэргийлэх талаар багш мэдээлэл өгнө.

Нэмэлт мэдээлэл:

Нөхөн төлбөр өгөх үйл ажиллагаа хэрхэн явагддаг талаар багш нэмэлт мэдээлэл өгнө.

Үүнд:

- Нөхөн төлбөрийн материалыг шалгаж, хүлээж авна.
- Нөхөн төлбөрийн материалтай холбогдох албан тушаалтнууд танилцаж дүгнэлт гаргана.
- Шаардлагатай бол даатгуулагчтай холбоо барьж, нэмэлт материал авах, тодруулга хийнэ.
- Нөхөн төлбөрийг гэрээнд заасан хугацааны дагуу даатгуулагчийн дансанд шилжүүлнэ.

Анхаарах зүйл:

Хэдийгээр гэрээ хийгдсэн ч даатгалын нөхөн төлбөр хийгдэхгүй байх тохиолдлуудын талаар тайлбарлаж өгнө.

9.4. Амьдралын даатгал

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Амьдралын даатгалын онцлог болон давуу талуудыг тодорхой мэдэх, энэ төрлийн даатгалын төлөвлөлтийг хийх чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томъёо:

Амь насны даатгал, хуримтлалын даатгал, эрүүл мэндийн даатгал

Хэрэглэгдэхүүн:

Амьдралын даатгал болон ердийн даатгалын ялгааг харуулсан баганан мэдээлэл бүхий цахим үзүүлэн, тараах материал.

Сургалтын арга:

Тодорхойлох, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Багш шинэ мэдээлэл өгөх, суралцагчдыг бүлгээр ажиллуулж мэдлэг бүтээлгэх, тайлбарлуулах, дүгнэлт хийлгэх арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчид ердийн даатгалын талаар мэдлэгтэй болсон тул дээрх мэдлэг дээр тулгуурлан амьдралын даатгал гэж юу вэ? гэдгийг тодорхойлуулах оролдлого хийлгэнэ. Ингэхдээ багш амьдралын даатгалд ямар ямар даатгал хамаарах талаар дараах бүдүүвч зураг ашиглан тайлбарлана.



Алхам 2:

Багш суралцагчдыг суудлаар 4 бүлэг болгоод 1-р бүлэгт “амь насны”, 2-р бүлэгт “хуримтлалын”, 3-р бүлэгт “тэтгэврийн”, 4-р бүлэгт “эрүүл мэндийн амьдралын даатгал”-ын ач холбогдлын талаар бичих даалгавар өгнө. Ингэхдээ ердийн даатгалаас амьдралын даатгалын ялгарах ялгааг тайлбарлах үндсэн дээр хийлгэнэ. 10 минут орчим бүлгийн ажил хийлгээд тус бүрийн төлөөллийн тайлбарыг сонсоод амьдралын даатгалын ач холбогдлыг тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл:

Амьдралын даатгалын үйлчилгээ үзүүлдэг компаниудын талаар мэдээллийг өгнө.

Анхаарах зүйл:

Ердийн даатгал богино хугацааны байдаг бол амьдралын даатгал урт хугацааны байдгаараа онцлог гэдгийг суралцагчдад ойлгуулах хэрэгтэй.

СЭДЭВ 10. ТАТВАР ТАНЫ АМЬДРАЛД

“Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмуй”

Чингис хаан

10.1. Татварын тухай ойлголт

Таны хөдөлмөрлөж олсон орлогоосоо төлсөн татвар ямар ач тустай вэ?

Татвар нь төрийн оршин тогтнох үндэс болдог. Өөрөөр хэлбэл төр үйл ажиллагаа явуулах, улс орныг батлан хамгаалах, эдийн засаг, нийгмийн хэрэгцээг хангах, хөгжүүлэхэд шаардлагатай мөнгийг татвараар бүрдүүлнэ. Таны төлсөн татвар зөвхөн улс эх орны хөгжлөөр зогсохгүй танд, таны үр хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, тав тухтай амьдралд чухал ач холбогдолтой. Тухайлбал:

1. Үйлдвэр, сургууль, цэцэрлэг барих, зам тавих гэх мэт төсвөөс зарцуулж байгаа мөнгийг татвараар бүрдүүлдэг.
2. Таны үр хүүхдийг үнэ төлбөргүй боловсрол эзэмших, сурч хүмүүжихэд татварын мөнгөний тодорхой хэсгийг зарцуулдаг.
3. Орлого олох боломжгүй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд зориулах нийгмийн халамжийн үйлчилгээний зардлыг мөн л татварын мөнгөнөөс зарцуулдаг.

Энэ мэтчилэн татварын ач тусыг дурдаад байвал багагүй. Иймээс хүн бүр татвараа үнэнч шударгаар төлж хэвших нь улс орны хөгжил, түүгээр дамжаад иргэдийн сайн сайхан амьдралд хэрэгтэй.

Та үүнийг мэдэх үү?

Монгол Улсын иргэний үндсэн үүргийн нэг нь хуулиар ногдуулсан албан татвар төлөх явдал юм.

Иргэн бүр татвар төлөх үүргээ биелүүлэхийн зэрэгцээ төлсөн татварынхаа мөнгийг юунд зарцуулагдаж байгааг хянаж байх хэрэгтэй. Үүний тулд татварын зохих мэдлэг шаардагдана.

Татвар: Хувь хүн, байгууллагын олсон орлого, ашиг, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнээс хуулинд заасан хувь хэмжээгээр авч, улсын төсөвт оруулж байгаа мөнгийг хэлнэ.

Улсын төсөв: Засгийн газрын мэдэлд төвлөрч, улс орны нийгэм, эдийн засгийн хэрэгцээнд зарцуулдаг мөнгөн хөрөнгийн сан юм.

Татварыг шууд болон шууд бус татвар гэж ангилна.

Шууд татвар: Татвар төлөгчийн орлого, Жишээ нь: Та сард 500 000 төгрөгийн ашгийн хэмжээ, эд хөрөнгийн үнийн цалин авдаг бол таны цалингийн орлогоос дүнгээс хамааруулан хэмжээг нь тогтоож, 10%-иар тооцож, хувь хүний орлогын хураан авч байгаа татварыг хэлнэ. албан татварыг хураан авдаг.

Шууд бус татвар: Татвар төлөгчийн үйл ажиллагааны үр дүнгээс хамааралгүйгээр тодорхой нэрийн бараа, үйлчилгээнд ногдуулж байгаа татвар юм.

Шууд бус татварыг татвар төлөгч хэдий хэмжээний ашиг, орлого олсон, ямар хөрөнгө эзэмшиж байгаагаас үл хамаарч бараа, үйлчилгээний үнээр дамжуулан хураан авч байгаа татвар юм. Энэ татварыг бараа, үйлчилгээний үнэд шингээсэн байдаг. Иймээс шууд бус татвар ногдуулсан бараа, үйлчилгээг худалдан авсан хэрэглэгч


тухайн татварыг төлнө. Жишээ нь: Таны худалдан авсан талхны үнэд нэмэгдсэн өртгийн албан татвар шингэсэн байдаг. Та талх худалдан авснаар үнээр дамжуулан уг татварыг төлдөг.

Татварын хуулинд заасан хувиар тооцож авахаас гадна хэдий хэмжээний орлого олсныг нь тэр бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээний орлого, зарим хөрөнгөнд тогтмол мөнгөн дүнгээр татвар ногдуулдаг. Тухайлбал, Улаанбаатар хотод оршин суудаг, цаг засварлах үйлчилгээ эрхэлдэг иргэн сар бүр 3000 төгрөгийн¹³ тогтмол татвар төлөхөөр хуульд заасан байдаг.

Тогтмол татвар: Татвар ногдуулах зүйлд тогтмол мөнгөн дүнгээр ногдуулж буй татварыг хэлнэ.

Хувь хүний төлдөг татварыг үндсэн дөрвөн төрөлд хувааж болно.

Зураг 10.1. Олон улсын жишгээр хувь хүний төлдөг татварын төрөл



10.2. Хувь хүний орлогын албан татвар, түүнийг тооцоолох нь

Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь хувь хүний хөдөлмөр эрхлэх, хөрөнгө борлуулах зэргээр олсон бүх орлогод ногдох албан татвар юм. Уг татварын харилцааг “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-иар зохицуулна. Хувь хүний орлогын албан татвар төлөгч нь тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, орлого олоогүй ч хуульд заасан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

Татвар төлөгч: Өөрийн олсон орлого, эзэмшиж байгаа хөрөнгөдөө ногдох татварыг төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татвар төлөгч байна.

“Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-д зааснаар хувь хүн олсон дараах орлогоосоо татвар төлнө. Өөрөөр хэлбэл, хувь хүний олсон орлогыг дараах байдлаар ангилдаг. Зураг 10.2-ыг харна уу.

¹³ Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль, 2001 он. 5.1.2 дахь заалт.

Зураг 10.2. ХХОАТ ногдох орлого



Хувь хүний орлогын хамгийн гол эх үүсвэр нь цалингийн буюу хөдөлмөрийн хөлсний орлого байдаг. Иймээс цалингаасаа хичнээн хэмжээний татвар төлж байгаагаа тооцоолж сурах нь орлогоо төлөвлөх, цалинг зөв бодсон эсэхийг хянахад хэрэгтэй.



Тэмүүлэнд тохиолдсон сургамжтай явдал

Тэмүүлэн дээд сургууль төгссөн даруйдаа нэгэн байгууллагад ажилд оржээ. Хөдөлмөрийн гэрээнд сарын 500,000 төгрөгийн цалин олгоно гэж бичсэн байв. Ажилд орсныхоо маргааш орой эхнэр Солонгын хамт цалингаа юунд зарцуулах тухайгаа ярилцаж, төсөв зохиов. Үүнд: Анхны цалингаасаа гэр бүлийнхэндээ бэлэг авч өгөх, хүүгийнхээ цэцэрлэгийн мөнгийг төлөх, ажилдаа ирж очих унааны зардал, өдрийн хоолны мөнгө гэх мэт шаардлагатай зардлуудаа төлөвлөж, 500,000 төгрөгийн орлогоо бүгдийг хуваарилжээ. Сарын эхний цалингаас төлөвлөсөн зүйлдээ мөнгөө зарцуулж эхлэв. Хүүгийнхээ цэцэрлэгийн мөнгийг сүүлийн цалин дээрээс өгөхөөр тооцсон байв.

Гэтэл сарын сүүлийн цалин буухад Тэмүүлэн тооцоолж байснаас 88,000 төгрөгийн дутуу цалин авчээ. Хүүгийнхээ цэцэрлэгийн мөнгийг яаж төлөх вэ? гэдэг том асуудал үүсэв.

УЧИР ЮУНД БАЙНА ВЭ???

Тэмүүлэн цалингаас татвар суутган авдгийг мэддэггүй байжээ.

Хувь хүний олгохоор тооцсон цалингаас байгууллага нь нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл (хуулийн дагуу хувь хүний өөрийн төлөх

10%)-ийг суутган авч, нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлнэ. Түүний дараа ХХОАТ-ыг 10%-иар тооцно. Үүнээс ХХОАТ-ын хөнгөлөлт болох сарын 7000 (84000₮/12 сар) төгрөгийг хасаж төлөх татварын дүнг гаргана. Учир нь “Хувь хүний орлогын албан татварын хууль”-ийн 24.1-д заасны дагуу хувь хүний цалин хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогод ногдох жилийн албан татвараас 84000 төгрөгийг хөнгөлдөг¹⁴. Эдгээрийг тооцож, суутгаж авсны дараа гарт олгох цалингийн дүн гардаг. Энэ аргачлалын дагуу Тэмүүлэнгийн цалингийн орлогоос авах татварыг тооцоолъё.

Зураг 10.3. Цалингийн орлогод ногдох татварын тооцоолол



10.3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Улс орны төр, Засгийн газар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулан иргэдийн сайн сайхан амьдралыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг явуулна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт: Татвар төлөгчийн олсон орлогыг татвараас чөлөөлөх болон төлбөл зохих татварыг бууруулах үйл ажиллагааг хэлдэг.

Зураг 10.4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн ач холбогдол

Бага татвар төлснөөр гарах зардал багасч, мөнгө хуримтлуулах боломжтой болно.

Татварт өгч байсан мөнгөө хуримтлуулан бизнес эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломжтой болно.

Хүн амын эмзэг, ядуу хэсгийн амьдралд тус нэмэр болно.

Хууль тогтоомжийн дагуу иргэнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхдээ:

- Олсон орлогыг нь татвараас чөлөөлөх;
- Төлбөл зохих татварыг нь багасгах 2 хэлбэрээр хэрэгжүүлнэ.


¹⁴ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, (2018). 24.1 дэх заалт.

Зураг 10.5. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт



Хувь хүн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхийн тулд шаардагдах материалыг бүрдүүлж, харьяа татварын албанд өгнө.

Зураг 10.6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд бүрдүүлэх баримт




Эдгээрээс гадна ямарч төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж байгаагаас хамаарахгүйгээр дараах бичиг баримтыг заавал бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

- Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр, хуулбарын хамт;
- Нийгмийн даатгалын дэвтэр, хуулбарын хамт;
- Ажлын газрын цалингийн тодорхойлолт;
- Иргэний өөрийн данс, банкны нэр;
- Татвар төлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэхдээ дараах хэлбэрүүдээс аль нэгийг сонгож хөнгөлөлт эдлэх тухай бичгээр гаргасан өргөдөлдөө бичнэ.


Зураг 10.7. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх хэлбэр



10.4. Татварын тайлан гаргах, төсөвт төлөх

Хувь хүн орлогын албан татварын тайлангаа хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн хуудсаар гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ.

Зураг 10.8. Татварыг төсөвт төлөх хэлбэр



Байгууллага нь хувь хүнд орлого олгох тухай бүрдээ ногдох татварыг суутган авч төсөвт оруулна. Хувь хүн өөрийн төлөх татварыг хуульд заасан хугацаанд төсөвт төлөх үүрэгтэй. Хувь хүний төлсөн татварыг “Татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэр”-т (иргэдийн ярьж заншсанаар “Цэнхэр дэвтэр”) тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулна. Энэ нь банкнаас зээл авах үед тухайн хүний олсон орлогыг тодорхойлох гол баримт болдог. Ялангуяа, хувиараа бизнес хийж байгаа иргэдийн хувьд чухал ач холбогдолтой юм. Тэд ихэвчлэн нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй тул орлого олсон гэдгээ нотлох баримт байдаггүй. Мөн татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэхэд татварын тайлангаа зохих хугацаанд нь гаргаж тушаасан байхыг шаарддаг. Түүнчлэн хилээр бараа бүтээгдэхүүн, автомашин, хувийн хэрэглээний зүйлс оруулж ирэхэд энэхүү дэвтрийн таних дугаараар гаалийн бүрдүүлэлт хийнэ.

Зөвлөмж: Та “Цэнхэр дэвтэр” авахын тулд өөрийн амьдарч байгаа дүүргийн татварын албанд иргэний үнэмлэх, 2% зурагтай очиж бүртгүүлээрэй.

Хүснэгт 10.1. Хувь хүн өөрөө төсөвт төлөх татварын хувь, хугацаа

№	Орлогод ногдох татвар	Татвар %	Төлөх хугацаа
1	Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар	2	д а р а а у л и р л ы н э х н и й сарын 15- ны өдрийн дотор;
2	Түрээсийн орлогод ногдох албан татвар	10	
3	Үйл ажиллагааны орлогод ногдох албан татвар	10	
4	Өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг бусдад ашиглуулснаас олсон орлогод ногдох албан татвар	10	
5	Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар	10	
6	Хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татвар	10	

10: “ТАТВАР ТАНЫ АМЬДРАЛД” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

10.1 Татварын тухай ойлголт

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Татварын талаар зөв ойлголттой болох, татварын тооцоолол хийж сурах

Хэрэглэгдэх нэр томьёо:

Татвар, улсын төсөв, шууд ба шууд бус татвар, тогтмол татвар, хэрэглээний татвар, хөрөнгийн татвар, өв залгамжлал, бэлэглэлийн татвар, орлогын татвар

Хэрэглэгдэхүүн:

Татварын ашиг тусыг харуулсан зурагт үзүүлэн, татварын төрлүүдийн бүдүүвч зураг, тооны машин

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, тайлбарлах, мэдээлэл олж авах, тооцоолон бодох

Сургалтын зохион байгуулалт :

Мэдээлэл өгөх, тайлбарлах, мэдлэг бүтээлгэх, тооцоолон бодох, бүлгээр ажиллуулах арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Татвар гэж юу болох, татвараас ангид байж болох эсэх талаар суралцагчидтай чөлөөт ярилцлага хийнэ. Тэднийг *“Хувь хүн, байгууллагын олсон орлого, ашиг, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнээс хуулинд заасан хувь хэмжээгээр авч улсын төсөвт оруулж байгаа мөнгийг татвар гэнэ”* гэсэн тодорхойлолтын болон *“татвар төлдөггүй нэг ч хүн байдаггүй бөгөөд татвар нь төрийн зүгээс нийгмийн сайн сайхны төлөө хийгддэг ажлын санхүүгийн эх үүсвэрийг бий болгодог”* гэдэг санааг гаргуулах, *“төр оршихуйн үндэс татвар юм”* гэдэг дүгнэлт хийхэд тусална.

Татвар төлөх бол иргэний журамт үүрэг бөгөөд татварын талаар зохих мэдлэгтэй байхыг шаарддаг тул татвар төлөгчийн төлсөн мөнгө яаж зарцуулагдаж байгааг хянадаг болгохын тулд яах ёстой талаар багш чиглүүлэн суралцагчдын оролцоог дэмжин ярилцана.

Алхам 2:

Багш Монгол улсын татварын бүтэц, зохион байгуулалт болон татвар төлөгчдийн төлөх татварын талаар бүдүүвч зураг ашиглан тайлбарлана. Ингэхдээ зураг 10.1-д үзүүлсэн 4 төрлийн үндсэн татварыг заавал төлөх ёстой тухай тайлбар хийнэ. Бидний хувь хүний орлогын албан татвар төлдөг бөгөөд энэ нь улсын төсөвт шууд ордог дээрх 4 төрлийн татварын сонгодог жишээ гэдгийг тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл:

Татвар төлөгчдийн мөнгө болон улсын орлогоос бүрддэг улсын болон орон нутгийн төсвийг хэрхэн бүрдүүлдэг, хэрхэн зарцуулдаг талаар мэдээллийг өгнө.

Анхаарах зүйл:

Монгол улсын иргэний үндсэн үүргийн нэг бол хуулиар ногдуулсан албан албан татвар төлөх явдал бөгөөд хэрэв татвар төлөхөөс зайлсхийвэл төр хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэг тухай сануулна.

10.2. Хувь хүний орлогын албан татвар, түүнийг тооцоолох нь

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Хувь хүний орлогын албан татварт хир хэмжээний мөнгө төлж байгаагаа тооцоолох, орлогоо төлөвлөх, цалинг зөв бодсон эсэхийг хянах чадвартай болох

Хэрэглэгдэх нэр томьёо:

ХХОАТ, ХХОАТ ногдох орлого, татвар төлөгч

Хэрэглэгдэхүүн:

ХХОАТ ногдох орлогын төрлийг харуулсан бүдүүвч зураг, тооны машин

Сургалтын арга:

Тодорхойлолт өгөх, мэдээлэл олж авах, тооцоолон бодох

Сургалтын зохион байгуулалт :

Мэдээлэл өгөх үндсэн дээр суралцагчдаар мэдлэг бүтээлгэх, тайлбарлуулах арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Багш ХХОАТ-ын тухай суралцагчдаас асууж тодруулаад “ХХОАТ-ыг хувь хүний ямар орлогоос авдаг вэ?” гэсэн асуултад анхаарлаа хандуулж зураг 10.2 –ыг үзүүлж ярилцана.

Дараах хүснэгтийг хэрэглэгдэхүүн болгон тайлбарлаад суралцагчдаар өөрсдийнх нь амьдралын туршлагад тулгуурласан жишээн дээр ногдох татварын тооцоолол хийлгэнэ. Тухайлбал цалингийн орлого болон худалдан авсан бараа, бүтээгдэхүүний үнийн дүнгийн 10 хувь гэх мэт.

Орлогын төрөл	Албан татварын хувь хэмжээ
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	10 %
Үйл ажиллагааны орлого	10%
Хөрөнгийн орлого	10%
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлого	2%
Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого	5%
Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын буй шагнал	5%
Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого	40%
Шууд бус орлого	10%

Алхам 2:

Суралцагчдаас цалин хөлсөө зөв бодсон эсэхийг нягталж шалгадаг талаар асууж суралцагчдаар цалингийн орлогод ногдох татварын тооцооллыг

хийлгэнэ. Ингэхдээ багш зураг 10.3-т үзүүлсэн цалингийн орлогод ногдох татварын тооцоолол хийсэн Тэмүүлэнгийн цалингийн орлогод ноогдох татварын бодолтын жишээг үзүүлнэ.

Харин санхүүгийн дундаас дээш мэдлэгтэй хэсэгт дараах хэлбэрийн тооцоолол хийлгүүлж болно.

Үүнд:

- Сарын үндсэн цалин 680,000 төгрөг , хоол унааны нэмэгдэл 88000, ур чадварын нэмэгдэл үндсэн цалингийн 15 хувь бол гарт олгох цалингийн хэмжээг тооцно уу.
- Ажилласан жил-14 жил, сарын үндсэн цалин 560,000 төгрөг, цалинтай адилтгах орлогын нийлбэр 136,500 төгрөг бол ээлжийн амралтын цалинг тооцоолно уу зэрэг.

Нэмэлт мэдээлэл:

Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны болон автомашины татвар зэрэг заавал төлөх татварын бодолтын аргачлалыг заана.

Анхаарах зүйл:

Цалин бодоход хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос (ур чадварын нэмэгдэл, хоол, унааны мөнгө г.м) НД, ЭМДШ-д 10 хувь төлөх суутгаад хассан дүнгээс ХХОАТ-т 10 хувь төлөх боловч хуульд заасан хөнгөлөлтийн дагуу 7000 төгрөг хасч төлнө гэдгийг сануулна.

10.3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Суралцагчид татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдаж сурах, холбогдох материалыг зөв бүрдүүлэх чадвартай болно.

Хэрэглэгдэх нэр томъёо:

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, албан татвараас чөлөөлөгдөх орлого, ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, үл хөдлөх хөрөнгийн албан татварын хөнгөлөлт, үл хөдлөх хөрөнгийн албан татвараас чөлөөлөгдөх хөрөнгө

Хэрэглэгдэхүүн:

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд бүрдүүлэх материалын жагсаалт бүхий үзүүлэн, тараах материал

Сургалтын арга:

Тодорхойлох, мэдээлэл олж авах, тооцоолон бодох

Сургалтын зохион байгуулалт :

Сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх, тайлбарлах, суралцагчдаар тооцоо хийлгэх арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдаас татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж байсан суралцагч байвал анхаарвал зохих ямар асуудал байсан талаар ярилцлага өрнүүлэн уг сэдвийн талаарх суурь ойлголт хир байгааг багш тодорхойлно. Үүний дараа багш “Татвар төлөгчийн олсон орлогыг татвараас чөлөөлөх болон төлбөл зохих татварыг бууруулах үйл ажиллагааг татварын хөнгөлөлт чөлөөлөлт гэнэ” гэсэн тодорхойлолтыг өгөөд зураг 10.4-т ач холбогдлыг танилцуулна. Мөн зураг 10.5-д харуулсны дагуу болон татварын тухай хуулийн албан татварын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой хуулийн

заалтыг үзүүлэн нэмэлт тайлбар өгнө. Жишээ нь: Татварын тухай хуулийн 24-р зүйл гэх мэт.

Алхам 2:

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд бүрдүүлэх баримтуудыг багшийн зүгээс сургалтын хэрэглэгдэхүүн болгон бэлтгэж харуулаад суралцагчдын туршлагаас хуваалцана. Жишээ нь: Орон сууцны хөнгөлөлт авахын тулд бүрдүүлэх материалын жагсаалт гэх мэт.

Энэ татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд бүрдүүлэх материалыг зураг 10.6-д харуулсны дагуу болон зураг 10.7-г хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хэлбэрүүдийг харуулсны дагуу тайлбарлал хийнэ.

Нэмэлт мэдээлэл:

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бусад хэлбэрүүдийн талаар нарийвчилсан мэдээллийг хүргэнэ. Тухайлбал, гаалийн болон онцгой албан татвараас чөлөөлөгдөх нөхцөл, тухайлан гарсан шийдвэр зэргийн талаар тайлбарлана.

10.4 Татварын тайлан гаргах, төсөвт төлөх

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Өөрийн төлөх татварыг тогтоосон хувь хэмжээгээр хуулийн хугацаанд нь төлж хэвших, тэгснээр татварын буцаан авалт авах нөхцөл бүрдэх тухай мэдэж авах

Хэрэглэгдэх нэр томьёо:

Татварын тайлан, татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэр / Цэнхэр дэвтэр/, орлогод ногдох татвар

Хэрэглэгдэхүүн:

“Цэнхэр дэвтэр”, хувь хүн төсөвт төлөх татварын хувь хэмжээ, хугацааг илэрхийлсэн мэдээлэл бүхий цахим үзүүлэн

Сургалтын арга:

Тодорхойлох, мэдээлэл олж авах, тооцоолон бодох

Сургалтын зохион байгуулалт:

Сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх, тайлбарлах, бүлгийн ажил хийлгэх, мэдлэг бүтээлгэх, мэдлэгээ бататгах арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Хувь хүн, байгууллага татварын тайлангаа хуулийн хугацаанд багтаан гаргаж, төсөвт төлөх татвараа хугацаанд нь төлж байх ёстой. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд татварыг тогтоосон хугацаанд төлсөн байх шаардлага тавигддаг тухай суралцагчидтай ярилцана. Сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан суралцагчдад хувь хүн өөрөө төсөвт төлөх татварын хувь, хугацааг харуулсан хүснэгтэн мэдээллийг өгч тооцоолол хийж сурсан мэдлэгээ бататгана. Ингэхдээ хүснэгт 10.1-д үзүүлсэн хувь хүний төсөвт төлөх хувь хэмжээний тухай мэдээллийг заавал өгнө.

Алхам 2:

Багш суралцагчдаас татварын “Цэнхэр дэвтэр”-т төлсөн татвараа бүртгүүлж баталгаажуулдаг эсэхийг асууж энэ нь орлого тодорхойлох гол

баримт гэдгийг ойлгуулна. Нийгмийн даатгал төлдөггүй хувиараа бизнес хийдэг хүмүүс энэхүү дэвтрийн бичилтийг тогтмол хийлгэх нь банкнаас зээл авах үед орлого тодорхойлох баримт болдог ач холбогдолтой тухай тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл:

Татвартай холбоотой мэдээлэл авахыг хүсвэл Татварын ерөнхий газрын <http://www.mta.mn>, холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээлэл авах бол <http://www.legalinfo.mn> цахим хуудаснаас авч болно.

Анхаарах зүйл:

Хувь хүн татвараас зайлсхийх нь гэмт хэрэг бөгөөд илэрсэн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээдэг тул заавал ийм байдалд хүрэхгүйгээр татвараа тогтмол, үнэн зөвөөр төлж байх нь иргэний үүрэг гэдгийг ухамсарлуулахад анхаарах хэрэгтэй.

СЭДЭВ 11. ТЭТГЭВЭР

11.1. Тэтгэврийн даатгал

Тэтгэврийн даатгал ямар ач холбогдолтой вэ?


Хэрэв тэтгэвэрт гарсны дараах үеэ амьдралын тав тухтай, жаргалтай хугацаа байлгахыг хүсэж байгаа бол амьжиргааны хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц мөнгөтэй байх шаардлагатай. Тэтгэвэрт гарсны дараа бусдаас байнга тусламж, хангамж аваад байх боломжгүй. Иймээс аль болох эртнээс төлөвлөж, тэтгэврийн насандаа хэрэглэх зориулалтаар мөнгө хуримтлуулж эхлэх хэрэгтэй. Хамгийн шилдэг арга нь тэтгэврийн даатгал!



Өндөр насны тэтгэвэр: Тэтгэврийн даатгалд даатгуулсан бөгөөд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол хангаж, тэтгэвэр тогтоолгосон хувь хүнд сар бүр, нас барсны дараагийн сар дуустал олгодог мөнгийг хэлнэ.

Тэтгэврийн даатгал бол нийгмийн даатгалын нэг төрөл юм. Нийгмийн даатгалыг төрөөс хэрэгжүүлдэг бөгөөд 5 төрлийн даатгалыг өөртөө багтаадаг.

Зураг 11.1. Нийгмийн даатгалд даатгуулах хэлбэр



Нийгмийн даатгалд даатгуулснаар өвдөх, өндөр насалсны улмаас хөдөлмөрийн чадваргүй болох, ажлаас халагдах, үйлдвэрлэлийн осолд орох зэргээр хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон үедээ тэтгэвэр, тэтгэмж авах замаар орлого олох боломжоор хангагдана. Мөн нийгмийн даатгалын сангаас ажилгүй болсон даатгуулагчдыг сургах, эмчилгээ, сувилгаа, хиймэл эрхтний үнийг төлөх зэрэгт зориулж мөнгө зарцуулдаг.

Нийгмийн даатгалыг төрөөс хэрэгжүүлдэг, ашгийн төлөө бус даатгал юм. Нийгмийн даатгалд иргэд заавал болон сайн дураар даатгуулж болно.

Зураг 11.2. Нийгмийн даатгалд даатгуулах хэлбэр

Албан журмаар даатгуулах	Сайн дураар даатгуулах
<ul style="list-style-type: none"> • Байгууллагатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй хувь хүн; • Төрийн албан хаагч; • Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын байгууллага, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа хувь хүн. 	<ul style="list-style-type: none"> • Хуульд заавал даатгуулахаар зааснаас бусад тодорхой хөдөлмөр эрхлээгүй хувь хүн.

Иргэд тэтгэврийн даатгалд даатгуулж, өндөр насны тэтгэвэр авах болзлыг хангасан тохиолдолд тэтгэврээ тогтоолгон авах эрх үүснэ.

Зураг 11.3. Өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх



Мөн дараах даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй¹⁵.

	<p>Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 түүнээс дээш хүүхдийг 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, 50 нас хүрсэн бол;</p>
	<p>Газрын дор болон хөдөлмөрийн халуун нөхцөлд ажиллаж, тодорхой болзлыг хангасан даатгуулагч;</p>
	<p>Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад хуульд заасан мэргэжлээр 20-иос доошгүй жил ажилласан, эсвэл нийтдээ 25-аас доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн иргэн;</p>
	<p>25-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр.</p>

¹⁵ Монгол Улсын хууль, (1994). Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 4-р зүйл.


1960 оноос өмнө төрсөн иргэд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаа, тэтгэвэр тооцож буй цалингийн дунджаас хамаарч ялгаатай тэтгэвэр авдаг. Харин 1960 оноос хойш төрсөн иргэд тэтгэврийн даатгалд зориулж төлсөн шимтгэлээ өөрийн нэрийн дансанд байршуулж, тэтгэвэр тогтоолгох болзол хангасан үедээ уг дансанд хуримтлагдсан хөрөнгөөс хамаарч тэтгэвэр авна. Өөрөөр хэлбэл, даатгуулагчийн ирээдүйд авах тэтгэврийн хэмжээ түүний ажиллах хугацаандаа авч байсан цалингаас биш, харин түүний төлсөн шимтгэлийн нийт хэмжээнээс хамаарна.



Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс: Тэтгэврийн даатгалд даатгуулагчийн нэр дээр нээсэн, даатгалын шимтгэлийг хуримтлуулан тооцож, даатгуулагч тэтгэвэрт гарах болзол хангасан үед уг дансанд хуримтлагдсан мөнгөнөөс тэтгэвэр олгох агуулга бүхий данс юм.

Өндөр насны тэтгэврийн тухай гэр бүлийн яриа

Нэгэн өдөр Самбуу өвөө тэтгэврээ аваад ач нартаа чихэр, жимс авч өгчээ. Үүнээс үүдээд тэдний гэр бүлийнхэнд тэтгэврийн тухай яриа өрнөлөө.



Энэ ярианд гэр бүлийн бүх гишүүд оролцлоо.

Тэнгис: Эмээ та яагаад өвөөгөөс бага тэтгэвэр авдаг юм бэ?

Эмээ: Эмээ нь залуудаа өвөөгөөс нь бага цалин авч байсан юм. Тиймээс бага мөнгө авч байгаа юм.

Тамир: Аав та тэтгэвэрт гарахаараа цалинтайгаа адилхан их мөнгө авах уу?

Аав: Үгүй ээ. Тэтгэврийн мөнгө тухайн хүний тэтгэвэр тооцуулахаар сонгон авсан дараалсан 5 жилийн дундаж цалингийн 45 хувьтай тэнцүү байдаг юм. Мөн хэдэн жил ажилласан, ямар хугацаанд шимтгэл төлж байсан гээд олон зүйлээс хамаарна.

Тэнгис: Ээжээ та ажил хийдэггүй юм чинь өвөө, эмээ шиг настай болохоороо тэтгэвэр авч чадахгүй яанаа?

Ээж: Ажил хийдэггүй хүн ч гэсэн тэтгэвэр авч болно.

Тэнгис: Та цалин авдаггүй байж яаж тэтгэвэр авах юм бэ? Эмээ авч байсан цалингийн хэмжээнээс хамаарч тэтгэврийн мөнгө авдаг гэсэн.

Ээж: Нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулж, шимтгэл төлөөд байвал өндөр настай болохоороо тэтгэвэр авч чадна.

Тамир: Та тэгвэл хурдан даатгуулаад намар хичээл эхлэхээс өмнө тэтгэврээ аваад цүнх авч өгөөрэй.

Аав: Өндөр насны тэтгэвэр авахын тулд 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байх ёстой. Тэгээд ч ээж нь дөнгөж 43 настай болохоор тэтгэвэр авах насанд хүрээгүй.

Тэнгис: Хэдэн нас хүрсэн хүн тэтгэвэр авдаг юм бэ?

Аав: Аав нь 60 нас, ээж нь 55 нас хүрч байж тэтгэвэр авах насанд хүрнэ.

Тэнгис: Та хоёр ч тэгвэл залуухан байгаа юм байна.

Аав: Тэтгэврийн даатгалд аль болох залуу наснаасаа даатгуулах хэрэгтэй. Ээжийн чинь хувьд харин ч оройтсон байна шүү.

Тэмүүлэн: Ээжээ та сонсож бай даа. Та одоо 43 настай.

Нийгмийн даатгалд сайн дураараа даатгууллаа гэхэд 55 хүрэх үед дөнгөж 12 жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байх тул хувь тэнцүүлсэн тэтгэвэр л тогтоолгоно. Иймээс та бага тэтгэвэр авах болно. Харин та амьдралын даатгалын үндсэн нэг төрөл болох сайн дурын нэмэлт даатгалд даатгуулбал нэмэлт тэтгэвэр авах боломжтой болно шүү.



Ээж: Баярлалаа. Би энэ талаар мэддэггүй байсан юм. Одоо ч тэтгэврийн талаар санаа зовох зүйлгүй боллоо. Нийгмийн даатгалдаа ч сайн дураар даатгуулъя. Нэмэлт тэтгэврийн даатгалдаа ч даатгуулъя.

Өндөр насны тэтгэврийн талаар мэдвэл зохих зүйлүүд¹⁶

1. Та эмэгтэй бол 55 нас, эрэгтэй бол 60 нас хүрээд харьяа дүүргийн Нийгмийн халамжийн газраас нийтийн тээврээр үнэгүй зорчих хөнгөлөлтийн картаа авах эрхтэй болно.
2. Өндөр насны тэтгэвэр авч буй иргэн нас барвал оршуулгын тэтгэмж болох 1.0 сая төгрөгийг ар гэрийнхэнд нь олгоно.
3. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед 3 жил цэргийн алба хаасан хүнийг улсад 3 жил ажилласанд тооцно.
4. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед Техник мэргэжлийн сургуульд сурч байсан хугацааг ажилласан жилд тооцно.
5. Өндөр настан жилд нэг удаа ахмадын сувилал болон амралтад тус, тус 50%-ийн хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх эрхтэй.
6. Зарим нэр заасан эмийг хөнгөлөлттэй үнээр авна.
7. Төрийн байгууллагын албан хаагчид, эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсад, цэргийн албан хаагчид тэтгэвэрт гарахдаа нэг удаагийн тэтгэмж авдаг.

¹⁶ Монголбанк, (2016). Хувь хүний санхүү, х.29.

11.2. Та хэдэн төгрөгийн тэтгэвэр авах вэ?



Та хэдэн төгрөгийн тэтгэвэр авахаа тооцоолж сурмаар байна уу. Тэгвэл дараах бодолтыг дуурайгаад тооцоолоод үзээрэй. Бид тооцоолол хийхийн тулд нийт 24 жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан, 55 нас хүрсэн эмэгтэйг сонгон авлаа.

Дагаад бодоорой.



1. Хамгийн өндөр цалин авч байсан дараалсан 5 жилийг сонгож, сарын дундаж цалинг тооцно. Жишээ нь:

Хамгийн өндөр цалин авч байсан жилүүд	2010	2011	2012	2013	2014
Жилийн цалингийн нийт хэмжээ	6.0 сая төг	6.0 сая төг	6.0 сая төг	7.2 сая төг	7.8 сая төг
Сард дунджаар авч байсан цалингийн хэмжээ	А. 5 жилийн цалингийн нийлбэрийг олно. $6.0 + 6.0 + 6.0 + 7.2 + 8.0 = 33.2$ сая төг Б. Сарын дундаж цалинг олно. 33.0 сая төг / 60 сар = 550,000 төг				

20 жил шимтгэл төлж ажилласан хугацаанд ногдох үндсэн тэтгэврийн хэмжээг тооцно. Энэ нь сарын дундаж цалингийн 45%-иар тогтоогдоно.

$$550,000 \text{ төг} \times 45\% = 247,500 \text{ төг}$$

2. 20-иос илүү жил ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцно. Үүний тулд шимтгэл төлсөн нийт жилээс 20-ийг хасна.

$$13. 24 - 20 = 4 \text{ жил}$$

3. 20- жилээс илүү ажилласан 4 жилд ногдох нэмэгдэл тэтгэврийн хувийг тооцно. Илүү ажилласан жил тутам 1.5%-иар тэтгэврийг нэмэгдүүлэн тооцдог.

$$14. 4 \text{ жил} \times 1.5\% = 6\%$$

4. 20 жилээс илүү ажилласан 4 жилд ногдох тэтгэврийн хэмжээг тооцно. Сарын дундаж цалинг нэмэгдэл тэтгэврийн хувиар үржүүлнэ.

$$15. 550,000 \text{ төг} \times 6\% = 33,000 \text{ төг}$$

5. Нийт тэтгэврийн хэмжээг тооцно. Үүний тулд үндсэн тэтгэвэр дээр илүү ажилласан жилд ногдох нэмэгдэл тэтгэврийг нэмнэ.

$$16. 247,500 + 33,000 = 280,500 \text{ төгрөг}$$

Өндөр насны тэтгэврийн тооцооллыг хялбараар хийхийн тулд томъёо ашиглаж болно.

$$\text{ӨНБТ} = \text{СДЦ} \times [\text{ТБХ} + 1.5 \times (\text{ШТХ} - \text{БХ})]$$

Үүнд:

ӨНБТ - өндөр насны бүрэн тэтгэврийн хэмжээ

СДЦ – сарын дундаж цалин, (даатгуулагчийн тэтгэвэр бодуулахаар сонгосон дараалсан 5 жилийн

ТБХ – 20 жил шимтгэл төлсөн даатгуулагчийн тэтгэвэр бодох хувь - 45%)

НТХ – нэмэгдүүлэн тооцох хувь (тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд -1.5%)

ШТХ - шимтгэл төлсөн хугацаа (жилээр)

БХ - болзолт хугацаа (Өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгох – 20 жил)
Өмнөх жишээг томъёогоор бодож үзье.

$$\text{ӨНБТ} = 550,000 \times [45\% + 1.5\% \times (24 - 20)] = 280,500 \text{ төгрөг}$$

Өндөр насны тэтгэвэр тогтоолгохын тулд дараах материалыг бүрдүүлэх шаардлагатай байдаг. Үүнд:



- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;
- Даатгуулагчийн 1995 оноос өмнө ажиллаж байсан хугацааны хөдөлмөрийн дэвтэр;
- Даатгуулагчийн нийгмийн даатгал (НД)-ын дэвтэр;
- Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан сүүлийн 10 жилийн дараалсан 5 жилийн хөдөлмөрийн хөлсний тодорхойлолт;
- Хэрэв 1995 оноос өмнөх 5 жилийн цалинг сонгосон бол байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, тамга тэмдэг бүхий цалингийн тодорхойлолт;
- Хугацаат цэргийн алба хаасан бол цэргийн батлах;
- Даатгуулагчийн ажилласан хугацааг сэргээн тогтоосон шүүхийн шийдвэр;
- Зураг 2 хувь (3x4);
- Иргэний үнэмлэх;
- Оршин сууж буй хорооны тодорхойлолт болон бусад шаардлагатай баримт.

11.3. Өв хөрөнгийн төлөвлөлт

Зураг 11.4. Өв хөрөнгийн холбогдолтой үгсийн тайлбар

МОНГОЛ ХЭЛНИЙ ИХ ТАЙЛБАР ТОЛЬ	
өв залгамжлах	эзэмших эрх бүхий хүн эд хөрөнгийг өмчлөн авах
өв эзэрхэх	бусдын эд хөрөнгийг өөрийн болгох
өв хөрөнгө	уламжлан ирсэн эд зүйл
өв хөрөнгөө булаалдах	эцэг, эх, өвөг дээдсийн үлдээсэн эд хөрөнгийг булаацалдах



Хэн нэгний нас барахад түүний эзэмшиж байсан хөрөнгө хэнд очих вэ? гэсэн асуулт гардаг. Зарим тохиолдолд өв хөрөнгийн асуудлаас шалтгаалан ах, дүү, хамаатан садны хооронд маргаан үүсэж, эв зээ алдахад хүрдэг.

Айлын том хүү
учраас аавын
байрыг би
авна шүү.



Аав минь амьд
ахуйдаа байраа
надад өгнө гэж
хэлж байсан
шүү дээ...

Хэдийгээр манай Монголчууд амьдралын мөнх бусыг үзүүлэх тухай ярих дургүй байдаг ч хожим өөрийн хөрөнгийг хүссэнээрээ хуваарилах, гэр бүлийн гишүүдийн дунд өмчийн маргаан үүсгэхгүйн тулд хувь хүн бүр өв хөрөнгийн төлөвлөлтийг эртнээс хийх нь зүйтэй юм.

Хэн нэгний амьдралын туршид болон түүнийг нас барсны дараах үеийн өмч хөрөнгийн удирдлага, ашиг сонирхлын асуудлыг тодорхой тусгасан төлөвлөгөөг өв хөрөнгийн төлөвлөлт гэнэ.



Хувь хүн гэрлэхээсээ өмнө олж авсан эд хөрөнгө, хөрөнгийн эрх, оюуны өмч, хувийн эд зүйлсийг хувь хүний хөрөнгө гэнэ. Хувь хүний хөрөнгө, түүний төрөл, хууль, эрх зүйн зохицуулалтын талаар Иргэний хуулийн 84, 125-127-р зүйлд тодорхой заасан байдаг.

Тухайн хүнийг нас барсны дараа түүний хөрөнгийг өмчлөх эрх бүхий этгээдийг өв залгамжлагч гэнэ.


Гэр бүлийн гишүүдийн хамтран амьдарсан хугацаанд бий болсон хөрөнгийг гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгө гэнэ.

Өв хөрөнгийн төлөвлөлтийн хамгийн энгийн хэлбэр бол гэрээслэл бичиж үлдээх арга юм.



Тухайн хүнийг нас барсны дараа хэрэгжих, түүний хөрөнгийн талаарх хувийн сонирхлыг илэрхийлсэн хууль ёсны баримтыг **гэрээслэл** гэнэ.

Зураг 11.5. Гэрээслэл бичих зөвлөмж



ТАНЫ МЭДЛЭГТ (Монгол Улсын Иргэний хуулиас)

Өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө. Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ.

Нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх хууль ёсны өвлөгч байна.

Өвлүүлэгч, эсвэл өвлөгчийг санаатайгаар алсан, тэдгээрийн аль нэгний нас барах шалтгаан болсон бусад гэмт хэргийг санаатайгаар үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол уг гэм буруутай этгээд өвлөх эрхээ алдана.

Хувь хүн өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг өөрийн хүссэнээр хуваарилан гэрээсэлж болно.

Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн хууль ёсны өвлөгчдөд өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ.

11. “ТЭТГЭВЭР” СЭДВИЙН АРГА ЗҮЙ

11.1. Тэтгэврийн даатгал

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Тэтгэврийн даатгалын ач холбогдлыг ойлгох үндсэн дээр албан болон сайн дурын нийгмийн даатгалд даатгуулах

Хэрэглэгдэх нэр томъёо:

Тэтгэврийн даатгал, өндөр насны тэтгэвэр, албан журмын даатгал, сайн дурын даатгал

Хэрэглэгдэхүүн:

Тэтгэвэрийн дэвтэр, бүлгийн ажлын цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Нийгмийн даатгал төлөх, тэтгэврийн нэрийн дансны тооцоолол хийх

Сургалтын зохион байгуулалт :

Сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх, мэдлэг бүтээлгэх арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

“Нийгмийн даатгалд даатгуулдаг уу?”, “Нийгмийн даатгалын ач холбогдол юу вэ?” гэсэн асуултуудыг суралцагчдад тавина. Тэдний төлөөллийг энэ тухай юу бодож байгааг асууж хариултуудыг аваад нэмж баяжуулан зураг 1.1-д үзүүлсэн нийгмийн даатгал юу даатгадаг тухай тайлбарлана.

Энэ 5 төрлийн даатгалд тэтгэврийн асуудал багтаж байгаа бөгөөд “Тэтгэвэрт гарсны дараа бусдаас байнга тусламж, хангамж аваад байх боломжгүй. Иймээс аль болох эртнээс төлөвлөж, тэтгэврийн насандаа хэрэглэх зориулалтаар мөнгө хуримтлуулж эхлэх хэрэгтэй. Хамгийн шилдэг арга нь тэтгэврийн даатгал” гэсэн тайлбарыг хийнэ. Нийгмийн даатгалыг зураг 11.2-т үзүүлсний дагуу албан болон сайн дураараа даатгуулж болох тухай тайлбарлана.

Алхам 2:

Иргэд тэтгэврийн даатгалд даатгуулж, өндөр насны тэтгэвэр авах болзлыг хангасан тохиолдолд тэтгэврээ тогтоолгон авах эрх үүсдэг тухай тайлбарлаад хэдэн наснаас тэтгэвэрт гарч болох тухай асууж ярилцана. Үүний дараа зураг 11.2-т үзүүлсэн тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөлийг тайлбарлана. Мөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4-р зүйлд заасан бусад тэтгэвэр авах нөхцөлийн талаар мэдээлэл өгнө. Тэтгэвэр тогтоогдохдоо “1960 оноос өмнө төрсөн ба түүнээс хойш” гэсэн 2 ялгаатай ангилал байдгийн учрыг тайлбарлана.

Алхам 3:

“Тэтгэврийн даатгалд даатгуулагчийн нэр дээр нээсэн, даатгалын шимтгэлийг хуримтлуулан тооцож, даатгуулагч тэтгэвэрт гарах болзол хангасан үед уг дансанд хуримтлагдсан мөнгөнөөс тэтгэвэр олгох агуулга бүхий дансыг тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс гэдэг” тухай мэдээллийг өгөөд номын “Өндөр насны тэтгэврийн тухай гэр бүлийн яриа” хэсгийн агуулгыг тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл :

Нийгмийн даатгалын тухай хуулинд заасан хувь хүнээс болон албан байгууллагаас төлдөг татварын хэмжээний тухай болон “Өндөр насны тэтгэврийн талаар мэдвэл зохих зүйлүүд”-ийн тухай мэдээллийг өгнө.

11.2 Та хэдэн төгрөгийн тэтгэвэр авах вэ?

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийн хувь хэмжээгээрээ ямар хэмжээний тэтгэвэр авахаа тооцоолж сурах

Хэрэглэгдэх нэр томьёо:

Тэтгэврийн даатгал, өндөр насны тэтгэвэр, албан журмын даатгал, сайн дурын даатгал

Хэрэглэгдэхүүн:

Нийгмийн даатгалын дэвтэр, тэтгэвэр тогтоолгоход шаардагдах материалын жагсаалт, цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Нийгмийн даатгал төлөлтийг ашиглан тэтгэврийн хэмжээг тогтоох, тооцоолол хийх, бүлгээр ажиллах

Сургалтын зохион байгуулалт :

Сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх, мэдлэг бүтээлгэх арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Суралцагчдыг насны байдлаар “залуу, дунд, ахмад” гэсэн 3 бүлэгт хувааж тус бүрд өөр өөр даалгавар өгнө. Ингэхдээ залуучуудын бүлэгт “Дагаад бодоорой” хэсгийн “ӨНБТ = СДЦ х [ТБХ + 1.5 х (ШТХ - БХ)]” томьёог өгөөд жишээ хүснэгтийн өгөгдлийг өгөх бол дунд насныханд тус хэсгийн 1-6 шатны тооцооллын аргыг тайлбарлаж өгнө. Харин ахмад настнуудын бүлэгт өндөр насны тэтгэвэр тогтоолгоход ямар материалыг бүрдүүлэх шаардлагатай тухай жагсаалт гаргуулна.

Бүлэг тус бүр ажиллаж дууссаны дараа дунд насны бүлгээр тооцооллын үе шатуудын тайлбарыг хэлүүлж, залуу насны бүлгээр томьёоны учрыг тайлбарлуулж ахмад настнуудын бүлэгт ойлгуулна. Энэ хэсэгт багш зөвхөн чиглүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

Алхам 2:

Тэтгэврийн хэмжээгээ тооцоолж сурсан эсэхийг ахмад насны бүлгийн гишүүдээр хэмжин чадаж байвал өндөр насны тэтгэвэр тогтоолгохын тулд дараах материалыг бүрдүүлэх шаардлагатай байдаг хэсгийн мэдээллийг өгнө. Энд багш хууль, тогтоомжоор заасан бүрдүүлэх материалын жагсаалт хэсгийг бүрнээр нь хэрэглэгдэхүүн болгон үзүүлнэ.

11.3. Өв хөрөнгийн төлөвлөлт

Сургалтын хүлээгдэж буй үр дүн:

Өв хөрөнгө эзэмших эрхийг бусдад шилжүүлж гэрээслэл бичих

Хэрэглэгдэх нэр томьёо:

Хувь хөрөнгө, гэрээслэл, өв залгамжлагч, гэр бүлийн гишүүдийн дундын

хөрөнгө, өв хөрөнгийн төлөвлөлт

Хэрэглэгдэхүүн:

Гэрээслэлийн жишээ, зөвлөмж, цаас, цаасны маркер

Сургалтын арга:

Нийгмийн даатгал төлөлтийг ашиглан тэтгэврийн хэмжээг тогтоох, тооцоолол хийх

Сургалтын зохион байгуулалт :

Сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх, мэдлэг бүтээлгэх арга зүйг баримтлан дараах 2 алхмыг хийнэ.

Алхам 1:

Өв хөрөнгийн холбогдолтой үгсийн утгыг зураг 11.3-т үзүүлсний дагуу тайлбарлана. Суралцагчдын суудлаар нь 3 бүлэг болгоод нэг бүлэгт “Өв хөрөнгө гэж юу вэ?, нөгөө бүлэгт “Өв залгамжлагч гэж хэн бэ?, гурав дахь бүлэгт “Гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгө гэж юу вэ?” гэсэн асуулт тавьж тодорхой хариултыг авна.

Ингээд хариултуудыг нэгтгэн “Хувь хүн гэрлэхээсээ өмнө олж авсан эд хөрөнгө, хөрөнгийн эрх, оюуны өмч, хувийн эд зүйлсийг хувь хүний хөрөнгө гэнэ” гэсэн тодорхойлолт, “Тухайн хүний нас барсны дараа өв хөрөнгийг нь эзэмших эрхтэй болох этгээдийг өв залгамжлагч”, “*Гэр бүлийн гишүүдийн хамтран амьдарсан хугацаанд бий болсон хөрөнгийг гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгө гэнэ*” гэсэн тодорхойлолтуудын талаар тайлбарлана.

Алхам 2:

Өв хөрөнгийн төлөвлөлтийн хамгийн энгийн хэлбэр бол гэрээслэл бичиж үлдээх арга гэдгийг дурдаад дээрх 3 бүлэгт тус бүр өөр төрлийн гэрээслэл бичих даалгавар өгнө. Ингэхдээ зураг 11.4-т харуулсан гэрээслэл бичих зөвлөмжийг харуулж удирдамж болгоно.

Залуу насны бүлэгт “хадгаламжийн хуримтлал”, дунд бүлэгт “үнэт эдлэл”, ахмад бүлэгт “орон сууц” өвлүүлэх гэрээслэл бичүүлнэ. Гэрээслэлийг бүлгээр 10 минут орчим бичүүлээд төлөөлөл тус бүрийг уншиж сонсоцгооно.

Нэмэлт мэдээлэл:

Багш “Таны мэдлэгт” хэсгийн Иргэний хуулийн өв залгамжлалтай холбоотой заалтуудын талаар тайлбарлана.

Анхаарах зүйл:

Гэрээслэл бичээгүй тохиолдолд гэр бүлийн гишүүдийн дунд эд хөрөнгөө булаацалдсан маргаан гарч цаашлаад эв эе эвдрэхэд хүрч болзошгүй тул “хэн ч бага хэмжээтэй гэхгүйгээр хөрөнгөө яах тухайгаа бичгээр гэрээслэл бичих хэрэгтэй” гэдгийг сануулах хэрэгтэй.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Амаржаргал. Р., Эдийн засгийн цагаан толгой. УБ, м2010.
2. Бакей.А., Оросоо.Р., Эдийн засгийн ухаан. УБ, 1998.
3. Балж.Г., Эрсдэл ба даатгал. УБ, 2006.
4. Батбаяр.Г., Даатгалын менежмент: Онол ба хэрэглээ. УБ, 2014.
5. Батжаргал.Н., Баянсан.П., Оюунцэцэг.Д., Хувь хүний санхүү. УБ, 2016.
6. Ганзориг.А., Эрсдэлийн удирдлагын лекц. УБ, 2007.
7. Даатгалын тухай хууль. Шинэчилсэн найруулга. УБ, 2004.
8. Нийгмийн даатгалын тухай хууль. УБ, 1994.
9. Дэлхийн эрсдэлийн зураглал-2016.
10. Жеймс Е. Стоверс., Санхүүгийн тусгаар тогтнол, УБ, 2010.
11. Монголбанк, Дэлхийн банк, Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь. УБ, 2015.
12. Монголбанк, Хувь хүний санхүү. УБ, 2016.
13. Монгол Улсын Иргэний хууль (шинэчилсэн). УБ, 2002.
14. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. УБ, 1994.
15. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль. УБ, 2001.
16. ОУХБ, Санхүүгийн боловсрол., УБ, 2010.
17. Оюунсүрэн. Б., Гэр бүлийн эдийн засгийн боловсрол. УБ, 2014.
18. Оюунцэцэг. Д., Хувь хүний санхүү. УБ, 2012.
19. Оюунцэцэг. Д., Хувьцаа эзэмших эрх - Таны алтан боломж. УБ, 2011.
20. Оюунцэцэг.Д., Санхүүгийн нэр томъёоны монгол-англи товч тайлбар толь, УБ, 2011.
21. Сангийн яам, Монгол Улсад тулгараад байгаа эрсдэлүүд. Санхүү, эдийн засгийн бодлогын газар, 2011.
22. СЗХ, Санхүүгийн хөтөч: Иргэдэд зориулсан гарын авлага. УБ, 2010.
23. ХДК, Дэлхийн банк, Эрдэм мэдлэг түгээх төв, Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн гарын авлагууд. УБ.
24. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль. УБ, 2006.
25. ХҮДС, XXI зуун: Эдийн засгийн онолын зарим асуудал. УБ, 2009.
26. ISO 31000:2009 – Эрсдэлийн удирдлага – Зарчим ба заавар стандарт

